



ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

ЦАЦ

**СУРГАЛТ, СУДАЛГАА,
АРГА ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН СЭТГҮҮЛ**

/№26/49 2023

- **Нийгмийн аюулгүй байдалд сэтгүүл зүйн бодлого, эрх зүйн үзүүлж буй нөлөөллийг сайжруулах арга зам**
- **Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдлын асуудалд**
- **Жижиг бүлгүүдийн байлдааны ёс суртахууны - сэтгэл зүйн хангалтын онцлог**
- **У.Мөнхбат: Цөмийн зэвсэгт хийсэн судалгаа**



ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИАС ЭРХЛЭН ГАРГАВ





ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:

Хурандаа Б.Өлзийхуяг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Хошууч Д.Идэшноров ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Ph.D)

Редакцийн гишүүд:

Хошууч Л.Одмаа ЦНДС-ийн Цэргийн холбоо, кибер аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

Б.Баатарсүрэн БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Х.Орхончимэг БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Техник редакцийн гишүүд:

Д.Энх-Од Техник редактор
Д.Насанжаргал Дизайнер

Редакцийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, БНМАУ-ын баатар Д.Нянтайсүрэнгийн гудамж, 16 дугаар хороо, Улаанхуаран

Утас/факс: 976 11 480172

Шуудангийн хайрцаг: 13300

Веб хаяг: www.mndu.gov.mn

Цахим шуудан: tsats@mndu.gov.mn

Олон улсын индекс: ISSN 2313-8076

Эрхлэх байгууллага: Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль

Хэвлэх үйлдвэр: ҮБХИС-ийн ЭШИХ-ийн Хэвлэх үйлдвэр



FOR INTELLECTUAL AND CREATIVE THINKING

EDITORIAL BOARD

Editor-In-Chief:

Colonel Ulziikhuyag.B Deputy Director for Research and cooperation, MNDU, Prof. (Sc.D)

Deputy Editor-In Chief:

Major Ideshnorov.D Chief of Division for Research and innovation, MNDU, Ph.D

Editorial Panel:

Major Odmaa.L Senior Lecturer of Military Signaling and cyber security Department of Joint Military School, MNDU, Ph.D

Baatarsuren.B Research fellow, Center of Defense Analyses, Institute of Defense Studies, MNDU, Ph.D

Orkhonchimeg.Kh Research fellow, Center of Security and Defense Studies, Institute for Defense Studies, MNDU, Ph.D

Technical Editor:

Enkh-Od.D Technical editor

Nasanjargal.D Designer, Illustrator

Address:

Mongolian National Defense University
Nyantaisuren Street, Bayanzurkh District, Ulaanbaatar, Mongolia, 13300

Phone: 976 11 480177

Fax: 976 11 480172

Mail box: 13300

Website: www.mndu.gov.mn

E-mail: news@mndu.gov.mn

ISSN: 2313-8076

Host: Mongolian National Defense University

Published by: Defense Press



ҮНДЭСНИЙ
БАТЛАН ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИАС
ЭРХЛЭН ГАРГАВ.

2023

№ 26/49/

СУРГАЛТ,
СУДАЛГАА, АРГА
ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН СЭТГҮҮЛ

ДУГААРЫН ТОВЧООН

Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал

Б.Өлзийхуяг: Хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангах нийтлэг асуудалд	6
Х.Орхончимэг, С.Байгалмаа: Нийгэмд залуучуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх онолын зарим асуудалд	14
Д.Энхчимэг: Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх зарим асуудалд	18
Т.Энхзаяа, Г.Нямхүү: Шифрлэлт ба харилцаа холбооны аюулгүй байдал	23
С.Болорцэцэг, Т.Оргилхүү: Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдлын асуудалд	30
Б.Болор-Эрдэнэ: Энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдод тулгарч буй эрүүл мэндийн эрсдэлт зарим хүчин зүйлийг тодорхойлох нь	35
Б.Бямбасайхан: Монгол соёл иргэншлийн аюулгүй байдлын уламжлал, өв соёлын төлөвшлийн хөтөлбөрөөр дамжуулан өсвөр үеийнхний төлөвшлийг дэмжих боломж	41
Б.Эрдэнэчимэг, Б.Түвшинсайхан: Нийгмийн аюулгүй байдалд мэдээллийн үзүүлж буй нөлөөллийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ	47
О.Үржин, С.Буянхишиг: Нийгмийн аюулгүй байдалд сэтгүүл зүйн бодлого, эрх зүйн үзүүлж буй нөлөөллийг сайжруулах арга зам	55
Ц.Зандан: Гадаадын банк геополитикийн хэрэгсэл болох нь	60
П.Цэдэв, З.Батгэрэл: Хүний аюулгүй байдлын зарим асуудал	66

Батлан хамгаалах боловсрол, цэргийн сургалт

А.Октябрь: Жижиг бүлгүүдийн байлдааны ёс суртахууны – сэтгэл зүйн хангалтын онцлог	72
Д.Идэшноров, Н.Уранчимэг: Монгол Улс, БНФУ-ын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа, Франц хэлний сургалт /УБХИС/	80

Судалгаа, боловсруулалтын ажил

Д.Долгормаа, Ц.Хонгорзул: Газрын доорх усны нөөцийн судалгаанд хийсэн шинжилгээ	86
М.Бүжлхам, Д.Гандолгор: Монгол уламжлалд суурилсан багшийн ёс суртахууны өнөөгийн байдал	96
П.Мөнхтөр, М.Индрабүд, Г.Оюунтуяа: Гамшигт нэрвэгдэгсэд үзүүлэх тусламж, үйлчилгээ	102
Д.Отгонцэцэг: Багш хөгжлийн талаарх олон улсын туршлага	108

Цэргийн зэвсэглэл техник, инновац судлал

У.Мөнхбат: Цөмийн зэвсэгт хийсэн судалгаа	112
М.Эрдэнэтөгс: Орос-Украины дайнд артиллерийг хэрэглэж байгаа байдалд хийсэн судалгаа	116
Л.Мандалбаяр: ОХУ-ын батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлж буй "Бамбай хөтөлбөр"	120

Шинжлэх ухаан судлал, дайны туршлага сургамж

Т.Эрдэнэхишиг, Д.Эрдэнэсүвд: Ухуань, Сяньбийн гарал, үүсэл, зан заншил	125
--	-----

ХҮН ТӨРӨЛХТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НИЙТЛЭГ АСУУДАЛД

Б.ӨЛЗИЙХҮЯГ /УБХИС-ийн дэд захирал Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, хурандаа

Түлхүүр үг: Аюулгүй байдал, шинжлэх ухаан, онол, зарчим

Key words: Security, science, theory, principle

Оршил. Эрдэмтэд аюулгүй байдлын тухай асуудлыг олон талаас нь судалж, холбогдох онол, үзэл баримтлалаар тайлбарлан практик үйл ажиллагааны үнэтэй санал, дүгнэлтийг гаргасаар байгаа билээ. Аюулгүй байдлын асуудлыг гүнзгийрүүлэн судалж, шинжлэх ухааны танин мэдэхүйн түвшин, мэдлэгийн тогтолцоонд тодорхой байр суурийг олох, нэгдсэн ойлголтод хүрэх нь шинжлэх ухаан судлалд төдийгүй улс гүрэн, нийгэм ба хүн ардын амар амгалан байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Хүн төрөлхтөн хөгжих тусам иргэншлийн асуудал хурцдах болж нийгэм, хувь хүний аюулгүй байдлын асуудалд онцгой анхаарал хандуулахад хүргэж байна. Ялангуяа дэлхийн II дайны дараа хүн төрөлхтний иргэншлийн агуулгад хувьсал өөрчлөлт хурдацтай явагдаж эхэлснээс үүдэн нийгэм, хувь хүний аюулгүй байдлын асуудал анхаарал татах болсон.

Аристотель, Ньютоноос эхлэн хүн төрөлхтний хөгжлийн турш шинжлэх ухаан дэлхий ертөнцийг нэгдмэл, бүхэл байдлаар төсөөлөхийг эрмэлзэж байв. Онолын физикийн нэгдмэл математик хуулийг үндэслэсэн А.Эйнштейн (1879–1955) “физик, биологи, сэтгэл зүй, социологи зэрэг бүх шинжлэх ухааны нийтлэг үндсийг хүн нээж чадвал үнэхээр гайхамшиг болох сон билээ” гэж хэлж байжээ.

Шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил ба үйлдвэрлэл нь дэлхийн бараа бүтээгдэхүүний эргэлтэд үндсэн өөрчлөлт оруулж, санхүүгийн урсгал, техникийн шинэлэг санааг идэвхжүүлж, улмаар дэлхий ертөнцөд глобал хүрээний багагүй асуудлыг бий

болгосон. Глобал асуудал нь бүх хүн төрөлхтөнд хамааралтай бөгөөд дэлхийн хамтын нийгэмлэгийн улс орнууд, байгаль орчин хоорондын харилцан уялдаа, нөөцийн хангалт, дэлхий дэх амьдралын аюулгүй байдлын асуудлыг хөндөж, тэдгээрийг шийдвэрлэхэд олон улсын хамтын ажиллагааны хүчин чармайлтыг шаардаж байна.

Үндсэн хэсэг. Хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангах глобал асуудалд нэгдүгээрт, дэлхийд энх тайван байдлыг тогтоон хадгалах хоёрдугаарт, байгаль орчныг бохирдуулах, унаган төрхийг алдагдуулахтай холбоотой экологийн асуудал гуравдугаарт, хүн амын өсөлт болон хүмүүсийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хүн ам зүйн асуудал дөрөвдүгээрт, хүнсний асуудал тавдугаарт, эдийн засгийн асуудал зургаадугаарт, дэлхий ертөнцийн эрдэс, түүхий эд, бусад байгалийн баялгийн нөөцийн хязгаарлагдмал байдалтай уялдсан эрчим хүч, түүхий эдийн асуудал долоодугаарт, мэдээллийн асуудал наймдугаарт, хүн төрөлхтний эрүүл мэндийн асуудал зэрэг хамрагдаж байна.

Цөмийн дайн болбол иргэншил төдийгүй эцэст нь дэлхий дээрх амьдрал төгсгөл болохыг хүн төрөлхтөн ухамсарлах болсон. Мөн ердийн зэвсэг хэрэглэсэн зэвсэгт мөргөлдөөн ч олон зуун сая хүний амь насыг бүрэлгэх, байгалийн унаган төрхийг эвдлэн сүйтгэх чадавхтай учраас хүн төрөлхтөнд аюултай юм.

Экологийн асуудал материаллаг үйлдвэрлэлийн бараг бүх салбарт илэрч, хүн төрөлхтний өмнө тулгамдсан нэг сэдэв болсон. Хүрээлэн буй орчны бохирдлоос үүдэн хүмүүсийн амьдрал, эрүүл мэнд, ургамал болон

амьтны ертөнц, усны нөөц ба агаарын орон зай, агаар мандлын озоны давхаргын бүрэн байдал зэрэгт аюул учирч байна.

Хүн ам зүйн глобал шинжтэй асуудлын зэрэгцээ хөгжиж буй орнууд дахь нийгэм, эдийн засгийн тааламжгүй нөхцөл түүнд нөлөөлж байна. Хоцрогдлыг даван туулахгүй бол хүн амын өсөлт ядуурлыг улам нэмэгдүүлэхэд хүргэж байна. Бүхэлдээ дэлхий дахинд хүнсний бүтээгдэхүүний хомсдол байгаа боловч газар зүйн хувьд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээний тархалт харилцан адилгүй байгаа нь хүнсний асуудалд нөлөөлж байна.

Ашигт малтмалын нөөц хязгаарлагдмал байгаа нь түүхий эд, эрчим хүчийг хэмнэх, нөөц хуримтлуулах, шинэ технологи нэвтрүүлэх шаардлагатайг харуулж, энэ асуудлыг шийдвэрлэхэд дэлхийн бүх улс орны хүч чармайлтыг чиглүүлэх хэрэгтэй болж байна.

Амьдрах үйл ажиллагааны мэдээллийн хангалт, эрүүл мэнд, сэтгэл зүйн шинжтэй олон асуудлыг хүн төрөлхтний глобал асуудал болгон тавьж байна. Хүн төрөлхтний глобал асуудлууд хоорондоо нягт уялдаатай бөгөөд аюулын зэрэглэлийн хувьд энх тайван, экологи, хүн ам зүй, хүнсний асуудлыг зарим судлаач тэргүүн зэрэглэлд авч үзсэн байна.

Глобал асуудлуудын нэг нь дэлхийн хүн амын хурдацтай өсөлт болж байна. 1900 онд дэлхийн хүн ам 1 тэрбум орчим байсан бол 2000 онд 6 тэрбум, 2020 онд 7 тэрбум гаруй болж, 2050 онд 12 тэрбумд хүрэх төлөвтэй. Хүн ам зүйн аюулын нэг шалтгаан нь настай хүмүүсийн эзлэх хувийн жин өсөж байгаа явдал юм. XXI зууны дундуур хүний дундаж нас 85 жил болох, одоогийн төрөгсөд дунджаар 100 жил наслахыг Дани улсын хэсэг судлаачид тогтоож, хүн дунджаар 150 жил наслах боломжтой гэж Оросын зарим эрдэмтэн үзсэн байна.

Эрчим хүчний асуудал хүнд хэвээр байна. Хүн амын өсөлт, иргэншлийн хөгжилтэй уялдан эрчим хүчний үйлдвэрлэлийг (нефть, хий, нүүрс ба усан цахилгаан станцын эрчим хүч)

нэмэгдүүлэхийг шаарддаг. Эрчим хүчний 90 орчим хувийг нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ашиглах замаар гарган авч байна. Одоогийн хэрэглээний тооцоогоор нефть, хий 50–70 жил, чулуун нүүрс 300 орчим жилд л хүрэлцэхийг мэргэжилтнүүд таамагласан байна. Эрчим хүчний эх үүсвэр болох байгалийн баялгийн нөөц хомсдохын хэрээр нефть, хий зэрэг байгалийн баялгийг импортлогч, экспортлогчдын хоорондын харилцаа хурцдах төлөвтэй. Технологийн боловсруулалтын явцад олборлосон анхдагч түүхий эдийн зарим хэсэг шууд хаягдал болдог, багагүй нөөцийг үр ашиггүй зориулалтаар ашигладаг байна.

Америкийн хэсэг эрдэмтэд дэлхийн хүн амын өсөлт, аж үйлдвэрлэлийн багтаамж, газар тариалангийн салбарын хөгжил, байгалийн нөөц баялгийн хэрэглээ, байгалийн бохирдол зэрэг хувьсагчдын хоорондын харилцан хамаарлыг загварчлах оролдлого хийж, судалгааны дүнгээр XXI зууны дунд үе гэхэд дэлхий дахиныг хамарсан хямралт байдал гарцаагүй гарна гэсэн дүгнэлт хийжээ.

Хөгжилтэй орнууд өөрийн ноёлох байдлаа бэхжүүлэх замаар дэлхийд тогтвортой байдлыг хангахыг эрмэлзэж, өөрсдийн сайн сайхны төлөө бусад улсуудын нөөц баялгийг ашиглах, сул хөгжилтэй орнуудад хүлцэнгүй хүнд сурталт элит хэсгийг бий болгох, өндөр үнэтэй эмнэлгийн үйлчилгээ, эм хангамж, архи, тамхи, мансууруулах бодис дэлгэрүүлэх, гэр бүлийг сарниулах, зэвсэгт мөргөлдөөн дэгдээх зэрэг далд “геноцид” явуулах замаар хүн амыг хорогдуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан сэтгэл зүй – ёс суртахууны болон мэдээлэл – сэтгэл зүйн дарамт үзүүлэх зэрэг харилцан тэнцвэргүй арга хэрэгслийг хэрэглэж байна.

Хөгжилтэй улсуудад дэлхийн болон тодорхой бүс нутгийн хүн амын сэтгэл санаа, үйл ажиллагааг эзэмдэж, удирдах зорилгоор сансрын янз бүрийн систем бүтээж байна. Энэ систем нь хиймэл дагуулуудаас бүрдэх

¹ Военный энциклопедический словарь. М.:Воениздат. 2007. с71.



бөгөөд тэдгээрээс дамжуулсан мэдээлэл, цацаргалт нь компьютерын программд вирус нэвтрүүлэх, удирдлагын болон компьютерын сүлжээг жагсаалаас гаргах, хүний сэтгэл зүй-физиологи, сэтгэл хөдлөлийн байдалд (айдас, өвдөлтийн мэдрэмж, сэтгэл санааг сэргээх, өөдрөг байдал, баярлах) нөлөөлөх зэрэг заналхийлэл үүсгэх ажээ. Энэ зорилгоор дэлхийн мэдээллийн систем, “интернэт”-ийг ашиглах болов. “Интернэт-хамаарал” хэмээх шинэ өвчин сэтгэл зовоож буйг европын эрдэмтэд тэмдэглэсэн байна.

Улс төр, эдийн засаг, цэргийн зэрэг үйл явцын мэдээллийн урсгалыг ганцаарчлан удирдах нь глобал түвшний нэг аюул занал болж байна. Нийгмийн бүх харилцааг бусниулах, нийгмийн дэг журам сулрах, ёс суртахуун, эрх зүйн соёл доройтох нь хувь хүн, нийгмийн бүлэг хүмүүс, улс орон, бүхэлдээ хүн төрөлхтний оршин тогтноход анхдагч аюул заналын сэдэл болж байна.

Цэргийн аюулгүй байдал гэдэг нь нийгэм, улс, иргэдийг цэргийн хүч хэрэглэх буюу хэрэглэх заналхийлэлтэй холбоотой гадаад ба дотоодын аюулаас хамгаалагдсан байдал бөгөөд түүнийг үндэсний болон олон улсын аюулгүй байдлын үндэснүүдийн нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг байна.

ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегид “Зэвсэгт хүчний бэлэн байдал ба дайчилгааны чадварыг өндөр түвшинд байлгах шаардлагатай” гэж үзсэн байна.

БНХАУ-ын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “Цэргийн аюулгүй байдлыг хангахыг үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм” гэж үзжээ.

Шинжлэх ухааны мэдлэгийг интеграцчилах чиглэлд хийсэн судалгаа хэд хэдэн шинжлэх ухааны чиглэл тухайлбал, дэлхий ертөнцийн мэдээллийн нэгдмэл талбарын тухай мэдээллийн шинжлэх ухаан, дэлхий ертөнцийн нэгдмэл байдлын тухай сансар огторгуйн шинжлэх ухаан (ноокосмоги), хүний хөгжлийн мөн чанар, хөгжлийн механизмын тухай хүний хөгжлийн тухай шинжлэх ухаан (акмеологи),

амьд болон “амьд бус” орчин дахь эрчим-мэдээллийн солилцооны тухай эрчим – мэдээллийн шинжлэх ухаан (эпиологи) зэрэг хүн, түүний үйл ажиллагаа, дэлхий ертөнцөд эзлэх байр суурьтай холбоотой шинжлэх ухааны олон шинэ чиглэл бий болж байна.

Хүн, түүний хүрээлэн буй орчны аюулгүй байдлын тухай шинжлэх ухааныг бий болгох хэрэгцээ гарч, тэр өмнө нь байсан байгалийн, нийгмийн болон техникийн шинжлэх ухааны уулзвар дээр бий болох нь батлагдаж байна. Аюулгүй байдлын олон талт асуудлыг эдийн засаг, цэрэг, хүнс, улс төр, мэдээлэл, шинжлэх ухаан, боловсрол, удам зүй зэрэг чиглэлтэй холбоотойгоор шинжлэх ухааны үүднээс гүнзгий судлан боловсруулах шаардлагатай нь улам тод илэрч байна.

Эдийн засаг, улс төр, экологи, мэдээлэл, цэргийн зэрэг аюулгүй байдлын чиглэлүүдийг шинжлэх ухааны олон салбарт тулгуурлан боловсруулдаг бөгөөд тус бүр нь аюулгүй байдлын ерөнхий онолыг боловсруулахад өөрийн хувь нэмрийг оруулж байдаг. Өнөө үед нийгмийн аюулгүй байдал нь чанарын хувьд цоо шинэ үзэгдэл болж байна.

Аюулгүй байдлыг хангах нь аюул заналыг илрүүлэн судлах, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, няцаан устгах талаарх хүн, нийгэм, улс орон, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд суурилагдсан байдаг учраас бүхэлд нь хамаарах аюулгүй байдлыг хангах асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэх хэрэг гарч байна.

Одоогоор энэ чиглэлд зөвхөн анхны алхам хийгдэж байгаа ч XXI зуунд хүн төрөлхтний амьдрах орчны асуудалд хүч чармайлтаа идэвхжүүлэх шаардлага тулгарч байна.

Аюулгүй байдлын тухай ерөнхий онолыг боловсруулах үндэслэл нь аюулгүй байдлын тогтолцоонд нэгдүгээрт, хүмүүс, нийгмийн бүлэг, нийгэм, улс орон, дэлхийн хамтын нийгэмлэг, түүнчлэн амьдрахын чухал объект, үнэт зүйлийг (байгалийн ба нийгмийн) хамгаалан хөгжүүлэх, зайлшгүй шаардлага гарсан хоёрдугаарт, хүмүүс, амьдрахын чухал



объект хоорондын эмзэг байдал улам өсөж байгаа гуравдугаарт, сөрөг үйлчилгээний олон чиглэл үүсэж, янз бүрийн төрлийн аюул глобал шинжтэй болж байгаа зэрэг бодит хүчин зүйлээс урган гарч байна.

Аюулгүй байдал судлалын үндсэн зорилго нь аюулгүй хөгжлийн зүй тогтлыг илрүүлэх, төвөгтэй систем болох хүн, хүн төрөлхтний амьдрах аюулгүй байдлын үйл явц, үзэгдлийг судлах, эмх цэгцтэй болгох, ангилах, системчлэх, аюул занал гарахаас сэргийлэх, тусгаарлах, арилгах талаар зохих арга хэмжээг боловсруулах явдал юм. Хүн төрөлхтөн ба хүний амьдрах үйл ажиллагааг хангахтай холбогдолтой үзэл баримтлал, зөвлөмжийг боловсруулах нь аюулгүй байдал судлалын практик ач холбогдол болдог байна.

Аюулгүй байдал судлалын төлөвшлийн үндсийг өөрийн аюулгүй байдлаа хангах, хүмүүс, улс орон, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааны туршлагыг судлах, аюулгүй байдлын тогтолцооны зүй тогтол, харилцан уялдаа, зарчмыг илрүүлэх, бусад улс орнуудын дотоод, гадаад аюулгүй байдлыг хангах үндэсний өвөрмөц онцлогуудыг харьцуулан судлах, аюулгүй байдлын тогтолцооны хэтийн загварчлал, хувьслын хандлагыг төсөөлөх, тэдгээрийн үр дүнтэй байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах явдал бүрдүүлж байна.

Мөн дэлхийн янз бүрийн улс орнуудын аюулгүй байдлын үзэл баримтлал, номлол, бодлого, стратеги, түүнчлэн энэ чиглэлийн судалгааны үр дүнг цэгцтэй шинжлэн судалж нэгтгэх шаардлагатай болдог. Түүнчлэн алдарт сэтгэгчид, нэрт эрдэмтэд, улс төрчдийн аюулгүй байдлын талаар туурвисан зохиол бүтээл, үзэл бодлыг судлах нь чухал юм.

Аюулгүй байдал судлалын үндсэн зорилтуудыг нэгдүгээрт, хүн болон хүн төрөлхтний амьдрах үйл ажиллагааны янз бүрийн хүрээнд аюулгүй байдлыг хангах үйл явцын тухай мэдлэгийг бий болгож, онолын хувьд нэгтгэн дүгнэх хоёрдугаарт, аюулгүй байдлын судалгааны саланги чиглэлүүдийн

хоорондох харилцан уялдааг илрүүлсний үндсэн дээр аюулгүй байдлын тухай ерөнхий онолыг боловсруулах гуравдугаарт, амьдрах үйл ажиллагааны аюулгүй байдлыг цогцоор хангах үзэл баримтлал, хөтөлбөр, санал боловсруулах дөрөвдүгээрт, хүн ба хүн төрөлхтний тогтвортой, аюулгүй хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн үндэслэл, зүй тогтол, хандлагыг илрүүлэх зэрэг гэж тодорхойлжээ.

Аюулгүй байдлын судалгааны объект нь хүн, нийгэм, иргэншил юм. Аюулгүй байдлын судлах зүйл нь хувь хүн, нийгэм ба улс орны хамгаалагдсан байдал, үндэсний ашиг сонирхлын хамгаалагдсан байдал, тогтолцооны тогтвортой байдал юм. Аюулгүй байдал судлалын арга зүй нь судалгааны аргуудыг сонгох, баримт материалыг шинжлэн судлах, цогц системийн хандлагын үндсэн дээр загварчлалыг боловсруулах, онолын боловсруулалт хийх, аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулах үе шатыг багтаадаг байна.

Аюулгүй байдал судлалын нийгмийн баримжаа нь улс төр судлал, философи, сэтгэл зүй, социологи зэрэг хүрээг хамаарч улам олон чиглэлтэй болж, харин технологийн баримжаа нь мэдээлэл, кибернетик зэрэг техникийн шинжлэх ухаантай харилцан уялдаатай байдаг.

Ардчилсан улс орнуудад үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн зарчмууд нь хууль сахих; хувь хүн, нийгэм ба улсын амин чухал сонирхлыг тэнцвэртэй байлгах; аюулгүй байдлыг хангах талаар хувь хүн, нийгэм ба төр харилцан хариуцлага хүлээх; аюулгүй байдлын олон улсын системтэй интеграцид орох явдал болдог байна.

Аюулгүй байдал судлалын судалгааны үндсэн чиглэл нэгдүгээрт, хүн, нийгэм, улс орон, хүн төрөлхтөнд учирч буй аюул занал хоёрдугаарт, хүн ба нийгмийн амьдрах үйл ажиллагааг хангах объект гуравдугаарт, аюулгүй байдал ба хамгаалалтын объект дөрөвдүгээрт, аюул заналын субъект тавдугаарт, аюул заналын шинж үүсэх онцлог, учруулах хохирол зургаадугаарт, аюул заналын эх үүсвэр онцлог



долоод, аюулгүй байдлыг хангах систем, хүч хэрэгсэл, бүтэц бүрэлдэхүүн, зорилго, зорилтууд, ажиллагааны зарчим зэрэг юм.

Болзошгүй аюул заналын эх үүсвэр ба шинжээс хамааруулан аюулгүй байдлын

судалгааны чиглэлийг геополитик, улс төр, эдийн засаг, нийгэм, хүн ам зүй, хүнс, соёл, цэрэг, экологи, шинжлэх ухаан технологийн гэх зэргээр ангилж үздэг (1 дүгээр хүснэгт).

Аюулгүй байдлын судалгааны чиглэлийн ангилал

1 дүгээр хүснэгт

№	Аюулгүй байдлын хүрээ	Аюулгүй байдлын объект	Аюул заналын үндсэн шалтгаан	Нөлөө бүхий аюул занал
1	Геополитик	–Олон улсын корпорац –Улс орнууд	–Хэт орлого олох –Хууль боловсронгуй бус –Нутаг дэвсгэрийн маргаан	–Цэргийн мөргөлдөөн, –Олон улсын терроризм, –Том хэмжээний дээрэм, луйвар –Дайн –Мансууруулах бодисын наймаа
2	Улс төр	–Нам –Нийгмийн хөдөлгөөн –Засаглалын бүтэц	–Засаглалын хямрал –Хуулийн боловсронгуй бус байдал	–Авлига –Зохион байгуулалттай гэмт хэргийн өсөлт –Терроризм –Нийгэм ба эдийн засгийн харилцаанд гэмт хэрэг өсөх –Захиалгат аллага
3	Эдийн засаг	Үйлдвэрлэлийн хүрээ –Худалдааны хүрээ –Байгалийн баялаг	–Хэт орлого олох –Хуулийн боловсронгуй бус байдал –Татварын бодлогын боловсронгуй бус байдал	–Мөнгө угаах –Үйлдвэр, худалдааны газрыг устгах –Байгалийн нөөц баялгийг хайр гамгүй ашиглах –Хүрээлэн буй орчныг бохирдуулах
4	Нийгэм	–Нийгмийн бүлэг –Олон нийтийн байгууллага	–Материаллаг баялгийн тэгш бус хуваарилалт –Ядуурал –Хүний эрх зөрчигдөх	–Нийгэм, нийгмийн бүлэг ба хүмүүсийн харилцаа дахь гэмт хэргийн өсөлт –Нийгмийн зөрчилдөөн –Терроризм
5	Хүн ам зүй	–Хүмүүс –Хамт олон	–Хүн ам хэт өсөх буюу буурах –Эмнэлгийн үйлчилгээ муудах –Бүс нутгийн үндэстэн, угсаатны харьцааны өөрчлөлт –Баялгийн тэгш бус хуваарилалт	–Хүнийг үй олноор устгах (геноцид) –Угсаатан хоорондын зэвсэгт мөргөлдөөн –Хүний амьдрах дундаж наслалт буурах –Үндэстэн ястан мөхөх
6	Хүнс	–Хүнсний бүтээгдэхүүн	–Хүнсний бүтээгдэхүүний хомсдол –Хөдөө аж ахуйн бэлчээр газар дутагдах	–Хүнсний чанаргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх –Хүн ам олноор хордох
7	Соёл	–Оюун санаа –Ёс суртахуун –Зан заншил	–Оюун санааны доройтол –Ёс суртахууны доройтол –Зан заншлын доройтол	–Ёс суртахууны дэггүй явдал өсөх (самуурал) –Зан заншил алдагдах –Архидалт өсөх –Мансууруулах бодисын хэрэглээ өсөх



8	Эрчим-мэдээлэл	–Хүний ухамсар –Дотоод ухамсар	– Хууль бус эрчим-мэдээллийн үйлчлэл	–Мэдрэгдэхгүй гэмт хэргийн нөлөөлөл –Мангар болгох (зомбирование)
9	Цэрэг	–Улсын сонирхол (тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал г.м)	–Гадаад улс орон ба цэргийн эвслээс түрэмгийлэл үйлдэх санаархал –Цэргийн аюулгүй байдлыг хангах субъектүүдийг зохих ёсоор санхүүжүүлэхгүй байх	–Зэвсэгт хүчин, цэргийн аж үйлдвэрийн салбар ба шинжлэх ухаан уналтад орох –Хүн амын оюун санаа болон эх оронч үзэл доройтох –Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний бэлтгэлийн түвшин буурах
10	Мэдээлэл	–Мэдээлэл –Мэдээллийн дэд бүтэц	–Мэдээллийн дэд бүтцийн боловсронгуй бус байдал –Хуулийн боловсронгуй бус байдал	–Мэдээллийг хулгайлах –Мэдээллийг устгах –Мэдээллийг гажуудуулах –Мэдээллийн нууцыг задруулах –Эдийн засгийн тагнуул хийх –Сүрдүүлэлт
11	Экологи	Хүрээлэн буй орчин	Экологийн байдал доройтох	–Экологийн хувьд “бохир” хүнсний болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх –Газар нутгийг хууль бусаар эзэмших –Дүрвэгсдийн тоо өсөх –Гэр оронгүй тэнэмэл хүний тоо өсөх
12	Шинжлэх ухаан, технологи	–Ноу–хау –Дэвшилтэт технологи	Дэвшилтэт технологийг гэмт хэргийн зорилгоор хэрэглэх боломж	Ноу–хау, дэвшилтэт технологийг гэмт хэргийн зорилгоор ашиглах

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт оршин тогтнохуйн аюулгүй байдал; эдийн засгийн аюулгүй байдал; дотоод аюулгүй байдал; хүний аюулгүй байдал; хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал болон мэдээллийн аюулгүй байдлыг багтаасан байна.

Оршин тогтнохуйн аюулгүй байдлын хүрээнд тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдал болон соёл иргэншлийн аюулгүй байдлын асуудлыг авч үзсэн байна.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн гэж тодорхойлсон байна.

Эдийн засгийн аюулгүй байдлын хүрээнд эдийн засгийн олон тулгуурт бүтэц, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого, төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал, эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого, гадаад худалдаа ба интеграцын бодлогын асуудлыг тусгасан байна.

Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн гэж тодорхойлжээ.

Дотоод аюулгүй байдлын хүрээнд үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх, Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх болон нийгмийн тогтвортой байдлын асуудлыг авч үзсэн.

Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс,



Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн гэжээ.

Хүний аюулгүй байдлын хүрээнд эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдал, амьдрах орчны аюулгүй байдал ба иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах асуудлыг тусгасан байна.

Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэж тодорхойлжээ.

Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын хүрээнд усны нөөцийн хомстлоос сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаврыг бууруулах, биологийн олон янз байдлыг хадгалах, нөөцийн хомстлоос сэргийлэх, хүрээлэн байгаа орчны бохирдлыг бууруулах болон байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг авч үзсэн байна.

Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомстлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэжээ.

Мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн бүрэн бүтэн байдал, мэдээллийн нууцлал ба мэдээллийн хүртээмжтэй байдлын асуудлыг тусгасан байна.

Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан,

хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэж тодорхойлжээ.

Дээр дурдсан судалгааны чиглэлийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд багтаасан үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүдтэй харьцуулан үзвэл оршин тогтнохуйн аюулгүй байдал хэсэгт геополитик, улс төр, хүн ам зүй, цэрэг, соёл ба шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдлын чиглэлийг, эдийн засгийн аюулгүй байдал хэсэгт үндсэндээ эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой чиглэлийг, дотоодын аюулгүй байдал хэсэгт улс төрийн аюулгүй байдлын чиглэлийг, хүний аюулгүй байдал хэсэгт нийгмийн ба хүнсний аюулгүй байдлын чиглэлийг, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал хэсэгт үндсэндээ экологийн аюулгүй байдалтай холбоотой чиглэлийг, мэдээллийн аюулгүй байдал хэсэгт эрчим-мэдээллийн ба мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой чиглэлийг тус тус тусгасан байдал ажиглагдаж байна.

Дүгнэлт. Дэлхий ертөнцийн улам өсөн нэмэгдэж буй харилцан хамаарал нэг талаас, шинэ зөрчил, хурцадмал асуудлыг нөгөө талаас, олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх шинэ боломж, хүч хэрэгслийг бий болгож байна. Олон улсын хамтын ажиллагаа гүнзгийрсэнтэй уялдан олон улсын шинжтэй зөрчил маргааныг шинэ байдлаар авч үзэх хэрэгтэй болж байна. Олон улсын тавцан дахь зөрчил, маргаант байдал зарим улс орон, бүс нутгийн доторх нөхцөл байдлыг тогтворжуулах буюу эвдрэлцүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлж байна.

Судалгаанаас үзэхэд дэлхийн улс төрийн тавцанд “голлон тоглогч” орнуудад аюулгүй байдлын үзэл баримтлалын (стратегийн) баримт бичигтээ цэргийн аюулгүй байдалд анхаарал хандуулсан байна.

Аюулгүй байдлын үзэл баримтлал (стратегийн)-ын бүрэлдэхүүн хэсэг нь тухайн улс орны улс төрийн нөхцөл байдал, эдийн засгийн чадавх, дэлхийн хамтын нийгэмлэгт эзлэх байр



суурь, газар зүйн байрлал зэрэг олон хүчин зүйлээс хамаарч янз бүр байна. Ийнхүү үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг хувиран өөрчлөгдөх аюулгүй байдлын орчинд нийцүүлж, шинэчлэн боловсронгуй болгож байх шаардлагатайг харуулж байна.

Аюулгүй байдлын судалгааны объект болон субъект, тэдгээрийн харилцан үйлчлэлийн

асуудлыг шинжлэх ухааны танин мэдэхүйн түвшинд судалж, мэдлэгийн тогтолцоонд эзлэх байр суурийг нь тодруулж, даян дэлхийн улс гүрэн, нийгэм, хүн ардын аюулгүй байдлыг хангах, аюул заналаас хамгаалах, учрах эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлийн онолын мэдлэгийг нэгтгэн, аргагүйн үндэслэлийг боловсруулж турших шаардлага бий болсон.

Ашигласан материал:

1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. <https://legalinfo.mn/mn/detail?law-id=208070&showType=1>
2. Военный энциклопедический словарь. М.:Воениздат. 2007, с71.
3. Б.Өлзийхуяг, Т.Намсрай. Шинжлэх ухааны арга судлал.УБ.,2022
4. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл.°26(36).2018



НИЙГЭМД ЗАЛУУЧУУДЫН ҮҮРЭГ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛД

Х.ОРХОНЧИМЭГ /БХЭШХ-ийн АББХСТ-ийн ЭШАА, доктор (Ph.D), дэд профессор/
С.БАЙГАЛМАА /ҮБХИС-ийн АБДС-ийн НУТ-ийн багш, докторант/

Түлхүүр үг: Залуучууд, онол, оролцоо, судалгаа

Key words: Youth, theory, participation, research

Залуучуудын оролцоотой нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг бодитоор нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгааны ажлуудын ач холбогдол өсөн нэмэгдэж байна. Нийгмийн өмнө тулгамдаж буй асуудлыг залуучуудын өөрсдийнх нь үзэл хандлага, дотоод сэтгэл зүйн давуу тал дээр тулгуурлан тодорхойлох нь асуудлыг шийдвэрлэхэд тэдний оролцоог нэмэгдүүлэх боломжийг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлох, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх нь чухал юм. Иймд залуучуудын оролцоог тодорхойлсон шинэ загварыг боловсруулахад нийгмийн хөгжлийн үндсэн онолуудыг эхлээд тодруулах шаардлага байна.

Нийгмийн хөгжил гэж юу болохыг хүн төрөлхтний амьдралын туулж ирсэн янз бүрийн замналыг шинжлэн дүгнэх тодорхойлох байдал философи, нийгмийн сэтгэлгээний түүхийн туршид ноёрхож иржээ.

Нийгэм-хөгжил хэмээх ойлголт нь нийгмийн зохистой зохион байгуулалт болох иргэншилд холбогдуулж авч үзэхэд хөгжил бол хуучин буюу нэгэнт байгаа энгийн, бас зохих утгаар доод зэргийг заавал халдаг биш харин тодорхой нөхцөлд тэдгээрийг гарцаагүй хадгалан үлдэж байдаг байна. Хөгжил бол тухайн юм зохистой оршихуйгаа ханган өөрчлөгдөхүй мөн. Г.В.Ф.Гегель нийгэм түүхийн өөрчлөлт хөгжилтийн тасралтгүй үйл явцыг авч үзэж нийгэм түүхийн үзэгдлийг тайлбарласан түүний тайлбар нь түүхэнд болж буй бүх юмс хөгжил эхлэхээс өмнө өөртөө оршиж байдаг гэж үзсэн нь хийсвэр шинжтэй гэж хэлж болно. Нийгмийн тухай үзэл сургаалын систем дотор Г.В.Ф.Гегелийн үзэл томоохон байр суурь эзэлдэг.

Зохиол бүтээлдээ Гегель хүн төрөлхтний нийгэм түүхийн үйл явцыг өөрийн байр суурин дээрээс тодорхойлж тайлбарлажээ.

Нийгмийн хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйлийг тайлбарласан газар зүйн, хүн ам зүйн, нийгэм дарвинизмийн нийгмийн сэтгэл зүйн, соёл иргэншлийн зэрэг олон тооны урсгал, чиглэл, шинэ үеийн философи нийгмийн сэтгэлгээнд бий болсны ихэнх нь нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүчний тухай асуудлаар байна.

Түүхийн хөгжлийн зүй тогтлыг ойлгохын тулд хүмүүсийн үйл ажиллагаанд сэдээгч тэр хүчийг таньж мэдэх нь чухал юм. Хүмүүсийн үйл ажиллагаа ямагт объектив нөхцөл, субъектив хүчин зүйлээр нөхцөлдөж байдаг. Объектив нөхцөл нь юуны урьд материаллаг юмс үзэгдэл хүмүүсийн бодитой үйл ажиллагаа, материаллаг харилцаа юм. Чухамхүү эл материаллаг амьдралаас хүмүүс өөрийгөө, хэрэглээ хэрэгцээгээ ойлгож, тодорхой зорилгод сэдээгддэг. Тэр нь тодорхой үйл ажиллагаанд түлхдэг байна. Хүмүүсийн эл үйл ажиллагаа нь нийгмийн өөрийн хөгжил, хөдөлгөөний үндэс болдог.

Хүмүүсийг үйл ажиллагаанд сэдээгч нэг чухал зүйл бол субъектив хүчин зүйлс хүмүүсийн өөрсдийнх нь ухамсарт үйл ажиллагаа юм. Энд хүмүүсийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, удирдлага, оюуны үнэт зүйлсийг бүтээх үйл ажиллагаа багтаж байдаг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бол үйлдвэрлэгч олон түмний санаа зорилго, мэдлэг, дадлагаа хэрэгжүүлэх үйл явц төдийгүй, бусдад бүтээх хэрэгцээ, хүсэл эрмэлзэл төрүүлэгч өвөрмөц механизм юм.



Таван формац ээлжлэн солигдох явдал нь энэ онолын гол цөм нь биш юм гэхэд нэг язгуур үндэслэл гэдгийг мартаж болохгүй юм. Энэ онол ёсоор аливаа нийгмийн байгууллын үндэс болсон материаллаг баялгийн үйлдвэрлэлийн арга нь өөртөө түүхэн тодорхой материаллаг харилцааг багтааж байдаг бөгөөд тэдгээрийн нийлбэр цогц нь тухайн нийгмийн байгууллын эдийн засгийн бүтэц, бодит суурийг бүрдүүлдэг. Үүн дээр оюун санааны харилцаа, хууль эрх зүй, улс төрийн давхарга сүндэрлэн түүнд нийгмийн ухамсрын тодорхой хэлбэрүүд нийцэн тохирч байдаг.

Гегелийн философийн сурвалж нь сэтгэхүй (ухамсар) ба ахуйн адилсал юм. Юмс ба тэдгээрийн тухай санаа давхцан тохирно. Иймд сэтгэхүй дотоод тодорхойлолтоороо мөн юмсын жинхэнэ уг чанар хоёр бол нэг утгатай юм. Ингээд Гегель нийгмийн хөгжлийн уг сурвалжийн тухай асуудлыг дээрх зарчмын үүднээс тайлбарлажээ.

Объектив оюун ухаан бол доодоос дээдэд шилжих, хөгжих үйл явцад оршин буй нэгэн нэгдмэл бүхэл юм. Гегель оюун ухаан хөгжих хөдөлгөгч хүч нь субъект объектын диалектик зөрчил мөн гэж үзсэн. Оюун ухаан энэ зөрчлийг даван чөлөөт байдлыг ухамсарлахад дэвшилт хийнэ. Оюун ухааны субстанц чөлөөт байдал буюу өөрөөр хэлбэл нөгөөгөөс хараат бус байдал өөрөө өөртөө харилцахуй мөн гэжээ.

Гегелийн үзлээр жинхэнэ чөлөөт байдал бол зайлшгүйг үгүйсгэхэд бус, харин түүнийг ухаарахад түүний сэтгэхүйн, шинжтэй агуулгыг нээн илрүүлэхэд оршдог байна.

Хүн төрөлхтний түүх бол чөлөөт байдлыг, тэгэхдээ оюун санаа сэтгэлгээний чөлөөт байдлыг ухамсарлах дэвшил юм. Түүний үзлээр чөлөөт байдал бол дур зориг биш, тодорхой нөхцөлөөр хязгаарлагдсан зүйл юм. Чөлөөтэй байна гэдэг бол хүн хийж байгаа зүйлийнхээ хязгаар хийгээд зайлшгүй чанарыг ухамсарлахыг хэлнэ. "Хэрвээ би ухаалаг зүйлийг хүсвэл, тусгаарлагдсан хувь хүн бус, харин зан суртахууны байдлын ойлголтод зохицуулан ажиллах болно. Ёс суртахууны

үйлдэлд өөрийгөө биш мөн чанарыг гол болгоно" гэж Гегель үзсэн нь буй. Хүн чөлөөт байдлаа ухамсарлах нь онцгой чухал. Боол нь өөрийн чөлөөт байдлыг мэдэж сэтгэдэггүй тул боол болдог гэж үзэж байв. Эрх чөлөө нь ямар нэг юмыг чөлөөлж, түүний агуулга нь өөртэйгөө адил болох тэр үед л чөлөөт байдал, чөлөөт байдлаа чөлөөлсөн тэр үед л жинхэнэ бий болдог.

Нийгэм дэх хүмүүсийн дураараа үйлдлийг даван туулж, хязгаарлаж болдог. Нийгэм дэх чөлөөт байдал бол хэсэг хүмүүсийн дур зоргоороо аашлахыг даван туулах явдал мөн гэж үзсэн нь чухал ач холбогдолтой санаа юм.

Хүмүүст хүсэл зоригоо тодорхой биш байдлаар дурын үйлдэл мэт биш, харин хязгаарлагдмал хүсэл зориг мэт илэрхийлдэг. Хүсэл зоригийн энэ хязгаарлал нь эрхийн хэм хэмжээ хуулиар зохицуулагдаж, өөрөөр хэлбэл эрхийн харилцааны хүрээнд хэрэгжиж байдаг байна. Эрх бол чөлөөт байдлын биет ахуй нь болж өгдөг. Ийм байдлаар Гегель нийгэм, түүхийн хөгжлийн уг сурвалжийн асуудлыг боловсруулжээ. Ингэж тайлбарлахдаа Гегель нийгмийн амьдралын оюун санааны амьдралын хөгжлийг авч үзэн, улмаар хаана оюун санааны хөгжил өндөр байна нөгөө талаас чөлөөт байдлын ухамсарт хүрсэн байна тэнд нийгмийн хөгжил өндөр түвшинд байна гэсэн үзэл санааг дэвшүүлжээ.

Гегелийн энэ үзлээс аливаа нийгмийн хөгжлийг тодорхойлж буй хүчин зүйл бол тухайн нийгмийн оюун санааны эрх, ёс суртахуун, шашин философи гэх мэт амьдралын хөгжлийн түвшин ойлгож байна. Өөрөөр хэлбэл нийгмийн ухамсрын түвшин уг нийгмийнхээ хөгжлийг тодорхойлно гэсэн үг юм.

Нийгмийн оюун санааны хүчин зүйлсийг нийгмийн хөгжлийн тодорхойлогч хүчин зүйл хэмээн үзэж буй Гегелийн үзэл баримтлал бол нийгмийг оюун санааны хүчин зүйлээр тайлбарладаг үзэл баримтлалын дотор томоохон байр суурь эзэлдэг юм.

Залуучуудын оролцоог нэмэгдүүлэхийн тухайд онолын загварын тухай авч үзсэн



судалгаануудаас Хартын онолын загварыг тодруулж үзье.

Энэ онолын загвар нь залуучуудын оролцоог чадавхжуулах, онолын тогтолцоог тодорхой ашиглах, залуучууд болон насанд хүрэгчдийн оролцоог чухалчлах гэсэн гурван агуулгын хүрээнд авч үзжээ.

Онолын энэ загвар /1 дүгээр зураг/ насанд хүрэгчдийн хяналт, залуучуудын хяналт, хамтын хяналт гэсэн гурван төрлийн оролцоог харуулсан. Насанд хүрэгчдийн хяналт болон залуучуудын хяналтыг ижил түвшинд байрлуулснаар оролцоог харьцангуй тэнцүү түвшинд хангаж, хамтын хяналтын түвшин байрлуулахдаа залуучуудын хяналтыг насанд хүрэгчдийн хяналтаас дээгүүр байрлуулснаар залуучуудын оролцоог насанд хүрэгчдийн оролцоотой үйл ажиллагааны хувьд чадавхжуулж түвшин нэмэгдэх боломжтойг санал болгосон. Ингэснээр залуучууд–насанд хүрэгчдийн хамтын ажиллагааны илүү оновчтой хэлбэрүүд рүү шилжиж үүрэг, оролцоог нэмэгдүүлэх боломжтой гэж үзжээ.



1 дүгээр зураг. Залуучуудын оролцооны онолын загвар¹

Залуучуудын оролцоог нэмэгдүүлэх тусам насанд хүрэгчдийн хамтын оролцоо илүү чадавхжиж тэдний оролцооны үйл ажиллагаа илүү оновчтой хэлбэр рүү шилжих тусам залуучууд болон насанд хүрэгчдийн оролцоо тэнцвэржиж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл насанд хүрэгчид залуучуудын үйл ажиллагаанд бүрэн хяналт тавьдаг, эсвэл

зарим түвшний удирдлага, шийдвэр гаргалтыг залуучуудад даатгадаг эсэхээс үл хамааран насанд хүрэгчдээр удирдуулсан залуучуудын оролцооны хэлбэр тийм ч оновчтой үр дүнтэй биш юм. Залуучуудад үйл ажиллагаа төлөвлөх, шийдвэр гаргах, үзэл бодлоо илэрхийлэхэд оролцох боломжийг олгохгүй бол тэд нийгмийн хөгжилд төдий л идэвхтэй бус оролцож үр дүн гарахгүй байна.

Насанд хүрэгчид залуучуудын үйл ажиллагаанд бүрэн хяналт тавих үед залуучуудын оролцооны оновчтой бус хэлбэрүүд үүсдэг. Ийм нөхцөлд насанд хүрэгчид эрх мэдэл бүхий бэлгэдлийн загварууд бий болдог. Залуучуудын суралцах, хөгжүүлэх нийгмийн хөгжилд гар бие оролцох нь насанд хүрэгчдийн тодорхойлсон чиг баримжаагаар явагддаг. Хэдийгээр залуучууд ур чадвар эзэмшиж, хэрэгтэй мэдлэг олж авах боломжтой ч залуучуудад өөрсдийн санаа бодлоо илэрхийлэх боломж хомс байдаг. Үнэн хэрэгтээ энэ нь чадавхжуулах үйл явцын гол хэсэг хөндий хийсвэр болгож чадавхыг сулруулдаг.

Залуучуудын оролцооны хэлбэр зонхилох үед өөрсдийн үзэл бодлыг илэрхийлэх боломжтой болж асуудал, тэдгээрийн боломжит шийдлүүдийг шийдвэрлэж, үүрэг нь ихэсдэг. Оролцооны зохион байгуулалт нь ардчилсан үйл явцын үед илүү хэрэгждэг. Залуучуудад тулгуурласан оролцооны хэлбэрийн үед залуучууд гол шийдвэр гаргагчид болдог учраас нийгэмд бодитой хувь нэмэр оруулж, оролцоог хангах боломжийг бий болгодог.

Зохиогчид “уламжлалт үзэл онолуудад насанд хүрэгчид залуучуудад эрх мэдлээ өгөх нь санаанд оромгүй сөрөг үр дагаварт хүргэж болзошгүйг олж тогтоосон, эсвэл насанд хүрэгчид залуучуудад эрх мэдэл, хяналтыг өгөх үндэслэл байхгүй гэсэн алдаатай таамаглалд тулгуурласантай холбоотой”² гэж үзсэн.

Залуучуудын оролцоонд тулгуурласан

¹ Typology of Youth Participation and Empowerment Pyramid. <https://organizingengagement.org/models/typology-of-youth-participation-and-empowerment-pyramid/>

² Мөн тэнд



үйл явцыг бүрэн хянах үед бие даасан түвшинд оролцооны хэлбэрүүд үүсдэг. Энэхүү оролцооны төрөл нь "насанд хүрэгчдийн оролцооноос үл хамааран залуучууд өөрсдийн дуу хоолой, оролцоо, эрх мэдлээ илэрхийлэх орон зайг бий болгох арга хэмжээ авсан хувилбаруудыг тодорхойлдог. Энэ төрлийн залуучуудын оролцоо нь насанд хүрэгчдийн зааварчилгаагүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Залуучууд өөрсдийн зорилгыг хангах орон зайг бий болгож болох боловч насанд хүрэгчдийн оролцоогүйгээр эдгээр орон зай нь эрүүл хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Хамтын хяналтын оролцооны хэлбэр нь залуучуудын үйл ажиллагаанд тодорхой хэмжээний хяналт тавих үед үүсдэг боловч насанд хүрэгчид залуучуудын шийдвэрт хориг тавих гэх мэт бага ч гэсэн хяналтаа хадгалдаг. Хэдийгээр энэ арга нь залуучуудын бие даасан байдлыг дээшлүүлдэг гэж үздэг ч зарим судлаачид насанд хүрэгчдийн оролцоо дутмаг байх нь зарим талаар сөрөг үр дагавартай. Тухайлбал залуучууд програмчлалын талаар олон бүтээлч санаатай байж болох ч стратеги төлөвлөгөөг хэрхэн боловсруулж хэрэгжүүлэх талаар мэдлэг дутмаг байж болно. "Залуучууд төлөвлөлт, үйл ажиллагаагаа илүү үр дүнтэй болгож чадах нөөцийн талаар мэддэггүй эсвэл туршлага дутдаг. Иймээс хамтын хяналтын загвар илүү тохиромжтой.

Хэдийгээр залуучууд, насанд хүрэгчдийн

хамтын ажиллагаа нь залуучууд болон насанд хүрэгчдийн дунд янз бүрийн түвшний хяналттай байж болох ч хамтын төлөвлөлт, шийдвэр гаргалт нь үр дүнтэй"³ гэж үзсэн байна.

Энэхүү онолын загварыг залуучуудын оролцооны янз бүрийн категори, хэлбэрийг хослуулсан оролцооны суурь болгож ашиглахад тохирдог. Тус загвар нь танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлийн хөгжлийн янз бүрийн үе шатууд тэдгээрт хэрэглэгдэх онолын суурь болох бүрэн боломжтой. Судлаачид нийгмийн хөгжлийн чадавхын тухай онолууд нь ихэвчлэн нийгэм, соёлтой холбоотой байдаг тул танин мэдэхүйн чадвараас илүү олон ургалч оролцооны төрөлд хэрэглэхэд тохиромжтой.

Ийнхүү залуучуудын оролцооны талаарх онолын судалгаа нь шинээр гарч ирж буй олон ойлголтыг авч үзэж оролцооны илүү оновчтой хэлбэрийг санал болгожээ. Залуучууд болон насанд хүрэгчдийн хамтын ажиллагааг амжилттай болгоход ямар үндсэн элементүүд зайлшгүй шаардлагатай талаарх онолын судалгааг илүү нарийвчлах тухай судлаачид тэмдэглэж байна. Онолын загвар нь залуучуудын оролцоо, залуучууд-насанд хүрэгчдийн чадавх, залуучууд-насанд хүрэгчдийн хоорондын харилцааны талаарх илүү нотолгоонд суурилсан тогтолцоог бүрдүүлдэг элементүүдийг олж тогтооход ач холбогдолтой юм.

Ашигласан материал:

1. Гегель.Г.В.Ф.Философия права.М.1990.стр339
2. Гегель.Г.В.Ф. Энциклопедия философских наук.М.1956.стр45
3. Esenstadt.S.Tradition change and moternity.1973.p66
4. Ленин.В.И.Пол.Собр.т.1.стр131
5. Маркс.К, Энгельс.Ф.Соч.т.23.стр10
6. Typology of Youth Participation and Empowerment Pyramid. <https://organizingengagement.org/models/typology-of-youth-participation-and-empowerment-pyramid>

³ Typology of Youth Participation and Empowerment Pyramid. <https://organizingengagement.org/models/typology-of-youth-participation-and-empowerment-pyramid/>



ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДАД ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ ТӨЛӨШҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛД

Д.ЭНХЧИМЭГ /ЭШИХ-ийн эрдэм шинжилгээний мэргэжилтэн, доктор (Ph.D), профессор/

Түлхүүр үг: Залуучууд, эх оронч үзэл, систем

Key words: Youth, patriotism, system

Аливаа улс үндэстэн төдийгүй хувь хүн өөрийн гэсэн үнэт зүйлтэй. Үнэт зүйл нь хүний амьдралын турш үзэл бодол, хандлага, шийдвэр гаргалт, ерөнхий зан төлөвт нөлөөлж байдаг. Хүн амьдралдаа чиг баримтлал болгодог үнэт зүйлгүй бол нийгэм хэмээх системийг нийтлэг зорилгоор удирдан чиглүүлэх боломжгүй болж, хүн бүр дур зоргоороо авирласан эмх цэгцгүй байдал үүснэ. Соёлын онолд тусгаснаар нийгмийн систем нь субъектийн хэрэгцээ, нийгэм соёлын орчны үнэт зүйл гэсэн дэд системийн харилцан уялдаанд үндэслэн бий болдог. Социологич Т.Парсоны тэмдэглэснээр, дэд системийн хооронд нэг талаас үнэт зүйл нь хэм хэмжээний тогтсон агуулга, мөн чанарыг институт болгож, нийгмийн гишүүдэд хэвшүүлэн мөрдүүлэх, нөгөө талаас нийгмээр дагаж мөрдөж байгаа үнэт зүйл нь хэм хэмжээг бие хүн өөртөө төлөвшүүлж, нийгэмших урвалж шинжтэй үйлдэл тасралтгүй явагдаж байдаг билээ. Үүнд тулгуурлан авч үзэхэд өнөөгийн залуучуудын амьдарч буй нийгмийн соёл, нийгмийн институт, хувь хүний амьдралын замнал туршлагаас үндэстэй. Хүмүүс, хүн төрөлхтний түгээмэл хийгээд нийгмийн бүлгийн үнэт зүйлсийг амьдралынхаа явцад харилцан адилгүйгээр итгэл үнэмшлээ болгодог учир нэг хүнд хамгаас чухалд тооцогдох үнэт зүйл нөгөөд нь чухал бус байж болно.

Эх орон, ээж аав, үр хүүхэд гурав бол хүнд байдаг хамгийн эрхэм үнэт зүйлс. Энэ гурваар амьдралын үнэ цэнэ, хайр хүндлэл, бахархал зэрэг ойлголтууд илэрхийлэгдэж, оршдог болов уу?. Хүн өөрөө өөрийгөө танин мэдэх тусам, сэтгэл оюунаа төгс төгөлдөр илэрхийлэх гэж эрэлхийлэх тусам төдийн чинээ эх орноо улам ухааран хайрладаг. Хайрлахын учир хамгаалах,

хөгжүүлэх болно.

Дэлхий нийтийг хамарсан даяаршил, мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжил дэвшлийн нөлөөгөөр өнөөгийн залуучуудын нийгмийн харилцаа бүхэлдээ хувьсан өөрчлөгдөж байна. Өнөөгийн залуучуудын үнэт зүйлс бүрэлдэн төлөвшихөд нөлөөлж буй хүчин зүйлсийг макро түвшний буюу улс төрийн тогтолцоо, эдийн засгийн харилцаа, нийгмийн бүтэц ба өмч хөрөнгө, оюун санааны өөрчлөлт, даяаршил, гадаад ба дотоод шилжилт хөдөлгөөн, амьдралын хэв маяг, өв уламжлал зэрэгтэй, нөгөө талаас микро түвшний буюу хувь хүнээс өөрөөс хамаарах нас, хүйс, боловсрол, орлого ба баялаг эзэмших байдал, гэр бүлийн харилцаа, шашин шүтлэг, оршин суугаа газар, хөдөлмөр эрхлэлт зэрэгтэй уялдуулан тайлбарлаж болох юм. Хувь хүний болон нийгмийн түвшний эдгээр хүчин зүйлс нь залуучуудын үнэт зүйлсийн чиг баримжааг тодорхойлдог.

Залуучуудын үнэт зүйлсийн бүрэлдэхүүнд эх оронч үзэл гэсэн ойлголт багтана. Эх оронч үзэл гэдэг нь хэн нэгэн хүнд үндэс гарлаа өөрийн амь, бие шигээ хайрлах үзлийг хэлдэг. Эзэн Чингис “Алд бие минь алжааваас алжаатугай, ахуй төр минь бүү алдартугай” гэж эх орон хэмээх орон зайндаа эзэн сууж, төр улсаа төвхнүүлж, хөгжүүлэх үзлийг хойч үедээ гэрээслэн үлдээжээ. 1911, 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын ололт, тусгаар тогтнол, 1939 оны халх голын байлдааны түүхэн ялалт, 1960–аад оны бүтээн байгуулалт, 1990 оны ардчилсан хувьсгалын үр дүн, ардчилал, 2000–аад оны нийгэм эдийн засгийн өөрчлөлт энэ бүхэн монгол хүн бүрийн үндэсний эх оронч үзлийн уламжлал шинэчлэлийн залгамж



чанарын бодит илэрхийлэл юм.

Эх оронч үзлийн тухай ойлголтыг хүн бүр өөр өөрийн харах өнцөг, үнэт зүйлсийн баримжаандаа тулгуурлан тайлбарладаг билээ. Тухайлбал, Монгол Улсын баатар Ж.Гүррагчаа “Эх оронч үзэл монгол хүн монгол хүнээ хүндэлж, бахархахаас эхэлнэ. Өнөөдрийн бидний бахархаж байгаа бүхэн өнгөрсөн цаг үеийнхний бий болгосон, бидэнд дамжуулан өгсөн зүйлс. Одоо бид өнөө үеийн, маргааш ирээдүйн бахархлаа бий болгохын тулд зогсолтгүй санаж сэрж, хөдөлмөрлөх ёстой” гэжээ. Монгол Улсын төрийн соёрхолт, ардын жүжигчин Ж.Жанцанноров эх оронч байх асуудал дээр уриа лоозогнолын, ганц өдрийн хийрхлээр хандаж болохгүйн чухлыг хэлээд, эх оронч үзэл, бахархал, омогшлоос салгаж ойлгохын аргагүй ч энэ үзэл хэт ихдэж, цээжээ дэлдэх нь “Саранд явган явж хүрэх хийгээд завьгүйгээр далайг гатлахтай” агаар нэгэн гэдгийг сануулсан байдаг. Энд гол санаа нь эх орондоо хайртай, эх оронч гэж хий хоосон ярихаас илүү өөрийн зөв үйлдэл, зөв хандлага, эерэг сэтгэлгээ, хүн чанар, зөв ёс суртахуунаас эхтэй гэж би эргэн тойрныхондоо хэлмээр байна¹ хэмээн залуу өсвөр үеийн төлөөлөл аравдугаар ангийн сурагч М.Бат-Оюуны “Эх оронч үзэл, үндэсний аюулгүй байдлын баталгаа” сэдэвт эссэнд бичсэнтэй утга нэгэн адил билээ.

“Эх оронч үзэл эх орноо хайрлах сэтгэлээс төрнө” хэмээн сэтгүүлч, сурвалжлагч Ц.Бадмаараг тайлбарлажээ. Тэрээр хайр, эх оронч үзэл илрэх хэлбэрүүд нь цаг үеийнхээ шаардлагатай холбоотойгоор урган гарч байгаа ч мөн чанар нь, эх үндэс нь хувь хүний үзэл бодол, элэг сэтгэл, зан төрх, бодгаль шинж, чанартай л холбоотой юм. Монгол ардын үгэнд “Сэтгэл үгүй бол нүдэнд үгүй” гэж, тэгэхээр эх орноо, Монголоо хайрлах сэтгэлгүй хүний нүдэнд бол Монгол орон байхгүй л байх нь. Үндэсний үзэл, ухамсар нь хүнийг үндэс, язгуураа хамгаалах, бататгах, хөгжүүлэх, хэрэгцээгээ хангах үйл ажиллагаанд нь

мэргэшүүлнэ. Өөрөөр хэлбэл, хүнийг тэмцэгч, хөдөлмөрлөгч, бүтээн байгуулагч иргэн болгон хөгжүүлдэг.

Хүн төрөлхтний түүхээр нотлогдсон үнэн бол тухайн улсын эх хэлийг эрлийзжүүлж, үндэсний оюун сэтгэлгээнд бусад улс үндэстний философи сэтгэлгээний ноёрхол тогтоох явдал байдаг. Энэ аюулаас эртнээс сэргийлж эх хэл, өв соёл, зан заншлынхаа түүхэн уламжлалын “хил”-ийг батлан сахиж чадвал Монгол маань эдийн засгийн хувьд буурай улс орон хэвээрээ байлаа ч монгол үндэстнээрээ үлдэж чадна.

Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх нь Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын бүх түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, монгол ахуй, өв соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, чанарыг дээшлүүлэх суурь үндэс болно хэмээн доктор (Ph.D) Н.Жалбажав тайлбарласан.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна” гэжээ. Ийм учраас эх оронч үзэл нь үндэсний мэдрэмж, үндэсний ухамсар, үндэсний үзэл, үндэсний бахархал, үндэсний сонирхол, үндсэрхэх үзэл зэрэг олон ойлголтуудтай нягт холбоотой.

Монголын хойч ирээдүйд эн тэргүүнд олгох хүмүүжил, төлөвшил бол яах аргагүй “Эх оронч үзэл”, “Эх оронч иргэн”-ийг боловсролоор нь дамжуулан төлөвшүүлэх явдал юм. Жишээлбэл, Түүхийн хичээлээр дамжуулан дунд сургуулийн сурагчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Бага наснаас нь энэ үзэл хүмүүжлийн суурийг зөв тавьж албан, албан бус сургалтаар дамжуулан төлөвшүүлэх юм.

Өдгөө эх оронч үзэл нэгэн улсын хүрээнээс хальж, нэг тив, нэг бүс нутаг-нэг гэр орон, улмаар энэхэн замбуулин-бидний өлгий нутаг хэмээн ярьж, бичиж тэлж задгайрах хандлага

¹ Бат-Оюун-2.pdf (gia.gov.mn)



бүхий байна. Иймд хүүхэд залуучуудад эх оронч үзэл, төлөвшлийг зайлшгүй суулгах шаардлагатай болж байгаа билээ.

Эх оронч үзлийн талаарх зарим судалгаанаас дурдвал К.Зардыхан “Монголын хөдөлмөрчдийн эх оронч, интернационалч ухамсар төлөвшиж байгаа нь” ном, Б.Дашзэвэг, Б.Солир “Эх оронч үзэл” эмхэтгэл (1999), Е.Моголцог “Залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил төлөвшүүлэх асуудал” (1985), Б.Солир “Монголын эх оронч үзлийн түүхийн зангилаа асуудал”, “Даяаршил ба эх оронч үзэл” үндэсний эрдэм шинжилгээний бага хурал (2002), Нийгэм, улс төрийн судалгааны “Прогноз” хүрээлэнгээс зохион байгуулсан “Эх оронч үзэл ба МАХН” хурлын эмхэтгэл (2005), ҮБХИС-ийн БХЭШХ-ийн “Монгол Улсын иргэдийн эх оронч үзлийн төлөвшил, шинэчлэл” судалгааны ажлын тайлан (2008) зэрэг бүтээлүүд байна².

“НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд”, НҮБ-ын “Залуучууд энх тайван аюулгүй байдалд” 2250 дугаар тогтоол, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”, “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”, “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоол “Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” зэрэг залуучуудын хөгжилд чиглэсэн бодлогын баримт бичгүүд байдаг.

Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилгыг дараах байдлаар зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ³. Үүнд:

Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох;

Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичигт эх оронч үзэл, монгол ахуй, өв соёл, зан заншлын агуулга, арга зүйг тусган

хэрэгжүүлэх;

Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх талын оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулах;

Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлан дэлгэрүүлнэ.

Хөтөлбөрийг 5 жилийн хугацаанд дараах үе шаттай хэрэгжүүлж байгаа болно. Энд:

1-р үе шат /2019–2022 он/: Хүүхэд залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх тогтолцоог бүрдүүлсэн.

2-р үе шат /2023–2024 он/: Эхний үе шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, эх оронч үзлийг төлөвшүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.

Батлан хамгаалах салбарын хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудад ажиллаж байгаад цэргийн тэтгэвэр тогтоолгосон ахмад настнуудыг нийгмийн идэвхтэй гишүүн байх нөхцөлийг бүрдүүлэн, тэдгээрт тулгуурлан эх орноо хайрлан хамгаалах, эх оронч үзэл, хүмүүжлийг түгээн дэлгэрүүлэх, гавьяа зүтгэлийг алдаршуулан сурталчлах, эх орныхоо хөгжил, цэцэглэлтэд өөрийн хувь нэмрээ оруулахад чиглэгдсэн “Бүтээн байгуулагч, нийгмийн идэвхтэй гишүүн иргэн байх”-ыг хүүхэд, залуучуудад тайлбарлан таниулах ахмад, залуу үеийн холбоог бэхжүүлэх, ур чадварыг хойч үеийнхэндээ өвлүүлэн эзэмшүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах нь хөтөлбөрийн гол зорилго гэж ойлгож болно.

Эх оронч үзэл, хүмүүжлийн тогтолцоо нь бүхэлдээ өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд тавигдаж буй бидний зорилтыг биелүүлэхэд иргэд, хүүхэд, залуучууд оюун санаа, ёс суртахууны хувьд бэлэн байж, хүч чадлаа бүрэн зориулах учиртайг Монгол Улсын Үндсэн хуульд ч тодорхой тусгасан байдаг.

Эх оронч үзлийг төлөвшүүлэх, эх орон, газар

² Б.Баатарсүрэн “Эх оронч үзлийг дээдлэх үзэл баримтлал ба ой тогтоолтыг судалсан үр дүн” Эх оронч үзэл СӨБ өгүүлэл.pdf

³ Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр (advocate.mn)



нутгаа хайрлан хамгаалах, ахмад үеэ хүндэтгэх, тэднээрээ бахархан, улс орныхоо төлөө байгуулсан гавьяа зүтгэлийг нь сурталчлан алдаршуулахыг Монгол Улсын Засгийн газраас төрийн бодлого болгон тодорхойлж, зохих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ирсэн уламжлал бий. Тухайлбал, Монгол Улсын ерөнхийлөгчийн ивээл зохион байгуулсан Батлан хамгаалахын сайдын нэрэмжит цэрэг–спортын “Дөл–2022” тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн шилдэг 400 сурагч оролцсон байдаг. Мөн “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”, Монгол Улсын засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоол “Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн заалтыг хэрэгжүүлж, аймаг, орон нутагт төр, засгийн бодлогыг сурталчлах хүрээнд Монгол цэргийн музейн үзмэр, үзүүлбэрүүдээр тусгайлсан үзэсгэлэн бэлтгэх, Монгол цэргийн баатарлаг түүхийг хүүхэд, залуучуудад “Музей нүүж явна” үйл ажиллагаагаар дамжуулан сурталчилсан. Түүнчлэн Монгол Улсын зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрхзүйн үндэс бүрдсэнээс эхлэн дэлхийн халуун цэгүүдэд монгол цэргүүдийн үүрэг гүйцэтгэсэн байдал, түүхэн дарааллыг цэргийн баг, ажиглагч болон штабын офицер, НҮБ–ын энхийг сахиулах ажиллагаанд хүчний командлагчийн орлогчийн хэмжээнд хүртэл оролцож ирсэн талаарх мэдээллийг түгээв.

Дээрхээс гадна “Тусгаар тогтнол–эх орон”, “Монгол эр хүн” сэдэвт лекцүүд уншигдаж, эх орны түүхийн бүхий л цаг үед Зэвсэгт хүчин эх орноо батлан хамгаалах үндсэн үүргээ амжилттай биелүүлэхийн зэрэгцээ улс орны бүтээн байгуулалтад манлайлан оролцож байсан бахархам түүх, өнөөгийн Таван толгой–Зүүнбаян, Зүүнбаян–Ханги чиглэлийн болон “Богдхан” төмөр замын бүтээн байгуулалт зэрэг Зэвсэгт хүчний сүүлийн жилүүдийн нөр их ажлыг гэрэл зураг, дүрс, видео бичлэгээр хүүхэд залуучуудад сурталчлан таниулсан.

Монгол эх оронч үзэл, эх оронч байх гэдэг бол өөрийн улс эх орон, ард түмний уламжлал, ёс суртахууны үнэт зүйлүүд, агуу түүхээ сайн судалдаг, сайн мэддэг, улс орныхоо амжилт ололтууд, алдаа оноог ч бас мэддэг тэр бүхнийг зөв ухаалгаар үнэлж дүгнэж чаддаг байх, эх орноо чин сэтгэлээсээ хайрлан дээдлэх үзэл, хамгийн гол нь эх орондоо зүтгэх үүрэг хариуцлага юм. Энэхүү үүрэг хариуцлага нь хөдөлмөрөөр илэрнэ.

Орчин цагт эх оронч үзлийн тухайд “Шударга хөдөлмөрийн илэрхийлэл нь эх оронч сэтгэлгээ мөн” гэдгийг хүүхэд залуучуудад ойлгуулах эрэлт хэрэгцээ нэгэнтээ бий болжээ. Эх оронч үзлийн гол шалгуур нь энэ болох ёстой. Учир нь хүүхэд залуучууд өөрийн авьяас билгийг нээн илрүүлж, мэдлэг боловсролоо дээшлүүлэн хөгжүүлж, мэдээлэл технологийг чадварлаг ашиглан эх орондоо баялгийг буй болгон нийгмийн амьдралын сайн сайхан байдлыг бэхжүүлнэ. Энд эртний түүхт тусгаар тогтнолын голомтыг сахигч бид эх орноо хөгжүүлнэ, баяжуулна, хүчирхэгжүүлнэ гэсэн Монголын залуучуудын эрмэлзлэлийг хүн бүр биелүүлж чадваас эх оронч сэтгэлгээг төлөвшүүлж чадна⁴.

Дүгнэлт. Өнөө үед даяаршигчид ба эх орончдын хооронд тэмцэл явагдаж байна. Эх оронч үзлийг хэтрүүлэлгүйгээр тухайн хүний сэтгэлгээний дархлааг бий болгож өгөх нь чухал байна. Учир нь мэдлэгтэй хүний тархийг тийм ч амархан угаачихгүй билээ. Эх оронч үзлийн сэтгэлгээг бүрэн төлөвшүүлснээр үндэсний аюулгүй байдлын баталгаа хангагдах учиртай.

Хүүхэд залуучууд хичээл сургуульдаа шамдан суралцаж байж л эх орондоо бид юу хийж чадах вэ? гэсэн асуултад олон зүйлийг хэлж чадна.

Бид “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэдэг үгийг санаж эхлээд өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлж, ар гэр, амьдралаа сайхан авч явах хэрэгтэй.

Монголчууд цөөхөн учраас хөгжлийг

⁴ Г.Мягмаржав “Үндэсний бахархлын номтой болцгооё” өгүүлэл “Цэргийн шинэчлэл” сэтгүүл УБ 2005 он №1 (17).



бид өөрсдөө бүтээх ёстой. Дэлхийн улс орны хөгжлийг харахад үндэсний компаниуд нь улсынхаа хөгжлийн том хөшүүрэг нь болсон байдаг. Тэгэхээр хувийн хэвшлийн компаниудыг төрөөс дэмжин залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл залуучуудын хөдөлмөр

эрхлэлт, тэдгээрийн үнэлэмжийг сайжруулах, хөгжүүлэхэд төрийн бодлого чиглэгдэх учиртай. Яагаад гэвэл өнөөдөр залуучууд эх орондоо хөдөлмөрлөх хүсэл, сонирхол тун бага, гадагшаа чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн шилжилт хөдөлгөөн нэлээд байгаа нь алсдаа хор уршигтай.

Ашигласан материал:

1. М.Бат-Оюуны “Эх оронч үзэл, үндэсний аюулгүй байдлын баталгаа” сэдэвт эссэ, УБ 2023 он.
2. Б.Баатарсүрэн “Эх оронч үзлийг дээдлэх үзэл баримтлал ба ой тогтоолтыг судалсан үр дүн”
3. Н.Жалбажав., “Эх оронч үзэл: Төлөвшил, уламжлал, шинэчлэл”., УБ 2008 он Соёмбо хэвлэх үйлдвэр.
4. Г.Мягмаржав “Үндэсний бахархлын номтой болцгооё” өгүүлэл “Цэргийн шинэчлэл” сэтгүүл УБ 2005 он №1 (17).
5. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ 2010 он.
6. МУЗГ. “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”. 2019 оны 200 дугаар тогтоолын хавсралт
7. МУИХ. "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" УБ 2010 он., 48 дугаар тогтоол.
8. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр (advocate.mn)
9. Бат-Оюун-2.pdf (gia.gov.mn)



ШИФРЛЭЛТ БА ХАРИЛЦАА ХОЛБООНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Т.ЭНХЗАЯА /УБХИС, ЦНДС-ийн ЦХКАБТ-ийн багш, магистр, хошууч/
Г.НЯМХҮҮ /УБХИС, ЦНДС-ийн ЦХКАБТ-ийн багш, магистр, дэд хурандаа/

Түлхүүр үг: Тэгш хэмт, тэгш бус хэмт шифрлэлт, алгоритм, түлхүүр

Key words: Symmetrical, asymmetrical, encryption, algorithm, key

Оршил. Цэргийн радиостанцуудад тавих чухал шаардлагуудын нэг бол аюулгүй байдал, өөрөөр хэлбэл, радиоэлектрон тэмцэл (мэдээлэл дамжуулахад саад учруулах) болон радиоэлектрон тагнуулын (нууцаар чагнах, мэдээлэл тайлах) эсрэг ямар нэгэн хамгаалалттай байх явдал юм.

Орчин үед цэргийн байгууллагууд цэргийн радио холбооны аюулгүй байдлыг хангах зорилгоор нууц харилцааны хамгийн найдвартай төрөл болох радио холбоог өргөнөөр ашиглаж байна. Тус өгүүлэлд шиферлэлтийн онцлог, ялгаа, хөгжил, харилцаа холбооны аюулгүй байдалтай холбогдож байгаа байдлыг тодруулан гаргахыг зорилоо.

Шифрлэлтийг зохион бүтээх болон шифрлэсэн мэдээллийг тайлах шинжлэх ухааныг криптолог (crypto– нуух, нууцлах гэсэн утгатай грек үг) гэдэг.

Криптологийн хувьд шифрлэлт нь зөвхөн эрх бүхий талуудад хандах боломжтой мэдээ, мэдээллийг кодлох үйл явц юм.

Кодлол (Coding) гэдэг нь анхны мэдээний үг эсвэл өгүүлбэрүүдийг өөр тэмдэгт эсвэл тэмдэгтүүдийн олонлогоор орлуулан өөрчилж мэдээний утгыг нууцлах арга. Орлуулах жагсаалт нь кодын номд агуулагддаг.

Шифрлэлт (Encryption) гэдэг нь мэдээг үсэг үсгээр кодлох арга бөгөөд мэдээний үсэг, тэмдэгт бүрийг өөр үсэг, тэмдэгтээр өөрчилж мэдээний утгыг нууцлах систем юм. Шифрлэлтийг бүтээхийн тулд алгоритм болон мэдээллийг нууцлах тусгай түлхүүр хэрэгтэй байдаг.

Үндсэн хэсэг. Өнөө үед шифрлэлтийн хөгжлийн чиг хандлага бол шифрлэлтийн

түлхүүрүүдийг автоматаар үүсгэхэд чиглэгдсэн аппарат–программ хангамжийн системийг сайжруулах, шифрлэлтийн түлхүүрийн уртыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.

Шифрлэлтийн гол зорилго бол мэдээ, мэдээллийг халдлага болон хөндлөнгийн оролцооноос хамгаалах бөгөөд илгээгч тал мэдээг дамжуулахад түүнийг довтлогч тал хүлээн авсан боловч тайлж уншиж чадахгүй байхад оршино.

Мэдээллийн халдлага нь дараах төрлүүдтэй байдаг:


1. Мэдээллийн нууцлал алдагдах.

Шифрлэлтийн алгоритмыг ашигласнаар гуравдагч этгээд өгөгдлийг сонсох, тайлах боломжгүй болдог. Энэ нь цэргийн команд зэрэг нууц мэдээллийг шилжүүлэхэд онцгой ач холбогдолтой.

2. Мэдээллийн бүрэн бүтэн байдал алдагдах. Дамжуулах явцад мэдээллийг өөрчлөх боломжгүй байх ёстой. Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулах оролдлого хийгдсэн бол хүлээн авагч тал үүнийг илрүүлж, зохих арга хэмжээг авах боломжтой.

3. Баталгаажуулалт алдагдах. Радио дохионы шифрлэлт нь мэдээлэл илгээгч болон хүлээн авагч хэн болохыг найдвартай тогтоох боломжийг олгодог. Энэ нь мэдээлэл өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлнэ. /1 дүгээр зураг/.

Шифрлэлтийг бүтээхийн тулд алгоритм болон мэдээллийг нууцлах тусгай түлхүүрийг ашигладаг. Алгоритм нь анхдагч мэдээллийг шифрлэсэн текст болгон хувиргах арга юм. Түлхүүр нь илгээгч болон хүлээн авагч хоёулаа мэддэг, хоорондоо тохиролцсон математик



1 дүгээр зураг. Мэдээллийн халдлагын төрлүүд

утгуудын багц бөгөөд уг түлхүүргүйгээр нууц мэдээллийг задлах боломжгүй байдаг.

Орчин үеийн шифрүүдэд шифрлэлтийн алгоритм нь мэдэгдэж байгаа бөгөөд шифрийн криптографийн бат бөх байдал, өөрөөр хэлбэл, шифр тайлахыг эсэргүүцэх шинж чанар нь түлхүүрийн нууцлалаар бүрэн тодорхойлогддог.

Шифрлэлт анх 4000 гаруй жилийн өмнө Эртний Египетэд үүссэн гэж үздэг.

Ашиглаж буй шифрлэлтийн аргуудын технологийн шинж чанараас шалтгаалан криптологийн түүхийг 5 үе шат болгож хуваадаг

Эхний үе шат (ойролцоогоор МЭӨIII мянганы үеэс): цагаан толгойн үсгийг өөр үсэг, тэмдэгтээр солих арга давамгайлж байсан. Тухайлбал:

- Скитал (Scital). НТӨ V зуунд Спартаны жанжин Лисандр Афины эсрэг дайнд скитал хэмээх анхны криптографик төхөөрөмжийг хэрэглэсэн байна. Энэ нь модоор хийсэн цилиндр хэлбэрийн саваа юм. Текстийг энэ саваад ороосон туузан дээр наах бөгөөд илгээгч болон хүлээн авагч талууд яг ижил хэмжээний 2 цилиндртэй байх ёстой. Бүх үсгүүдийг зөв цуглуулснаар хэрэгцээт хэллэг эсвэл өгүүлбэр бий болно.
- Цезарийн шифр (Caesar cipher). Энэ шифрийн мөн чанар нь цагаан толгойн



үсгүүдийг баруун эсвэл зүүн тийш тодорхой тооны байрлалаар солих явдал юм. Доорх хүснэгт дээр цагаан толгойн үсгийг баруун тийш 3-үсгээр шилжүүлсэн түлхүүрийг харуулсан байна.

ТАБЛИЦА ДЛЯ СДВИГА, РАВНОГО Э

А	Б	В	Г	Д	Е	Ё	Ж	З	И	Й
Г	Д	Е	Ё	Ж	З	И	Й	К	Л	М
К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф
Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч
Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я
Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	А	Б	В

“Багш” гэдэг үгийг энэ аргаар шифрлэе: “дгёы”

Полибиусын квадрат (Polybius cipher эсвэл Polybius square). Цагаан толгойн үсгийг тоо болон тэмдэгтээр кодлох арга юм. Зохиогч нь НТӨ 200–118 онд амьдарч байсан грекийн жанжин, түүхч Полибиус юм.

	1	2	3	4	5	6
1	А	Б	В	Г	Д	Е
2	Ё	Ж	З	И	Й	К
3	Л	М	Н	О	П	Р
4	С	Т	У	Ф	Х	Ц
5	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь
6	Э	Ю	Я	.	,	?

“Багш” гэдэг үгийг энэ аргаар шифрлэе: 12 11 36 14 52

2 дахь үе шат (Ойрх Дорнодод IX зуун, Европт XV зуунаас XX зууны эхэн үе хүртэл):

олон үсэг бүхий шифрийг нэвтрүүлж эхэлсэн. Тухайлбал: Вижинерын шифр, Гронсфельдын шифр, Морзын код

Вижинерын шифр (Vigenere cipher). Түлхүүр үг ашиглан текстийг олон үсэгтээр шифрлэх арга. Хэрвээ Цезарийн шифрт +3-ийн шилжилтээр А нь Д болж, В нь Е болох мэтээр явагддаг бол Вижинерын шифрын гол зарчим үсэг бүрийг цагаан толгойн дарааллаар тогтмол биш, харин өөр өөр тоогоор шилжүүлдэг. Үсэг бүрийн шилжих утгыг түлхүүр буюу нууц үгээр тогтоодог. Шифрлэлтийн хувьд tabula recta эсвэл квадрат гэж нэрлэгддэг цагаан толгойн хүснэгтийг ашиглаж болдог.



Буквы исходного текста

	А	Б	В	Г	Д	Е	Ж	З	И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я
А	Б	В	Г	Д	Е	Ж	З	И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	А
Б	В	Г	Д	Е	Ж	З	И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Б	
В	Г	Д	Е	Ж	З	И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	В		
Г	Д	Е	Ж	З	И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Г			
Д	Е	Ж	З	И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Д				
Е	Ж	З	И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Е					
Ж	З	И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Ж						
З	И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	З							
И	Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	И								
Й	К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Й									
К	Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	К										
Л	М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Л											
М	Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	М												
Н	О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Н													
О	П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	О														
П	Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	П															
Р	С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Р																
С	Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	С																	
Т	У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Т																		
У	Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	У																			
Ф	Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Ф																				
Х	Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Х																					
Ц	Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Ц																						
Ч	Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Ч																							
Ш	Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Ш																								
Щ	Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Щ																									
Ъ	Ы	Ь	Э	Ю	Я	Ъ																										
Ы	Ь	Э	Ю	Я	Ы																											
Ь	Э	Ю	Я	Ь																												
Э	Ю	Я	Э																													
Ю	Я	Ю																														
Я	Я																															

Буквы ключа

“Корпус” гэдэг үгийг энэ аргаар шифрлэе. Түлхүүр үг нь “Зар”. Улаан өнгөөр шифрлэх үг, ногоон өнгөөр түлхүүр үгийн үсгүүдийн тэмдэглэсэн болно.

Корпус үгний эхний үсэг **К** болон түлхүүр үгний эхний үсэг **З** нь Т үсэг дээр огтлолцож байна. 2 дэх үсэг **О** болон түлхүүр үгний 2 дэх үсэг **А** нь П үсэг дээр огтлолцоно. Ингэснээр “Корпус” үгний шифрлэсэн хэлбэр: ТПБЧФВ болж байна.

К	О	Р	П	У	С
з	а	р	з	а	р
т	п	б	ч	ф	в

График кодлох арга (Морзын код, Morse code). Морзын код нь цагаан толгойн үсэг, тоо, болон тэмдэгтүүдийг цэг, зураас гэж нэрлэгддэг богино ба урт дохионы дараалал хэлбэрээр дүрсэлсэн тэмдгийн кодчиллын арга юм. Морзын кодыг 1838 онд америкийн зохион бүтээгчид болох Самуэль Морзе (Samuel Morse), Альфред Вайл (Alfred Vail), Жозеф Хенри (Joseph Henry) нар Морзын аппарат гэж нэрлэдэг телеграфын төхөөрөмжид зориулан бүтээжээ. 1848 онд Германы Фридрих Херке (Friedrich Gerke) энэ кодыг сайжруулсан

бөгөөд энэ сайжруулсан код нь өнөөг хүртэл ашиглагдаж байна.


А ●—	Ж ●—	С ●●●
В —●●●	К ●—	Т —
С —●—●	Л —●●●	У ●●—
Д —●●	М —	В ●●●—
Е ●	Н ●—	W ●—
Ф ●●—●	О —	Х —●—●
Г —●—	Р —●—●	Y —●—
Н ●●●●	Q —●—●	Z —●—●
И ●●	Р —●	

А —	Л —●●	Ц —●●●
Б —●●●	М —	Ч —●●●
В —	Н —	Ш —●●●
Г —	О —	Щ —●●●
Д —●●	П —●●	Ъ —●●●●
Е ●	Р —●	Ы —●●●
Ж ●●●	С ●●	Ь —●●●
З —●●●	Т —	Э ●●●●
И ●●	У ●●	Ю ●●●●
Й ●●●●	Ф ●●●●	Я ●●●●
К —●●	Х ●●●●	

3 дэх үе (XX зууны эхэн үеэс дунд үе хүртэл, 1901– 1950): криптологийн салбарт цахилгаан механик төхөөрөмжүүд нэвтэрч эхэлсэн. Тухайлбал: Герман улсад 1920 онд үйлдвэрлэсэн шифлэлтийн анхны машин “Энигма” (Enigma), мөн Герман улсад үйлдвэрлэсэн дэлхийн II дайны үед хэрэглэж байсан “Лоренц” (Lorenz),



Дэлхийн II болон Солонгосын дайны үеэр хэрэглэж байсан M-209 (АНУ), ЗХУ-д 1956 онд үйлдвэрлэсэн “Фиалка” M-125 гэх мэт.



Зураг 2. Enigma



Зураг 3. Lorenz-Chiffre



Зураг 4. M-2



Зураг 5. “Фиалка”

4 дэх үе (XX зууны дунд үеэс 1970–аад он хүртэл): математик криптолог руу шилжсэн үе. Америкийн инженер, криптоаналитик, математикч Клод Шеннон (Claude Elwood Shannon) 1949 онд хэвлэгдсэн “Communication Theory of Secrecy Systems” – “Нууц систем дэх холбооны онол” бүтээлдээ анх удаа криптографийн функцүүдийг математикийн шинжлэх ухаантай холбон харуулсан.


5 дэх үе (1970 оноос одоог хүртэл): шинэ чиглэл болох нээлттэй түлхүүрийн криптолог үүсч хөгжиж байна: тэгш бус хэмт криптосистемууд, электрон тоон гарын үсэг, квант криптограф.

Түлхүүрийн онцлогоос шалтгаалан шифрлэлт нь тэгш хэмт, тэгш бус хэмт гэсэн 2 үндсэн аргатай байдаг.

Тэгш хэмт аргын үед мэдээллийг шифрлэхэд ашигладаг түлхүүр нь шифр тайлах түлхүүртэй ижил байна. Жишээлбэл, Хурандаа Болд ахмад Туяад нууц мэдээлэл дамжуулах шаардлагатай болов. Үүний тулд тэр хоёр нууц үгийг тайлах түлхүүр ямар байх талаар урьдчилан тохиролцоно, тухайлбал, 1234567. Бат энэ түлхүүрийг (1234567) ашиглан мэдээллийг шифрлэнэ, Туяад ойлгомжгүй тэмдэгтүүд ирэх боловч

шифр тайлах 1234567 түлхүүрээ ашиглан мэдээллийг унших боломжтой болно.

Тэгш хэмт шифрлэлт



6 дугаар зураг. Тэгш хэмт шифрлэлт

Өнөө үед тэгш хэмтэй олон төрлийн алгоритмууд байна: AES, RC4, DES, 3DES, RC5, RC6 гэх мэт. Үүнээс хамгийн түгээмэл нь AES (Advanced Encryption Standard) бөгөөд олон программд ашиглаж байна:

- Радио холбоо: “Hytera”, “Motorola” серийн радиостанцууд, Argut A73 радиостанц;
- Процессорын хамгаалалт ба файлын шифрлэлт;
- SSL/TLS протокол (сайтын аюулгүй байдал);
- WiFi аюулгүй байдал;
- Гар утасны программуудыг шифрлэх;
- VPN (виртуал хувийн сүлжээ) гэх мэт

AES алгоритм нь орлуулах, солих аргуудыг ашигладаг. Эхлээд шифрлэгдээгүй өгөгдлийг блок болгон хувиргаж, дараа нь түлхүүрийг ашиглан шифрлэлтийг хийнэ. Шифрлэлтийн процесс нь мөр шилжүүлэх, багана холих, түлхүүр нэмэх зэрэг янз бүрийн үйлдлээс бүрддэг. Түлхүүрийн уртаас хамааран 10, 12 эсвэл 14 хувиргалтыг (тойрог) гүйцэтгэж болдог.


AES нь 128, 192 эсвэл 256 битийн урттай гурван өөр түлхүүр ашиглах боломжийг олгодог (түлхүүрийн уртаас хамааран шифрийн хувилбаруудыг AES-128, AES-192 эсвэл AES-256 гэж тэмдэглэдэг). Шифрлэлтийн тойрог нь түлхүүрийн хэмжээнээс хамаарна: урт 128 бит – 10 тойрог; урт 192 бит – 12 тойрог; урт 256 бит – 14 тойрог.

AES-256 битийн шифрлэлт нь хамгийн урт бөгөөд хамгийн найдвартай шифрлэлт гэж



үздэг, учир нь 256 битийн AES шифрлэлтийг тайлахын тулд хакерууд 2256 янз бүрийн хослолыг оролдох шаардлага гарна.

Тэгш бус хэмт шифрлэлт нь тэгш хэмт шифрлэлтээс ялгаатай нь мэдээллийг шифрлэдэг болон шифр тайлдаг түлхүүрүүд нь хоорондоо ялгаатай байдаг. Эдгээр түлхүүрүүдийн нэгийг "нийтийн түлхүүр", нөгөөг нь "хувийн түлхүүр" гэж нэрлэдэг. Жишээлбэл, өмнөх жишээнд дурдагдсан хурандаа Болд ахмад Туяагаас гадна өөр хэд хэдэн хүмүүстэй аюулгүй харьцах шаардлага гарсан. Харилцагч бүртэй өөр өөр түлхүүр ашиглаж холбогдох нь тохиромжгүй байсан. Энэ асуудлыг шийдэхийн тулд Бат шифрлэлтийг нийтийн түлхүүрээр хийнэ, өөрөөр хэлбэл, мэдээлэл илгээсэн хүн бүхэнд нийтийн түлхүүрийг өгдөг бөгөөд нууц түлхүүрийг өөртөө хадгалдаг. Тэрээр харилцагчдадаа нийтийн түлхүүрээр мэдээллийг шифрлэх зааварчилгаа өгнө. Гэхдээ мэдээллийг зөвхөн түүний хувийн түлхүүрээр тайлж болно.




7 дугаар зураг. Тэгш бус хэмт шифрлэлт

Өнөө үед тэгш бус хэмтэй хэд хэдэн төрлийн алгоритмууд байна: RSA, EEC, Diffie–Hellman, El Gamal, DSA гэх мэт. Үүнээс хамгийн түгээмэл нь RSA, EEC болно.

- RSA тэгш хэмт бус шифрлэлтийн алгоритмыг 1977 онд Массачусетскийн технологийн их сургуулийн эрдэмтэд болох Рон Ривест (Ron Rivest), Ади Шамир (Adi Shamir), Леонард Адлеман (Leonard

Adleman) нар бүтээсэн. "RSA" хэмээх нэршил нь эдгээр нэрсийн товчлолоос үүссэн байна. Энэ алгоритмын мөн чанар нь "анхдагч хүчин зүйлчлэл" аргад оршдог. Тодорхой хэмжээний 2 өөр тоог (жишээлбэл, тус бүр 1024 бит) санамсаргүй аргаар сонгож хооронд нь үржүүлж өөр аварга тоо үүсгэнэ. Үүссэн аварга тооноос анхны тоог тодорхойлох нь хүн битгий хэл өнөөгийн супер компьютерын хувьд бараг боломжгүй юм байна. Энэ алгоритмыг интернэт дэх харилцаа холбооны (web browsers, email, online-bank) аюулгүй байдлыг хангахад ихэвчлэн ашигладаг. Радиостанцуудаас Motorola DP 4801 ашиглаж байна.

- ECC (Elliptic Curve Cryptography) алгоритмыг анх 1985 онд америкийн математикчид Нейл Коблиц (Neal Koblitz), Виктор Миллер (Victor Miller) нар бүтээсэн бөгөөд шифрлэлтэд математикийн $y^2 = x^3 + ax + b$ тэгшитгэлд нийцэх эллипс муруйг ашиглахыг санал болгосон. Энэ алгоритмыг 2004–2005 оноос өргөнөөр ашиглаж эхэлсэн.



8 дугаар зураг. ECC алгоритмын эллипс муруй

Уг алгоритмыг ихэвчлэн Bitcoin, Ethereum зэрэг криптовалют дахь тоон гарын үсэг, мөн email, дата, программ хангамжийн нэг талыг шифрлэхэд ашигладаг.

Тэгш хэмт шифрлэлт

Давуу тал

- Зөвхөн нэг түлхүүр ашигладаг тул илүү хялбар;



- Илүү өндөр гүйцэтгэлийг хангаж, бага боловсруулалтын хүч шаарддаг;
- Их хэмжээний өгөгдлийг шифрлэхэд тохиромжтой.

Сул тал

- Түлхүүр дамжуулах асуудал, түлхүүрийг ойр ойрхон солих шаардлага;
- Цөөн тооны харилцагч;
- Өгөгдлийг шифрлэхийн тулд бага урттай түлхүүрийг ашигладаг (128–256 бит).

Тэгш бус хэмт шифрлэлт

Давуу тал

- 2 түлхүүр ашигладаг учраас аюулгүй байдлыг илүү сайн хангана;
- Найдвартай баталгаажуулалт, зөвхөн хувийн түлхүүрээр шифрийг тайлна;
- Өгөгдлийг шифрлэхийн тулд түлхүүрийн бага уртыг ашигладаг (1024–4096 бит);
- Тоон гарын үсэг гүйцэтгэх боломжтой.

Сул тал

- Нарийн төвөгтэй үйлдэл ихтэй учраас илүү их тооцоолох хүч шаарддаг;
- Бага хэмжээний өгөгдлийг шифрлэх үед ашигладаг.

Орчин үед цэргийн радио холбооны аюулгүй байдлыг өндөр түвшинд хангахын тулд шифрлэлтийг FHSS (англ. frequency-hopping spread spectrum, ППРЧ–орос. псевдослучайная перестройка рабочей частоты) буюу ажлын давтамжийн хуурамч санамсаргүй тохируулга горимтой хослуулан хэрэглэж байна.

FHSS–радиостанцаар мэдээлэл дамжуулах арга бөгөөд түүний онцлог нь дамжуулагчийн давтамжийг байнга өөрчлөхөд оршдог. Давтамж нь илгээгч болон хүлээн авагчийн аль алинд нь мэдэгдэж буй тоонуудын санамсаргүй дарааллын дагуу өөрчлөгддөг. FHSS нь мэдээлэл дамжуулалтыг халдлагаас (TRANSEC – TRANsmission SECurity) хамгаалдаг.

Шифрлэлт нь мэдээллийн аюулгүй байдал болон нууцлалыг (COMSEC – COMmunications SECurity) хамгаалдаг.

Цэргийн радио холбооны аюулгүй байдлыг хангадаг хамгаалалтын аргуудыг дараах байдлаар ангилж үздэг:

- Маш муу хамгаалалт:
 - ✓ Ирж буй дохиог давтамжаар нь ялгагдаг аналог дохионы CTCSS (Continuous tone control squelch system) болон DTCSS (Dual tone control squelch system) кодууд;
 - ✓ Скремблер–цацагдаж буй дуут дохиог кодлох, декодлох зориулалтаар ашиглагддаг тусгай төхөөрөмж.
- Сул хамгаалалт:
 - ✓ АМБЕ (Advanced MultiBand Excitation) ++ CODE2 зэрэг кодек ашигласан тоон кодчиллол;
 - ✓ Тоон стандарт протоколууд: DMR, APCO P25;
- Сайн хамгаалалт: Өргөн зурвасын FHSS;
- Маш сайн хамгаалалт: FHSS+ шифрлэлт 32 / 56 бит;
- Онц сайн хамгаалалт: FHSS+ шифрлэлт 72 / 128 бит;
- Хамгийн сайн хамгаалалт: FHSS+ шифрлэлт 128 / 256 бит

Цэргийн радио холбооны аюулгүй байдлыг хангахын тулд FHSS горим болон шифрлэлтийг хослуулан ашигладаг радиостанцуудаас дурдвал AN/PRC–152 (“Harris” компани, АНУ) “Азарт Р–187П1” (“Ангстрем нэгдэл”, ОХУ), Трансивер Codan 2110M (“Codan” компани, Австрали), MR–3000 (“Rohde & Schwarz” компани, Герман), RF–20 (“Dicom” компани, Чех) PRC–9651 (“Aselsan” компани, Турк улс), AN/PRC–148 JTRS (Joint Tactical Radio System) (“Thales” компани, Франц).

“Harris” компани нь өөрийн үйлдвэрлэсэн радиостанцуудад шифрлэлтийн “Citadel”, “Sierra” хэмээх бага оврын төхөөрөмжүүдийг суулгаж өгдөг. Эдгээр төхөөрөмжүүд бичил схем бүтэцтэй бөгөөд “Citadel” “Harris” компанийн уг төхөөрөмжид зориулж боловсруулсан МК–128 шифрлэлтийн алгоритмыг хэрэглэдэг бол “Sierra” Type–1,2,3, DES болон 3DES алгоритмуудыг хэрэглэж байна. 1997 онд



үйлдвэрлэгдсэн “Citadel I” төхөөрөмжийн түлхүүрийн урт 56–128 байсан бол 2004 онд үйлдвэрлэгдсэн “Citadel II” төхөөрөмжийн түлхүүрийн урт 256 бит байна.



9 дүгээр зураг.

“Citadel” төхөөрөмжийн бичил схем

Орчин үед хөгжилтэй орнуудын цэргийн холбооны аюулгүй байдлыг шинэчлэх арга замууд дараах зарчмууд дээр үндэслэгдэж байна:

- Шифрлэлтийн түлхүүрүүдийг автоматаар үүсгэхэд чиглэгдсэн аппарат–программ хангамжийн системийг сайжруулах, шифрлэлтийг программчлах шинэ алгоритмыг боловсруулах;
- Шифрлэлтийн түлхүүрийн уртыг нэмэгдүүлэх;
- Команд постуудын орон нутгийн радио сүлжээнд өгөгдөл солилцох нууцлалын технологийг хөгжүүлэх,
- Нэг төхөөрөмж ашиглан шифрлэлтийн

хурд болон нэгэн зэрэг үйлчлэх холбооны сувгийн тоог нэмэгдүүлэх;

- Шифрлэсэн мэдээллийг IP протоколоор дамжуулах боломжтой сүлжээний төхөөрөмжүүдийн цэргүүдэд нийлүүлэх тоо хэмжээг нэмэгдүүлэх.

Дүгнэлт: Цэргийн холбооны аюулгүй байдлыг өндөр түвшинд хангахын тулд шифрлэгдсэн харилцаа холбоог өргөнөөр хэрэглэдэг;

Шифрлэлт анх 4000 гаруй жилийн өмнө үүссэн бөгөөд жилээс жилд улам боловсронгуй болж шифрлэлтийн аргуудын технологийн шинжээс шалтгаалан хөгжлийн 5 үе шатад хуваагддаг;

Шифрлэлтийг бүтээхийн тулд алгоритм болон мэдээллийг нууцлах тусгай түлхүүрийг ашигладаг;

Түлхүүрийн онцлогоос шалтгаалан шифрлэлт нь тэгш хэмт, тэгш бус хэмт гэсэн 2 үндсэн аргатай;

Өнөө үед шифрлэлтийн хөгжлийн чиг хандлага бол аппарат– программ хангамжийн системийг сайжруулах, шифрлэлтийн түлхүүрийн уртыг нэмэгдүүлэх, шифрлэлтийг программчлах шинэ алгоритмыг боловсруулахад чиглэгдэж байна.

Орчин үед цэргийн радио холбооны аюулгүй байдлыг өндөр түвшинд хангахын тулд шифрлэлтийг FHSS горимтой хослуулан хэрэглэж байна.

Ашигласан материал:

1. Matt Blaze, Whitfield Diffie, Ronald L. Rivest, Bruce Schneier, Tsutomu Shimomura, Eric Thompson, and Michael Wiener, “Minimal Key Lengths for Symmetric Ciphers to Provide Adequate Commercial Security;
2. Mike Kurdziel PhD, Military Threat Model and Cryptographic Response MK-128;
3. Citadel is a military-grade cryptographic engine for non-type 1 applications. [https:// yandex. ru/search](https://yandex.ru/search)
4. Аппаратура шифрования - шифровальное оборудование вооружённых сил сша (2016) - техническое обеспечение - армия (сухопутные войска) - top secret. Toto-school.ru;
5. Про военную связь. <https://combat-radio.Ru>, 27-VIII,2022;
6. Защита ячеек шифром Виженера. <https://www.planetaexcel.ru/techniques/5/212/>
7. <https://ppt-online.org/166713>
8. <https://hostpro.ua/wiki/security/encryption-types-algorithms#>
9. https://wpristav.su/news/sovremennye_zarubezhnye_takticheskie_ustroistva_portativnye_radiostancii/2016-04-28-15233
10. Криптографын тухай. <https://dowell.mn>

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛД

С.БОЛОРЦЭЦЭГ /ҮБХИС-ийн Эрдмийн сургуулийн сургалт судалгаа
хөгжүүлэлтийн ахлах мэргэжилтэн доктор (Ph.D), дэд профессор/
Т.ОРГИЛХҮҮ /ҮБХИС-ийн докторант/

Түлхүүр үг: Эрчим хүчний аюулгүй байдал, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, эрдэст чулуужсан түлшний цахилгаан хангамж, нийлүүлэлтийн аюулгүй найдвартай байдал, технологи-эдийн засгийн шинжилгээ

Key words: Symmetrical, asymmetrical, encryption, algorithm, key Energy Security, renewable energy sources, fossil- fuelled electricity supply, sustainability and security of supply, techno-economic analysis.

Эрчим хүчний аюулгүй байдлын тухай ойлголт, мөн чанар. 1970–аад оны эрчим хүчний хямралын үед Дэлхийн Эрчим Хүчний Зөвлөлөөс анх удаа эрчим хүчний аюулгүй байдал (ЭХАБ)–ыг “Энерги тухайн өгөгдсөн эдийн засгийн нөхцөлд шаардагдах тийм тоохэмжээтэй, тийм чанартайгаар хангагдсан байх явдал юм” гэж томъёолсон.

Эрчим хүчний аюулгүй байдал бол олон талтай ойлголт юм.

Эрчим хүч гэдэг нь нэг талаас “байгалийн эрчим хүчний эх үүсвэрүүдийн үүсгэгчдээс энергийг гарган авч хэрэглэгч хүртэл дамжуулж, хувиргах процессын нийлмэл цогц”, өөрөөр хэлбэл энергийг (түлш эрчим хүчний эх үүсвэрийн олборлох, үйлдвэрлэх, хувиргах, тээвэрлэх, хадгалах ба ашиглах үйлдвэрүүд ба тоног төхөөрөмжүүдийн цогцоос бүрдсэн харилцан уялдаа холбоо бүхий цогцолбор” юм. Өргөн утгаараа бол “Эрчим хүчний аюулгүй байдал гэдэг нь улс, нийгэм, хувь хүний хамгийн чухал “эрчим хүчний ашиг сонирхол”–ыг гадна болон дотоодын аюулаас хамгаалсан байдал”–ыг ойлгоно.

Улс орны эрчим хүчний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн бөгөөд тасралтгүй өсөж байгаа эрчим хүчний хэрэгцээг хэвийн нөхцөлд эдийн засгийн үр ашигтай, чанартай энергиэр хангахад дотоодын болон гадаадын хүчин зүйлүүдийн таатай нөхцөл, мөн түлш эрчим хүчний тасралтгүй ба тогтвортой байдал алдагдахаас хамгаалагдсан

байх төлөв байдал юм.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр эрчим хүчний анхдагч нөөцийн хэрэглээний хувьд уламжлалт нөөцөөс уламжлалт бус нөөц рүү огцом хурдтай шилжилт явагдаж байна. Энэ нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн анхны хөрөнгө оруулалтын хэмжээ мэдэгдэхүйц буурч байгаа, мөн энэ төрлийн санхүүжилтийн механизм дэлхий нийтээр улам боловсронгуй хөнгөлөлтэй нөхцөлөөр хийгдэх болсонтой холбоотой юм.

Эрчим хүчний хэрэглээ нь хүн амын өсөлт, амьжиргааны түвшний өөрчлөлт, хот суурины өргөжин тэлэх процесс, хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн өсөлт зэргээс хамаарч байнга нэмэгдэж байдаг. Харин эрчим хүчний анхдагч нөөц хязгаарлагдмал, улс орон бүрийн хэрэглээ болон нөөцийн харьцаа харилцан адилгүй байдгаас хамаарч, эрчим хүчний нөөцийн хангамжийн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй байдал зэрэг нь тогтвортой хөгжлийн зорилтын тулгамдсан асуудал болсоор байна. Иймд тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, нөхөн сэргээгдэх нөөцийг түлхүү ашиглах, ингэснээр хүртээмжийг нэмэгдүүлэх нь улс орон бүрийн нийтлэг гол зорилт болж байна.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн ба эрчим хүчний аюулгүй байдалд тодорхой сөрөг нөлөөлөл бий болж байгаагаас эрчим хүчний аюулгүй байдлын асуудал улс орнуудын



үндэсний аюулгүй байдлын тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Үүнээс өмнө эрчим хүчийг техникийн систем гэдэг талаас нь авч үзэж, зөвхөн найдвартай ажиллагааны хувьд дүн шинжилгээ хийж байсан. Үүнтэй уялдан эрчим хүчний системийн тогтворжилт, тасралтгүй ажиллах чадвар, засвар үйлчилгээ, насжилт г.м үзүүлэлтийг тооцоолох аргуудыг боловсруулсан байдаг. Өөрөөр хэлбэл, энэ чиглэлд эрчим хүчний системийн найдвартай ажиллагааны онол хөгжиж иржээ. Эрчим хүчний системийн шинж чанаруудын салшгүй нэг хэсэг нь найдвартай ажиллагаа тул түүний ямар түвшинд байгаад дүн шинжилгээ хийж байх нь маш чухал юм.

Эрчим хүчийг эдийн засгаас ангид авч үзэж болохгүй тул эрчим хүчний аюулгүй байдлыг улс орны эдийн засгийн аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг гэж үзэх бөгөөд энэ нь эрчим хүчний аюулгүй байдлын төлөв байдлын дүн шинжилгээний ач холбогдлыг тодорхойлж байна.

Дэлхийн Эрчим Хүчний Зөвлөлөөс гаргасан суурь тодорхойлолтыг үндэс болгон өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан “эрчим хүчний аюулгүй байдал”-ыг дараах байдлаар тодорхойлов.

“ЭХАБ нь тасралтгүй өсч байгаа эрчим хүчний хэрэгцээг хэвийн нөхцөлд эдийн засгийн хямд төсөр, шаардлагатай чанартай, энергиэр хангахад дотоодын болон гадаадын хүчин зүйлүүдийн таатай нөхцөл, мөн түлш эрчим хүчний тасралтгүй ба тогтвортой байдал алдагдахаас хамгаалагдсан байх төлөв байдал” юм. Энэ хамгаалагдсан байх төлөв байдал нь хэвийн нөхцөлд үндэслэлтэй хэрэгцээг бүрэн хэмжээгээр хангах, онцгой нөхцөл байдалд зайлшгүй шаардлагатай хамгийн бага хэрэгцээг баталгаатай хангахад нийцэж байх ёстой.

Эрчим хүчний аюулгүй байдлын талаарх эрх зүйн зохицуулалт. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, тэр дундаа эрчим хүчний аюулгүй байдал хэрхэн хангагдаж

байгаа талаарх эрх зүйн баримт бичгүүдийг судлан үзвэл:

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал¹ . . . эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл” гээд эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтлахыг чухалчилсан байна.

Мөн эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлэх, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох, хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой, өндөр өртөг бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлэх, эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангах, газрын

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол



тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтиэр 6 сараас доошгүй хэмжээнд байлгах, цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлэх, цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож, бэхжүүлэх асуудлыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгайлан тусгасан байдаг.

Тэгвэл, Эрчим хүчний тухай² Монгол Улсын хууль нь эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдох харилцааг, Сэргээгдэх эрчим хүчний тухай³ Монгол Улсын хууль нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж эрчим хүч үйлдвэрлэх, нийлүүлэхтэй холбогдсон харилцааг тус тус зохицуулж байна.

“Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”⁴-д Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын тулд эрчим хүчний хангамжийг найдваржуулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах зорилгоор Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем байгуулах, эдийн засаг, нийгмийн хөгжилтэй уялдуулан, эрчим хүчний нөөцийг аль болох үр ашигтайгаар хэрэглэх бодлого тодорхойлогдож, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг гурван 10 жилээр төлөвлөн гаргасан.

Дээрх эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд үе үеийн Засгийн газрууд үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг 4 жил тутамд боловсруулан, эрчим хүчний хөгжлийн дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлдэг.

Одоогийн Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөртөө⁵ Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг 46 МВт-аар, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар тус тус өргөтгөх, Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлж, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх, Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа цахилгаан, дулааны хэрэглээ болон эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Улаанбаатар хотын Дулааны II цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станцын ажлыг төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар эхлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангах зэрэг эрчим хүчний аюулгүй байдлыг хангах талаар шийдвэрлэх ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Манай улсын эрчим хүчний хөгжлийн бодлогыг харахад зах зээлийн эдийн засагт шилжих процесс эрчим хүчний салбар, ялангуяа нүүрс үйлдвэрлэл ба цахилгаан эрчим хүчний салбарт хүндээр тусч байна. Учир нь тус салбарууд нь онцгой эрхт шинж чанартай, үнийн хувьд улсаас хатуу хяналттай, хөрөнгө оруулалт ихтэй, барьж байгуулах хугацаа урт тул хөрөнгө оруулагчийн сонирхлыг бага татаж байна. Энэ нь тэдгээрийн хөгжлийг сааруулж, үйлдвэрлэлийн үндсэн фондын насжилт их болсноор эрчим хүчний аюулгүй байдалд

² Эрчим хүчний тухай хууль, 2001

³ Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, 2007

⁴ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-Алсын хараа:2050. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын 2020 оны 24 дүгээр тогтоол.



бодит аюулыг бий болгож байна. Иймээс тус салбаруудад хөрөнгө оруулалтыг зохистойгоор нэмэгдүүлж, идэвхжүүлэх асуудал ихээхэн тулгамдаж байна.

Иймд бид үндэсний аюулгүй байдлыг эрчим хүчний салбарын аюулгүй байдлын чиглэлүүдтэй харилцан уялдаа холбоотой систем байдлаар авч үзэх шаардлагатай юм. Энэ систем дэх харилцан уялдаа холбоо бүр нь эрчим хүчний салбарын нөлөөлөл, түүний үйл ажиллагаа болон хөгжлийн үр ашигтай тэдгээрийн төлөв байдлын эсрэг нөлөөллийг тодорхойлж өгдөг.

Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдлын тухайд. Монгол орон эрчим хүчний анхдагч нөөцөөр Зүүн хойд Азидаа төдийгүй дэлхийд дээгүүрт орохоор нөөцтэй орон. Хүрэн болон чулуун нүүрсний геологийн нөөцөөр 170 гаруй тэрбум тонн, ураны хувьд батлагдсан нөөц 73000 тн, тооцоот нөөцөөр 1,5 сая тн байгаа нь дэлхийд эхний 16-р байр, газрын тос геологийн нөөцөөр 205 сая тонн, сэргээгдэх эрчим хүчний нөөцөөр 15000 ТБ.ц буюу Зүүн хойд Азийн эрчим хүчний 2030 оны хэрэглээг дангаар хангах нөөцтэй⁶ болохыг 2016 оны “Монгол улсын Сэргээгдэх эрчим хүчний бэлэн байдлын үнэлгээ”-ий тайланд дурдсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2023 оны эхний зургаан сарын байдлаар 11,059.3 тэрбум төгрөг, үүнээс уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 3,701.6 тэрбум төгрөг болжээ. Үүнээс харвал Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 25 гаруй хувь, экспортын орлогын 90 орчим хувь, төсвийн орлогын 33,5 хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байна. Уул уурхай, олборлох салбарын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого 2023 оны эхний зургаан сарын байдлаар нүүрс 2,044.1 тэрбум, зэс 1,172.3 тэрбум, алт 114.3 тэрбум төгрөг болжээ. Эдгээр экспортын ашигт малтмалуудаас нүүрсний экспорт 2022 онтой харьцуулахад 3,6 дахин, зэс 25 хувиар өссөн бөгөөд эдгээрийн олборлож буй

уурхайнуудын ихэнх нь ил уурхайнууд юм. Ил уурхайн олборлолтын зардлын 50 орчим хувь технологийн тээврийн зардал эзэлдэг бөгөөд уг зардал импортоос 100 хувь хамааралтай дизель түлшнээс бүрдэж байна.

Өнгөрсөн хугацаанд эрчим хүчний салбарт томоохон төслүүд хэрэгжээгүй үндсэн хэд хэдэн шалтгаан байна гэж үзэж байна. Үүнд: Эрчим хүчний салбар нь монопол шинж чанартай, үнийн хувьд улсаас хатуу хяналттай, бодит өртгөөс доогуур, хөрөнгө оруулалт ихтэй, барьж байгуулахад урт хугацаа шаарддаг, улс орны эдийн засгийн чадавх, хөрөнгө оруулалтын орчин нөхцөл сул, тогтвортой хөгжлийн урт хугацааны бодлого, салбар хоорондын бодлогын уялдаагүйгээс хөрөнгө оруулалтын эрэмбэ алдагдсан нь нөлөөлж байна. Энэ нь эрчим хүчний салбарын хөгжлийг сааруулж, үйлдвэрлэлийн үндсэн фондын насжилт их болсноор эрчим хүчний аюулгүй байдалд бодитоор сөргөөр нөлөөлж байна. Үүнд:

1. Монголын цахилгаан эрчим хүчний хөгжлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, түүний цаашдын чиг хандлагыг тодорхойлохдоо юуны өмнө улс орны хот суурин, хөдөө орон нутгийн цахилгаан хангамжийн тулгамдсан асуудлуудыг цогцолбор байдлаар авч үзэж, зах зээлийн үеийн өнөөгийн нөхцөл байдал, бусад салбаруудын хэтийн хөгжлийн чиг хандлагыг сайтар тооцох;

2. Бүс нутгийн эрчим хүчний нэгтгэлд идэвхтэй оролцож, том чадлын дамжуулах чадвар бүхий шугам сүлжээгээр хөрш орнуудтай холбогдох, эрчим хүчний экспорт, импортын зохистой харьцааг бий болгож, улмаар аюулгүй байдлын баталгаа бий болгох;

3. Сэргээгдэх эрчим хүчний нөөц ихтэй манай улсад Зүүн хойд Азийн бүс нутгийн (The Gobitec project and Asian Super Grid Asia for Renewable Energies in North East Asia) улс орнуудад цахилгаан экспортлох зорилготой Азийн Супер сүлжээнд нэгдэх, хамтран байгуулах

⁶ Олон Улсын Сэргээгдэх эрчим хүчний агентлагаас (IRENA) 2016 онд гаргасан “Монгол Улсын Сэргээгдэх эрчим хүчний бэлэн байдлын үнэлгээ”-ий тайлан



4. Монгол Улс нүүрс, нүүрсний давхаргын метан хий, нар, ус, салхины эрчим хүчний арвин их нөөцтэй нь тогтоогдоод байгаа үед аюулгүй байдлаа хангах үүднээс цахилгаан үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, дотоодын хэрэглээгээ бүрэн хангах, эрчим хүчний системийнхээ нөөцийг олон төрөлд шилжүүлэх, цаашлаад эрчим хүчийг орчин үеийн технологиор шинэчилж, автоматжуулсны үндсэн дээр бүс нутагтаа экспортлох ажлыг эхлүүлэх шаардлагатай байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Зүүн хойд Азийн улс орнууд эрчим хүчний салбарын хувьд бие биеэсээ харилцан хамааралтай ба энэ хамаарал

цаашид нэмэгдэх хандлагатай. Эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа нь бүс нутгийн энх тайван, уур амьсгалын зохистой менежмент, аюулгүй байдлыг хангах хүчин зүйлсийн нэг болох боломжтой.

Дэлхийн эрчим хүчний хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэж, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хатуу түлшний нөөц, хэрэглээ багасаж, цэвэр эрчим хүч, цөмийн эрчим хүчний үйлдвэрлэл, ногоон эдийн засгийг хөгжүүлэхийг зорьж байгаа өнөө үед Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдлын стратеги энэ чиглэлд хөгжих ёстой.

Ашигласан материал:

1. Energy Dictionary World Energy Council-Paris Jouve SI, 1992-635p
2. Лобов О.И. Энергитическая безопасность России во взаимосвязи с проблемами энергетической безопасности других стран СНГ // Энергетическая безопасность сотрудничества независимых государств. материалы международ. консультат.
3. Рыбкин И.П. Необходимый целостный взгляд на национальные интересы государства // независимая газета 1998-29 янв (№13) –с.8
4. Безопасность-глобальная проблема XX века. Материалы научной дискуссии (Ю.М.Батурин, А.М.Васильев, Е.П.Велихов, В.В.Журкин, Г.А.Арбатов) .-Вести.РАН, -1996, -Т, 66, №3, -С212 -215,
5. Д.Содномдорж “Монгол улсын эрчим хүчний аюулгүй байдлын үнэлгээ, түүнийг дээшлүүлэх арга замыг судлах” сэдэвт шинжлэх ухаан, технологийн төслийн тайлан, Улаанбаатар хот, 2012
6. Үндэсний Аюулгүй Байдлын Онолын үндэс, Ж.Бор, В.Чулуунбат, 2012 он
7. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010
8. International Energy Outlook, 2013. DOE/EIA-0484 (2013)
9. srep_ip_mongolia_final_14_dec_2015-latest.pdf (cif.org)
10. Глобальная энергетическая безопасность 2006, URL
11. Иргэншилд учирч буй 100 аюул занал. Д.Намсрай, Д. Цанжид 2018
12. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдал. 2022
13. Улс төрийн газар зүй. Окунев.И.Ю 2022
14. Energy Information & Administration Energy, International Energy Outlook, 2022

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДОД ТУЛГАРЧ БУЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛТ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Б.БОЛОР-ЭРДЭНЭ /УБХИС-ийн докторант, хурандаа/

Түлхүүр үг: Энхийг сахиулах ажиллагаа, цэргийн алба хаагч, цэргийн алба хаагчдын эрүүл мэнд, цэргийн алба хаагчдын өвчин, цэргийн алба хаагчдын эрүүл мэндэд учирч болох эрсдэлийн хүчин зүйлүүд

Key words: Peacekeeping operation, military member, military member's health, military member's illness, factors of the risks to military member's health

Оршил. XXI зуунд аюулгүй байдлын орчин нэлээд өөрчлөлтүүд гаргаж, уламжлалт аюулаас гадна хүний наймаа, мансууруулах бодис, зэвсгийн хууль бус худалдаа, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, олон улсын терроризм зэрэг уламжлалт бус аюул занал ч гарч, эдгээрээс ихээхэн хамааралтай болоод байна. Хэдийгээр дэлхийн улс орнуудаас энх тайвныг бэхжүүлэх талаар хүчин чармайлтыг гаргаж, аливаа маргаантай асуудлыг яриа хэлэлцээрийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэн тодорхой үр дүнд хүрч байгаа хэдий ч дэлхий дахин, бүс нутагт, улс, овог аймаг, шашин хоорондын мөргөлдөөн арилахгүй байна.

Ийм ээдрээтэй нөхцөл байдалд Монгол Улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүний хувьд олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг биелүүлж, бусад улс орнуудтай хамтран ажиллаж, НҮБ-ын энхийг дэмжих болон олон улсын цэргийн эвслийн ажиллагаанд 2002 оноос хойш үүрэг гүйцэтгэж байгаа нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг улс төр, дипломатын аргаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна.

2002 онд Монгол Улс цэргийн ажиглагч анхны хоёр офицероо Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад Энхийг дэмжих ажиллагаанд илгээснээс хойш 20 гаруй мянган цэргийн алба хаагчдаа даян дэлхийн энх тайван,

аюулгүй байдлын төлөө үйлсэд оролцуулснаар олон улсын тавцанд эх орныхоо нэрийг өндөрт өргөж, өдгөө монгол цэрэг Дэлхийн цэрэг болоод байна.

Онолын хэсэг. Энхийг дэмжих ажиллагааны хууль, эрх зүйн үндэслэл

НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн тогтоол, шийдвэрийн заалтуудыг биелүүлэхийн тулд энхийг сахиулах ажиллагааг цэргийнхний хувьд хяналт тогтоох, хүчирхийллийг намжаах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, улс төрийн хувь засаг захиргааны нэгжийг хууль ёсны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн хувьд хөгжил, дэвшлийн явцад дэмжлэг үзүүлэхэд оршиж байгаа нь орчин үеийн энхийг сахиулах ажиллагааны үндсэн агуулга, мөн чанарын илэрхийлэл болж байна (1 дүгээр зураг)¹.



1 дүгээр зураг. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийнхний гүйцэтгэх үүрэг оролцоо

Энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчнээ оролцуулах хүсэлтээ 1996 онд гаргаж, хууль эрх зүйн үндсээ бүрдүүлэх ажлыг эхлүүлж, 1998 онд Монгол Улсын Их Хурлаас “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт

¹ Гандорж Ц., Очхүү Э., Амарбаясгалан Ш., Нанжид Д., Баттүвшин Д., Давааням Л., Цогтгэрэл Н., Бадрал Г., Монгол цэрэг энхийн үйлсэд 2002–2022., I боть. –УБ., БХЯ., ЗХЖШ. 293 хуудас., т10;

бичгийг баталж хэрэгжүүлсэн эхэлсэн түүхтэй. 1999 онд Засгийн газраас тогтоол гаргаж, НҮБ-тай “Харилцан ойлголцлын санамж бичиг”- гарын үсэг зурснаар манай Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн үндэс суурь бүрдэж эхэлсэн. “Цэрэг, цагдаагийн алба хаагчдыг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай” хууль 2002 онд батлагдаж, 2010 онд “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчлэн баталснаар Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын хууль эрх зүйн байдлыг тодорхой болгож өгсөн.

Өдгөө “Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Монгол “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд зэрэг төрийн дунд, урт хугацааны бодлогын баримт бичигт Монгол Улсын Зэвсэгт хүчний НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх, бэлэн байдлын чадавхыг дээшлүүлэх зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлээд байна. Үүний нэг тод илрэл нь Зэвсэгт хүчний тайван цагийн үндсэн үүрэгт энхийг дэмжих ажиллагаанд оролцох гэж хуульчилсан өгсөн.

Судалгааны хэсэг.

Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн алба хаагчдад тулгарч буй эрүүл мэндийн эрсдэлт зарим хүчин зүйл. Монгол Улс нь Бүгд Найрамдах Сьерра Леон Улс, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Бүгд найрамдах Өмнөд Судан Улс, Бүгд найрамдах Ардчилсан Конго Улс, Бүгд найрамдах Ардчилсан Баруун Сахар Улс, Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улс, Эритрей Улс, Бүгд Найрамдах Гүрж Улс, Бүгд Найрамдах Косово Улс, Бүгд Найрамдах Йемен Улс зэрэг гурван тивийн 10 гаруй улсад цэргийн ажиглагчаас хүчний командлагчийн

орлогч, мотобуудлагын салаанаас батальон хүртэл хүчийг сурган бэлтгэж, энхийг сахиулах ажиллагаанд үе шат, бодлого зохион байгуулалттайгаар оролцож, өдгөө давхардсан тоогоор 20 гаруй мянган цэрэг, дайчдаа хүн төрөлхтний энх тайван, аюулгүй байдлын төлөө үйлсэд оролцуулаад байна².

Энхийг дэмжих ажиллагаанд оролцож буй Монгол Улсын цэргийн алба хаагчдад тулгарч буй эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлохын тулд эрсдэл, аюул, эмзэг байдал, өртөх байдал, чадавх, хүрээлэн буй орчин гэж юу вэ? Тэдгээрийн мөн чанарыг ойлгох нь чухал юм. Иймээс эдгээр ухагдахууныг товч авч үзвэл:

Эрсдэлийг тайлбарласан олон тодорхойлолтууд байдаг ба түүнээс өргөн утга бүхий тодорхойлолт нь зорилтыг тодорхой бус болгож буй амь нас эрсдэх, хөдөлмөрийн чадвар алдагдах зэрэг үр нөлөө өөрөөр хэлбэл аюул учрах магадлал түүнээс үүсэх сөрөг үр дагавар юм. Аюул гэдэг нь тухайлбал энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн алба хаагчд өвчлөх, гэмтэх зэргээр тэдний эрүүл мэндэд хохирол учруулах боломжтой хүчин зүйлс юм.

Эмзэг байдал гэж аюулд хүн ам (цэргийн алба хаагч), мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөгдөхийг хэлнэ өөрөөр хэлбэл урьдчилан төсөөлөх боломжгүй нөхцөл байдлын улмаас сөрөг нөлөөлөлд автах эрсдэлийг гэж ойлгож болно.


Хүрээлэн буй орчинд ус, агаар, хөрс, хүн ам гэсэн үндсэн бүрэлдэхүүн орно.

Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаал³ заасны дагуу энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн алба хаагчдад тулгарч болзошгүй эрсдэлийг үнэлж, харин Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/256 дугаар тушаалаар⁴ эрсдэл, гарах үр дагаврыг тодорхойлж байна (2 дугаар зураг).

² НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд жил бүр 900 орчим цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байна. (2022). Монголын үндэсний мэдээний агентлаг МОНЦАМЭ. <https://montsame.mn/mn/read/297918..>, 2022.05.29;

³ Монгол Улсын шатар сайдын тушаал. 2018. №125 т

⁴ Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын тушаал. А/566, 2019, Улаанбаатар хот



2 дугаар зураг. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн алба хаагчдад тулгарч болзошгүй эрсдэлийг үнэлэх, тодорхойлох арга зам

Цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн эрсдэл нь: Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн алба хаагчдад тулгарч болзошгүй эрүүл мэндийн эрсдэл нь амь нас, хөдөлмөрийн чадвар алдагдах явдал юм.


Цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн эрсдэлт хүргэж буй аюул нь өвчин эмгэг, гэмтэл, бэртэл болж байна. Эмзэг байдал нь урьдчилан төсөөлөх боломжгүй нөхцөл байдлын улмаас сөрөг нөлөөлөлд автах эрсдэл буюу цэргийн алба хаагчид болж байна.

НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх явцад цэргийн алба хаагчдын эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх магадлал өндөр байдаг. Энэ талаар товчхон судалгааг хийж үзэхэд. 1948 оноос хойш 2408 цэргийн алба хаагч, 332 энгийн ажилчид, 237 цагдаа, 232 штабын ажилтан, 87 цэргийн ажиглагч, бусад 24 нийт 3320 алба хаагч нас барсан судалгаа бий⁵. Энэхүү судалгаанаас харахад нас барсан хүмүүсийн дийлэнх хувийг цэргийн алба хаагчид эзэлж байна.

Эдгээр алба хаагчдын 37.5% нь осол

гэмтлийн шалтгаанаар, 31% нь өвчнөөр, үлдсэн хувь нь бусад шалтгаанаар амь эрсэдсэн байна. Мөн 2011 онд “Иракийн эрх чөлөө” ажиллагаанд АНУ-ын 4486 цах, 2016 онд Афганистанд 2386 цах амь үрэгдсэн байна⁶.

Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн байдал, өвчлөлд тухайн газар орны байгаль, цаг уурын онцлог, хуурайшилт, тоосжилт зэрэг нөлөөлж буй талаарх судалгааны үр дүнгүүдийг харьцуулж авч үзэхэд агаарын хэм буюу тогтмол өндөр хэмийн халуун, чийгшил нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болж байна.



3 дугаар зураг Агаарын температур, чийгшил

⁵ UN Department of Peacekeeping Operations, “Fatalities by Year”, as of January 31, 2015, available at www.un.org/en/peacekeeping/fatalities/documents/stats_1.pdf;

⁶ Defenseink Casualty Report Jump uj. Central New York /2012.07.20/. “Iraq/Afghanistan Military Casualty update”



Дээрх зургаас харахад, 11 сараас 2 дугаар сар хүртэл хугацаанд харьцангуй сэрүүсэж, 9 дүгээр сараас хойш агаарын чийгшил буурч байна.


Харин борооны улирал эхэлж, агаарын чийгшил нэмэгдэн, халууны хэм буурахын хэрээр цэргийн алба хаагчдын уушгины агаар солилцуулах хэвийн үйл ажиллагаа алдагдаж улмаар уушгины эмгэгүүд үүсэх, архаг өвчин сэдрэх нэг үндсэн шалтгаан болж байна.

Монгол Улсын хүн амын дунд зүрх судасны тогтолцооны өвчин, хавдар, амьсгалын замын эрхтэн системийн тогтолцооны эмгэгт өвчлөл дийлэнх хувийг эзэлдэг бол халуун оронд үүрэг

гүйцэтгэгч буй цэргийн алба хаагчдын өвчлөлд хийсэн судалгааны үр дүнгүүдийг харьцуулж үзэхэд хамгийн их хувийг мэс заслын эмгэг, арьс харшил, мэдрэл, хоол боловсруулах тогтолцооны эмгэгүүд эзэлж байна.

4 дүгээр зургаас харахад, цэргийн алба хаагчдын эрүүл мэндэд тулгарч буй эрсдэл тухайн орны байгаль, цаг уураас ихээхэн шалтгаалж байна. Өөрөөр хэлбэл нийт өвчлөлийн 20 хувийг мэс засал, 13.5 хувийг арьс харшлын эмгэг эзэлж байна.


2017 оноос хойших энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагчдын өвчлөлийн байдлыг авч үзэхэд хоол



4 дүгээр зураг. БНӨСУ-д үүрэг гүйцэтгэсэн Зэвсэгт хүчний 2017 оны ээлж, хувиар



5 дугаар зураг. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагчдын өвчлөлийн судалгаа, 2017–2022 он



6 дугаар зураг. Цэргийн алба хаагчдын өвчлөлийн насны байдал

боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл 24 хувь; арьс, арьсны дайврын өвчлөл 11 хувь, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл 11 хувь; харин шүд, нүд, гэмтэл, хордлого бага хувийг эзэлж байна (5 дугаар зураг).

Цэргийн алба хаагчдын өвчлөлийг насны байдалтай нь харьцуулж үзэхэд 20–30 насны залуучуудын өвчлөл өндөр байгаагаас дунд амьсгалын системийн тогтолцооны өвчлөл, лордийлэнх хувийг эзэлж байгаагаас дайчилгааны бэлтгэл нөөц болох цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн асуудлыг онцгойлон авч үзэхээ шаардлагатай гэж судлаачдын хувьд дүгнэж байна /6 дугаар зураг/.

Ажиллагааны газар оронд эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан цэргийн алба хаагчдын өвчлөлийн бүтцийн тоон үзүүлэлтийг халуун бүсийн цаг уур, улирлын байдалтай харьцуулан үзэхэд⁷:

Хуурай халууны улирал (11–1 сар)–д цэргийн алба хаагчдын 51 хувь илүү өвчлөмтгий байлаа.

Ажиллагааны эхний үед буюу борооны улирлын төгсгөл (8–10 сар)–д мэдрэл толгойн өвдөлт 17.0 хувь, чих хамар хоолойн эмгэг 15.3%–ийг эзэлж байсан.

Хуурай халууны улирал (11–1 сар)–д мэдрэл–толгойн өвдөлт (15.0 хувь, ХБЗ–н эмгэг

(14.8 хувь), амьсгалын эрхтний эмгэг (13.3 хувь), зүрх судасны эмгэг (12.3 хувь) зэрэг эмгэгүүд ерөнхийдөө их байсан.

Бие бүрэлдэхүүн давамгайлан ХБЗ–н эмгэг (22.9 хувь) болон мэдрэл–толгойн өвдөлт (14.0 хувь) зэрэг эмгэгээр өвчилсөн.

Дүгнэлт. Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”, мөн “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, –“Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа бөгөөд энэ хүрээнд олон тулгуурт энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг тууштай баримталж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно” гэж заасан нь манай улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн үндсэн суурь болж байна.

Дэлхийн энх амгалан байдлын төлөө зүтгэх

⁷ Самбуужанцан П., Алтайсайхан Х., Гандорж Ц., Батболд С., Оюунцэцэг Ч., Болор–Эрдэнэ Б. нар., “НҮБ–ын энхийг дэмжих болон олон улсын ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн цогц үнэлгээ” шинжлэх ухаан, технологийн төслийн тайлан. 2019–2021 он., –УБ., ШУТС



ариун үйл хэргийн эхлэлийн 2003 оноос өнөөг хүртэл 20 гаруй жилийн хугацаанд “Иракийн Эрх Чөлөө” ажиллагаа, Сьерра Леон улс дахь “UNMIL” ажиллагаа, Чад болон Төв Африкийн БНУ дахь “MINURCAT” ажиллагаа, Судан улсын Дарфур муж дахь “UNAMID” ажиллагаа, Өмнөд Судан улс дахь “UNMISS” ажиллагаа, Бүгд Найрамдах Конго улс дахь энхийг дэмжих ажиллагаа, Судан улс дахь “UNMISS” ажиллагаа, Этиоп, Эритрей улс дахь энхийг дэмжих ажиллагаа, Гүрж улс дахь энхийг дэмжих ажиллагаа, Абей муж дахь “UNISFA” ажиллагаа, АНУ болон НАТО-ийн тэргүүлсэн Исламын Бүгд Найрамдах Афганистан улс дахь “ISAF” ажиллагаа, НАТО-ийн тэгүүлсэн “KFOR” ажиллагаа зэрэг дэлхийн 10 гаруй улс оронд

20,000 гаруй “Цэнхэр дуулгатан” цэргийн алба хаагчаа оролцуулаад байна. Энэхүү статистик үзүүлэлтээр Монгол Улс нь НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд илгээсэн цэргийн алба хаагчдынхаа тоогоор эхний 24 байранд багтдаг орны нэг болсон.

Тухайн орны байгаль, цаг уурын онцлог, агаарын хэм, чийгшилтээс шалтгаалан энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагчид нэлээд өвдөмтгий байгааг нь судалгаанаас харагдаж байна.

Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагчид мэдрэл-толгой өвдөлт, амьсгалын замын эмгэг, хоол боловсруулах тогтолцооны зэрэг эмгэг нэлээд гарч байна.

Ашигласан материал:

1. Гандорж, Ц., Очхүү, Э., Амарбаясгалан, Ш., Нанжид, Д., Баттүвшин, Д., Давааням, Л., Цогтгэрэл, Н., Бадрал, Г. (2022). Монгол цэрэг энхийн үйлсэд 2002-2022., I боть. -УБ., БХЯ., ЗХЖШ. 293 хуудас., т10;
2. НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд жил бүр 900 орчим цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байна. (2022). Монголын үндэсний мэдээний агентлаг МОНЦАМЭ. [https://montsame.mn/mn/read/297918.](https://montsame.mn/mn/read/297918), 2022.05.29;
3. Монгол Улсын шатар сайдын тушаал. 2018. °125 т
4. Монгол улсын Эрүүл мэндийн сайдын тушаал. А/566, 2019, УБ
5. UN Department of Peacekeeping Operations, “Fatalities by Year”, as of January 31, 2015, available at www.un.org/en/peacekeeping/fatalities/documents/stats_1.pdf;
6. Defense link Casualty Report Jump uj. Central New York /2012.07.20/. “Iraq/Afghanistan Military Casualty update”
7. Самбуужанцан, П., Алтайсайхан, Х., Гандорж, Ц., Батболд, С., Оюунцэцэг, Ч., Болор-Эрдэнэ, Б. нар. (2023). “НҮБ-ын энхийг дэмжих болон олон улсын ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн цогц үнэлгээ” шинжлэх ухаан, технологийн төслийн тайлан. 2019-2021 он., -УБ., ШУТС



МОНГОЛ СОЁЛ ИРГЭНШЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УЛАМЖЛАЛ, ӨВ СОЁЛЫН ТӨЛӨВШЛИЙН ХӨТӨЛБӨРӨӨР ДАМЖУУЛАН ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ТӨЛӨВШЛИЙГ ДЭМЖИХ БОЛОМЖ

Б.БЯМБАСАЙХАН /УБХИС-ийн докторант/

Түлхүүр үг: Соёл иргэншил, эх оронч үзэл, үндэсний уламжлал, өв соёл, өсвөр үеийнхний төлөвшил

Key words: Civilization, patriotism, national traditions, heritage, youth development

Оршил. Өсвөр үеийнхэнд эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх нь өвөг дээдэс ахмад настнаа хүндэлдэг, хүнлэг энэрэнгүй зан чанарыг олгох, Монгол өв соёлоо таниулж зааж, сургаж, ойлгуулах, эерэг хандлага төлөвшүүлэхээс эхэлнэ. Тиймээс ёс заншил, түүх, уламжлал, өв соёлыг орчин үеийн чиг хандлагатай хослуулан илэрхийлсэн, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэтэй, ач холбогдолтой, эх оронч үзэл, бахархлыг төлөвшүүлэх, танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх, боловсрол олгох, сурган хүмүүжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, үйлчилгээг сургууль, гэр бүл, олон нийт, нийгмийн орчинд зохион байгуулдаг байх шаардлагатай байна.

Өнөө үед өвөг дээдсийн бүтээсэн түүх, соёлын өвийг эрхэмлэн, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, бидэнд түүнээс чухал хэрэгтэйг нь сонгон авч, өдөр тутмын амьдрал ахуйдаа хэрэглэн хэвшүүлэх, өсвөр үеийнхэнд өвлүүлэн уламжлуулах хэрэгцээ шаардлага урьд урьдаас илүү чухал болж байна.

Үндсэн хэсэг. Монголчуудын уламжлалын үүргийн нийтлэг талыг үндсэн шинж, үүрэгт нь тулгуурлан тодорхойлбол:

Нэгдүгээрт, уламжлал нь хүмүүсийн тодорхой үеүүдийн залгамж холбоог хангахад идэвхтэй тусалдаг. Ахмад үеийнхэн эх орон, улс нийгмээ хөгжүүлж, үр хүүхэд, өсвөр үеэ бойжуулах, аж төрж амьдрах ухаан, ажилч чанар, уламжлалт ёс заншлаа хүүхэд, залуучуудад өвлүүлэх үүрэг хүлээдэг. Хүүхэд, залуучууд эцэг, өвгөдийнхөө бүтээж буй

болгосон сайн бүхнийг залгамжлан бүтээлч үйлсээрээ баяжуулж, улс орноо хөгжүүлж, ах захаа хүндэтгэн, үр хүүхдээ хүмүүжүүлж одоо, ирээдүйн өмнө давхар үүрэг хүлээдэг. Ахмад, залуу үеийн холбоо нь тэд харилцан бие биедээ итгэж хүндэтгэх, харилцан ойлгож, хайр халамж, амжилт бэрхшээлээ чин сэтгэлээсээ хуваалцаж байгаагаар тодорхойлогддог.

Хоёрдугаарт, мэдээллийн үүрэгтэй. Уламжлал энэ үүргээ биелүүлэхдээ аман яриа, гар бичмэл, хэвлэмэл зүйлс, олон нийтийн мэдээлэл зэрэг хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлдэг. Монголчууд хүн хүндээ, байгаль дэлхийдээ хүнлэг энэрэнгүй хандах, эх орноо хайрлан эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалах, ажил хөдөлмөр, эрдэм номыг эрхэмлэх тухай үлгэр домог, ерөөл, магтаал, баатарлаг туульс, зүйр цэцэн үг, сургаал, оньсого, таавар, ардын дуу зэрэгт илэрхийлж уламжлан дамжуулж ирсэн түүхтэй.

Гуравдугаарт, хуримтлуулах, хадгалах үүрэгтэй. Хүмүүс тухайн үеийнхээ зөвхөн өмнөх үеийнхний туршлагыг аваад зогсохгүй түүнээс өмнөх бүх үеийнхний туршлагад суралцаар байдаг.

Дөрөвдүгээрт, уламжлал, зан заншлын олон нийтийг хамарсан, тогтвортой дахин давтагдах шинж нь нийгмийн харилцааг бэхжүүлэхэд нөлөөлдөг.

Тавдугаарт, олон нийт, нийгмийн төлөвшилд голлох үүрэг гүйцэтгэдэг.

Зургаадугаарт, хүмүүс (гэр бүл, олон нийт, нийгмийн) хоорондын харилцаанд хэмжүүрийн үүрэг гүйцэтгэдэг. Өрх гэрийн дотор тогтсон



уламжлал нь нийгэм хамт олонд нөлөөлж, нийгмийн гишүүдийг хүмүүжүүлэх төлөвшүүлэх аятай нөхцөл болсоор иржээ.

Монгол уламжлал, өв соёлын хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан өсвөр үеийнхний хөгжил төлөвшлийг дэмжихдээ дараах зүйлийг анхаарах шаардлагатай.

Нийгмийн өргөн хүрээтэй өөрчлөлт нь Монгол хүн бүрээс сэтгэлгээний бүтээлч шинэчлэлийг зүй ёсоор шаардах болсон энэ цаг үед шинжлэх ухаан, технологи, эдийн засаг эрчимтэй хөгжиж байгаа ч хүмүүсийн сэтгэлгээ, харилцааны хөгжлийг дээрх өөрчлөлт орлохгүй тул Монгол хүний онцлог, уламжлал өв соёлоо мэддэг, учир холбогдлыг ойлгодог өөрийнхөө давуу талд тулгуурлан хөгжих ёстой. Үүний үндэс тулгуур нь өвөг дээдсийн үүсгэж, өвлүүлэн уламжлуулсаар ирсэн уламжлал, ёс заншил зайлшгүй мөн. Энэ бүхнийг өсвөр үеийнхэнд хүргэж чадсанаар Монгол үндэстний дархлааг бий болгох, төлөвшүүлэх боломжтой.

Соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах, өсвөр үеийнхний төлөвшилд нөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг үзвэл энэ нь нэг салбарын буюу тэр дундаа хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудал хариуцсан газрын харьяа Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яамны хүрээнд хамаарч байна. Хүүхдийн хөгжил төлөвшлийн асуудлыг дээрх яамдын үйл ажиллагааны хүрээнд авч үзэх нь хязгаарлагдмал болох бөгөөд бүх байгууллага, иргэний нийгэмд харьяалуулах нь зүйтэй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны тушаалаар хүүхдийн хөгжлийг дэмжих хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн ба тухайн хөтөлбөрийн агуулгад эх дэлхий, эх орноо хайрлах, үндэсний үзэлтэй эх оронч өсвөр үеийг бэлтгэх, уламжлалт соёл, эх түүхээ мэддэг байхад нөлөөлөх зорилтуудыг багтаасан

байна.

Монгол уламжлал, өв соёлын хөтөлбөрөөр дамжуулан өсвөр үеийнхний төлөвшлийг дэмжихэд:

Нэгд, *Сургуулийн орчинд хичээлээс гадуурх үйл ажиллагаанд соёл иргэншлийн аюулгүй байдлын агуулгыг тусгаж хүүхдийн төлөвшлийг дэмжих.*

Өсвөр үеийнхэнд чиглэсэн тэдний төлөвшлийг дэмжих үйл ажиллагааны нэлээд хэсэг нь сургуулиас зохион байгуулдаг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамаарах бөгөөд сургууль дээрх хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь агуулгын хувьд дараах хүрээг хамарсан байна.

- Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих;
- Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах;
- Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх;
- Бие бялдар, авьяас чадварыг хөгжүүлэх;
- Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих;
- Нийгэм, олон нийтийн хамтын ажиллагааг дэмжих;
- Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих;
- Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх.

Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь хэлбэрийн хувьд дугуйлан, секц ба клуб гэсэн үндсэн хоёр хэлбэрээр хамгийн түгээмэл зохион байгуулагдаж буй бөгөөд эдгээрээс гадна сургууль, хот, улсын чанартай тэмцээн уралдаан, өдөрлөг, аян зэрэг хэлбэрээр зохион байгуулагддаг уламжлалд тулгуурлах нь зүйтэй.

Хоёрт, *Хүүхдийн зуслан¹, өдөр өнжүүлэх төв, өдрийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаагаар дамжуулан соёл иргэншлийн*

¹ Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг үндэслэн ХНХ-ын Сайдын 2019 оны 4 сарын 15-ны А/150 тушаалаар Хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөр болон хөгжлийн хөтөлбөр боловсруулах удирдамжийг батлан ГБХЗХГ, Нийслэлийн ГБХЗХГ-ын дарга нарт хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг арга зүйгээр хангаж ажиллахыг үүрэг болгосон байна.

аюулгүй байдлын агуулгад суурилан өсвөр үеийнхний төлөвшлийг дэмжих. Тухайлбал:

- эх орныхоо түүх соёл, үндэсний уламжлалаа мэдэх, хүндэтгэлтэй хандах;
- өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх, бусдын ялгаатай байдалд нь хүндэтгэлтэй чин сэтгэлээсээ хандаж, үе тэнгийнхний дээрлэхэлтээс урьдчилан сэргийлэх, бусдыг мэдэрч ойлгох чадвартай;
- байгаль, эх дэлхийгээ хайрлах сэтгэлтэй, байгаль цаг уурын өөрчлөлт түүний учир шалтгаан зүй тогтлын талаар мэдлэгтэй;
- эрүүл аж төрөх ёс мэддэг, эх орон гэр бүлээ хүндэтгэдэг, тууштай ханддаг; бусадтай хамтран ажиллах, өөрийн тасралтгүй хөгжилд анхаарч, аливааг тунгаан бодох шийдвэр гаргах чадвартай болгоход чиглэсэн өсвөр үеийнхний төлөвшлийг дэмжсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломжтой.

Энэхүү төлөвшлийг дэмжих хөтөлбөрүүд нь мэдлэгт суурилсан гэхээсээ илүүтэй нийгмийн ур чадваруудыг олгохыг зорьсон байна.

Гуравт, Хүүхдийн номын сан, үзвэр үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаатай соёл иргэншлийн аюулгүй байдлын үйл ажиллагааг уялдуулан өсвөр үеийнхний хөгжил төлөвшлийг дэмжих.

Хүүхдийн номын сан нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ном, мэдээллийн үйлчилгээг үзүүлнэ гэж Номын сангийн тухай хуулийн 10.5-д заасны дагуу өсвөр үеийнхний насны онцлогт тохирсон монгол соёл иргэншлийн номоор номын санг зузаатгах хэрэгтэй. Ингэснээр номын сангийн уншигчдад үзүүлэх үйлчилгээний хүрээнд соёл иргэншлийн мэдлэг олгох боломж бүрдэнэ. Мөн тодорхой хугацаанд (3–7 хоног, 14 хоног, 1–3 сар, 6–12 сар гэх мэт) хүүхдийн чадварыг хөгжүүлэх зорилготой, тухайлбал хүүхдийн оюун ухаан, сэтгэлгээг хөгжүүлэх, эрүүл мэнд, зөв хооллолт болон эрүүл чийрэг бие бялдартай болгох, мэдрэмж, мэдрэхүйг хөгжүүлэх, урлан

бүтээх, суралцах үйл ажиллагааг хөгжүүлж бүтээлч чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг сургалтын төв, курс, дамжаа хэрэгжүүлж байна. Эдгээр төвүүд хүүхдийн оюун ухаан, танин мэдэхүйн чадвар, чадамжийг хөгжүүлэхээс гадна хувь хүний суурь ур чадварууд болох өөрийн давуу тал, онцлогийг мэдрэх, багаар ажиллах, найз нөхдөөсөө суралцах, сурсан, мэдсэнээ бусдад зааж өгөх боломж нөхцөлийг хангаж, хүүхэд хүүхдийнхээ дунд суралцах онцлогийг харгалзан, тоглоом наадмаар нь дамжуулан хүүхдийн төлөвшлийг дэмжсэн олон талт арга хэмжээг зохион байгуулна.

Музей нь хүүхдэд тухайн ард түмний болон хүн төрөлхтний түүхэн өв, соёл уламжлалын талаар мэдлэг олгох, зөв төлөвшил, хандлага төлөвшихөд чухал үүрэгтэй байгууллага юм. Манай улсад 36 музей байгаагаас төрийн өмчийн 12, орон нутгийн өмчийн 24 музей байдаг байна². Музейгээс гадна орон нутгийг сурталчлах 56 танхим, хувийн өмчийн музей болон галерейн чиг үүрэг бүхий 20 гаруй байгууллага, 10 гаруй бэсрэг музей байдаг байна. Музейн тухай хуульд зааснаар 16 хүртэлх насны хүүхэд музейн үзмэрийн танхимаар үнэ төлбөргүй үйлчлүүлэхээр тусгасан байдаг³. Музей нь 12 төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр зааснаас хүүхдийн хөгжил төлөвшилтэй холбоотой үйл ажиллагаа нь а) боловсрол танин мэдэхүйн ажил зохион байгуулах, б) сургалт зохион байгуулах, в) өгүүллэг дэглэх, үйлчлэх зэрэг юм.

Дөрөвт, Хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарын үйл ажиллагаатай соёл иргэншлийн аюулгүй байдлын үйл ажиллагааг уялдуулах замаар өсвөр үеийнхний хөгжил төлөвшлийг дэмжих.

Олон нийтийн радио телевиз хөтөлбөрөө бэлдэж түгээхдээ баримтлах бодлогод “хувь хүний болон нийгмийн төлөвшлийг дэмжих, ялангуяа хүүхэд залуучуудын оюуны болон бие бялдрын хөгжилд онцгой анхаарах”

² https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSQ_2002_004V1

³ Музейн тухай хуулийн 9.1 дэх заалт



тухай⁴ туссан байна. Улмаар олон нийтийн радио телевизийн хөтөлбөрт тавих тусгай шаардлагад хуулиар хориглоогүй боловч хүүхэд, залуучуудын бие махбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлж болохуйц агуулга бүхий нэвтрүүлэг, баримтат болон уран сайхны киноны дамжуулах цагийг зохицуулах гэж заасан байна.

Хүүхдийн нэвтрүүлэг нь боловсрол танин мэдэхүй, үндэсний онцлог хэв шинж, нийгэмшил, хүмүүжил төлөвшлийн үүрэг гүйцэтгэх ёстой. Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь нэвтрүүлгийн агуулгад насны ангилал тогтоож, түүнийг таних тэмдэг тэмдэглэгээг стандартад⁵ заасны дагуу зурагтын дэлгэц дээр үзүүлэх үүрэгтэй. Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн бэлтгэн дамжуулж байгаа соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх, хүүхэд боловсролын нэвтрүүлэг нь нэг сарын хөтөлбөрийн нийт цагийн 15 хувиас багагүй байна гэж холбогдох эрх зүйн зохицуулалтад⁶ тусгажээ.

Өсвөр үеийнхний хөгжил төлөвшлийг дэмжих зорилготой соёл иргэншлийн аюулгүй байдлын агуулгыг тусгасан Монгол уламжлал, өв соёлын хөгжлийн хөтөлбөр нь тэдний бие махбодын хөгжлийг дэмжих танин мэдэх, нийгэмшихүйн чадвар олгох, хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн байна.

Хөтөлбөрийн зорилго, зорилт: Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг хангах арга зам болон бусад хууль, журамтай нийцсэн байна. Мөн бүтээлч болон шинэлэг сэтгэлгээ, хүмүүс хоорондын харилцаа, хувь хүний чадвар, дэлхийн иргэн, мэдээллийн технологийн хэрэглээ гэсэн 5 хүрээнд харгалзах чадваруудыг эзэмших, хандлага төлөвшүүлэх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Эх орныхоо түүх соёл, үндэсний уламжлалаа мэдэх, хүндэтгэлтэй хандах;

- Байгаль, эх дэлхийгээ хайрлах сэтгэлтэй, байгаль цаг уурын өөрчлөлт түүний учир шалтгаан зүй тогтлын талаар мэдлэгтэй;
- Эх оронч, үндэсний үзэлтэй, хувь хүний үнэт зүйлс төлөвшсөн, нийгмийн үнэт зүйлсийг ойлгодог, баримжаалдаг, хүндэтгэдэг байна;
- Монгол ахуй, уламжлал соёл, зан заншлын талаар мэдлэгтэй, амьдралд хэрэглэх чадвартай
- Ёс заншил, түүх, уламжлал, өв соёлыг орчин үеийн чиг хандлагатай хослуулан илэрхийлэх, тайлбарлах, хэрэглэх мэдлэг, чадвар, хандлагатай өсвөр үеийнхэнд олгох мэдлэг–мэдээлэл, чадварыг үр дүн талаас нь тодорхойлсон байна.

Хөтөлбөрийн агуулга: Энэхүү хөтөлбөрийн агуулгыг өсвөр үеийнхний давуу чанарт суурилан боловсруулах ба эх дэлхий, эх орон, эцэг эхээ хайрлах үнэт зүйлтэй, уламжлал соёл, ёс заншлаа мэддэг, асуудлыг эерэг аргаар шийдвэрлэн шийдвэр гаргах болон багаар ажиллах болон бусдад чин сэтгэлээсээ хандах чадвартай, эх оронч өсвөр үеийнхнийг төлөвшүүлэх хүрээнд тодорхойлно. Хүрэх үр дүнг өсвөр үеийнхэнд төлөвшүүлэх боломжтой байна.

Хөтөлбөрийн зохион байгуулалт, арга зүй: хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй нь хөтөлбөрийн зорилго, зорилттой нийцсэн байна. Өсвөр үеийнхэнд олгох мэдлэг–мэдээлэл, ур чадварыг оролцооны болон хөгжлийн давуу чанарт тулгуурласан зарчмаар хүргэх боломжтой байна. Өсвөр үеийнхний хувь хүний болон нийгэмшихүйн чадвар, чадамжуудыг дэмжин, хандлага төлөвшүүлэхдээ өсвөр үеийнхний иргэний оролцооны зарчимд тулгуурлан мэдлэг–мэдээлэл олгох хэлбэрээр зохион байгуулна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ байгууллагууд өөрийн үйл ажиллагааны болон өсвөр үеийнхний насны онцлог, нөөц боломжийг харгалзаж, тодорхой хугацаанд (1 өдөр, 7

⁴ Олон нийтийн радио, телевизийн тухай хууль

⁵ Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэглэгээг ашиглах шаардлага MNS 3587:2016

⁶ Мөн тэнд



хоног, 1 сар, 3 сар, 1 жил) хэрэгжүүлж болно. Мөн хөтөлбөрт дурдагдсан үйл ажиллагааны зорилгыг өөрчлөхгүйгээр нэмэлт хувилбар, үйл ажиллагааг шинээр боловсруулан давхар ашиглаж болно.

Хөтөлбөр нь өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээнд нийцэхүйц, бодит, шинжлэх ухаанч, энгийн байхын зэрэгцээ өсвөр үеийнхний иргэний оролцоог хангасан хэлбэрээр мэдлэг, дадал, чадвар, итгэл үнэмшил, сэдэл тэмүүлэл төрүүлэхэд чиглэгдсэн бүтээлч, зорилго чиглэл бүхий үйл ажиллагаа байна.

Хөтөлбөрийг өсвөр үеийнхний насны бүлгээр (10–12, 13–15, 16–18) тэдний хэрэгцээ, сэтгэхүйн онцлогт тохируулан хөгжилтэй, сонирхолтой хэлбэрээр тэдний оролцоонд тулгуурласан идэвхтэй арга зүйг ашиглан зохион байгуулна.

Байгууллагууд (өсвөр үеийнхний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг нийгмийн үйлчилгээний байгууллагууд) хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, удирдамж боловсруулж, баталгаажуулан, хэрэгжилтэд тогтмол дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийн агуулга, арга зүйг хүүхдийн санал, судалгаан дээр үндэслэн жил бүр шинэчлэн боловсруулдаг байна. Хөтөлбөр нь төрөлжсөн болон холимог хэлбэрээр танхимд болон байгаль түшиглэн хэрэгжүүлэх, зохион байгуулах аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлэн шаардлагатай материал, хэрэгслээр хангасан, нөөцтэй, орчин нөхцөлийг тогтмол сайжруулдаг байна.

Хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн: Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг хэрэгслийг Монгол улсын стандартад заасны дагуу урьдчилан бэлтгэж, зохион байгуулагч хэрэгжүүлэгчид өөрсдийн нөөц боломждоо тулгуурлан зохион байгуулна. Өсвөр үеийнхний насны онцлогт тохирсон спорт тоглоомын, техникийн, аяллын, гадаад орчны болон танин мэдэхүйн сургалтын хэрэгсэл, хөгжмийн зэмсэг хэрэглэгдэхүүнд орох бөгөөд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн, хэрэгслийг хүүхэд бүрд хүрэлцэхүйц байдлаар бэлтгэсэн,

нөөцтэй байх шаардлагатай.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш, ажилтны үүрэг, оролцоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, агуулгыг хүүхдийн насны ангиллаар боловсруулж, хэрэгжүүлэх
- Шаардагдах материал бусад хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэх
- Хөтөлбөрийг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан бүтээлчээр зохион байгуулах
- Хөтөлбөрийн дэд сэдвийн агуулга, арга зүйтэй танилцан, сэдэвтэй холбоотой нэмэлт мэдээлэл болох үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, соёл иргэншлийн аюулгүй байдал, соёлын талаар судалсан байх
- Хөтөлбөрийн суурь зарчим, туршлага болон өсвөр үеийнхний хөгжлийн хэрэгцээг ойлгосон байх
- Зохион байгуулсан хөтөлбөрөө тогтмол баяжуулан, дүгнэж сайжруулдаг байх. Өсвөр үеийнхний хөтөлбөрийн талаар эхлээд ямар мэдлэг–мэдээлэл, чадвар, хандлагатай байсан, хөтөлбөрийн төгсгөлд мэдлэг–мэдээлэл, чадвар, хандлага нь хэрхэн нэмэгдсэнийг ажиглаж, хүүхдийн санал хүсэлт, сэтгэл ханамжид тулгуурлан хөтөлбөрийн хэрэгжилтэд дүгнэлт хийх нь цаашид хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх, боловсронгуй болгоход нөлөөлнө.

Дүгнэлт. Монголчуудын уламжлалын үүргийн үндсэн шинж, үүрэгт нь тулгуурлан *нэгдүгээрт*, хүмүүсийн тодорхой үеүдийн залгамж холбоог хангахад идэвхтэй тусалдаг, *хоёрдугаарт*, мэдээллийн үүрэгтэй, *гуравдугаарт*, хуримтлуулах, хадгалах үүрэгтэй. *дөрөвдүгээрт*, нийгмийн харилцааг бэхжүүлэхэд нөлөөлдөг. *тавдугаарт*, олон нийт, нийгмийн төлөвшилд голлох үүрэг гүйцэтгэдэг, *зургаадугаарт*, хүмүүс (гэр, хамт олон, нийгмийн) хоорондын харилцаанд хэмжүүрийн үүрэг гүйцэтгэдэг зургаан нийтлэг талтай



болохыг тодорхойллоо.

Соёл иргэншлийн аюулгүй байдлын монгол уламжлал, өв соёлын төлөвшлийн хөтөлбөрийн хүрээнд ашиглах дараах боломжуудыг санал болгож байна:

- Сургуулийн орчинд хичээлээс гадуурх үйл ажиллагаанд соёл иргэншлийн аюулгүй байдлын агуулгыг тусгаж хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих боломж;
- Өдөр өнжүүлэх ба хүүхэд харах үйлчилгээ дэх хүүхдийн төлөвшлийг дэмжих үйлчилгээг ашиглах боломж;
- Хүүхдийн зуслангийн төлөвшлийн үйл ажиллагаа (Зуслангийн төлөвшлийн хөтөлбөр);
- Хүүхдийн номын сан дах төлөвшлийн үйлчилгээг ашиглах боломж;
- Сургалтын төвийн хэрэгжүүлж буй сургалт, хөтөлбөр, курс дамжаагаар дамжуулан соёл иргэншлийн аюулгүй байдлын талаар мэдлэг олгох боломж;
- Музей, галерей дэх хүүхдийн төлөвшлийн үйлчилгээг ашиглах боломж;
- Хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбар дахь хүүхдийн төлөвшлийн үйлчилгээг өргөжүүлэх боломж;
- Эрүүл мэндийн салбар дахь төлөвшлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагааг зөв чиглүүлэх замаар өсвөр үеийнхний төлөвшлийг дэмжих боломж;
- Хувийн хэвшил, бизнесийн салбар ба хүүхдийн хөгжих эрхийн хүрээнд соёл иргэншлийн өсвөр үеийнхний хөгжилд үзүүлэх эерэг нөлөөг дээшлүүлэх боломж;
- Олон улсын байгууллагууд ба хүүхдийн хөгжих эрхийн уялдааг сайжруулах боломж;
- Хүүхдийн хөгжилд чиглэсэн бусад үйл ажиллагааг ашиглах боломж.

Монгол уламжлалын зургаан нийтлэг тал болон эдгээр боломжийг ашиглах нь өсвөр үеийнхнийг монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлааг хадгалж, хамгаалж, тээн хөгжүүлэх жинхэнэ монгол хүн болж төлөвшихөд ач тустай байх болно.

Ашигласан материал:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 4 сарын 15-ны А/150 тушаалаар батлагдсан Хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөр болон хөгжлийн хөтөлбөр боловсруулах удирдамж
2. https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_2002_004V1
3. Музейн тухай хууль
4. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль
5. Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэглэгээ ашиглах шаардлага MNS 3587:2016



НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД МЭДЭЭЛЛИЙН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Б.ЭРДЭНЭЧИМЭГ /ҮБХИС-ийн Эрдмийн сургуулийн доктор (Ph.D), профессор/
Б.ТҮВШИНСАЙХАН /ҮБХИС-ийн докторант/

Түлхүүр үг: Олон нийтийн сүлжээ, нийгмийн сүлжээ, ташаа мэдээлэл,
үндэсний аюулгүй байдал, тогтворгүй байдал

Key words: Social networking, social media, disinformation, national security, instability

Оршил. Дэлхийн хэмжээнд хүн амд ноогдох интернэт хэрэглэгчдийн эзлэх хувийг тивээр нь авч үзвэл, Европ хамгийн өндөр буюу 91.73%; Америк 77.53%; Австрали 72.4%; Ази 67.8%; харин Африк тив хамгийн бага буюу 45.14% тус тус байгаагаас интернэтийн хэрэглээ нь тухайн улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлөөс шууд хамааралтай байна. (World & Data Reportal., 2022)¹


Олон улсын Kerois судалгааны байгууллагаас 2022 оны 10 дугаар сард гаргасан судалгаагаар 2021 оны мөн үетэй харьцуулахад дэлхийн хүн ам 0.8%-аар өсөж, 7.99 тэрбум болсон байна (World & DataReportal., 2022)²:

- 5.48 тэрбум хүн буюу 68.6% нь үүрэн телефон ашигладаг нь 3.2%-аар өссөн.
- 5.07 тэрбум хүн буюу 63.5% нь интернэтийн орчинд ажилладаг нь 3.5%-аар өссөн.
- 4.74 тэрбум хүн буюу 59.3% нь нийгмийн сүлжээнээс мэдээлэл авдаг нь 4.2% өссөн үзүүлэлттэй байна.

Хэрэглэгчид нийгмийн сүлжээг голдуу компьютер, таблет, гар утасны тусламжтайгаар веб дээр тулгуурлан ашиглаж байна. Тухайлбал Baidu, Facebook (Facebook-ийн Messenger), Gab, Google+, Mespase, Instagram, Telegram, Linkedin, Pinterest, Snapchat, Tumblr, Twitter, Viber, VK, WeChat, Weibo, WhatsApp, Wikia зэрэг

системүүд багтана.

Олон улсын Statista байгууллагаас гаргасан судалгаагаар дэлхий дахины нийгмийн сүлжээний хэрэглэгчийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд 2027 онд гэхэд 5.85%-аар өсөх хандлагатай байна (1 дүгээр зураг). (Statista, 2023)³



Эх сурвалж: <https://www.statista.com/statistics/278414/number-of-worldwide-social-network-users/>
1 дүгээр зураг. Дэлхий дахины нийгмийн сүлжээний хэрэглэгчдийн тоо (2017–2027 он хүртэл, тэрбумаар)

Гар утас, ухаалаг гар утас, компьютер, таблет, ухаалаг цаг, телевиз зэрэг төхөөрөмжүүдийг ашиглан хүмүүс мэдээллийг олж авч, заримдаа өөрсдийн санал бодол, сэтгэгдлээ хуваалцаж байна. 2022 оны байдлаар дэлхийн хүн амын 96.1% нь гар утас хэрэглэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3%-аар өссөн үзүүлэлттэй байна. интернэтийн орчин нийгмийн сүлжээнд

¹ Digital 2022. October Global Statshot Report. (2022): <https://datareportal.com/reports/digital-2022-october-global-statshot/>;

² Digital 2022. October Global Statshot Report. (2022): <https://datareportal.com/reports/digital-2022-october-global-statshot/>;

³ Statista: <https://www.statista.com/statistics/278414/number-of-worldwide-social-network-users/>



өдөрт дунджаар 6 цаг 37 мин. зарцуулж байна (Хүснэгт 1, 2).

Хүснэгт 1. Дэлхийн хүн амын нийгмийн сүлжээнд ашиглаж буй төхөөрөмж

(өмнөх оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт)

№	Нийгмийн сүлжээнд ашиглаж буй төхөөрөмж	Эзлэх хувь	Өсөлт, хувь	Холбогдож буй хурдны өсөлт, bps
1	Гар утас	96.1	+0.3	+30
2	Ухаалаг гар утас	95.8	+0.4	+40
3	Feature phone	7.7	-8.3	-70
4	Компьютер (суурин болон зөөврийн)	59.0	-8.5	-550
5	Таблет	34.0	-2.0	-70
6	Тоглоом тоглох	20.3	-0.5	-10
7	Ухаалаг цаг	28.7	+10	+260
8	TV	15.9	+5.3	+80
9	Гэрийн ухаалаг төхөөрөмж	15.2	+12.6	+170
10	Виртуал төхөөрөмж	5.4	+14.9	+70

Хүснэгт 2. Нийгмийн сүлжээнд өдөрт зарцуулж буй хугацаа

№	Нийгмийн сүлжээний төрөл	Зарцуулж буй хугацаа	Өмнөх оны мөн үетэй харьцуулсан	
			Хугацаа, мин	Өсөлт, %
1	Интернэтийн орчин, нийгмийн сүлжээ	6 цаг 37 мин.	-20	-4.8
2	TV	3 цаг 25 мин.	+4.0	2.0
3	Нийгмийн сүлжээнд	2 цаг 28 мин.	+1	+0.7
4	Онлайн мэдээ, мэдээлэл унших	2 цаг 09 мин.	+4	+3.2
5	FM, радио сонсох	1 цаг 01 мин	Өөрчлөгдөөгүй.	

6	Podcast сонсох	1 цаг 01 мин	4	7.0
7	Тоглоом тоглох	1 цаг 13 мин	Өөрчлөгдөөгүй.	

Дээрх хүснэгтээс дүгнэхэд:

- Интернэтийн орчин, нийгмийн сүлжээнд өдөрт 6 цаг 37 мин. зарцуулж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 мин буюу 4.8%-аар буурсан.
- Нийгмийн сүлжээнд 2 цаг 28 мин зарцуулж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1 мин буюу 0.7%-аар өссөн байна.
- Онлайн мэдээ, мэдээлэл унших, сэтгэгдэл бичихэд 2 цаг 09 мин зарцуулж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4 мин буюу 3.2%-аар өссөн.

Нийгмийн сүлжээ болон нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг “Тав дахь засаглал” гэж үздэг бөгөөд нийгэмд нөлөөлж чадах хүчтэй хэрэгсэл юм. Вебстерийн толь бичигт нийгмийн мэдээллийн хэрэгслийг онлайн холболтоор хүмүүс мэдээлэл, үзэл бодол, хувийн захиа түгээдэг, хуваалцдаг цахим харилцааны нэг хэлбэр юм⁴ гэж тайлбарласан байна.

Монгол Улс нь хүн ам цөөн, газар нутаг удам, байгалийн нөөц арвин зэргээс шалтгаалж, бусад улс орны сонирхол татсан хөгжиж буй улсын хувьд дотоод аюулгүй байдлын асуудлаа онцгойлон анхаарахыг дэлхийд өрнөж буй үйл явц, манай орны улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөлт, сорилт бэрхшээл харуулж байна.

Улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах тулгуур асуудалд тухайн улс дотооддоо аюулгүй байх явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой байдаг. Тодруулбал, гадаад орны зүгээс аливаа улс оронд чиглэсэн бодлого хэрэгжүүлэхдээ тухайн улсын дотоодод, тэр дундаа нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж, тогтворгүй байдал бий болгох, түүнийг шийдвэрлэхдээ өөрсдийн ашиг сонирхлыг суулгадаг технологи хуучраагүй,

⁴ Dictionary and Thesaurus | Merriam-Webster". www.merriam-webster.com. Retrieved 2022-08-10



харин ч шинэ агуулга, хэлбэрээр хөгжиж байна.

Монгол Улсын дотоод аюулгүй байдал нь доорх үндсэн дөрвөн тулгуур асуудал /багана/-аас бүрдэнэ гэж судлаачийн хувьд үзэж байна (2 дугаар зураг).

дэх хуурамч мэдээ, мэдээллээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын бодлогыг үндэсний эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт



2 дугаар зураг. Монгол Улсын дотоод аюулгүй байдлын үндсэн тулгуур багана

Манай улсад дотоод аюулгүй байдлын хамрах хүрээ тэлж, дотоод дахь улс төр, нийгэм, эдийн засаг, шашны хуваагдал, бүлэглэлүүдийн өрсөлдөөн, баян ядуугийн ялгаа улам ихсэж, "Тав дахь засаглал" хэмээн нэрлэгдэх нийгмийн сүлжээ, нийгмийн мэдээллийн хэрэгслээр хуурамч мэдээлэл тарааж байгаа нь үндэсний эв нэгдлийг сулруулж, урт хугацаандаа нийгмийн тогтвортой байдалд сөрөг нөлөө учруулж болзошгүй байдал ажиглагдаж байна. Нийгмийн тогтвортой байдлыг хангахад улс төрийн намууд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагууд, тэдгээрийн нийгэмд үзүүлж буй үр нөлөөг үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн төр, Засгийн газар, төрийн захиргааны болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд, бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчид анхааралдаа авч, нийгмийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй хүчин зүйлсээс тухайлбал, нийгмийн сүлжээн

байдал, үндэсний аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагатай гадаад болон дотоод нөхцөлүүд эрс өөрчлөгдөж байгаа энэ цаг үед үндэсний эв нэгдэл, улс төр, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдал хамгийн чухал асуудал болж байна.

Дотоод, гадаад янз бүрийн учир шалтгааны улмаас нийгмийн сэтгэл зүй тогтворгүйтэж эмзэг, хэврэг байдалд орох нь дотоодын зөрчил, хуваагдалд амархан өртөх, улмаар гаднаас удирдан жолоодох сонирхол бүхий их гүрнүүдийн хараанд өртөх магадлалыг улам бүр нэмэгдүүлдэг. Үүнийг даван туулах, үндэсний нэгдмэл байдлыг бүрдүүлэхэд нийгмийн оюун санааны дархлаа, эх оронч, үндэсний үзлийг төлөвшүүлэх асуудал чухал.

Улс орны дотоод дахь улс төр, нийгэм, эдийн засаг, шашны хуваагдал, бүлэглэлүүдийн өрсөлдөөн, баян ядуугийн ялгаа ихсэж байгаа нь үндэсний эв нэгдлийг сулруулах, цаашилбал нийгмийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрч болзошгүй байна.



“Мэлрэг цэцэг”-ийн гэх тодотголтой үйл явдлууд нийгэм, эдийн засгийн олон улсын үзүүлэлтээр нийгэм, эдийн засгийн хувьд тогтвортой байх улсуудад гарч байна. Ойрх Дорнод, Хойд Африк, Украинд нийгмийн тогтворгүй байдлыг үүсгэсэн гол шалтгаан нь тус улс оронд авлига газар авсан, байгалийн их нөөцтэй, үнийн өсөлт зэргээс шалтгаалсан. Манай Улсад ч дээрх хүчин зүйлс бий болсон гэж үзэж байна.

Ажилгүйдэл, ядуурлын улмаас архидалт, танхайрал, онц ноцтой гэмт хэргийн гаралт ихсэж, хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт сөргөөр нөлөөлж, монгол хүний аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг хамгаалах асуудал улам бүр төвөгтэй болоод байна.

Даяаршлын олон талт үйл явц, мэдээллийн асар хурдацтай урсгалын нөлөө нь хүүхэд, залуучуудын оюун санаа, сэтгэлгээ гаднын хэл, соёл, иргэншлийн түрлэгт өртөж, үндэсний сэтгэл зүй, түүхийн ой санамжийг бүдгэрүүлэх сөрөг үр дагавартай. Улс орны хойч ирээдүй болсон хүүхэд, залуучууд өвөг дээдсийнхээ түүх, уламжлалт өв соёл, зан заншлаа үл тоомсорлох, үгүйсгэх хандлага ажиглагдаж, гаднын кино, мэдээллийн бусад сувгийн урлагаар дамжсан үзэл суртал, соёл ахуйд ихээр автаж байгаа нь улс, үндэсний оюун санааны тусгаар тогтнол, нийгмийн тогтвортой байдалд учрах эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Ташрамд дурдахад, олон улсын Кероис судалгааны байгууллагаас 2022 оны 01 дүгээр сард гаргасан судалгаагаар манай улсын хувьд 2,16 сая хүн буюу 64.4% нь интернэтийн хэрэглэгч байгаа бөгөөд энэ үзүүлэлт 2021 онтой харьцуулахад 4.7%-аар өссөн байна.

Цахим шинэ технологи ашиглаж, хуурамч мэдээллийг зориудаар түгээн, олон нийтийн санаа бодлыг төөрөгдүүлж байна. Монгол хүн эх нутагтаа оршин байгаа хэдий ч зах

хязгааргүй мэдээллийн шинэ ертөнц, шинэ орчинд амьдарч байна. Мэдээлэл харилцаа, холбооны технологийн дэвшлээс шалтгаалан сүүлийн жилүүдэд хүмүүсийн оюун санаа, амьдралын хэвшилд өөрчлөлт гарч байна. Мэдээллийн хэрэгсэл ашиглан хувь хүний оюуны дархлаа, үндэсний эв нэгдэл, ухамсарт нөлөөлөх эрсдэлүүд үүсэж байна. Учир нь өдгөө мэдээлэл өөрөө үндэсний нөөц баялаг, улс орны хөгжил, дэвшилд нөлөөлөх чухал хүч болоод байгаа тул энэ баялгийг эзэмших шинэ тэмцэл өрнөж, мэдээллийн шинэ дайн чимээгүй явагдаж байна. Үүний тод жишээгээр Хойд Африк, Ойрх Дорнод, Украинд болсон үйл явдлыг нэрлэж болно. Дэлхийн улс орны фейсбүүкийн платформ судалгаанд улс төрийн зорилгоор хуурамч хаягаар хяналтгүй мэдээ, мэдээлэл дамжуулдаг орнуудыг гаргасан бөгөөд энэ асуудлыг анхааралдаа авч ажиллахгүй байгаа улс орнуудад Монгол Улсыг хамааруулсан байна. (Даваадорж & Энхсайхан, 2022)⁵

Ханбургийн их сургуулийн профессор Ханс Ж.Клайнштойбер хэвлэл мэдээллийн салбарын хүрээн дэх зохицуулалтыг төрийн оролцоотой зохицуулалт (state-regulation), салбарын бие даасан зохицуулалт (self-regulation), сүүлийн үед цахим ертөнцөд үүсэж буй ээдрээтэй асуудлуудыг зохицуулах үүднээс эрчимтэй яригдах болсон төрийн, салбарын болон иргэний нийгмийн оролцоотой хамтын зохицуулалт (co-regulation) гэж ерөнхийд нь гурав ангилсан байна. (ХЗҮХ, 2013)⁶

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нийгмийн оюун санааны амьдрал, тэр дундаа олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж, улмаар нийгмийн тогтвортой байдлыг хангахад онцгой үүрэг гүйцэтгэдэг маш хүчирхэг механизм юм.

Өдгөө сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнууд олон нийтийн анхаарал

⁵ Даваадорж Ц., (доктор, профессор), Энхсайхан Д., (2022). Үндсэн хуульт байгууллын талаарх ойлголт, түүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүд. Стратегийн судалгаа сэтгүүл. Дотоод аюулгүй байдал. № 83 /2022/. т131–141;

⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2013). Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх зүйн орчин: Бүртгэл, тусгай зөвшөөрөл, эзэмшил, татаасын асуудал” судалгааны тайлан ., <https://nli.gov.mn/?p=1921>



татсан асуудлыг шүүрэн авч, тэд баримт нотолгоогүйгээр шуугилдаг, улс төрийн зорилгоор хэт нэг талыг барьж бичдэг, аль нэг нам, улс төрийн хүчнийг дарж авах хэрэгсэл болгодог бохир аргаас салж чадаагүй байна. (Норовсүрэн, 2019)⁷

Тийм ч учраас “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.4.3–т “Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана” гэж заасан. (УИХ. & АБГББХ., 2018)⁸

Кабелийн телевизийн 100 орчим сувгаар 20 гаруй хэлээрх мэдээлэл хүлээн авч, өдөр тутмын 16 сонин гарч, Улаанбаатарт 32, Монгол Улсын нутагт дэвсгэрт 162 телевиз үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд 84 радио үйл ажиллагаа явуулж байгаагийн 77 нь хэт богино долгионы радио станцууд (FM) юм. (Зулькафиль, 2017)⁹

Монголын Хэвлэлийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Монголын хэвлэл мэдээлэл – Өнөөдөр” тайланд 2020 оны байдлаар манай улсад 84 сонин, 51 радио, 140 телевиз, 154 вебсайт гээд нийт 502 хэвлэл мэдээллийн хэрэгсэл байна. Энэхүү тайланд дурдсанаас харахад 2013 оноос хойш мэдээллийн хэрэгслийн тоо жил бүр буурч байсан бол 2018 онд 14–өөр, 2019 онд 45–аар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлт нь гол төлөв мэдээллийн сайтын тоо олширсонтой холбоотой гэж үзэж байна. Цаасан мэдээллийн хэрэгслийн тоо, тухайлбал сонины тоо багассан хэвээр байгаа бөгөөд, 2019 онд сонины нэр төрөл сүүлийн 20 жилийн туршид байгаагүйгээр цөөрч, сонины борлуулалт 5 хувиар, сэтгүүлийн борлуулалт 44

хувиар тус тус буурчээ. (Хэвлэлийн хүрээлэн, 2022)¹⁰

Хэвлэл мэдээллийн салбарт цахим шилжилт эрчимтэй явагдаж, 2019 оны эхний байдлаар 154 мэдээллийн сайт цаг үеийн мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэж байгаагаас 20 нь орон нутагт ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд нийгмийн мэдээллийн сүлжээг ашиглаж, өөрийн контентыг түгээх, сурталчлах, хэрэглэгчидтэй харилцах нь түгээмэл болж байна. Тухайлбал, телевизүүдийн 85 хувь нь албан ёсны фейсбүүк хуудсаараа нэвтрүүлгээ дамжуулж, үзэгчдийн санал, сэтгэгдлийг хүлээн авч байна. Түүнчлэн, цахимаар сонсох боломжтой радиогийн тоо сүүлийн жилүүдэд 3–аар нэмэгдсэн бол веб сайтаар дамжуулан нэвтрүүлгийг нь хүлээн авах боломжтой 23 телевиз байна.

Хэвлэл мэдээллийн салбарт 4700 орчим хүн ажиллаж байгаагаас 50% нь сэтгүүлч, редактор зэрэг сэтгүүл зүйн хэм хэмжээний дагуу ажиллах үүрэг бүхий ажилтан байгаа бөгөөд тэдний 60 орчим хувь нь сэтгүүлч мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн. Хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллагсдын 50 гаруй хувь нь телевизийн салбарт ажилладаг.

Хэвлэл мэдээллийн системийн талаарх олон улсын болон Монгол Улсын хууль эрх зүйн орчинг шинжилж үзье.

1991 онд Виндхукийн тунхаг (Declaration of Windhoek)–аар чөлөөт, хараат бус, олон ургалч хэвлэлийн гол зарчмуудыг тунхаглаж, чөлөөт хэвлэл нь ардчиллын оршин тогтнохын салшгүй хэсэг гэдгийг зааж, НҮБ–ын Ерөнхий Ассемблей 1993 онд хэвлэлийн эрх чөлөөний өдрийг баталсан байна. Мөн хэвлэлийн хяналтын эсрэг олон улсын төвөөс “Йоханнесбургийн

⁷ Норовсүрэн, Л. (2019). Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд. XVII боть. Сэтгүүл зүй (21 боть зохиол). –УБ., “Хангай принтинг” ХХК. ISBN: 978–99978–66–110., 37.0 х.х, 487 дахь тал;

⁸ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Улсын Их Хурал. Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо. (2018). Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын талаарх төрөөс баримтлах бодлогын эмхэтгэл. –УБ., “Колор Ланд” ХХК., хуудас 4–31;

⁹ Зулькафиль, М. (2017). Дэлхийн сэтгүүл зүйн хөгжлийн хандлага Монголын сэтгүүл зүйд нөлөөлөх нь. “Сэтгүүл зүй” сэтгүүл. МУИС. ШУС. Нийгмийн ухааны салбар. Эрдэм шинжилгээний бичиг. ISSN: 2306–4463. № 18/479., хуудас 9–20

¹⁰ Хэвлэлийн хүрээлэн. <https://pressinst.org.mn/>



зарчмууд: Үндэсний аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж” баримт бичгийг 1995 оны 10 дугаар сард баталсан байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засаг, олон намын тогтолцоонд 1990–ээд оны эхэн үеэс шилжсэнээс хойш мэдээллийн хэлбэрт асар их өөрчлөлт орж, интернэт, нийгмийн сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд бий болсноор хүмүүст үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлтэй байх, бусадтай холбогдох өргөн боломжууд бий болсон. Гэсэн хэдий ч хуурамч мэдээлэл, үзэн ядалтын үг хэллэг, хэвлэл мэдээллийн бизнесийн загвар, цөөн хэдэн хувийн компаниуд эрх мэдлийг өөрсдөдөө төвлөрүүлэх асуудлууд нэмэгдсэн байна.

Өдгөө манай улсын хэвлэл мэдээллийн салбарт холбогдох 30 орчим хууль үйлчилж байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага нь “Төрийн нууцын тухай хууль”, “Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль”, “Байгууллагын нууцын тухай хууль”, 6 стандартууд, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2010–2015 он”, “Төрийн нууцыг хадгалах, хамгаалах журам”, “Нууцын талаарх санамж” зэрэг мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох ёстой.

“Мэдээллийн эрх чөлөө” гэдэг ойлголт нь өргөн хүрээтэй, олон салаа утгатай учир буруу ойлгогдох эрсдэлтэй. Үүний хувьд “Монгол Улсын Үндсэн хууль”–д тусгагдсан “Үгээ хэлэх эрх чөлөө”–тэй огт холбоогүй учраас “Мэдээлэлд хандах”, “Ил тод байдал”, эсхүл “Акттай танилцах” хэмээх ойлголтууд илүү оновчтой юм.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хуулиар хамгаалан хөгжүүлж байгаа ч сүүлийн жилүүдэд нийгмийн сэтгэл зүйд үзүүлж буй нөлөөлөл эергээсээ илүү сөрөг тал нь давамгайлах хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр

цацагдаж буй мэдээллийн дийлэнх нь нийгмийг соён гэгээрүүлэхээс илүү бухимдал, гутрал төрүүлэх эх сурвалж давамгайлж байна. Аливаа улс оронд шүүмжлэлтэй хандах асуудал ямагт байдаг хэдий ч хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийгэмд хүргэх, хэлэлцэгдэх хэм хэмжээ, хязгаар гэж бий. Энэ хэм хэмжээ, хязгаар манай улсад байхгүй байгаагаас үүдэн шүүмжлэлт сэдэв гол анхааралд байж, нийгмийн сэтгэл зүйд ямагт сөрөг нөлөө үзүүлж, үндэсний эв нэгдлийг сулруулахад хүргэж байна. (Минжин, Төмөр–Очир, Ариунболд, Энхсайхан, & Энхмаа, 2022)¹¹

Олон нийтэд хуурамч мэдээллийг хараа хяналтгүй цацах нь нийгмийн сэтгэл зүйг булингартуулж, аажимдаа нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ. Ийм нөхцөл байдал зөвхөн нийгмийн тогтвортой байдалд олон талын эрсдэл бий болгоод зогсохгүй Монгол Улсад геополитик, эдийн засгийн ашиг сонирхлоо гүнзгийрүүлэх зорилготой гадаадын зарим байгууллага, тухайлбал шашны байгууллага, хувь хүмүүст нэн таатай нөхцөл үүсгэж, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхэд сөргөөр нөлөөлөхийн сацуу дотоодын зөрчил, хуваагдалд амархан өртөх магадлалтай байна.

Монголын олон нийтийн санаа бодолд төрд бүхнээ даатгах, төрөөр тэтгүүлэх байр суурь социалист, үзэл суртлын үеэс уламжлан өдгөө улам бүр өсөн тэлж байгааг “Сант Марал” сангийн 2017 оны 3 дугаар сард хийсэн улс төрийн барометрийн судалгаа нотолж байна. Энэхүү судалгаагаар нийгэм, эдийн засаг, улс төрийн тулгамдсан асуудалд олон жилийн давталттайгаар ажилгүйдэл (43.3%), амьжиргааны уналт (15.7%), эдийн засгийн хямрал (8.2%), үнийн өсөлт (5.8%) гэсэн эрэмбэ дарааллаар эгнэсэн мөртлөө эдгээрийг шийдэх тэргүүлэх үүрэгтнийг 49.3% нь Засгийн газар, 16.3% нь Улсын Их Хурал, 9.1% нь Ерөнхийлөгч хэмээн хариулаад иргэний нийгмийн хүчинд 10% нь л санал өгсөн байна.

¹¹ Минжин, Ц., Төмөр–Очир, С., Ариунболд, Ц., Энхсайхан, Д., Энхмаа, Э., (2022). Төр, нийгмийн аюулгүй байдал, ҮАБЗАА, ССХ. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд). Гуравдугаар бүлэг. 151–211;



Энэ нь нэг талаас нийгмийн сүлжээний хэрэглээ, нөлөө эрчтэй өссөн, нөгөө талаас олон нийтийн хүлээлт хүсэлтэд Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа нийцээгүйн дээр өөрийгөө илэрхийлэх, бусдад нөлөөлөх гэсэн зорилгод хэт эрхшээгдсэн нийгмийн сүлжээний хэрэглэгчдийн зан сэтгэхүйн түрэлт зэрэг нь Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх мэдээллийн орон зайн голлох хүчин зүйл болсон байна.

“Сант Марал” сангийн судалгаагаар Улаанбаатар хотын иргэдийн 68.7, хөдөө орон нутгийнхны 51.8% нь фейсбүүк хаягтай бөгөөд тэдний 96.4% нь идэвхтэй хэрэглэдэг. Харин твитерийн хувьд Улаанбаатар хотын оролцогчдын 14.5%, хөдөө орон нутгийнхны 8.6% бүртгэлтэй, нийт дүнгээрээ 7.6% нь идэвхтэй ашигладаг байна. Мөн 15.8% Google, 9.1% Youtube, 5.1% Instagram зэрэг нийгмийн сүлжээг ашигладаг. Хэрэглээний талаасаа ч 86.3% нь мэдээлэл авах сонирхолтой, 76.2% нь хайлт хийх зорилгод нийцдэг, 63.8% нь зугаатай болохыг онцолжээ.

Ийнхүү нийгмийн сүлжээний орчинд эрх баригч хүчний эсрэг ямар ч хуурамч, эргэлзээтэй мэдээлэл түгээхэд олон нийтийн үгүйсгэл хөөрөл, туйлшрал, сэтгэл догдлолын хүчин талаасаа ч, суваг хэрэгслийн хурд, хүртээмж, хэрэгслийн нөөцөөрөө ч тэр нөлөө үзүүлэх бүрэн боломжтой нөхцөл бүрдсэн байна.

Нийгмийн сүлжээний фэйсбүүкийн “Messenger”, “What’s App”, “Snapchat” зэрэг томоохон мессеж аппликэйшнийг олон хэрэглэгч өргөнөөр ашиглаж байна. Жишээлбэл, фэйсбүүкийн “Messenger”-ийг сард нэг тэрбум хүн хэрэглэдэг ба энэхүү мессенжер, “What’s App” хоёрын дунд өдөрт 60 тэрбум мессеж солилцож байна гэсэн судалгаа бий. Хүмүүс нээлттэй, том сүлжээнд мэдээлэл солилцохдоо илүү хяналт сайтай “Messenger”, “What’s App”, “Snapchat”-ийг ашиглахыг илүүд үзэж байна. “What’s App”-ийн хэрэглэгчид жишээ нь фэйсбүүкийн хэрэглэгчдээс 60 хувиар илүү зураг хуваалцдаг. Дижитал лидерүүд ч мөн эдгээр платформууд дээр төвлөрч байна. Тэдний 56% “Facebook Messenger” маш чухал

хэрэгсэл болохыг, 53% нь “What’s App”, 46% “Snapchat” чухал болохыг, мөн “WeChat”, “Line”, “Viber”, “Kik”, “Telegramm” туршихаар төлөвлөсөн байна.

Хэвлэн нийтлэгчид мессежийн орчинд нэвтрэхэд байнга төвөгтэй байсан бөгөөд бот платформ бий болсноор энэ байдал өөрчлөгдсөн. Бот бол компьютерын маш ухаалаг программ бөгөөд чат хэрэглэгчдэд хариултыг түргэн шуурхай өгөх боломжоор хангадаг. Заримдаа түүнийг хүн, компьютер хоёр хамтдаа удирддаг ч харилцан ярианы интерфэйсийг өөр өөрөөр хийдэг. Чат бот нь өөр аппликэйшн татаж авахгүйгээр мэдээллийг шинэчлэх, такси дуудах, оройн зоогийн жорыг заах боломжтой. Сүүлийн жилүүдэд 3 төрлийн бот бий болсон байна.

- Нийгмийн сүлжээ сайтад Feed-ээсээ шинэ мэдээлэл авах үед автоматаар шинэчлэл хийж, мэдээлэл өгдөг.
- Хэрэглэгчийн хайсан мэдээллийн дагуу мэдээлэл санал болгож нийлүүлдэг.
- Хэрэглэгчийн асуултад хариу өгөх.

Энэ салбарт баримтыг нягтлах бот ч бий болж байна. Их Британид бий болсон “Full Fact” нь хэвлэлийн хурал дээр шууд баримтыг нягтлах чиглэлээр хөгжиж байна. Мөн Францын “Le Monde” сонины уншигчид улс төрийн мэдэгдлийг нягтлах системтэй болсон байна.

Нийгмийн сүлжээ нь мэдээлэл харилцааны өргөн хэрэгсэл болохын хувьд сэтгүүл зүйн мэдээлэл үйлдвэрлэлийн бүхий л үе шат болон хэрэглэгчтэйгээ эргэх холбоотой харилцахад асар их нөлөөтэй учраас сэтгүүл зүйн ёс зүйн нягт нямбай ажиллах, шударга ажиллах, хүнлэг энэрэнгүй байх буюу хор уршгийг бууруулах зарчмууд зөрчигдөж; хувийн болон мэргэжлийн орон зайн зааг ялгаа холилдож, дараах зарчим зөрчигдөж байна. Үүнд: (Идэржаргал, 2022)¹²

- Нягт нямбай ажиллах зарчим
- Хүнлэг энэрэнгүй байх зарчим
- Хариуцлага хүлээх чадвар болон нэвтрэх эрхийн хянах
- Шударга ажиллах, үл ялгаварлах зэрэг болно.



Дүгнэлт.

1. Өдгөө манай улсын хэвлэлийн мэдээллийн салбарт 30 орчим хуль тогтоомж, эрх зүйн баримт бичиг үйлчилж байна. Монгол Улсад 1990 онд ардчилсан хувьсгал өрнөснөөс хойш либерал загварын хэвлэл мэдээллийн систем хожуу хөгжиж байна.

2. Монгол Улсын нийгэм-төрийн байгуулал, нийгмийн тогтвортой байдал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын дотоод аюулгүй байдал баталгааждаг.

3. Монгол Улс нь хүн ам цөөн, газар нутаг уудам, байгалийн нөөц арвин зэргээс шалтгаалж, бусад улс орны сонирхол татсан хөгжингүй улсын хувьд дотоод аюулгүй байдлын асуудлаа онцгойлон анхаарахыг дэлхийд өрнөж буй үйл явц, манай орны улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд сүүлийн

жилүүдэд гарч буй өөрчлөлт, сорилт бэрхшээл харуулж байна.

4. Манай улсад дотоод аюулгүй байдлын хамрах хүрээ тэлж, дотоод дахь улс төр, нийгэм, эдийн засаг, шашны хуваагдал, бүлэглэлүүдийн өрсөлдөөн, баян ядуугийн ялгаа улам ихсэж, “Тав дахь засаглал” хэмээн нэрлэгдэх нийгмийн сүлжээ болон нийгмийн мэдээллийн хэрэгслээр хуурамч мэдээлэл тарааж байгаа нь үндэсний эв нэгдлийг сулруулж, урт хугацаандаа нийгмийн тогтвортой байдалд сөрөг нөлөө учруулж болзошгүй байдал ажиглагдаж байна.

5. Нийгмийн тогтвортой байдлыг хангахад улс төрийн намууд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагууд, тэдгээрийн нийгэмд үзүүлж буй үр нөлөөг үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Digital 2022. October Global Statshot Report. (2022): <https://datareportal.com/reports/digital-2022-october-global-statshot>;
2. Statista: <https://www.statista.com/statistics/278414/number-of-worldwide-social-network-users/>
3. Dictionary and Thesaurus | Merriam-Webster". www.merriam-webster.com. Retrieved 2022-08-10
4. Ц.Даваадорж (доктор, профессор), Энхсайхан, Д. (2022). Үндсэн хуульт байгууллын талаарх ойлголт, түүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүд. Стратегийн судалгаа сэтгүүл. Дотоод аюулгүй байдал. ° 83 /2022/. Хуудас 131-141;
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2013). Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх зүйн орчин: Бүртгэл, тусгай зөвшөөрөл, эзэмшил, татаасын асуудал” судалгааны тайлан ., <https://nli.gov.mn/?p=1921>
6. Норовсүрэн, Л. (2019). Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд. XVII боть. Сэтгүүл зүй (21 боть зохиол). -УБ., “Хангай принтинг” ХХК. ISBN: 978-99978-66-110., 37.0 х.х, 487 дахь тал;
7. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Улсын Их Хурал. Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо. (2018). Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын талаарх төрөөс баримтлах бодлогын эмхэтгэл. -УБ., “Колор Ланд” ХХК., хуудас 4-31;
8. Зулъякафиль, М. (2017). Дэлхийн сэтгүүл зүйн хөгжлийн хандлага Монголын сэтгүүл зүйд нөлөөлөх нь. “Сэтгүүл зүй” сэтгүүл. МУИС. ШУС. Нийгмийн ухааны салбар. Эрдэм шинжилгээний бичиг. ISSN: 2306-4463. ° 18/479., хуудас 9-20
9. Хэвлэлийн хүрээлэн. <https://pressinst.org.mn/>
10. Минжин, Ц., Төмөр-Очир, С., Ариунболд, Ц., Энхсайхан, Д., Энхмаа, Э., (2022). Төр, нийгмийн аюулгүй байдал, ЯАБЗАА, ССХ. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд). Гуравдугаар бүлэг. 151-211;
11. Идэржаргал, Д. (2022). “Монголын сэтгүүл зүйн ёс зүй: зохицуулалт, төлөвшил, тулгамдсан асуудлууд” докторын зэрэг горилсон диссертац. -УБ. МУИС;
12. Nic Newman. (2017). Journalism, Media, Technology Trends and Predictions.

¹² Идэржаргал, Д. (2022). “Монголын сэтгүүл зүйн ёс зүй: зохицуулалт, төлөвшил, тулгамдсан асуудлууд” докторын зэрэг горилсон диссертац. –УБ. МУИС;



НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД СЭТГҮҮЛ ЗҮЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨЛЛИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

О.ҮРЖИН /Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, хошууч генерал/
С.БУЯНХИШИГ /ҮБХИС-ийн докторант/

Түлхүүр үг: Хэвлэл мэдээллийн бодлого, хэвлэл мэдээллийн зохицуулалт, олон нийтийн мэдээллийн байгууллага, хэвлэл мэдээллийн хараат бус байгууллага

Key words: Media policy, regulation of the media, mass media organization, private media organization, media independence

Оршил. Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгааждаг¹. Үндэсний аюулгүй байдлын эдгээр 3 объект цогц систем бөгөөд сэтгүүл зүйн бодлого, эрх зүйн зохицуулалтаас гурвуулаа хамаардаг.

Одоогоор манай орны хэвлэл мэдээллийн хэрэгслийн зохицуулалт нь бүртгэлийн асуудал дээр тодорхойгүй, тусгай зөвшөөрлийн зохицуулалт хэт ерөнхий, эзэмшил, өрсөлдөөний бодлого байхгүй, татаасын асуудал ил тод бус байгаа нь энэ салбарын хөгжлийг боогдуулан иргэдийн мэдээлэлтэй танилцах үндсэн эрхийг хязгаарлаж байгааг судалгаагаар тогтоосон байдаг.

Судалгаанаас үзэхэд хэвлэл мэдээллийн салбарын зохицуулалтыг төрийн оролцоотой зохицуулалт, салбарын бие даасан зохицуулалт, иргэний нийгмийн оролцоотой хамтын зохицуулалт гэсэн гурван хэлбэрийн зохицуулалт байж болохоор харагдаж байна.

Үндсэн хэсэг. Манай улсын сэтгүүл зүйн бодлогын орчин дээрх зохицуулалтын хэлбэрүүдийг дараах туршлага, шаардлагыг харгалзан ашиглах нь үр дүнтэй байх болно. Үүнд:

Нэгд. Хэвлэл мэдээллийн салбарт төр нь агаарын долгионыг ашиглан өргөн нэвтрүүлэг дамжуулахад тусгай зөвшөөрөл олгодог олон улсад тогтсон жишиг байна. Манай улсад Харилцаа холбооны зохицуулах газар

/ХХЗГ/ энэ зохицуулалтыг гүйцэтгэж байна. Чингэхдээ төр тусгай зөвшөөрөл хүсэгчийг тодорхой шаардлага хангасны дараагаар тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тодорхой хяналт тавин ажиллах ёстой. Иймд бие даасан зохицуулах байгууллага болох манай ХХЗГ нь төрийн шууд бус оролцоог ханган Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалан зохицуулах үйл ажиллагаа явуулах ёстой юм.

Хоёрт. Хэвлэл нийтлэлийн салбарын хүрээнд ихэнх оронд бие даасан салбарын зохицуулалт хэрэгждэг байна. Энэ зохицуулалтын үед салбарын мэргэжлийн холбоо нь өөрсдийн санхүүжилтээр, өөрсдийн боловсруулан баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийн хүрээнд хэвлэлийн үйл ажиллагаанд хяналт тавин ажилладаг байна. Энэ хүрээнд:

- Сонины болон хэвлэлийн байгууллагуудын төлөөлөл болсон бие даасан холбоо сэтгүүлчдийн ёс зүйн дүрмийн дагуу хяналт тавьж, шийдвэр гаргах эрх мэдэлтэй байдаг.
- Мэргэжлийн холбооны /зөвлөлийн шийдвэрээр холбооны гишүүнчлэлээс хасах, олон нийтэд хандан залруулга хийх, уучлал хүсэх, мэдэгдэл хийх зэрэг арга хэмжээ авдаг.

Энэ зохицуулалтыг тухайн салбар бие даан

¹¹ <https://old.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>



зохицуулдаг бөгөөд төрийн оролцооноос ангид байдаг. Мэдээлэл технологийн хөгжилтэй холбоотойгоор сонин, сэтгүүлийн мэргэжлийн холбоонууд цахим байдлаар түгээгдэж байгаа мэдээ мэдээллийг ч хянах боломжтой болсон. Ингэхдээ ихэнх оронд интернэтийн үйлчилгээ үзүүлэгч болон холбогдох сонин сэтгүүлийн холбоо хамтран ажиллах хэлбэрээр ажиллах болсон байна.

Гуравт. Хамтын зохицуулалтын үед төр, хувийн хэвшил хамтран холбогдох үйл ажиллагааг зохицуулна.

Олон улсын туршлагаас үзэхэд энэ зохицуулалтын үед хувийн институцийн үйл ажиллагааг төрийн зохицуулалттай хослуулж чадсан байх ёстой байна. Хувийн байгууллага нь Харилцаа холбооны зохицуулах газартай хамтран ажиллах бөгөөд гаргасан шийдвэрийг дагахгүй байгаа тохиолдолд байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авдаг байна. Манайд хэрэгжүүлэх бүрэн боломжтой хамтын ажиллагаа юм.

Сэтгүүл зүйг ямар байр сууринаас харж хөгжүүлэх талаарх үзэл баримтлал үгүйлэгдэж байгаа манай улсын хувьд гадаадын улс орны туршлага, сургамжийг бодит нөхцөл байдалдаа тохируулан бодлогодоо тусган хэрэглэх нь асуудлыг шийдэх нэг гарц мөн. Тухайлбал:

1. Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байлгах, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна гэсэн төр, иргэний хамтын ажиллагааны зарчмын үүднээс хандвал:

- Францад хэвлэл мэдээллийн байгууллагуудыг үндэсний соёл, хэл, ёс заншлыг түгээгч, дэлгэрүүлэгч гэж үздэг байна. Ийм чиглэл баримталсан үзэл баримтлал нь манай хууль тогтоомжид хэл, соёл, ёс заншлыг хамгаалах тухай заасан заалтуудтай нийцэхийн зэрэгцээ

монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа болсон үндэсний түүх, хэл, соёл өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна. Түүнчлэн “Үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орны хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой” гэсэн үзэл баримтлалын заалтыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой².

2. Хэвлэл мэдээллийн салбарт төрөөс дэмжлэг үзүүлэх нь эдийн засаг, нийгэм, соёл урлагийн чиглэлээр эерэг үр нөлөөтэйгөөс гадна олон ургалч үзлийг дэмжин зах зээлийн гажуудлыг арилгах арга замд тооцогддог. Эрх зүйн үндэслэл нь улс орны Үндсэн хуулийн үзэл баримтлалд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон ургалч үзлийг дэмжих, цөөнхийн эрх ашгийг хамгаалах байдлаар тусгагдсан байдаг. Тиймээс төрөөс дэмжлэг үзүүлэх нь хараат бус сэтгүүл зүйг хөгжүүлэх, олон нийтэд өргөн хүрээний мэдээлэлтэй танилцах эрхийг нь хангахад чиглэгддэгийг үндэс болговол:

- АНУ–д хэвлэл мэдээллийн хэрэгслийг “бизнес хийх нэг арга” гэж үзэн хэвлэл мэдээллийн салбар дахь татаас, эзэмшил, өрсөлдөөний зэрэг асуудлаар тусдаа бодлого хэрэгжүүлдэг байна.
- БНСУ–д хэвлэл мэдээллийн салбар дахь үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, зөвхөн дотоодын эзэмшлийг зөвшөөрөн, гадаадын эзэмшилд хязгаарлалт тавьдаг.

Олон улсад дараах төрлийн дэмжлэг, татаасны хэлбэрүүд байдгаас сонголт хийх боломж байна. Үүнд:

- Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг шууд санхүүжүүлэх;
- Хувийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг шууд бусаар санхүүжүүлэх (ихэвчлэн янз бүрийн татвараас чөлөөлөх,

² ЯАБҮБ–ын 3.6.1.1 дэх хэсэг <https://old.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>

хөнгөлөлт үзүүлэх замаар);

- Хувийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг шууд санхүүжүүлэх, дэмжих;
- Хэвлэл мэдээллийн салбарт шинээр үүсэж буй цахим үйлчилгээнд төрөөс дэмжлэг үзүүлэх.

3. Харин Их Британид зах зээлд тулгуурласан шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нь нэн тэргүүний асуудал байдаг учраас Аж ахуйн нэгжийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Харилцаа холбооны тухай хуульд бодлогын асуудлыг тусгасан байна.

Дараагийн чухал асуудал бол хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангах явдал юм. Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг баталгаажуулах дараах шаардлагуудыг хангах нэгдсэн бодлого, эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь сэтгүүл зүйд нэн тулгамдсан асуудал гэж үзэж байна Үүнд:

- Сэтгүүл зүйн агуулга түгээдэг мэдээллийн байгууллагын эзэмшил харьяаллын бүтэц нь олон түмэнд ил тод нээлттэй байх ёстой бөгөөд үүнд гадаадын хөрөнгө оруулалт бүхий байгууллага нэгэн ижил багтаж байх;
- Редакцын хараат бус байдлыг баталгаажуулах зорилгоор хэвлэл мэдээллийн удирдах дээд байгууллага болон сэтгүүлч, редакцын ажилтнууд дагаж мөрдөх сэтгүүлзүйн нийтлэг зарчмуудыг тохиролцсон байх;
- Улс төрийн байгууллагад албан ёсны харьяалал бүхий хэвлэл мэдээллийн хэрэгсэл байвал харьяаллаа ил тод зарлах.

Чөлөөт хэвлэлийн туршлага бага, газар нутаг өргөн уудам, хүн амын нягтрал бага манай орны хувьд чөлөөт хэвлэлийн хараат бус байдлын шалгуурыг дараах байдлаар тодорхойлж болохыг судалгаагаар тогтоосон. Үүнд:

1. Төр засгаас хараат бус байх;
2. Эдийн засаг, санхүүгийн хувьд хараат бус байх;

3. Мэдээллийн хэрэгсэл иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй солилцох индэр нь байж чадаж байх;

4. Редакц болон сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагааны хараат бус байдал хангагдаж байх.

Хэвлэл мэдээллийн хараат бус байдлын шалгуурын дотор дэд шалгууруудыг боловсруулахад Чөлөөт хэвлэлийн харти, Ардчилсан хэвлэл мэдээллийн соёлын тунхаг, Чөлөөт хэвлэлийн 10 номлол, Виндхукийн тунхаглал зэргийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай. Чингэхдээ хэвлэлийн эрх чөлөө бол ардчилсан нийгэмд хүний эдлэх ёстой тулгуур эрхийн нэг бөгөөд нийгэмд гүйцэтгэх үүрэг, олон нийтийн үнэнийг мэдэх эрх ашгийг хамгаалдагаараа хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн өмнө онцгой хариуцлага хүлээдгийг байнга харгалзан үзэх ёстой.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Хүүхдийн эрхийн тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Зохиогчийн эрхийн тухай зэрэг хуулиудад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор тогтоосон агуулгын хязгаарлалтуудад нэр томъёоны тодорхойлолтыг шинээр оруулах нь зүйтэй байна. Энэ нь тухайн заалтад хамрах хүрээг тодорхой болгож, нийгмийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шүүмжлэл өрнүүлсэн сэтгүүлчдийн эсрэг хуулийн заалтыг буруу хэрэглэх эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой байна.

Сэтгүүлчийн хараат бус байдалд нөлөөлдөг гадаад болон дотоод хэд хэдэн хүчин зүйл байдаг бөгөөд үүнд сэтгүүлчийн мэдээлэл хайх, боловсруулах, түгээх бүхий л үйл ажиллагаанд хамааралтай эрх, үүнд, сэтгүүлчийн эрэн сурвалжлах үйл ажиллагааны эрх зүйн хамгаалалт, төрийн байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах эрх, эх сурвалжаа нууцлах эрхийн хамгаалалт, редакцын хараат



бус байдал зэрэг бүлэг асуудлууд багтдаг.

Сэтгүүлчийн хараат бус байдлыг “сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад хэн нэгнээс хараат бус байж, олон нийтийн мэдэх эрхэд шударгаар үйлчлэх таатай орчин” гэж хэлж болох бөгөөд харин үүний эсрэг дараах төрлийн хараат байдал сэтгүүлчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байдаг. Үүнд:

1. Улс төрийн хараат байдал
2. Эдийн засгийн хараат байдал
3. Редакцын хараат байдал.

Хэдийгээр нэлээдгүй улс орон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төрөөс тавих хяналтыг багасгаж, хуулиар хориглосон ч тухайн мэдээллийн агуулга, зорилгыг харгалзан тодорхой хязгаарлалтыг хийж байна. Аливаа улс орны хуулиар доорх хязгаарлалтыг тодорхой хэмжээний хүрээнд хийхийг зөвшөөрдөг. Иймд доорх хязгаарлалтуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

- Ёс суртахууны хязгаарлалт буюу олон нийт, иргэдэд хүргэхэд ёс зүйн хувьд тохиромжгүй мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэхийг хориглох. Ийм хязгаарлалт нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг хязгаарлан, дайсагнал, ялгаварлан гадуурхах үзэл, үзэн ядалтыг сурталчилсан, дэмжсэн сурталчилгаа, мэдээллийг таслан зогсоох, саармагжуулах чадавхыг бий болгож, үл зөвшөөрөх сэтгэхүйг нийгэмд төлөвшүүлэх талаарх үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын зорилтыг сэтгүүл зүйн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх ач холбогдолтой байх болно.
- Батлан хамгаалахын хязгаарлалт буюу аливаа улс орны батлан хамгаалах, цэрэг цагдаагийн хүчин чадалтай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, түгээхийг улсын аюулгүй байдлын үүднээс хориглодог. Ийм хязгаарлалтыг манай сэтгүүл зүйн бодлого, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх нь үндэсний аюулгүй

байдлын үзэл баримтлалын “Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна.” гэсэн үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим болон “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэсэн зорилтыг хангахад чухал ач холбогдолтой юм. Үүний зэрэгцээ иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байлгах, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарах үүргээ сэтгүүл зүйн бодлого, үйл ажиллагаатай цогцоор биелүүлэх боломж бүрдүүлнэ.

- Улс төрийн хязгаарлалт буюу ард иргэдийн дунд үймээн самуун дэгдээх, улс төрийн тогтворгүй байдал бий болгохгүйн үүднээс аливаа сөрөг, ташаа мэдээллийг нийтэд хүргэхийг хориглодог.
- Шашны хязгаарлалт буюу тухайн улс оронд зэрэгцэн оршин тогтнож буй аливаа шашны үнэ цэн, тэнцвэрт байдлыг хадгалах үүднээс хэт нэг талыг барьсан, бусад шашны холбогдолтой сөрөг мэдээллийг нийтлэхийг хориглох. Ийм хязгаарлалт Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал эрхийг нь хязгаарлаж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байх ёстой. Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гаднын шашин, соёл, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хязгаарлана гэсэн



зорилттой зөрчилдөхгүй нийцнэ гэж үзэж байна.

Харин дээр дурдсанаас давсан хязгаар хийсэн тохиолдолд улс төрийн хараат байдал тодорхой хэмжээнд бий болно гэж үздэг болохыг анхаарах шаардлагатай юм.

Ардчилсан бусад орны туршлагаас харахад хяналт/цензур/–ыг хориглохын зэрэгцээ хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд төрийн зүгээс нөлөөлөхийг хуулиар хориглодог байна.

Дүгнэлт. Нийгмийн сүлжээ хүмүүсийн мэдээлэл авах, түгээх гол хэлбэр, хэрэглээ болсон өнөө цагт олон нийтийн анхаарлыг татах, хандалтыг өсгөх арилжааны зорилгод сэтгүүл зүйн ёс зүй, хариуцлагын асуудал бүрхэг, тэргүүлэх үнэлэмжийн түвшинд үнэлэгдэхгүй хэвээр байна. Өөрөөр хэлбэл, олон нийтийн оролцоо, итгэл үнэмшил, мэдээллийн эрэлт хэрэгцээг ёс зүйт, үнэн бодит сэтгүүл зүйн төлөвшил, нэр хүнд, эрхэмлэлийн түвшинд хөгжүүлж чадаагүй байна. Төр засгаас хараат бус, бие даасан байх сэтгүүл зүйн үндсэн хэм хэмжээ болох өөрийн зохицуулалтын тогтолцоо Монголын сэтгүүл зүйд бодит зүйл болж төлөвшөөгүй байна. Тиймээс ч сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүл зүйн салбарын аль ч түвшинд өөрийн нэгдсэн бодлого зохицуулалт, мөрдлөг, нөлөө үгүйлэгдсээр байгааг боловсрол, нийгмийн

байр суурь, идэвх оролцоо өндөр уншигч, үзэгчдийн шүүмжлэл нотолж байна.

Аюулгүй байдлын орчны хурдацтай өөрчлөлттэй уялдуулан хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчинг яаралтай бүрдүүлэхийг цаг хугацаа шаардаж байна.

Хэвлэл мэдээллийн салбарын хараат бус байдлыг хангахын тулд хуульд эзэмшил харьяаллын асуудлыг нарийн тусгаж өгөх нь зүйтэй. Ингэснээр нэгд. төрийн зүгээс, хоёрт. редакцын зүгээс, гуравт. санхүүгийн хувьд хараат бус байдал хангагдах учиртай.

Хуульд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор тогтоосон агуулгын хязгаарлалтуудад нэр томъёоны тодорхойлолтыг шинээр оруулахыг санал болгосон. Энэ нь тухайн заалтад хамрах хүрээг тодорхой болгож, нийгмийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шүүмжлэл өрнүүлсэн сэтгүүлчдийн эсрэг хуулийн заалтыг буруу хэрэглэх эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой юм.

Сэтгүүлчдийн боловсролын талаар нэгдсэн бодлоготой болох, сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг чанд сахиулах шаардлагатай гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Сэтгүүлч хүн өргөн мэдлэгтэй, олон эх сурвалжаас (гадаад хэл дээр) мэдээлэл олж авах чадвартай, олж авсан мэдээлэл дээрээ боловсруулалт сайн хийж, нийгэмд тулгамдсан, шийдлээ хүлээсэн асуудлыг гаргаж ирж чадна.

Ашигласан материал:

1. <https://old.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>
2. Монгол Улсын аюулгүй байдлын үзэл баримтлал



ГАДААДЫН БАНК ГЕОПОЛИТИКИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ

Ц.ЗАНДАН /УБХИС-ийн докторант/

Түлхүүр үг: Хөрөнгө оруулалтын банк, хөгжлийн банк, арилжааны банк, геополитикийн ээвсэг, санхүүгийн эрсдэл

Key words: Investment bank, development bank, commercial bank, geopolitical weapons, financial risk Civilization, patriotism, national traditions, heritage, youth development

Оршил. Их гүрнүүд нөлөөллийн хүрээгээ тэлэхийн төлөөх геополитикийн тэмцэлдээ дипломатын, мэдээллийн, цэргийн болон эдийн засгийн салбарыг ашиглаж байна. Цогц дайны стратеги гэж хэлж болохуйц уг (Дипломат, Мэдээллийн, Цэргийн, Эдийн засгийн) стратеги¹-ийн хүрээнд аливаа улс өөрийн давуу талаа ашиглан өрсөлдөгч оронд нөлөөлдөг. Үүнээс эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх асуудал нь төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө, өр, зээлийг тойрсон өргөн цар хүрээтэй.

Их гүрнүүдийн зүгээс эдийн засгаараа дамжуулан нөлөөллөө тогтоох зорилго нь *нэгд.* дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ дээр өрсөлдөхүйц давуу талтай улс орон болох; *хоёрт.* бүс нутгийн хэмжээнд капиталыг удирдах; *гуравт.* хөрөнгөөр дамжуулан улс төрийн бодлогоо хэрэгжүүлдэг орон болох юм. Эл зорилгыг биелүүлэхэд банкны салбар чухал үүрэгтэй. Иймээс улс гүрнүүд геополитикийн давуу байдлаа бататгахын тулд банкуудыг ил болон далд байдлаар зэвсэг болгон ашигладаг. Энэ ч утгаараа эдийн засгийн аюулгүй байдлын төлөөх өрсөлдөөнд мөнгийг дарь гэж үзвэл банкуудыг ТАНК мэтээр зүйрлэдэг².

Банкны төрөл, онцлог.

Банкуудыг үйл ажиллагааны хувьд төв банк, хөрөнгө оруулалтын банк, хөгжлийн банк, арилжааны банк гэж 4 ангилдаг. Эдгээр нь нийгэм, эдийн засагт гүйцэтгэдэг

үүргээрээ ялгаатай санхүүгийн үйлчилгээний байгууллагууд юм.

Арилжааны банк нь иргэд, аж ахуйн нэгжид данс нээх, төлбөр тооцоог хийх, хадгаламж, зээл зэрэг өргөн хүрээний санхүүгийн үйлчилгээг үзүүлдэг.

Хөрөнгө оруулалтын банк нь бизнес болон засгийн газарт хөрөнгө босгох, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө удирдах чиглэлээр мэргэшсэн илүү томоохон харилцагчтай институт юм. Хөрөнгө оруулалтын банк томоохон корпорацууд болон засгийн газарт санхүүгийн эрсдэлээ удирдахад тусалж компаниудыг нэгтгэх, худалдан авах, хувьцаат компани болгох зэрэг үйл ажиллагааг хийдэг.

Хөгжлийн банкны хувьд ихэвчлэн мега хэмжээний эдийн засаг болон нийгмийн шинж чанартай, урт хугацаандаа макро түвшинд үр өгөөжөө өгөх төслүүдийг олон улсын болон засгийн газрын эх үүсвэрээр санхүүжүүлдэг ашгийн гэхээс илүү бодлогын санхүүжүүлэгч байгууллага байдаг.

Хүснэгт 1.

Банкны төрөл

Онцлог	Арилжааны банк	Хөрөнгө оруулалтын банк	Хөгжлийн банк
Гол хэрэг-лэгчид	Хувь хүн, аж ахуйн нэгжүүд	Томоохон аж ахуйн нэгжүүд, Засгийн газар	Томоохон аж ахуйн нэгжүүд, Засгийн газар

¹ Banks, Not Tanks: Using Money as a Geopolitical Tool, Nikolas Gvosdev is the Director of the National Security Program at the Foreign Policy Research Institute (FPRI), 2016, <https://www.fpri.org/article/2016/05/banks-not-tanks-using-money-geopolitical-tool/>

² https://www.iatp.org/sites/default/files/2015_06_05_TTIP_GeoPolitics_SS.pdf



Үндсэн үйлчилгээ	Хадгаламж, зээл, төлбөр тооцоо	Хөрөнгө босгох, хөрөнгө оруулах, эрсдэлийн удирдлага, нэгтгэх-худалдан авах	Хөрөнгө оруулалт, бага хүүтэй зээл, буцалтгүй тусламж
Үйл ажиллагааны загвар	Зээлийн хүү, шимтгэлийн орлого	Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, шимтгэл, арилжаанаас орлого бий болгох	Хөгжлийн томоохон төслүүдийг дэмжих

Дээрх банкнуудаас геополитикийн арга хэрэгсэлд арилжааны банкнаас илүүтэйгээр хөрөнгө оруулалтын болон хөгжлийн банкныг ашигладаг. Чухамдаа эл төрлийн том банкны институт аливаа бусад улсын санхүүгийн салбарт байр сууриа эзлэх, капиталаараа хөшүүрэгдэн бодлогоо хэрэгжүүлэхэд нь их гүрнүүдэд тусалдаг.


Банкны салбар дахь их гүрнүүдийн манлайлал. Хүйтэн дайны дараа банк, санхүүгийн салбарын даяаршил нэмэгдэж, хөгжиж буй орнууд дахь гадаадын банкны оролцоо, нөлөө өссөн.

Өндөр хөгжилтэй орны банк нь хөгжиж буй орны дотоодын банкуудтай харьцуулахад үйл ажиллагааны зардал бага, хүний нөөцийн өндөр чадавхтай, их активтай, засаглал сайн, ашиг өндөр байдаг. Энэ давуу тал хувийн болон төрийн өмчит банкинд хоёуланд нь хамаатай ажээ³. Ийм учраас их гүрнүүдийн банк хөгжингүй болон хөгжиж буй оронд үйл ажиллагаа явуулах нь зөвхөн бодлогоос гадна бизнесийн ашиг талаасаа ч ихээхэн өгөөжтэй байдаг.

Арилжааны банк болон хөрөнгө оруулалтын

банкны салбар дахь дэлхийн хамгийн хүчирхэг гүрнүүдийн жагсаалтад барууны орнуудаас АНУ, ЕХ, Их Британи нэрлэгдэх бол дорнодоос БНХАУ, Япон улсын нэр тодордог. Тодруулбал дэлхийн их гүрнүүдийн банкны активын чанар, эрсдэл шингээх чадвар, үйл ажиллагааны үр ашиг, орлогын бүтэц, бизнесийн бүтцээр эрэмбэлэхэд АНУ 23 оноо авч, банкны салбарын хамгийн сайн үзүүлэлттэй орноор шалгарсан. Харин БНХАУ, Их Британи нийлбэр дүнгээр 18 оноогоор удаалсан бол ЕХ 17.5 оноогоор дөрөвдүгээр байрт бичигдэж байна. Японы банкны салбар дээрх 4 улстай харьцуулахад хэмжээ, үр ашиг харьцангуй бага байх тул топ 5-д эрэмбэлэгддэг⁴.

Дэлхий дээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт банкнууд дахь бэлэн активын хэмжээ 2023 онд 12.1 их наяд ам.доллараар хэмжигдэж байсан бол энэ үзүүлэлт 2026 он гэхэд 13.1 их наяд ам.долларт хүрэх төлөвтэй байна⁵. Дээрх 3 төрлийн банкны активын дийлэнх хэсэг их гүрнүүдэд байрлах ба 2021 онд БНХАУ 4.2 тэрбум ам.долларын дансны активаараа тэргүүлж байсан бол *хоёрт*, Япон, *гуравт*, АНУ, *дөрөвт*, Швейцар улс тус тус оржээ. Эдгээр



1 дүгээр. Дэлхийн банкуудын чадавхын талаарх матрикс

³ Foreign Banks in Poor Countries: Theory and Evidence, Enrica Detragiache, International Monetary Fund, 7THJACQUES POLAKANNUALRESEARCHCONFERENCE NOVEMBER9-10, 2006

⁴ Global Banking Industry Outlook, Institute of International Finance, Bank of China, Chen Weidong, 2018

⁵ Forecast: Global Number of Transferable Deposits Accounts Held by Banks, <https://www.reportlinker.com/dataset/fd5e7a6a139e30d6fa6edbe24f58d56eb9a1b8af>



орны хувьд банкны салбарын хөгжил нь эдийн засгийн өсөлтийн өнгийг тодорхойлж байгаа бол олон улсын харилцаа талаасаа бусад орнуудад асар их нөлөөтэй болохыг илтгэнэ.

Банкны салбарыг нээлттэй болгосны үр дагавар. Улс орнууд эдийн засгийн харилцааны даяаршил зонхилсон өнөөгийн олон улсын харилцааны тогтолцоонд хилийн чанадаас хямд эх үүсвэртэй капиталыг татах явдал энгийн үзэгдэл болсон. Ялангуяа 1990–ээд оны сүүлч, 2000–аад оны эхэн үеэр гадаадын банкны хөрөнгө оруулалтын идэвхжилт дэлхийн өнцөг булан бүрд маш хурдан өрнөжээ. Энэ нь нэг талаас Зүүн Европ тэргүүтэй пост коммунист орнууд эдийн засгаа нээлттэй болгосон, нөгөө талаас Зүүн Азийн орнуудад эдийн засгийн либералчлал явагдаж, үйлдвэржилт эрчимжсэнээс шалтгаалсан шинэчлэлийн давлгааны тусгал байсан гэж үздэг.

1995–2009 онуудад өндөр хөгжилтэй, аж үйлдвэржсэн орнуудад гадаадын банкны тоо 40 гаруй хувиар өссөн бол хөгжиж буй орнуудад 72 хувиар өссөн байна. 1995 он гэхэд ердөө 19 улс гадаадын банкинд зөвшөөрөл олгодоггүй байсан бол 2009 онд 11 улс (Куба, Этиоп, Гаити, Исланд, Иран, Ливи, Оман, Катар, Саудын Араб, Шри Ланка, Йемен) гадаадын банкгүй хоцорсон байжээ⁶. Харин өдгөө гадаадын банк ажиллуулахыг хориглосон цөөхөн улс, тухайлбал Куба, Иран, Хойд Солонгос, Сири зэрэг улсуудын нэрс гарч ирж байна.

Цаашид гадаадын банкиг өөрийн улсдаа үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох замаар эдийн засгийн өсөлтөд зайлшгүй шаардлагатай хямд эх үүсвэр татах явдал ихсэх хандлагатай байна. Учир нь чөлөөт эдийн засагтай, үйлдвэржсэн орнууд гадаадын хөгжлийн, хөрөнгө оруулалтын, арилжааны банктай хамтран ажиллаж, дэд бүтцийн хөгжлийн мега төслүүдээс эхлээд жижиг дунд бизнесийн орчин дахь санхүүжилтийг өргөжүүлдэг.

Хөгжиж буй орнууд санхүүгийн салбартаа гадаадын банкиг оруулж ирснээр зээлийн хүүг бууруулах, гадаад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, валютын ханшийг тогтворжуулах, өндөр хөгжсөн финтек технологийг нэвтрүүлэх, салбарын хөгжлийг сайжруулах зэрэг олон давуу талыг авчирдаг⁷ байна.

Хэдийгээр гадаадын банкны үйл ажиллагаанд дэлхийн бараг бүх улсууд нээлттэй хандаж, хамтран ажиллах замаар эдийн засгийн өсөлтөө хурдасгаж байгаа боловч гагцхүү хөшигний цаана гадаадын банкнаас ирэх эрсдэлийг нарийн тооцоолж, өөрийн орны салбартай тааруулан эрсдэлийг ихээс бага түвшинд байнга тохируулдаг ажээ. Ингэхдээ бодлого тодорхойлогчид ямар улсын, ямар төрлийн банк, ямар нөхцөлтэй байх, дотоодын санхүүгийн салбарын хөгжилд хэр их хэмжээнд хувь нэмэр оруулах, гадаадын банкууд хүлээн авагч орны банкны системд үзүүлэх цочролыг хэрхэн бууруулах, хөрөнгө оруулалтын банкны аль салбарт чөлөөтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлэх эсэх, активт тавигдах шаардлага, өрсөлдөөнийг тэнцвэржүүлэх арга хэрэгслүүд зэргийг маш сайн, өргөн хүрээнд судалдаг.

Ийнхүү эрсдэлийн цогц судалгаа хийх үндэс нь эдийн засгийн аюулгүй байдал төдийгүй улс орны үндэсний аюулгүй байдалтай холбоотой юм.

Банкаар дамжуулж геополитикийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх нь. Аливаа улсад хөрөнгө оруулалтын банкны өргөн хүрээний нөөцтэй капиталыг бий болгож эргэлдүүлснээр геополитикийн ашиг сонирхлоо олон янзаар хэрэгжүүлэхэд ашиглагдаж болохуйц нөхцөл байдлыг бий болгодог.

Дэлхийн II дайны төгсгөлд байгуулагдсан Бреттон Вудсын гэрээнээс эхлэлтэй гэж хэлж болохуйц санхүүгийн үйлчилгээгээр дамжуулж банкиг олон улсын харилцаанд геополитикийн зэвсэг болгон ашиглах явдлууд гарч эхэлсэн.

⁶ Foreign Banks: Trends, Impact and, Financial Stability, Stijn Claessens and Neeltje van Horen, 2012 International Monetary Fund, 2012

⁷ EBRD working paper No. 170, The dark and bright sides of global banking: a (somewhat) cautionary tale from emerging Europe, Ralph De Haas, 2014



Хамгийн сүүлийн жишээ гэхэд банк, санхүүгийн байгууллагууд санхүүгийн үйлчилгээгээрээ дамжуулан геополитикийн зэвсэг болон ашиглагдах үзэгдэл Украины хямралын үеэр бодитоор харагдах болжээ. Талууд харилцан хөрөнгө оруулалтын банкуудын үйл ажиллагааг зогсох, томоохон төслийн санхүүжилтийг таслах, дайны бондыг гаргах, дайны бондод хөрөнгө оруулалт хийх, худалдан авах, хориг арга хэмжээ авах, хөрөнгийг царцаах, санхүүгийн мессежний үйлчилгээ болох SWIFT-ыг зогсоосон⁸. Харин сөргөлдөгч гүрнүүд үүний эсрэг хариу арга хэмжээг авахдаа банкны салбартаа ам.долларын бус өөр мөнгөн тэмдэгтэд суурилсан төлбөрийн системийг боловсруулах, холбоотныхоо банкны салбарыг дэмжих байдлаар капиталыг нь хамгаалах, хөрөнгө оруулалт хөгжлийн банкны өөр эх үүсвэрийг харилцан тохиролцож том төслийг санхүүжүүлэх зэрэг санал санаачилгуудыг хийсээр байна. Тухайлбал, БРИКС+ орнууд долларыг орлох мөнгөн тэмдэгтийг судлах болсон, ОХУ болон БНХАУ юанийг олон улсын төлбөр тооцоонд ашиглаж байгаа, зарим улсууд SWIFT системээс өөр олон улсын төлбөрийн системийг судалж байгаа, Энэтхэг ОХУ-аас нефтийг ам.доллараас бусад валютаар худалдан авч байгаа, Саудын Араб Бээжинтэй газрын тосны борлуулалтын асуудлыг шийдвэрлэхийн тулд юаниар төлбөр тооцоог хийхээр судалж байгаа, Франц болон БНХАУ-ын хооронд хоёр улсын хил дамнан худалдаагаа юаниар хийх талаар яриа өрнөсөн⁹ зэргийг дурдаж болно.

Нөгөө талаас дэлхийн их гүрнүүд геополитикийн эрсдэлд тулгуурласан гадаадын банкны салбар дахь хяналтаа тогтмол сайжруулах болжээ. Жишээ нь сүүлийн жилүүдэд АНУ болон ЕХ гадаадын

банкинд тавих хяналтаа янз бүрийн түвшинд нэмэгдүүлсээр байна. Тухайлбал, АНУ-д Додд-Фрэнкийн хууль, Волкерын дүрэм, Гадаад дансны татварыг дагаж мөрдөх тухай хууль (FATCA) зэрэг тус улсад үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагуудад зориулсан хэд хэдэн зохицуулалтын бодлогыг нэвтрүүлсэн. Ингэснээр АНУ-ын зах зээлд нэвтрэх гадаадын банкны хөрөнгө, хөрвөх чадвар, зохион байгуулалтын бүтцэд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт чангарсан юм. Мөн адил ЕХ-ны зүгээс Капиталын шаардлагын дүрмийг шинэчилж, Европ дахь гадаадын банкуудын салбаруудыг охин компани хэлбэрээр нээхийг шаардах болсон¹⁰. Энэ бүгд их гүрнүүд банкны салбарыг геополитикийн зэвсэг болгож буй бодит жишээнүүд юм.

Банкнудаас ирж болох эрсдэлүүд. Их гүрнүүд онолын хувьд банкныг олон чиглэлээр геополитикийн ашиг сонирхолдоо нийцүүлэн ашиглах боломжтой. Улс орнууд гадаадын банкнаас ирж болох эрсдэлийг урьдчилан харж, стратегиа боловсруулдаг. Гадаадын банкнудаас ирж болох эрсдэлүүд нь:

- *Зах зээлийг нөлөөндөө оруулах зээлийн урхи.* Хэрэв гадаадын арилжааны банк тухайн орны чухал салбарт зээл олгохдоо хүлээн авагчийг зээлийн шаардлага хангаагүй, муу зээлдэгч гэдгийг мэдсээр байж үл хайхарч хөрөнгө оруулбал макро түвшинд санхүүгийн тогтвортой байдал эрсдэлд ордог. Учир нь эдийн засгийн чухал салбар муу зээлдэгч болж, өрийн дарамтад орсноор тэр чигтээ зах зээлээс “арчигдах” бодит эрсдэл үүсдэг¹¹. Эл төрлийн эрсдэлд төрийн өмчит арилжааны болон хөрөнгө оруулалтын банкууд илүү стратегийн шинж чанартай үйл ажиллагаа явуулах хандлагатай байдаг. Энэ нь

⁸ Steering a bank through geopolitical rapids, 12 January, 2023, Derek Leatherdale, London Institute of Banking and Finance, <https://www.libf.ac.uk/news-and-insights/news/detail/2023/01/12/steering-a-bank-through-geopolitical-rapids>

⁹ <https://www.swanglobalinvestments.com/geopolitical-risk-long-dormant-threat-awakens/>

¹⁰ Global Banking Industry Outlook, Institute of International Finance, Bank of China, Chen Weidong, 2018

¹¹ See China to Buy Stake in Another Troubled Regional Bank: Report, BUS. TIMES (Aug. 9, 2019), <https://www.businesstimes.com.sg/banking-finance/china-to-buy-stake-in-another-troubled-regional-bank-report>



хөрөнгө оруулалт татаж буй зээлдэгчид зээлийн шаардлага хангаагүй байсан ч тодорхой зорилгын хүрээнд зээл олгох шийдвэр гаргаж байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл, төрийн өмчийн банкууд тухайн хөрөнгө оруулалтаас хүлээж болох том хэмжээний алдагдлыг үл тоон Засгийн газрынхаа ашиг сонирхлын төлөө золиослох чадамжтай байдаг¹².

- *Чоно сүргийн хөрөнгө оруулалт.* “А” улсын хөрөнгө оруулалтын банк эсвэл томоохон сангууд өрсөлдөгч “Б” орны компанийг худалдан авч нийлүүлж, салгах замаар хүчтэй компаниудыг задлах, хувьцааг авах, улмаар салбарыг өөрсдийн орноосоо хамааралтай болгох эрсдэлийг Чоно сүргийн хөрөнгө оруулалт гэж нэрлэдэг. Тус стратегийг ихэвчлэн өрсөлдөгчийнхөө үйлдвэр, технологийн салбарыг дотроос нь задлах зорилгоор ашигладаг байна¹³. Үүний эсрэг зарим улс банкны хөрөнгө оруулах салбарыг урьдаас тодорхойлж, зохицуулалт хийж өгсөн байдаг.
- *Хориг арга хэмжээ.* “А” орон “Б” орны эдийн засгийн чухал төсөлд урт хугацааны хөрөнгө оруулалт хийн санхүүжүүлж эхэлсний дараа геополитикийн хүсэл сонирхолдоо нийцүүлэх шахалтыг үзүүлэх, хямд эх үүсвэртэй санхүүгийн үйлчилгээнд нэвтрэх эрхийг хаах зэрэг хориг арга хэмжээг авч болзошгүй байдаг. Энэ нь тухайн улсад хөгжлийн томоохон төслүүдээ үргэлжлүүлэх ажлыг доголдуулж, эдийн засгийн тогтвортой байдал садаа болдог.
- *Хар жагсаалт.* “А” орон “Б” орны томоохон төслийг будлиантуулах замаар тухайн улс болон төслийг олон улсын хөрөнгийн зах зээлийн хар жагсаалтад оруулж гацаах эрсдэлтэй. Мөн цаашлаад тухайн улс

орны эдийн засагт нөлөө бүхий бизнесмен болон аж ахуйн нэгжүүдийг дэлхийн санхүүгийн системээс тусгаарлах аргаар тухайн орны санхүүгийн аюулгүй байдалд хүндрэл учруулах эрсдэлтэй бадаг.

- *Холбоотнууддаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх.* “А” орон өрсөлдөгч “Б” орны эсрэг өөрийн холбоотны шаардлагатай дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулах, хориг арга хэмжээнд орсон тохиолдолд шаардлагатай санхүүгийн үйлчилгээг нээж өгөх, дайн хийж байгаа бол олон улсын зах зээлээс дайны бондын санхүүжилтийг хөрөнгө оруулалтын банкаараа дамжуулах гаргаж өгөх, зэвсэглэлд шаардлагатай санхүүжилтийг хөрөнгө оруулалтын банкаар дамжуулан босгодог.
- *Зохицуулалтын дарамт.* “А” орон өөрийн нөлөө бүхий банкны лоббигор дамжуулан “Б” орны хууль тогтоомж, дүрэм, журмыг өөрчлөхөд шахалт үзүүлдэг. Ингэснээр олон улсын санхүүгийн системээс хөндийрүүлэх, капиталын хувьд өөрсдөөсөө хэт хараат болгох эрсдэлтэй байдаг.

Дүгнэлт. Чөлөөт эдийн засгийн тогтолцоотой улс орон бүр гадаадын банктай хамтран ажиллаж, хөрөнгө оруулалтыг ухаалгаар ашиглах замаар ДНБ-ний өсөлтөө нэмэгдүүлсээр байна. Өдгөө дэлхий дээр цөөн хэдэн улс гадаадын банкны эх үүсвэрийг ашиглахаас татгалзсан хэвээр байгаа ба тэдгээр улсууд тогтолцооны хувьд хаалттай, эдийн засгийн хувьд дорой ажээ. Энэ нь олон улсын байгууллагуудын империк судалгаануудаар батлагдсан “Банк санхүүгийн салбарын глобалчлал хүлээн авагч орны дотоодын эдийн засагт эерэг нөлөөлдөг” гэх дүгнэлтийг баталж байна. Чингэхдээ улс орнууд гадаадын арилжааны, хөрөнгө оруулалтын банк болон

¹² Christopher Balding, China's Banks Have a Hidden Wave of Bad Debt, STRAITS TIMES (Mar. 18, 2019), <https://www.straitstimes.com/business/banking/c-hinas-banks-have-a-hidden-wave-of-bad-debt>

¹³ Joel Slawotsky, Hedge Fund Activism in an Age of Global Collaboration and Financial Innovation: The Need for a Regulatory Update of United States Disclosure Rules, 35 REV. BANKING & FIN. L. 275, 279 (2015)



хөгжлийн банкуудад анхаарал хандуулж, төрөл онцлогийг судалж, эдийн засаг дахь оролцооны түвшин тохируулсаар иржээ. Тус байдалд геополитикийн эрх ашгийн төлөөх их гүрнүүдийн бодлого холбоотой.

Өөрөөр хэлбэл, геополитикийн эгзэгтэй үед дэлхийн улс орнууд санхүүгийн аюулгүй байдалдаа эрсдэлийн удирдлагыг байнга хэрэгжүүлдэг. Эрсдэлийг удирдахдаа гадаадын банкны аль болох төрөлжүүлж, харьяа улс, эзэмшлийн төрөл, үйл ажиллагааны чиглэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбар дахь гадаадын банкны болон дотоодын банкуудын хүчний тэнцвэрийг тогтмол хангаж ажиллахад төвлөрдөг. Нэн ялангуяа их гүрнүүд холбогдох

хууль тогтоомжийн хүрээнд гадаадын банкны дотоодын зах зээл дэх эзлэх активыг тодорхой түвшинд барих, тайланг тогтмол авах, компаниудад оруулж буй хөрөнгө оруулалтын талаар хязгаарлалтуудыг тогтоож өгөх, тодорхой стратегийн салбаруудад зориулсан тусгайлан журам боловсруулах зэрэг арга хэмжээнүүдийг авч байна.

Цаашид улс орнууд санхүүгийн салбараа чөлөөлөхийн хажуугаар гадаадын банкны геополитикийн зэвсэг болон ашиглагдах эрсдэлийг тогтмол үнэлж санхүү, хуулийн аргуудыг хослуулсан харилцан ашиг хүртэхэд анхаарч байна.

Ашигласан материал:

1. Banks, Not Tanks: Using Money as a Geopolitical Tool, Nikolas Gvosdev is the Director of the National Security Program at the Foreign Policy Research Institute (FPRI), 2016, <https://www.fpri.org/article/2016/05/banks-not-tanks-using-money-geopolitical-tool/>
2. https://www.iatp.org/sites/default/files/2015_06_05_TTIP_GeoPolitics_SS.pdf
3. Foreign Banks in Poor Countries: Theory and Evidence, Enrica Detragiache, International Monetary Fund, 7THJACQUESPOLAKANNUALRESEARCHCONFERENCE NOVEMBER9-10,2006
4. Global Banking Industry Outlook, Institute of International Finance, Bank of China, Chen Weidong, 2018
5. Forecast: Global Number of Transferable Deposits Accounts Held by Banks, <https://www.reportlinker.com/dataset/fd5e7a6a139e30d6fa6edbe24f58d56eb9a1b8af>
6. Foreign Banks: Trends, Impact and, Financial Stability, Stijn Claessens and Neeltje van Horen, 2012 International Monetary Fund, 2012
7. EBRD working paper No. 170, The dark and bright sides of global banking: a (somewhat) cautionary tale from emerging Europe, Ralph De Haas, 2014
8. Steering a bank through geopolitical rapids, 12 January, 2023, Derek Leatherdale, London Institute of Banking and Finance, <https://www.libf.ac.uk/news-and-insights/news/detail/2023/01/12/steering-a-bank-through-geopolitical-rapids>
9. <https://www.swanglobalinvestments.com/geopolitical-risk-long-dormant-threat-awakens/>
10. Global Banking Industry Outlook, Institute of International Finance, Bank of China, Chen Weidong, 2018
11. See China to Buy Stake in Another Troubled Regional Bank: Report, BUS. TIMES (Aug. 9, 2019), <https://www.businesstimes.com.sg/banking-finance/china-to-buy-stake-in-another-troubled-regional-bank-report>
12. Christopher Balding, China's Banks Have a Hidden Wave of Bad Debt, STRAITS TIMES (Mar. 18, 2019), <https://www.straitstimes.com/business/banking/chinas-banks-have-a-hidden-wave-of-bad-debt>
13. Joel Slawotsky, Hedge Fund Activism in an Age of Global Collaboration and Financial Innovation: The Need for a Regulatory Update of United States Disclosure Rules, 35 REV. BANKING & FIN. L. 275, 279 (2015)

ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДЛУУД

П.ЦЭДЭВ /Доктор (Ph.D) профессор/

З.БАТГЭРЭЛ /ҮБХИС-ийн магистрант, дэд хурандаа/

Түлхүүр үг: Хүн, Аюулгүй, Байдал, Аюул, Занал, Хэрэгцээ

Key words: Man, sefy, situation, danger, offer, need

Оршил. Хүний аюулгүй байдал хэмээх ойлголтыг 1994 оны НҮБ-ын Хүний хөгжлийн (НҮБХХ) хөтөлбөрийн тайланд дурьдсанаар "хүний аюулгүй байдал гэдгийг тайлбарлахдаа дарангуйлал, хэлмэгдүүлэлт өвчин эмгэг, өлсгөлөн зэрэг аюулаас юун түрүүнд хамгаалагдсан байх явдал юм" гээд "орон гэр, ажлын байр, нийгмийн харилцааны алинд ч байсан хүний өдөр тутмын амьдралын хэв маягт гэнэтийн болон ноцтой, сүйрлээс хамгаалагдсан байхыг хэлнэ"¹ гэж заасан байна.

Мөн тайланд анх удаа хүний аюулгүй байдлын тодорхойлолт тусгагдаж, хүний аюулгүй байдлыг "айдас, амьжиргааны наад захын хомсдолоос ангижрах гэсэн хоёр үндсэн эрхийг хангах явдал" гэж тодорхойлсон бөгөөд "Байгаль орчны аюулгүй байдал" нь хүний аюулгүй байдлын тодорхойлолтын үндсэн бүрэлдэхүүн хэсэг гэж онцлон тэмдэглэсэн байна². Энэ үеэс хойш энэ ойлголт олон улсад эрчимтэй гарч ирж, 2001 онд "Хүний аюулгүй байдлын комисс" байгуулагдсан.

"Хүний аюулгүй байдал" нь дэлхий нийтийн энх тайван, хөгжил ба дипломат үзэл баримтлалын асуудалд томоохон орон зай эзэлдэг сэдэв хэдий ч ойлголтын тодорхой бус байдлаас шалтгаалан ихэнхдээ олон шүүмжлэл дагуулдаг. НҮБ-н Ерөнхий Ассамблей 2012 онд Хүний аюулгүй байдлын тухай нийтлэг ойлголтод хүрч, 9 дүгээр сарын 10-нд батлагдсан НҮБ-н A/RES/66/290-р тогтоолдоо хүний аюулгүй байдлыг "хүний эрх чөлөөтэй, нэр төртэй, ядуурал болон айдсаас ангид амьдрах эрх" хэмээн илүү өргөн хүрээгээр тодорхойлжээ.

Хүний аюулгүй байдалд учрах аюулын төрлийг бие мах бодийн, амьжиргааны болон нийгмийн тогтолцооны гэж ангилан тэдгээрийн учир шалтгаан, даван туулах хэрэгсэл, хүний аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага зэргийг системтэйгээр судлах нь зүйтэй юм.

Аюул заналын эх үүсвэрийг бие мах бодын, амьжиргааны, нийгмийн тогтолцооны гэж гурван ангилсан нь физик ба химийн шинжлэх ухаан дээр үндэслэгдсэн инженерчлэл, экологийн ба биологийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухаан гэсэн эрдэм шинжилгээний гурван чиглэлийн судалгааны объектуудтай тохирч байна. Хүний аюулгүй байдалд заналхийлэх аюул нь хүний бие махбод, биологи, нийгмийн тал дээр нөлөөлдөг тул янз бүрийн системүүдийн харилцан үйлчлэлийг судлах ёстой байдаг.

Үндсэн хэсэг. Хүний аюулгүй байдал нь харьцангуй шинэ судлагдахуун хэдий ч уг ойлголтыг байгалийн гамшигт хэрхэн ашиглах талаар эрдэмтэд авч үзэж байгаа нь чухал ач холбогдолтой юм. Дэлхий нийтэд хүний аюулгүй байдлын тухай бодлого нь зэвсэгт мөргөлдөөн, хүний эрх зөрчих зэрэг хүнээс үүдэлтэй гамшигт илүү анхаарах хандлагатай байдаг.

Улс орнууд бодлого боловсруулахдаа хүний аюулгүй байдлын асуудлыг чухалчилж байна. Тухайлбал, Япон улс 2015 онд "Хөгжил Хамтын ажиллагааны дүрэм"-дээ хүний аюулгүй байдал бол Японы хөгжил хамтын ажиллагааны суурь, үндсэн зарчим юм хэмээн тунхагласан байна. Түүнчлэн, Ази, Номхон

¹ НҮБ-ын Хүний хөгжлийн хөтөлбөрийн тайлан, 1994

² Human development report, UNDP, 1994



далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга уулзалт (АРЕС), Америкийн улсуудын байгууллага (ОАС) зэрэг бүс нутгийн форумууд хүний аюулгүй байдлын асуудлаарх тунхаглалууд гаргаж, эрдэм шинжилгээний байгууллагууд хүний аюулгүй байдлын хэтийн төлөвийг судлах хөтөлбөрүүдтэй болсон байна.

Хүйтэн дайн дууссанаас хойш улс хоорондын дайн багасаж, оронд нь иргэний дайн, үндэстэн ястны өрсөлдөөн, дотоодын үймээн самуунаас үүдэлтэй томоохон хүчирхийлэлд илүү их анхаарал татах болсон. Иймээс бодлого боловсруулагчид хувь хүний оршин байх орчин нөхцөлд илүү анхаарал хандуулах, мөн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд хүн төвтэй аюулгүй байдлын талаарх судалгаанд ач холбогдол өгч байна.

Хүний аюулгүй байдал, хүний хөгжил хоёр хоорондоо нягт холбоотой. Хүний хөгжил нь боловсрол эзэмших эрх, эрүүл байх эрх, амьжиргааны зохистой түвшинд байх эрх болон бусад эрхээ эдлэх боломжийг олгодог бол айдас, хомсдолоос ангид байх нь хүний хөгжлийн зайлшгүй нөхцөл болж өгдөг³.

Хүний аюулгүй байдалд зах зээлийн гэнэтийн хэлбэлзэл, газар хөдлөлт, цаг агаарын гамшиг, халдварт өвчин, иргэний дайн гэх мэт зүйлс багтах тул аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд төрийн бодлогын бүх арга хэрэгсэл багтаж болно.

Манай улсын хувьд Хүний аюулгүй байдал гэдэг нь “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн⁴ хэмээн тодорхойлсон байна.

Хүний амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний аюулгүй байдлыг баталгаажуулах чухал үндэс болно. Хүний аюулгүй байдалд

олон аюул заналхийлж байдаг. Эдгээр өргөн хүрээний аюулын шалтгаанууд нь олон янз байдаг ч даван туулах боломжтой арга хэрэгсэл нь мөн адил олон янз байдаг.

Аюулын төрлүүд, тэдгээрийн шалтгаанууд, нөлөөлөх хүчин зүйлс, боломжит арга хэмжээ зэргийг ангилж, аюулын магадлалыг багасгаж, аюул нэгэнт болох үед учрах хохирлыг аль болох бууруулах ёстой. Үүний тулд нийгэм, байгалийн ухаан инженерчлэл, хүмүүнлэгийн ухаан зэрэг шинжлэх ухааны холбогдох бүх салбараас аль болох их мэдлэг, мэдээллийг ашиглах хэрэгтэй болно.

Хүний аюулгүй байдалд заналхийлж болох аюулыг энгийнээр: амь нас, амьжиргаа, нэр төрд заналхийлэх аюул гэж ангилж болно. Эдгээр аюулыг эх үүсвэрт нь тулгуурлан физик системийн, биологийн системийн, нийгмийн тогтолцооны аюул гэж ялган үздэг.

Амь насанд заналхийлэх аюулын эхний төрөл нь физик системээс үүссэн буюу ихэвчлэн газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, цунами, үер, далайн шуурга, хүчтэй цасан болон шороон шуурга, хар салхи, түймэр зэрэг байгалийн гамшиг байдаг. Амь насанд заналхийлэх хоёр дахь төрлийн аюулд биологийн системээс үүдэлтэй цар тахал, орон нутгийн чанартай халдварт өвчин, өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдал, экологийн гамшиг зэрэг орно. Амь насанд заналхийлэх гурав дахь төрлийн аюул нь хүчирхийлэл (гэр бүлийн хүчирхийлэл, аллага, хүчингийн хэрэг, терроризм, үймээн самуун, эмх замбараагүй байдал, иргэний дайн, осол гэх мэт), амьдралын хэв маяг өөрчлөгдөх, эрүүл мэндийн байгууллагуудын хангалтгүй байдал гэх мэт нийгмийн тогтолцооноос үүсдэг.

АНУ-ын менежментийн ухаанд нэрд гарсан эрдэмтэн, сэтгэл зүйч судлаач Абрахам Маслоу 1940-д оны үед хүнийг судалсны үндсэнд хэрэгцээний 5 шатлалын онолоо боловсруулжээ. Үүнийг менежментийн ухаанд өргөн хэрэглэдэг. Хүний амьдралын суурь хэрэгцээ хангагдаж

³ The Human Development Index, used by the UNDP, is a composite measure of education, life expectancy, and per capita income, roughly corresponding to the basic rights to education, health, and standard of living.

⁴ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл



байж дараагийн хэрэгцээ хангагддаг бөгөөд дараах пирамид чанд эрэмбэлэгдсэн, шаталсан 5 хэлбэрт байдаг гэж үзээд 1943 онд "A Theory of Human Motivation" бүтээлдээ ангилаад доод шатны хэрэгцээ хангагдаагүй цагт дээд хэрэгцээ үүсэхгүй буюу орхигддог. Мөн хүний хүсэл тэмүүлэл (motivation) нь хэрэгцээгээрээ тодорхойлогддог тухай онол дэвшүүлсэн билээ.

А.Маслоу хүний бүх хэрэгцээг таван түвшинд ангилан хуваан үзсэн бөгөөд үүнийгээ анхдагч болон соёлын (дээд) хэрэгцээнүүд гэж тоймлож, эхний хэрэгцээ хангагдсаны дараа дараагийн түвшний хэрэгцээ бий болно. Өмнөх хэрэгцээ тодорхой түвшинд хангагдаагүй байхад дараагийн дээд түвшний хэрэгцээ хангагдахгүй гэсэн нь онолын гол дүгнэлт нь хүний аюулгүй байдлын аргагүйн үндэс болж байна.

Эрдэмтэн өөрийнхөө онолыг 1 дүгээр зурагт үзүүлсэн байдлаар гаргаж, түүнийг нь эрдэмтэд **Маслоугийн пирамид** гэж нэрлэсэн нь бий.



1 дүгээр зураг. 5 түвшин бүхий Маслоугийн пирамид

Пирамидын бүтцээс харахад, эхний түвшний хэрэгцээ болох *физиологийн хэрэгцээ* бүх хүнд нэгэн адил төрөнгүүт бий болно. Энэ хэрэгцээний 85–аас багагүй хувийг хангаж байж *аюулгүй байдлын хэрэгцээ* үүснэ.

Аюулгүй байдлын энэ хэрэгцээнд эрүүл мэнд, санхүүгийн тогтвортой байдал, бие сэтгэлийн амар амгалан байдал зэрэг багтана. Өөрөөр хэлбэл хүний орлого, ажил хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал, хууль эрхзүй зэргийн нийлэмжээс бүрдсэн хүнийг болзошгүй эрсдэлээс хамгаалсан тогтвортой

орчин нөхцөлийн хэрэгцээ юм.

Аюулгүй байх ирээдүйдээ итгэлтэй байх хэрэгцээ нь орчны зүгээс бие мах бодь, сэтгэл зүйд учруулах аюул заналаас хамгаалах, физиологийн хэрэгцээ ирээдүйд хангагдах итгэлтэй байх явдал юм. Ирээдүйд итгэлтэй байх хэрэгцээний илрэл бол даатгал, тэтгэвэр тэтгэмж баталгаатай, найдвартай ажлын байртай, ажиллах аятай нөхцөлөөр хангагдсан мэргэжил боловсролтой байх зэрэг болно.

Нэг хоёрдугаар хэрэгцээ бол хүний үндсэн суурь хэрэгцээнүүд бөгөөд хангагдаагүй тохиолдолд хүнд дараагийн шатны хэрэгцээг хүсэл тэмүүлэл алга болно. Харин аюулгүй байдлын түвшинд хэрэгцээнийхэн 70% нь хангагдаж байж *нийгмийн хэрэгцээ* бий болно.

Нийгмийн хэрэгцээ нь *өөрийгөө хүндлэх хэрэгцээ* үүссэн хүний 70%–ийг хангаж байх ёстой байна.

Өөрийгөө хүндлэх хэрэгцээгээ хангасан бие хүний 60% нь *өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ* рүү тэмүүлж эхэлдэг байна.

Сүүлийн түвшний энэ хэрэгцээг хангахад нэлээд хэцүү. Энэ түвшний хэрэгцээ 40%–д хүрвэл хүн өөрийнхөө аз жаргалтайг мэдэрдэг. Хамгийн сонирхолтой нь, дэлхийн хүн амын ердөө 1–4% л энэ түвшинд хүрдэг байна.

Маслоугын онолоор хүний аюулгүй байдал бол хүний амьдралын хэрэгцээтэй шууд холбогдож байна.

Хүний амьжиргаанд заналхийлж буй аюулыг мөн гурван төрөлд хувааж болно. Эхний төрөлд амь насанд нөлөөлдөг физик үзэгдлүүд, түүнчлэн амь насанд шууд заналхийлдэггүй ч эдийн засгийн ноцтой үр дагавартай бусад үзэгдлүүд, тухайлбал онц хүчтэй биш боловч өргөн газар нутаг хамарсан үер, газар доорх усны нөөц буурах, гамшгаас үүдэлтэй тусгаарлалт зэрэг орно. Хоёр дахь төрөл нь биологийн системээс гаралтай аюулууд байдаг. Амьжиргаанд нийгмийн системээс заналхийлж буй аюулд засаглалын дорой байдал, төрийн алдаатай бодлого, зах зээлийн доголдол, ядуурал, дэд бүтцийн хангалтгүй байдал, ялгаварлан гадуурхалт зэрэг багтдаг.



Хүний нэр төрд заналхийлэх аюул нь онолын хувьд мөн л энэ физик системээс, биологийн системээс, нийгмийн системээс гэсэн гурван төрлийг агуулна. Нэр төр гэдэг нь үндсэндээ нийгмийн ойлголт учраас нэр төрд заналхийлж буй асуудлыг авч үзэхэд нийгмийн системийн аюул занал маш чухал байдаг. Үүнд санаатай (илэрхий ялгаварлан гадуурхах, дарамтлах), санамсаргүй (далд ялгаварлан гадуурхах, эдийн болон эдийн бус баялгаар хомсдох) аюул хамаарна. Мөн физик систем болон биологийн системд үүссэн аюулууд, ялангуяа тэдгээр нь нийгмийн системийн хавсрах үед хүний нэр төрд нөлөөлөх тохиолдол байдаг. Тухайлбал, байгалийн гамшгаас амьд үлдсэн хүмүүс ихэвчлэн гэр бүл, найз нөхдөө алдсан дурсамжаас болж ихээхэн цочирддог.

Хүний аюулгүй байдалд учрах аюулын үндсэн шалтгаан нь физикийн хуулиар тодорхойлогддог газар хөдлөлт, цунами, цасан ба шороон шуурга, хар салхи, үер, галт уулын дэлбэрэлт гэх мэт байгалийн гамшгийн (ихэвчлэн амь нас, амьжиргаанд заналхийлдэг) шалтгааныг тодорхойлоход хялбар байдаг.

Хүний аюулгүй байдлыг хангах арга зам. Хүний аюулгүй байдал хөндөгдөх шалтгаанууд тодорхой бус тул эдгээрийг илүү судалж, эмпирик байдлаар баталгаажуулах шаардлагатай юм. Зөвхөн учир шалтгааныг ойлгох нь хүний аюулгүй байдлыг сайжруулах үр дүнтэй арга биш хэдий ч аюулын шинж чанар, дүн шинжилгээнд үндэслэн даван туулах янз бүрийн арга хэмжээг хамгийн сайн хослуулахыг судлах явдал маш чухал. Ерөнхийдөө шалтгаан ба үр дагавар гэсэн хоёр төрлийн боломжит арга зам байна:

1. Аюулын шалтгааныг арилгах, багасгах, урьдчилан сэргийлэх арга зам,
2. Аюул болсон ч учирч болох хохирлыг багасгах арга зам.

Нэгдүгээр арга замын хувьд аюулын шалтгаануудад нөлөөлөх зорилготой бодлогын арга хэмжээ байх боловч арилгах боломжгүй, гэнэтийн аюул байдгийг анхаарах нь зүйтэй. Байгалийн зарим аюулыг хянах боломжгүй

байдаг. Жишээлбэл, хүн төрөлхтөн хүчтэй салхи шуурга, ширүүн борооны эрсдэлийг арилгахын тулд агаарын урсгалыг удирдаж чадахгүй байгаа. Ийм учраас хамгаалалтын хоёрдох төрлийн арга зам шаардлагатай болдог.

Аюулын хүчийг бууруулах сонголтууд байж болно. Үүний жишээнд уур амьсгалын өөрчлөлтийг "сааруулах" оролдлогууд орно. Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах бодлого урт хугацаанд үргэлжлэх уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хохирлыг бууруулах төлөвтэй байдаг. Энэ нь хэдий чухал боловч урт хугацаа шаардана. Бид хүлэмжийн хийн ялгарлын өсөлтийг одоо зогсоож чадсан ч ойрын хэдэн арван жил, зуунд уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх томоохон нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжгүй. Иймд уур амьсгалын өөрчлөлтийн тухай асуудал яригдахад "дасан зохицох" арга хэмжээ гэж нэрлэгддэг хамгаалалтын арга хэмжээг авах шаардлагатай болдог.

Хүний амьжиргаанд учирч болох аюулыг бууруулахад шаардлагатай суурь арга хэмжээг хэрэгжүүлэх хялбар биш. Хүртээмжтэй хөгжил (хүний амьдралын чанарыг нэмэгдүүлэх, нийгэм, байгаль орчны тогтвортой байдлыг хангахын тулд нийгмээс гадуурхагдсан хүмүүсийг хамруулсан) бол хөгжлийн хамгийн зөв хандлага гэдэгтэй дэлхий нийт санал нэгдсээр байна. Өнөө үед дэлхий нийтэд хүртээмжтэй хөгжилд хувь нэмэр оруулах тодорхой арга хэмжээний талаар бодит маргаан өрнөж байна. Эдгээр арга хэмжээний гол бүрэлдэхүүн хэсэгт улс орны өнцөг булан бүрд ашигтай дэд бүтэц, бүх нийтийн суурь боловсрол, жижиг бизнесийг чадавхжуулах хөдөө аж ахуйн бодлого, мэргэжлийн сургалт, бүх нийтийн эрүүл мэнд, зохистой хоол тэжээл зэрэг багтдаг.

Дээрх бүгд урт хугацаанд үр дүнтэй арга хэмжээ тул богино хугацааны аюул буюу цаг агаарын гамшиг, иргэний дайн, халдварт өвчний үед аюулгүй байдлыг хангах тохиромжтой биш юм. Ийм үед хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, дэд бүтцийг шуурхай засаж хөгжүүлэх, богино



хугацааны, хэрэгцээт мэргэжлийн боловсрол олгох зэрэг хамгаалалтын механизм чухал байдаг.

Дээрх байдлаас үзэхэд хүний аюулгүй байдлыг хэн хангах ёстой вэ гэсэн асуулт гарч байна. Засгийн газар хүний аюулгүй байдал зөрчигдсөн бүс нутгуудад хүмүүсийн сайн сайхан байдлыг хангахад онцгой эрхтэй оролцож чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Онцгой эрхт байдал гэдэг бол төр нь иргэдээ хүний аюулгүй байдалд заналхийлэх аюулаас хамгаалах үүрэг хариуцлага юм.

Уламжлал ёсоор төр нь иргэдийнхээ нийтийн аюулгүй байдал, нийгмийн баталгаа, үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Төр дотоод хүчирхийлэлтэй тэмцэх, хүний сайн сайхан байдал, нэр төрийг хамгаалах, хувь хүнийг хүчирхийллээс хамгаалах учиртай. Төрийн аюулгүй байдал иргэн хүний аюулгүй байдлыг дээшлүүлж байдаг. Гэвч хүний аюулгүй байдлын шалтгаан, тэдгээрийг шийдвэрлэх арга хэрэгслийн талаар дээр дурдсан зүйлсээс үзвэл төр нь хүний аюулгүй байдлыг хангах цорын ганц төлөөлөгч биш юм.

Нэгдүгээрт, хүний аюулгүй байдалд заналхийлж буй үндсэн шалтгаануудын зарим нь улсын хил хязгаарт хамаардаггүй. Геологи, газар зүй, цаг уур, биологи, экологи, эдийн засаг, нийгмийн үзэгдлүүдийн олон нөлөөлөл нэг улсын хүчин чадлаас давж гардаг.

Хоёрдугаарт, тусгаар тогтносон улсууд хүч чадал, шинж чанараараа ялгаатай. Өндөр орлоготой орнууд ерөнхийдөө батлан хамгаалах, дасан зохицох чадавх өндөртэй байдаг бол хөгжиж буй олон оронд хүний аюулгүй байдалд учрах аюулаас урьдчилан сэргийлэх бүү хэл болж буй аюулаас хамгаалах чадвар дутмаг байдаг. "Эмзэг төр" гэсэн ойлголтыг тухайн улс хүний аюулгүй байдлыг хангахад тулгарч буй асуудлыг илэрхийлэхэд ихэвчлэн ашигладаг.

Гуравдугаарт, төрөөс бусад оролцогч талууд ч хүний аюулгүй байдлыг сайжруулахад хувь нэмрээ оруулах тодорхой чадавхтай байдаг. Бизнесийн салбар болон Төрийн бус байгууллагууд тодорхой нөхцөл байдалд

хүний аюулгүй байдлын хямралд илүү хурдан, үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх боломжтой. Чанартай иргэний нийгэм нь нийгмийн тогтолцооны аюулаас урьдчилан сэргийлж чаддаг.

Байгалийн гамшгийг хохирол багатай даван туулах, хүний аюулгүй байдлыг хангахад дараах 5 зүйлийг чухалчлан авч үздэг:

1. Нэгдмэл арга хэмжээ авах: байгалийн тогтолцоо ба нийгмийн зохион байгуулалтын харилцан үйлчлэлийг цогц байдлаар авч үзэх, байгалийн аюулыг даван туулахад шинжлэх ухаан, инженерийн дэвшлээс гадна хүний аюулгүй байдлын асуудлуудыг анхаарах.
2. Нийгмийн нөхцөлд анхаарах: Тухайн нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан байгалийн аюул нь байгалийн гамшиг болж хувирдаг. Тиймээс хүний аюулгүй байдлыг хангахад зөвхөн хатуу дэд бүтцэд төдийгүй хариу арга хэмжээ авах, дасан зохицох чадвар бүхий нийгмийн тогтолцоог бүрдүүлэх зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийхэд анхаарах.
3. Тайвширч болохгүй: Ямар ч төрлийн гамшиг тохиолдож болох тул байж болох хамгийн муу тохиолдлыг төлөвлөлтийн явцад орхигдуулахгүй байх.
4. Хамгийн эмзэг бүлгийн хэрэгцээ: Гамшигт нэрвэгдсэн бүс нутгийн хамгийн эмзэг бүлгийн хэрэгцээг хүн рүү чиглэсэн, бодит байдлаар тодорхойлох.
5. Амьд үлдэгсдийн аюулгүй байдал: Амьд үлдэгсэд цаашид гамшгийн дараах нийгмийн эмх замбараагүй байдалд өртөж болзошгүй байдаг тул хохирогчдыг бүх төрлийн хүчирхийллээс хамгаалах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зэрэг юм.

Дүгнэлт. Хүний аюулгүй байдал нь МУ-ын Үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг бөгөөд хүний аюулгүй байдлыг хангах нь



төрийн үүрэг мөн. Хүний аюулгүй байдалд учрах аюулын төрлийг бие махбодийн, амьжиргааны болон нийгмийн тогтолцооны гэж ангилан үзлээ.

Хүний аюулгүй байдал нь ерөнхийдөө аюулын шалтгааныг арилгах, багасгах, урьдчилан сэргийлэх болон учирч болох хохирлыг багасгах гэсэн хоёр төрлийн боломжит арга зам байна. Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанууд бүгд хүний аюулгүй байдлын асуудлуудтай холбоотой байна.

Хүний аюулгүй байдлын тухай ойлголт нь хүн амын хамгийн эмзэг хэсгийн хэрэгцээ, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настныг илүү анхаарахад хүргэдэг. Гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн бодлого, үйл

ажиллагаануудад илүү тодорхой тусгаснаар бид гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг илүү сайн төлөвлөж, бэлтгэх боломжтой болно.

Хүний аюулгүй байдал нь хувь хүн амьдралын наад захын хэрэгцээгээр хангагдсан байдал болон айдасгүй байхыг хамгаалахад чиглэсэн хүн төвтэй ойлголт бөгөөд энэ ойлголт энхийг бэхжүүлэх, хүмүүнлэгийн тусламж, хөгжил, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон салбарт өргөн хэрэглэгдэж байна.

Хүний аюулгүй байдлын онол аргазүйн үндэс ба олон улсын туршлага, сургамжийг судалж, Монгол Улсын хүн амын аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлд шинжилгээ хийх замаар эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлох нь тулгамдсан асуудлын нэг болж байна.

Ашигласан материал:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
2. Должинсүрэн М, дисс. "Цаг уурын гамшигт үзэгдлийн хүн амд үзүүлэх нөлөөллийн судалгаа", 2023
3. Хулан Г, Хүний аюулгүй байдлын талаарх онол, арга зүйн зарим үзэл баримтлал, УБ., 2020
4. Abraham Maslow "A Theory of Human Motivation"
5. Human development report, UNDP, 1994
6. Tanaka (1996) included my first analysis of fragile states, which I then called the "sphere of chaos."
7. Jonn E.Mroz, Beyond Security: Private perception amond Arabs and israeiis (New York: inter-natiol Peace Akademy, 1980.p.105)
8. Human development report, UNDP, 1994
9. НҮБ-ын A/RES/66/290 тогтоолд НҮБХХ (1994) болон Хүний эрхийн комисс (2003)



ЖИЖИГ БҮЛГИЙН БАЙЛДААНЫ ЁС СУРТАХУУН–СЭТГЭЛ ЗҮЙН ХАНГАЛТЫН ОНЦЛОГ

А.ОКТЯБРЬ /УБХИС-ийн магистрант, хошууч/

Түлхүүр үг: Байлдаан, ёс суртахуун, сэтгэл зүй

Key words: Battle, morality, psychology

Оршил. Сүүлийн үед явагдсан дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлагаас үзэхэд байлдааны үйл ажиллагаа нь мэдээллийн давамгайлал, сэтгэл зүйн нөлөөлөл, ёс суртахуун сэтгэлзүйн бэлтгэлийн нэгдсэн арга зүйн тогтолцоогүйгээр байлдааны өндөр идэвхтэй байж чадахгүй, жижиг бүлгийн байлдаанд болон тусгай операцад амжилтад хүрэх боломжгүй ба байлдаанд сэтгэл зүйн ажиллагаа томоохон байр суурийг эзэлж, бүрэлдэхүүний байлдах чадвар, үүрэг гүйцэтгэх боломжид ихээхэн нөлөөлдөг болох нь харагдаж байна.

Жижиг бүлгүүдийг идэвхтэйгээр ашиглах нь томилогдсон бүрэлдэхүүн болон нийт бие бүрэлдэхүүн, ард иргэдийн эх оронч үзэл хүмүүжил, ёс суртахуун–сэтгэл зүйн бэлэн тогтвортой байдал зэргээс үлэмж шалтгаалдаг болохыг цэргийн хэргийн онолч, эрдэмтэн судлаачид дурдсан байдаг.

Жижиг бүлгийн байлдааны ажиллагаанд үүрэг гүйцэтгэхэд сургаж бэлтгэх, эх орноо хамгаалах цэрэг–эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх асуудал, ёс суртахуун–сэтгэл зүйн хангалтыг оновчтой, үр дүнтэй явуулснаар тавигдсан үүргээ биелүүлэх бэлтгэлжилт, бэлэн байдлыг хангах чухал хүчин зүйл юм.

Иймээс жижиг бүлгийн байлдааны ажиллагааны үед ард иргэд, бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн байдлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй, өгөгдсөн үүрэг, цагийн байдалтай уялдуулан нарийн төлөвлөгөөтэй зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Жижиг бүлгийн байлдааны ажиллагааны талаар ном, гарын авлагуудад сэтгэл зүйн хангалтын асуудлууд төдийлөн тусгагдаагүй байна. Сэтгэл зүйн бэлтгэл, хангалтын ном,

сурах бичиг, гарын авлагуудад үндсэн төрлийн байлдааны үеийн сэтгэл зүйн хангалтын асуудлууд түгээмэл байдаг ч жижиг бүлгийн байлдааны ажиллагааны үеийн сэтгэл зүйн хангалтын талаар ховор тусгагдсан байдаг нь судалгааны явцад ажиглагдав.

Зарим судлаачид монголчууд цэрэг эрсийг сургаж, бэлтгэхдээ сэтгэл зүйн бэлтгэлд нь анхаардаг байсан тухай бичжээ. Тухайлбал Цэргийн сэтгэл зүйн бэлтгэл гэдэг нь байлдааны талбарын орчинг дуурайж, өдөр тутам цэрэг жанжид байлдааны бэлтгэл болон бусад үйл ажиллагааг хослуулан ухамсартайгаар, төлөвлөгөөт, үе шаттайгаар тодорхой арга зүйг ашиглан тодорхой зорилтыг хэрэгжүүлэхийг хэлнэ гэж зарим судлаачид үздэг. Цэргүүдийн бие хүний болон армийн сэтгэл зүйд үзүүлэх нөлөөллийг тэдгээрийг үзэл санааны хувьд зоригжуулснаар байлдааны даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай сэтгэл зүйн чанарыг төлөвшүүлэх, оюун санааны үйл ажиллагааны чадварыг дээшлүүлэх тусгай сургалтын үйл ажиллагаа юм. Монголын эртний улсуудад цэрэг эрсийг эх орноо хамгаалах сэтгэл зүйн хат суулгахад анхаарч байжээ. Тухайлбал, цэргийн ололт амжилтыг урамшуулж урам зориг өгч байсан. Энэ тухай сурвалжид “Хүннү нар цэргийн ололт амжилтыг урамшуулж олзолсон олзоо өөрийн болгох боломжийг олгож байсан. Тиймээс дайн тулаанд хүн бүр өөрийн ашиг сонирхлыг идэвхтэй эрэлхийлж, дайсанд отолт хийхдээ гарамгай байдаг бөгөөд дайсны цэргүүдийг хараад хамтдаа нисэж буй шувууд шиг эрх ашгийнхаа хойноос амь бие үл хайрлан хөөцөлддөг. Мөн хэрэв тулалдаанд нас барсан хүмүүст тусалсан бол нас барсан дайчны бүх хөрөнгийг авч болно. Өөрөөр хэлбэл, тулалдаанд



нас барсан цэрэг нөхрийнхөө цогцсыг авчирч чадсан хүн бүх эд хөрөнгийг авч болно”¹. Энэ урамшууллын бодлого нь тулалдаанд амь үрэгдсэн цэргүүдийг үрэгдсэний дараа эх орондоо ирж, амар тайван нойрсох боломжийг олгодог. Ийм журам нь цэргүүдийн эв нэгдэл, байлдааны үр нөлөөг сайжруулахад сэтгэл зүйн маш том түлхэц болж”² байсан тухай бичжээ. Энэ тухай нарийвчлан судлах шаардлага байна. Жижиг бүлгийн байлдааны ажиллагаа явуулах үеийн сэтгэл зүйн онцлог, үүрэг биелүүлэх онцлог, нөхцөлөөс үүдэн бие бүрэлдэхүүний сэтгэл зүйд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох, түүнээс урьчилан сэргийлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг дээшлүүлэх үйл ажиллагааны чиглэлийг энэ өгүүлэлд гаргахаар зорилоо.

НЭГ. ЖИЖИГ БҮЛГИЙН БАЙЛДААНЫ АЖИЛЛАГААНЫ СЭТГЭЛ ЗҮЙН ХАНГАЛТЫН ОНЦЛОГ

Өнгөрсөн зуунд явагдсан байлдааны ажиллагаануудын туршлагаас үзэхэд зэвсэгт мөргөлдөөнүүд нь зөвхөн жижиг бүлгүүдийн байлдааны хэлбэрээр явагдсан байдаг. Эдгээр дайн, байлдаанд цэргийн томоохон нэгтгэл, ангиудыг хэрэглэх боломж олдохгүй байгаагаас агаар десант, тусгай томилгоот хүчин болон бусад цэргийн жижиг нэгжийг оролцуулан тусгай операциудыг явуулах болсон.

Харьцангуй бага хүчтэй тал нь давуу хүчний эсрэг амжилттай байлдах тактикийн нэг сонгомол хэлбэр нь партизаны дайн, жижиг бүлгийн тактик байсныг сүүлийн үед явагдсан бүс нутгийн байлдааны туршлага харуулсаар байна. Энэ нь өөрийн ажиллагааг байнга нуун, далд байрлах, байрлал фронтоо цаг ямагт өөрчлөх, бүслэлтээс зайлсхийх, жижиг бүлгээр дайсныг өдөөн дагуулж, гол хүчнийхээ галын уут, отолт, урхи занганд оруулах, чухал объектыг журам мэт шөнийн цагаар хорлон сүйтгэх, бүх төрлийн хангалтыг нь тасалдуулах,

шийдвэрлэх ажиллагаа болон хөдөлгөөнд нь гэнэтийн хүчтэй эсэргүүцэл, хөнөөл үзүүлэх явдлаар хангадаг байна.

Жижиг бүлэг, салбаруудын байлдааны ажиллагаа нь өвөрмөц шинж чанартай, гол төлөв бие даасан тусгай байлдаануудыг хийдэг. Гэнэтийн цохилт, дайралтууд нь харилцан ажиллах зэргэлдээх салбар байхгүй, дээд шатнаас дэмжлэг хэрэглэхгүйгээр явагддагаараа онцлогтой. Тэдний тэмцлийн арга, тактик нь ерөнхий цэргийн байлдааны уламжлалт тактикийн ажиллагаанаас өөр өөрийн гэсэн онцлогтой тактикийн аргуудыг хэрэглэж байдаг.

Жижиг бүлгийн байлдааны үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний сэтгэл зүйн хангалтын зорилго нь тавигдсан байлдааны үүргийг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, байлдах чадварыг хадгалах, эсрэг талын хөнөөлийн ердийн, химийн, биологийн нэн өндөр цэцтэй болон бусад төрлийн зэвсгүүдийн аюулын сэтгэл зүйн нөлөөллийг бууруулахад чиглэгдэнэ.

Сүүлийн үед явагдсан дайн, зэвсэгт мөргөлдөөн, тэр дундаа жижиг бүлгээр байлдааны ажиллагаа явагдаж буй тэр цаг үед нийгмийн сэтгэл зүйн хүрээнд болон байлдааны ажиллагааны ёс суртахуун–сэтгэлзүйн хангалтыг зохион байгуулах үед зайлшгүй харгалзаж үзэх асуудлууд байнга гарч байдаг. Үүнд:

- Тулгамдсан дайны асуудлыг шийдвэрлэхэд нийгэм талуудад хуваагдах, хүчтэй нөлөөлөх нийгмийн сэтгэл зүйн нэгдмэл байдал алдагдах, улсын болон зэвсэгт хүчний удирдлага, цэргийн алба хаагчдад мэдээлэл сэтгэлзүйн хүчтэй даралт үзүүлэх;
- “Хүчтэй” тал нь гол төлөв цэргийн мөргөлдөөнийг хүчээр шийдвэрлэхээс илүү үзэл суртлын болон сэтгэлзүйн нөлөөллийг бий болгох, жолоог алдагдуулах;

¹ 司马迁. 史记. 北京: 中华书局.1982

² Орхончимэг Х., Монголын эртний улсуудад цэргийн сургалтын үүрэг хэрэгжсэн нь. БХЭШХ–ийн Аюулгүй байдал батлан хамгаалах судлал” сэтгүүл. 2022 №35(45)



- Мөргөлдөөнийг зохицуулах талаар авах арга хэмжээ, үргэлжлэх хугацаа болон хурцадмал байдал удаан үргэлжлэх төлөвтэй байх;
- Ард иргэд байлдаанд орох нөхцөл бүрдэх ба эмх замбараагүй шинж чанартай байдаг.

Жижиг бүлгийн байлдаан нь:

- Үүрэг гүйцэтгэлт гэнэтийн, өндөр эрчимтэй, түргэн шуурхай байдлаар өрнөдөг;
- Эрс шийдэмгий, өгөгдсөн үүрэг нарийн нарийн төлөвлөгдсөн байдаг;
- Газар орны болон байгаль, цаг уурын ямар ч нөхцөлд явагддаг;
- Цаг ямагт өргөн маневр, идэвх санаачилга, ов мэх, оновчтой хувилбарыг шаардаж байдаг;
- Бие даан шийдвэр гаргаж үүрэг гүйцэтгэдэг;
- Бага хүчээр их хүчний эсрэг ажиллах төлөвтэй зэрэг онцлогтой байдаг”¹.

Дээрх нөхцөл байдлаас үүнээс үүдэн жижиг бүлгийн байлдааны ажиллагааны сэтгэл зүйн хангалтын онцлогийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Байлдааны үүрэг гүйцэтгэх бүлгийн гишүүд бүрийн байлдах чадвар тэр дундаас сэтгэл зүйн бэлтгэлтээр үр дүн тодорхойлогдож байдаг.
- Жижиг бүлэг, тусгай томилолын, хорлон сүйтгэх бүлгүүдээр гүйцэтгэх үүрэг нь богино хугацаанд хүчтэй нөлөөлөл, хохирол учруулах, сэтгэл зүйн өндөр бэлтгэл, тэмцэх, хамгаалах чадвар шаардаж байдаг.
- Сэтгэл зүйн хангалтыг эрчимтэй үр дүнтэй, өндөр түвшинд явуулахыг шаардаж байдаг.
- Эсрэг талаас үзүүлэх мэдээлэл–сэтгэл зүйн дайралтын хор хөнөөл үүрэг гүйцэтгэлтэд маш хурднаар нөлөөлдөг.
- Хүчний харьцаанаас илүү, газар орон, тактикийн ажиллагааны давуу байдал,

бага хүчний давуу байдлыг оюун санаанд суулгах, үүнд эр зориг, ялалтад хүрэх өндөр эрмэлзэл чухал болохыг өргөн хүрээгээр ухуулах нь үр дүнтэй байдаг. Энэ тохиолдолд дайчдын дунд өөрийн хүч, зэвсэг, дайсны үзэл сурталд итгэхгүй байдал гарч болзошгүй юм.

- Орон нутгийн иргэд оролцох, партизаны байлдааны хэлбэрт шилжих хандлагатай.
- Хамт олны гар нийлэмжтэй ажиллагаа, нэгдэл, нягтрал, сэтгэл зүйн уур амьсгал хүчтэй нөлөөлөл үзүүлдэг
- Удирдах бүрэлдэхүүний шийдвэр гаргах үеийн сэтгэл зүйн бэлтгэл зэргээс нийт бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн бэлтгэлжилт тодорхойлогдож байдаг байна.

Сэтгэл зүйн хангалтын чиглэлийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Жижиг бүлгийн байлдааны ажиллагааны онцлог, хүрэх үр дүнг үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнд ухуулан ойлгуулах, сурталчлах, идэвхжүүлэх, уриалах;
- Эх оронч үзэл хүмүүжил олгох ухуулга, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;
- Үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний сэтгэл зүйн хангалт явуулах;
- Байлдааны ажиллагаа явагдах орон нутгийн хүн амын сэтгэл зүйг бэлтгэх, сэтгэл зүйн ажил, дэмжлэг, тусламжийг үйл ажиллагааг эрчимжүүлэх зэрэг болно.

Сүүлийн үед явагдсан дайн, зэвсэгт мөргөлдөөний үед хөгжил, зэвсэгт хүчний хөгжлөөрөө тэргүүлэх улс гүрнүүд сэтгэл зүйн ажиллагааг дараах үе шатаар хэрэгжүүлдэг байна. Үүнд:

Нэгд: Дайсан улсын үндэсний хүсэл зоригийн эсрэг ажиллагаа:

Хоёрт: Эсрэг талын цэргийн командлагч, захирагч нарын эсрэг ажиллагаа:

Гуравт: Дайсны цэргүүдийн эсрэг ажиллагаа:

Дөрөвт: Үзэл суртлын зөрчилдөөн бий болгох гэж дөрөв ангилсан байна. Энэ нь хувь хүн, олон нийтийн ухамсарт

³ Цогтжаргал Ч., “Жижиг бүлгийн байлдааны үндэс”, 2010 он



нөлөөлөх, шинэ төрлийн мэдээлэл өгөх, хэлбэрээр явагддаг.

Жижиг бүлгийн байлдааны ажиллагааны үе дэх сэтгэл зүйн ажиллагаа нь: суртал ухуулгыг ашиглан үүгээрээ дайсныг албадах, дайсны мэдрэмж, сэдэл, сэтгэл хөдлөл, оюун санаанд нөлөөлөл үзүүлж төөрөгдүүлнэ.

Байлдааны ажиллагааны талбарт сэтгэл зүйн ажиллагааны тактикуудыг авч үзвэл:

- дайтаж бууж өгөх, аюулгүйгээр хэрхэн бууж өгөх талаар зааварчилгаа өгөх, дайныг дэмжсэн товхимол, хуудас тараах
- технологийн зэвсэг ашиглан айдаст автуулах, цочруулах
- дуу чимээ, чанга яригч ашиглах, ядарч туйлсан хөгжим, чимээ шуугианыг бий болгож, төсөөлөл бий болгох
- химийн болон биологийн зэвсэг ашиглах болон заналхийлэх /психотроп, психотроик/
- телевиз радиогоор сөрөг суртал ухуулгын мэдээг давтамжтай цацах
- хуурамч мэдээ “fake news”-ыг итгүүлэх, төөрөгдөлд оруулах
- зориуд зохион байгуулсан ажиллагаа буюу олон нийтийн санааг эзэмдэх, тархи угаах “**манипуляц**” үзэл суртлын хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, хорлон сүйтгэх суртал ухуулгаар тодорхойлогдоно.

Аль ч тохиолдолд дайны талбарт сэтгэл зүйн дайны ажиллагааны зорилго нь эсрэг талынхаа ёс суртахууныг хөндлөнгөөс доройтуулах, бууж өгөх явдал юм.

Кибер халдлага нь олон нийтийн сэтгэл зүйг хандуулахын тулд сонирхолтой мэдээллээр анхаарлыг нь төвлөрүүлж сэтгэл зүй, ухамсар, ёс суртахууныг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл өгөх зэргээр тодорхойлогддог.

Өндөр хөгжилтэй улс орнууд цэргийн алба хаагчдад мэдээлэл сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлэхийн тулд:

Тайван цагт:

- болзошгүй дайсан улсын улс төрийн байдлыг тогтворгүй болгох
- хүн ам, цэрэг-дайчдын сэтгэл санааг

доройтолд оруулах

- улсын доторх тодорхой улс төрийн хүчин бүлэглэлийг дэмжих
- олон улсад тухайн улсын хүн ам, зэвсэгт хүчний талаар дургүйцлийг бий болгох

Дайчилгааны үед:

- Зэвсэгт хүчний бэлэн байдал, байлдааны чадавхыг бууруулах
- ЦАХ-ын ёс суртахууныг доройтуулах, байлдах ур чадварыг бууруулах
- ЦАХ-ын дотор дургүйцэл, үл ойлголцол, хагарлыг өдөөх зэрэг үйл ажиллагааг өрнүүлэх
- Байлдааны үйл ажиллагааны үед:
- Бууж өгөх байдалд оруулах/эсэргүүлцлийг зогсоох/
- Урвалтыг зохион байгуулах
- ЦАХ-ыг буруугүй болохыг ойлгуулах, өдөөх
- Төөрөгдөлд оруулах

Мэдээлэл-сэтгэл зүйн тэмцэл

Тайван цагт:

- Хуучирсан үзэл санаа, ойлголтыг нэвтрүүлэх хүн нэг бүрд;
- Цэргийн удирдагч болон төрийн өндөр албан тушаалтнуудад зөрчил үүсгэх;
- Урвагч нарт туслах;

Дайчилгааны үед:

ЦАХ-ын сэтгэл санаанд үзүүлэх нөлөөлөл:

- Бүх түвшинд хэн нэгний эрх мэдэл, нэр хүнд, итгэлийг гутаан доромжлоход чиглэгдсэн санаатай үйлдэл явуулах;
- “Тавдугаар цувраа”-г идэвхжүүлэх ажиллагааг өрнүүлэх;
- Цэргүүдэд тулгарч буй бэрхшээлийг ашиглах /мөнгө, санхүүгийн хомсдол, ахуйн хангалт, өлсгөлөн гэх мэт/

Байлдааны ажиллагааны үед:

- Сөрөг суртал ухуулгыг өрнүүлэх /мэдээллийн хэрэгсэл, радио станц, дүрс, сонин хэвлэл, зурагт хуудас гэх мэт
- Үхэл зайлшгүй ирэх тохиолдлыг сурталчлах /бүх төрлийн мэдээллийн хэрэгслээр/
- Байлдаанд оролцож буй ЦАХ-ын ар



гэрийнхэнд учирч болох аюул занал, үйлдлийг байнга сануулах зэргээр явуулдаг байна.

Сэтгэл зүйн хангалтын үндсэн нэг үүрэг нь сэтгэл зүйн тэмцэл юм.

Зорилго нь:	Дайсны санаа сэтгэлийг алдагдуулж, сэтгэл зүйн тогтворгүй байдал оруулснаар байлдах идэвх, урам зоригийг алдагдуулах
Гол объект нь	Эсрэг зогсож байгаа дайсны гол чиглэлд ажиллаж байгаа анги салбаруудын бие бүрэлдэхүүн, түүний резервет байгаа бүрэлдэхүүн
Хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> ➢ Аман нэвтрүүлэг ➢ Хэвлэлийн суртал ухуулга ➢ Радио телевизийн нэвтрүүлэг

ХОЁР: ЖИЖИГ БҮЛГИЙН БАЙЛДААНЫ АЖИЛЛАГААНЫ ҮЕД СЭТГЭЛ ЗҮЙН ХАНГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭЛБЭРҮҮД

Урьд өмнө явагдсан дайн байлдааны туршлагаас харахад ихэнхдээ том хүчирхэг армиудтай улс орнууд яагаад нь ялагдал хүлээж байсан бэ? гэсэн асуудалд тухайн дайтагч талуудын орон нутгийн оршин суугчид, цэргийн бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн байдал, сэтгэл зүйн тэмцэх чадвараас ихээхэн шалтгаалж байсан нь харагддаг ба хүн амын сэтгэл зүйг бэлтгэх ажлыг аль болох эрт эхлэх, иргэд нь эх оронч үзэл, итгэл үнэмшилтэй, эх орон, тусгаар тогтнол, түүх, өв соёлоороо бахархах, үндэсний хувьд нэн чухал дархлаатай болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байдаг байна.

Зэвсэгт тэмцлийн амжилтыг тодорхойлдог хүчин зүйлсийн дотроос хүний хүчин зүйл хамгийн чухал байсаар ирсэн бөгөөд одоо ч хэвээр хадгалагдсаар байна. галын цохилтын улмаас бие бүрэлдэхүүнд учруулах хохирохын зэрэгцээ тэдэнд мэдээлэл, сэтгэл зүйн нөлөөллөөр ялахыг төлөвлөдөг болсон байна.

Ерөнхий хандлага нь дайсныг ердийн аргаар устгах, хохирол учруулахгүйгээр түүний сэтгэл санааг сулруулах, үйл ажиллагааг нь саармагжуулах оролдлого руу шилжих явдал юм. Энэ нь хүний ухамсар, зан үйлийг эмх

замбараагүй болгох, эсэргүүцэх чадамжийг дарах, дайсанд хандах хандлагыг өөрчлөхтэй холбоотой.

“Орчин үеийн дайны шинж чанар, номлол, батлан хамгаалах бодлого үндсээрээ өөрчлөгдөж “сэтгэл зүйн дайн”, “мэдээллийн дайн” болно хэмээн судлаачид нэгэн дуугаар бичиж байна. Орчин үед ЦАХ–ын төдийгүй, хүн амын оюун санаа, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хамгаалах, сэтгэл зүй, ёс суртахууны бэлтгэлийг хангах явдал чухлаар тавигдаж байна”⁴.


Судлаачдын үзэж байгаагаар “сэтгэл зүйн дайн” гэдэг бол тухайн ард түмнийг үндэснийхээ үнэт зүйлст эргэлзээтэй ханддаг болгож, аажмаар өөрсдийн үнэт зүйлсэд дагуулах бодлого бөгөөд гол зорилго нь үндэсний үнэт зүйлсийг нь бүрхэгдүүлэх, эргэлзээтэй болгох арга замаар орчин, нийгэмдээ үл итгэх, гутранги аяс төрүүлэхэд чиглэгддэг байна.

Үүнээс хамгаалах гол арга зам нь үндэсний үнэт зүйлсийг ЦАХ болон хүн бүрийн ухамсарт суулгаж шингээх, улс үндэстнээ гэсэн чин зориг сэтгэлгээтэй болгон төлөвшүүлэх явдал бөгөөд ингэж чадвал гаднаас явуулах сэтгэл зүйн өдөөн хатгалтаас хамгаалж чадах болно.

Мэдээлэл–сэтгэл зүйн шинжээр нь авч үзвэл: сөргөлдөгч талын зэвсэгт хүчин, тусгай албадын бие бүрэлдэхүүн болон хүн амын сэтгэл санаа, нийгмийн ухамсар, санаа бодол болон шийдвэр гаргалтын хэрэгслүүдийг мэдээлэлгүй болгох, ов мэх гаргах, суртал ухуулга явуулах, айлган сүрдүүлэх аргаар мэдээлэл–сэтгэл зүйд нөлөөлөл үзүүлэх ажиллагааг тасралтгүй явуулах болжээ.

Байлдааны ажиллагааны цагийн байдал, юмс үзэгдэл бие бүрэлдэхүүний сэтгэцэд туссанаар тодорхой сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг бий болгоно. Айх сандрах, гутрах, цөхрөх, итгэл үнэмшлээ алдах зэрэг шинж илрэх нь бие хүнд өөрийгөө хянаж жолоодох чадварт сөргөөр нөлөөлж тавигдсан байлдааны тусгай үүрэг гүйцэтгэх чадварыг бууруулж болно.

⁴ “Мэдээллийн дайн” Хамтын бүтээл., 2022., т383



Байлдааны ажиллагааны явцад цэрэг, дайчдад үүссэн нөхцөл байдал, танин мэдэх үйлийн өвөрмөц онцлог, хүний сэтгэцийн шинж чанараас хамааран хуурамч аюул занал үйлчилж, тэр нь бодит байдлаас ч илүү сөрөг үр дагавар гарах боломжтой юм.

Дайсныявуулжбуйсэтгэлзүйнажиллагааны улмаас үүсч буй хуурамч аюул заналаас бие бүрэлдэхүүнийг хамгаалахын тулд идэвхтэй сөрөг ажиллагаа явуулах шаардлагатай. өөрөөр хэлбэл бие бүрэлдэхүүнийг үнэн бодит мэдээллээр шуурхай хангах, тэдний үзэл суртал, итгэл үнэмшилд байнга идэвхтэй нөлөө үзүүлж сэргээж байх нь чухал юм.

Түүнчлэн бие бүрэлдэхүүний оюун санаа, сэтгэл зүйн бэлтгэлд онцгой байр суурь эзлэх ёс суртахууны асуудал чухал үүрэг гүйцэтгэнэ. Цэрэг дайчдыг эх оронч, хамт олонч, цэргийн албаны хариуцлагыг чанд мөрдөж төлөвшүүлэхэд нөлөөлж, хүний үнэт зүйлсийн баримжааллыг бий болгох шаардлагатай.

Бие бүрэлдэхүүнийг дайсны мэдээлэл, сэтгэл зүйн нөлөөллөөс хамгаалах ажил нь

- Үүрэг гүйцэтгэж буй газар нутагт цэрэг-улс төр, нийгэм, сэтгэл зүйн нөхцөл байдалд байнга дүн шинжилгээ хийх, урьдчилан таамаглах, хамгаалах;

- ЦАХ-ын ухамсар, зан үйлд хор хөнөөлтэй нөлөө үзүүлэх сөрөг мэдээллийг таслах;
- Дайсныг сөрөг мэдээлэл-сэтгэл зүйн нөлөөллийг эсэргүүцэх, эрчимтэй сөрөг суртал ухуулга явуулах;
- Бусад байгууллагуудтай нягт харилцан ажиллах /олон нийт, соёл, шашин/

Гадаадын зарим орнуудын цэргийн оюун санаа, сэтгэл зүйн хамгаалалтын асуудлыг авч үзье. АНУ-ын зэвсэгт хүчний ЦАХ-ын сэтгэл зүйн бэлтгэл нь бүх төрлийн байлдааны бэлтгэлжилтийн явцад цэргийн нэгтгэл, ангийн бэлэн байдлыг дээшлүүлэх, ёс суртахуун-сэтгэл зүйн тогтвортой байдлыг бий болгоход чиглэсэн байлдааны сургалтын агуулга, зорилготой нийцсэн арга хэлбэрүүдийг багтаасан тусгай хөтөлбөрийн дагуу явагддаг байна. Харин Хятад, Япон болон НАТО-гийн эвслийн орнуудын ЦАХ-ын сэтгэл зүйн хангалтын үндсэн чиглэлдээ цэргийн мэргэжлийн өндөр ур чадвар, алба хаах хүсэл сонирхол, удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэхэд бэлэн байх бэлтгэл, эх оронч үзэл, үндэсний үнэт зүйлсээ хайрлах сэтгэл, түрэмгий чанар, бие бялдрын өв тэгш хүмүүжил зэрэг чанарыг бие бүрэлдэхүүнд эзэмшүүлж, хөгжүүлэхэд чиглэгддэг. Түүнчлэн дэлхийн хүчирхэг, хөгжлөөрөө тэргүүлэх улс, орнуудын



зэвсэгт хүчний бүрэлдэхүүн нь мэргэжлийн бэлтгэлийн өндөр түвшинд бүрэн итгэлтэй, тухайн улсын иргэн, зэвсэгт хүчнийхээ нэг хэсэг гэдгээрээ байнга бахархах, дайчин уламжлалыг баримтлах, оюун санаа, сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй байхыг **“хамгаалалттай оюун санаа, сэтгэл зүйн бэлтгэлтэй байна”** хэмээн ойлгодог байна.

“Цэргийн оюун санаа, сэтгэл зүйн асуудлын хувьд⁵:

1. Бие бүрэлдэхүүний сургалт, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах хамгийн үр ашигтай арга зам, хэрэгслийг боловсруулах
2. Цэргийг байлдааны бэлэн байдалд хамгийн богино хугацаанд оруулах аргыг хайж оруулах
3. Удирдах бүрэлдэхүүний ажлын арга барил, цэргийн хэргийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах ажлыг сайжруулахад анхаарал хандуулах юм.

Эндээс бие бүрэлдэхүүний оюун санаа, сэтгэл зүйн зарим үндсэн зорилгыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Цэргийн албыг амжилттай хаах;
- Болзошгүй ажиллагаанд шаардлагатай сэтгэл зүйн ухааны зүй тогтлыг илрүүлэх;
- Бие бүрэлдэхүүний үйл ажиллагааны идэвхийг дээшлүүлэх сэтгэл зүйн арга замыг боловсруулах зэрэг болно.

Дээрх зорилтыг шийдвэрлэхийн тулд дараах хамгаалалтын ажил, арга хэмжээг хэрэгжүүлж болох юм. Үүнд:

1. Бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, тэдгээрийн сэтгэцэд цэргийн үйл ажиллагааны үзүүлж буй үр нөлөөг судлах /хувь хүн, хамт олны дунд сэтгэл зүйн судалгаа явуулах/;
2. Мэдээлэл, сэтгэл зүйн ажиллагааг идэвхтэй явуулах /сөрөг мэдээллүүдийг няцаах/;
3. Эсрэг талын бие бүрэлдэхүүний үндэсний болон сэтгэл зүйн онцлогийг

судлах;

4. Хээрийн дадлага сургуулийг байлдааны нөхцөлд ойртуулах /дарамт, аюул, бэрхшээл, амь дүйсэн, хүч чадал гаргах гэх мэт/;
 5. Сэтгэцэд нөлөөлөх сөрөг хүчин зүйлүүдийг илрүүлэх /тодорхойгүй байдал, хүлээлт, хоол хүнсний дутагдал, амрах ая тухгүй байдал гэх мэт/;
 6. Зөрчил, дутагдал, осол, гэмтлийн сэтгэл зүйн шалтгаан, нөлөөлөлд дүн шинжилгээ хийх зэрэг болно.
- Бие бүрэлдэхүүний сургалт, оюун санаа, сэтгэл зүйн бэлтгэлийг харилцан хамааралтай явуулснаар

1. Өөрийн зан үйл, үйлдэл, үйл ажиллагааг ямар ч нөхцөлд хэвийн тогтвортой, өөрийгөө удирдаж хянаж жолоодох чадвартай, сэтгэл зүй, бие бялдрын тэсвэр хатуужилтай болно.
2. Өөрийн хүлээсэн үүрэг, гүйцэтгэх даалгавар, үйл ажиллагааны мөн чанар, ач холбогдлыг ухамсарлаж, түүнийг өндөр ач холбогдолтой биелүүлэх эр зоригийн хүмүүжил төлөвшиж, суралцах.
3. Байлдааны болон амь өрссөн аюултай нөхцөл байдлыг зөв тусгаж, хүртэж хүлээж авах, айдсыг даван туулах чадварыг эзэмшсэн, сургагдсан буюу сэтгэл зүйн бэлтгэлтэй болгох зэрэг үр дүнд хүрнэ.

Бие бүрэлдэхүүний оюун санаа, сэтгэл зүйн хамгаалалтыг нэмэгдүүлэх арга зам нь:

1. Сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах эрх зүйн орчныг сайжруулах;
2. Зэвсэгт хүчний анги, байгууллагын сэтгэл зүйн хангалтын бүтэц, орон тоог нэмэгдүүлэх, албан тушаалтнуудыг зохих жижигт нийцүүлэн мэргэшүүлэх, томилгоог оновчтой зохион байгуулах;
3. Сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх /сэтгэл зүйн

⁵ Пүрэвдорж С., “Цэргийн нэгтгэл ангийн бие бүрэлдэхүүний оюун санаа, сэтгэл зүйн хамгаалалтын зарим асуудалд” “ЦАЦ” Сэтгүүл 2019 он №15 /38/, т62



- алжаал тайлах төв, лаборатори, танхим, хотхон, байр, нөхөн сэргээлтийн байр/;
4. Сэтгэл зүйн албан тушаалтнуудын чадварыг дээшлүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх
 5. Сэтгэл зүйн хангалтыг шинэлэг арга хэлбэрээр, мэдээлэл технологийн хөгжилд тулгуурлан явуулах, туршлага, сургамжийг судлах;
 6. Бүх шатны захирагч, дарга нарын сэтгэл зүйн болон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх арга барилыг дээшлүүлэх зэрэг болно.

Эндээс харахад ёс суртахуун сэтгэл зүйн бэлтгэл нь дайн байлдаанд ялалт байгуулахад шаардагдах байлдааны ёс суртахуун, сэтгэл зүйн чанаруудыг олгох, ёс суртахуун–улс төрийн хувьд дайнд бэлэн байхаар тодорхойлогдоно.

Мэдээллийн эрин зуунд цэргийн алба хаагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх, мэдээ, мэдээллээс хамгаалах, өөрийн удирдлага, зэвсэг техниктээ итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн чанартай сургалт зайлшгүй шаардлагатай.

Сүүлийн үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлага, сургамжаас харахад дайчдыг ямар ч хүндрэл бэрхшээлийг даван туулах, ялан дийлэх, сөрөг мэдээлэлд өртөхгүй, түүнийг няцаах чадвартай болгох асуудлыг улам бүр хурцаар тавьж байна.

Дүгнэлт. Сүүлийн үед явагдаж байгаа жижиг бүлгийн шинжтэй дайн, зэвсэгт

мөргөлдөөний туршлага сургамжаас харахад дайтагч талуудын гадаад дотоод сэтгэл зүйн орчин, нийгэм, цэрэгжсэн байгууллагын сэтгэл зүйн ёс суртахуун байдал, эх оронч үзэл хүмүүжил нь түүний ялалтад хүрэх нэг чухал хүчин зүйл болж байна.

Жижиг бүлгийн байлдааны талаарх үзэл баримтлалд сэтгэл зүйн хангалтын үндсийг ул үндэстэй болгох шаардлага тулгарч ирээдүйд болзошгүй жижиг бүлгийн байлдааны арга тактикт нийцсэн сэтгэл зүйн ажлыг үе шаттай, стратеги, тактикийн түвшинд авч үзэж улс үндэсний, зэвсэгт хүчний, цэргийн алба хаагч бүрд хүргэх замаар зохион байгуулах тогтолцоог шинжлэх ухаанч, туршлага, сургамжид тулгуурласан төлөвлөлт бий болгох шаардлага тулгарч байна гэж үзэж байна.

Жижиг бүлгийн байлдааны үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүн нь монгол улсын иргэн, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нэгээхэн хэсгийн хувьд үндэсний эх оронч үзэл хүмүүжил, нийгмийн сэтгэл зүйн дархлаа, цэргийн алба хаагчийн эрхэмлэх үнэт зүйлсийг дээдлэх чанар хэрхэн төлөвшиж бий болсноор сэтгэл зүйн тогтвортой байдлын үндэс суурь тавигдана. Иймд жижиг бүлгийн байлдааны үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний сэтгэл зүйн хангалтын асуудалд онцгой анхаарал хандуулах нь тэдний өмнө тавигдсан үүргийг амжилттай биелүүлэх үндсэн суурь болно.

Ашигласан материал:

Эрдэм шинжилгээ судалгааны бүтээлүүд:

1. Х.Орхончимэг. Монголын эртний улсуудад цэргийн сургалтын үүрэг хэрэгжсэн нь. БХЭШХ-ийн Аюулгүй байдал батлан хамгаалах судлал” сэтгүүл. 2022 °35(45)
2. С.Пүрэвдорж “Цэргийн нэгтгэл ангийн бие бүрэлдэхүүний оюун санаа, сэтгэл зүйн хамгаалалтын зарим асуудалд” “ЦАЦ”., Сэтгүүл 2019 он
3. Ч.Цогтжаргал “Жижиг бүлгийн байлдааны үндэс”., 2010 он
4. Ч.Цогтжаргал “Жижиг бүлгийн тактик”., 2007 он
Ном сэтгүүлүүд
1. “Мэдээллийн дайн” Хамтын бүтээл., 2022 он
2. Цэргийн шинэчлэл сэтгүүл. УБ., 2006 он °02 /18-19-р хуудас/;
3. Б.Түмэн “Оперативын урлаг”., 2021 он
4. Т.Мөнхсаруул “ Цэргийн ёс суртахуун сэтгэл зүйн хангалт” , УБ., 2012 он
5. Г. Мягмаржав “Сэтгэл зүйн бэлтгэл ” УБ 2005 он
6. С.Энхтайван “Цэргийн сэтгэл зүй ” УБ 2007 он



МОНГОЛ УЛС, БНФУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ФРАНЦ ХЭЛНИЙ СУРГАЛТ (ҮБХИС)

Д.ИДЭШНОРОВ /ҮБХИС-ийн ЭШИХ-ийн дарга, доктор (Ph.D), хошууч/
Н.УРАНЧИМЭГ /ҮБХИС-ийн ГХСТ-ийн багш, докторант/

Түлхүүр үг: Гадаад хэлний сургалт, цэргийн алба хаагчид, цэргийн мэргэжлийн сургууль, цэргийн хамтын ажиллагаа, энхийг дэмжих ажиллагаа

Key words: Foreign language training, military personnel, military vocational schools, military cooperation, peace support operations

Нэг. Монгол Францын харилцаа


Монгол Улс Франц Улстай 1965 онд дипломат харилцаа тогтоосон бөгөөд 1966 онд Франц Улсын анхны элчин сайд Монгол Улсад суухаар томилогдсон байна. Гэвч тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан тус ЭСЯ 1984 онд хаагджээ. Монгол Улс Франц Улсад суух ЭСЯ-аа 1969 онд нээсэн байна. Франц улс нь Монгол дахь ЭСЯ-аа 1996 онд дахин нээж, элчин сайдаар ноён Жа Оливье Манан томилогдсон¹.

Түүхээс сөхөж харвал Монгол, Францын харилцааны эхлэл тэртээ 800 гаруй жилийн өмнө тавигдсан түүхтэй. 1252 онд Францын Людвиг IX хааны зарлигаар Их Монгол Улсын нийслэл Хархорум хотноо Францын хааны элч Уиллиам дэ Рубрук анх хүрэлцэн ирж байсан


бол 1289 ба 1305 онуудад Ил хаант улсын Аргун түүний хөвүүн Илхаан Өлзийт нар Францын хаан Гоо Филипптэй харилцаа тогтоож, захидал бичиг солилцож байв.

Эдгээр захидлыг Абел-Ремуза² Францын Үндэсний Архиваас олж 1824 онд хоёр захидлын чулуун барын хуулбарыг худам монгол бичгийн галиг, хагас хугас орчуулга, тайлбар сэлттэй хамтатган хэвлүүлсэн нь эрдэмтдийн хүрээнд даруй шуугиан дэгдээсэн учир гэвэл ганц түүхийн талаасаа төдийгүй хэл судлалын үүднээс бас чухал байсанд оршино³. (1, 2 дугаар зураг)

Мөн 1254 онд Францын архитекторч Вильгельм Бушьегийн удирдлага дор Хархорум дахь алдарт Мөнгөн модыг урлан бүтээсэн



1 дүгээр зураг⁴. /Аргуны захидал 1289 он/



2 дугаар зураг⁵. /Өлзийтийн захидал 1305 он/

¹ Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг сахиулахын цагаан ном 1999–2015. УБ., 2015, т218

² ABEL-RÉMUSAT, JEAN-PIERRE (1788–1832) Францын анхны хятад соёл, хэл судлаачдын нэг

³ А.Мостэрт, Ф.В. Клиев "Ил хаан Аргун, Өлзийт нараас 1289, 1305 онд гоо Филипп илгээсэн захидлууд" УБ., 1998, т19

⁴ Мөн тэнд. iii дахь тал

⁵ Мөн тэнд. X дахь тал



байдаг.

Нэн шинэ түүхийн үед буюу 1946–1961 онд БНМАУ–ыг НҮБ–д элсүүлэхийг Франц Улс анхнаас нь тууштай дэмжиж ирсэн бөгөөд 1946 онд НҮБ–ын Аюулгүйн Зөвлөлд сууж байсан Францын Байнгын төлөөлөгч А.Пароди хэлэхдээ “Монгол шиг эртний аугаа их түүхтэй, эртний төрт улс НҮБ–д заавал байх ёстой” гээд манай улсыг дэмжсэн санал өгч байжээ⁶.

Франц улс нь Европ тив дэх Монгол Улсын ойрын чухал түнш, гуравдагч хөршүүдийн нэг, тус улсын Ерөнхийлөгч Э.Макрон манай улсад 2023 оны 5 дугаар сарын 21–нд төрийн айлчлал хийсэн нь хоёр орны харилцааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой, харилцааны түүхэнд шинэ хуудас нээсэн үйл явдал болсон билээ. Уг айлчлал нь хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойших 58 жилийн хугацаанд Францын талаас төрийн тэргүүний түвшинд хийсэн анхны айлчлал гэдгээрээ онцлог байв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, БНФУ–ын Ерөнхийлөгч Эммануэл Макрон нар албан ёсны уулзалт, хэлэлцээний үр дүнгийн талаар мэдээлэл хийж, уулзалт, хэлэлцээ үр дүнтэй болж, харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон гэдгийг төрийн тэргүүн нар тэмдэглэв⁷.

Ташрамд сонирхуулахад, 1986 онд Францын ерөнхийлөгч асан Валери Жискар д’Эстэн БНМАУ–ын Ардын Их Хурлын урилгаар Улаанбаатар хотноо айлчлан ирж байсан бол 1996 онд Ерөнхийлөгч П.Очирбат, 2007 онд Ерөнхийлөгч Н.Энхбаяр, 2015 онд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нар Франц улсад айлчилж байжээ⁸.

Монгол Улс Франц Улсыг чухал “Гуравдагч хөрш” гэж үздэг бол Франц Улс Монгол Улсыг “Онцгой түнш” гэж тодорхойлдог. Монгол,

Францын харилцаа “Найрсаг харилцаа, хамтын ажиллагаа”–ны түвшинд нэгэн жарны турш амжилттай хөгжиж ирсэн бол өдгөө харилцааны түвшнийг ахиулж, “Иж бүрэн түншлэл”–д, цаашдаа “Стратегийн түншлэл”–д хүргэхээр талууд зорьж байна⁹.

Хоёр. Франц, Монголын батлан хамгаалах салбарын харилцаа

Монгол, Франц хоёр улсын дипломат харилцаа сүүлийн жилүүдэд, ялангуяа Батлан хамгаалах салбарт улам бүр хөгжиж байгааг бид харж байна.

Франц, Монгол хоёр улс батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг сургуулилт хийх, цэргийн салбарт туршлага солилцох зэрэгт тулгуурлан хөгжүүлж байна.

Хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн зарим үйл явдлыг онцолвол:

- ОХУ–аас Монгол Улсыг хавсран сууж байсан Францын элчин сайд Н.Моррелийг 1995 оны 5 дугаар сард Монголд айлчлахад ЭСЯ–ны батлан хамгаалахын атташегийн аппаратын ажилтан дэд хурандаа Жак Бильбо дагалдан ирж манай БХЯ–ны холбогдох ажилтнуудтай уулзаж албан ёсоор танилцсан байна.
- Францын Батлан хамгаалахын атташе бригадын генерал Бернар Оседа 1996 оны 5 дугаар сард Монгол ирж Батлан Хамгаалахын дэд сайд Ц.Дашзэвэгтэй уулзаж, Францын цэргийн сургалтад монголын офицерыг хамруулах асуудлыг тохиролцон, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон байна.
- Батлан Хамгаалахын сайд Ж.Гүррагчаа 2001 оны 10 дугаар сард Францын элчин сайд О.Манантай уулзаж хоёр орны цэргийн хамтын ажиллагааны талаар

⁶ <https://montsame.mn/mn/read/> Монгол–Франц: Түүхэн харилцааг шинэ шатанд гаргах төрийн айлчлал

⁷ <https://paris.embassy.mn/> ЭСЯ–НЬИ МЭДЭЭ.

⁸ <https://montsame.mn/mn/> Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Франц Улсад төрийн айлчлал хийхээр эх орноосоо мордлоо.

⁹ <https://montsame.mn/mn/read/> Монгол–Франц: Уламжлалт харилцаанд шинэ хуудсыг нээсэн айлчлал.



- ярилцаж Францын цэргийн сургалтад хамрагдах, энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах асуудлаар ярилцсан.
- ГХХАХ-ийн дарга хурандаа Н.Нүрээд Франц улсаас Монгол Улсад суугаа батлан хамгаалахын атташе, 3 дугаар нарийн бичгийн дарга нартай 2002 оны 3 дугаар сард тус тус уулзаж, Франц Улсад Монголын цэргийн албан хаагчдыг сургах боломж, **БХИС-д франц хэлний сургалт явуулах асуудал дэвшүүлсний дунд 2004 болон 2006 онд 1 цэргийн албан хаагч Франц улсад хэлний дамжаа болон багшлах дадлагын дамжаанд суралцсан ба БХИС-д франц хэлний дамжаа хичээллэх болсон**¹⁰.
 - Францын БХЯ-ны төлөөлөгч 2002 оны 6 дугаар сард Монгол Улсад айлчил энхийг сахиулах анги болон цэргийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцах дээрх болон мина арилгах чиглэлээр хүн сургах боломж байгааг мэдэгдсэн болно.
 - Франц Улсын Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Фредерик Кансир Монгол Улсад 2004 оны 3 дугаар сараас 2007 он, хошууч Ж.Даррас 2007 2008, дэд хурандаа Надя Пьерси (Nadia PIERCY) 2008 оны 10 дугаар сараа 2012 оны 7 сар хүртэл Бээжингээс хавсран суусан ба одоо Бээжин дэх ЭСЯ-ны дэргэдэх Батлан хамгаалахын атташе хурандаа Дэпонсэль Филип (Philippe DEPONCELLE), дэд хурандаа Серил Дюпон (Cyril DUPONT), дэд хурандаа Арно Шасан (Arnaud CHASSAING), хошууч Карин Пужет (Celine POUGET) тус тус Монгол Улсыг хавсран ажилласан ба 2023 оны 10 сараас хошууч Амандин Крос (Amandine CROS) үргэлжлүүлэн ажиллаж байна.
 - **Францын Батлан хамгаалахын атташегийн дэмжлэгтэйгээр БХИС-ийн Дэргэд франц хэлний сургалтын төвийг байгуулсан бөгөөд анхан шатны ба гүнзгийрүүлсэн дамжаа хичээллүүлж байна**¹¹.
 - 2008 оны 11 дүгээр сард БНФУ-аас буцалтгүй тусламжийн журмаар Монгол Улсын Зэвсэгт хүчинд нийлүүлсэн 483,2 сая төгрөгийн үнэ бүхий цэргийн хувцас хэрэглэлийг хүлээн авсан.
 - 2009 оны 11 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд БНФУ-ын БХЯ-ны Зэвсэглэлийн удирдах газрын Ази Номхон далайн бүс нутгийн орнуудынасуудлыг зохицуулагч хурандаа Пиеэ (Pillet) тэргүүтэй төлөөлөгчид ажлын айлчлал хийв. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тус газрын мэргэжилтэн Грэли, "Талес" компаний төлөөлөгч Годель, "Еврокоптер" компаний төлөөлөгч Тресамини, БНФУ-аас Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе Надя Пьерси нар багтсан болно. Тус ажлын айлчлалаар хоёр тал тус тусын Зэвсэгт хүчний зэвсэг, техникийн хангалт хийдэг газрын бүтэц зохион байгуулалт, журам, мөн зэвсэг, техник болон бусад тоног төхөөрөмж нийлүүлдэг БХЯ-ны харьяа болон гадны бусад байгууллагууд, гаргадаг бүтээгдэхүүний талаар харилцан мэдээлэл хийж, санал солилцов. Монголын талаас одоо шаардлагатай байгаа техник хэрэгсэл, тэдгээрийг дэмжлэг тусламжийн журмаар нийлүүлэх боломжийг судлах саналыг францын талд дэвшүүлсэн байна.
 - ... БНФУ-аас Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе Надя Пьерситай БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, холбогдох мэргэжилтнүүд тусдаа уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудал, үүний дотор дээд, дунд түвшний албан хаагчдын харилцан айлчлал, францын

¹⁰ Батлан Хамгаалах Гадаад Харилцаа, Хамтын Ажиллагаа, Энхийг Сахиулахын Цагаан Ном 1999-2015. Уб., 2015, т219

¹¹ Мөн тэнд, т219

цэргийн сургуулиудад монголын цэргийн албан хаагчдыг үргэлжлүүлэн суралцуулах, тоог нэмэгдүүлэх, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд хамтран үүрэг гүйцэтгэх асуудлыг гүнзгийрүүлэн судлах. Чад Улс дахь НҮБ-ын ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн баг оролцож эхэлсэн, цаашид Суданы Дарфур дахь Африкийн Холбоо, НҮБ-ын хамтарсан энхийг сахиулах ажиллагаанд манай Зэвсэгт хүчний 2 дугаар түвшний цэргийн хээрийн эмнэлгийг оролцуулахтай холбогдуулан манай албан хаагчдад **франц хэлний мэдлэг авахын хэрэгцээ өндөр байгаа, манай БХИС-ийн франц хэлний сургалтыг сайжруулах материаллаг баазыг бэхжүүлэх, багшаар хангах**¹² асуудлыг хөндөж санал бодлоо солилцсон.

- БНФУ-ын нийслэл Парис хотноо 2012 оны 6 дугаар сарын 11–13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Евросатори 2012" олон улсын зэвсэглэл техникийн үзэсгэлэнгийн арга хэмжээнд Батлан хамгаалахын дэд сайд С.Баасанхүү тэргүүтэй төлөөлөгчид оролцсон ба үзэсгэлэнгийн үеэр БНФУ-ын Цэргийн нэгдсэн штабын зарим удирдлагатай ажлын уулзалт хийж хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцов.
- БНФУ-ын Үндэсний Батлан хамгаалахын (SGDN) Ерөнхий нарийн бичгийн дарга Франсис Дэлони 2013 оны 7 дугаар сарын 03–05-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан есны айлчлал хийх хийх үеэр Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ хүлээн авч уулзаж хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцааны асуудлаар санал солилцсон.

Цаашид хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг дээд, дунд түвшний төлөөлөгчдийн уулзалтыг харилцан хийх, францын цэргийн

сургуулиудад монголын цэргийн албан хаагчдыг үргэлжлүүлэн суралцуулах, тоог нэмэгдүүлэх, энхийг дэмжих чиглэлээр дэмжлэг тусалцаа авах, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд хамтран үүрэг гүйцэтгэх; **Монгол Улсын БХИС-ийн франц хэлний сургалтыг сайжруулах. материаллаг баазыг бэхжүүлэх;** мэдээлэл солилцох зэрэг чиглэлээр хөгжүүлэхээр хоёр тал ажиллаж байна.

Гурав. ҮБХИС-ийн ГХСТ-ийн франц хэлний сургалт

ҮБХИС 100 жилийн ойгоо ёслол төгөлдөр, хүндэтгэлтэйгээр тэмдэглэн өнгөрүүлээд удаагүй байгаа билээ. Батлан хамгаалах салбарын үе үеийн гадаад хэлтэй боловсон хүчнийг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан ГХСТ-өөр бахархдаг бөгөөд тус төв нь гадаадын долоон хэлээр сургалт зохион байгуулдаг, удахгүй хагас зууны түүхтэйгээ учран золгох ҮБХИС-аас өөр хаана ч байхгүй гадаад хэлний төв юм.

ГХСТ-д Франц хэлний сургалт зохион байгуулагдсанаас хойш 200 гаруй офицер, ахлагч нар франц хэл сурсан байна.

Монгол Улсын Зэвсэгт Хүчин, ОБЕГ /Онцгой байдлын ерөнхий газар/ /Agence Nationale De Gestion Des Urgences/, "Дотоод Хэргийн Их Сургууль" /University of Internal Affairs /, ШШГЕГ-ын / General Executive Agency of Court Decision/ офицер ахлагч, албан хаагчдад гэх мэт өргөн хүрээнд франц хэлний сургалтыг зохион байгуулж ирсэн.

2023 оны байдлаар дэлхий даяар ойролцоогоор 321 сая хүн франц хэлээр ярьж байна. Үүнээс 235 сая нь өдөр тутмын үйл ажиллагаа, ажил мэргэжил, 90 сая хүний төрөлх хэл нь жээ. 2018 оны судалгаагаар 80 сая сурагч, оюутан франц хэл сурчээ. Олон улсын Франкофони байгууллагын (OIF) мэдээлснээр 2050 он гэхэд дэлхий дээр 700 сая франц хэлээр ярих магадлалтай хэмээжээ. Франц хэл нь англи, хятад, хинди, испани хэлний дараагаар дэлхийд тавдугаарт ордог ба

¹² Мөн тэнд, т220



дэлхий дээрх хамгийн их сурсан хоёр дахь хэл, бизнес, худалдааны гурав дахь хэл, интернетэд ашигладаг дөрөв дэх хэл юм¹³.

НҮБ-ын албан ёсны зургаан хэлний нэг бөгөөд НҮБ-ын ажлын хоёр хэлний нэг ; түүгээрч зогсохгүй Франц хэл нь олон улсын засгийн газрын олон байгууллагын албан ёсны буюу ажлын хэл юм.

Энэ жил Монгол Улсад франц хэл зааж эхэлсний 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлээ.

ҮБХИС-ийн ГХСТ-ийн хувьд 2003–2004 оны хичээлийн жилд анх франц хэлийг зааж эхэлсэн бөгөөд эдүгээ франц хэлний анхан, дунд шатны дамжаа хичээллэж төгсөгчид DELF A1, A2, B1 шатны шалгалтыг амжилттай өгч Канад улсын Сянт Жон дахь /Saint Jean/ цэргийн хэлний төвд франц хэлийг гүнзгийрүүлэн судлахаас гадна БНФУ-д цэргийн төрөл мэргэжлийн сургалтанд амжилттай суралцан Монгол Улсын ЗХ-д үнэтэй боловсон хүчин болон ажиллаж байна. Тухайлбал:

ҮБХИС-ийн ГХСТ-д франц хэл сурсан офицер ахлагч нар БНФУ-ын Парис хот дахь “Йcole de guerre” буюу Дайны коллежи болон явган цэрэг, инженер, артиллер, ар тал, эмнэлэг, ахлагчийн сургууль гэх мэт олон чиглэлээр сургалт дамжаанд суралцаж байна. Одоогийн бадлаар Канад улсад 40 гаран офицер, ахлагч, БНФУ-д 30 гаран офицер, ахлагч /давтагдсан тоогоор/ нар тус тус сургалт дамжаанд хамрагдаад байна.

Түүнчлэн Монгол Улс дахь БНФУ-ын элчин сайдын яам, Улаанбаатар хот дахь Монгол, Францын соёлын төвөөс зохион байгуулдаг “Франц хэлний өдөр” буюу дэлхийн олон улсад зохиогддог соёлын төрөл бүрийн арга хэмжээнд тус төв хамтрагч байгууллагын хэмжээнд оролцож, суралцагчид уралдаан тэмцээн, олимпиадад жил бүр оролцож тодорхой амжилт гарган Батлан хамгаалах салбар болон сургуулийнхаа нэрийг өндөрт өргөж ирснийг бахархалтайгаар дурдахад таатай байна. Тухайлбал:

- 2011 онд Франц хэлний улсын 15-р

олимпиадад д/ч Н.Насанбат Тэргүүн байр эзэлсэн.

- 2013 онд Франц хэлний улсын 17-р олимпиадад д/ч Н.Наранцогт уран уншлагын төрөлд 5-р байр
- 2015 онд Франц хэлний улсын 18-р олимпиадад д/ч Х.Үүрийнтуяа цээж бичгийн төрөлд шагналт байр
- 2023 Франц хэлний улсын 24-р олимпиадад д/ч Б.Түмэн-Өлзий Дэд байр тус тус шалгарсан байна.

ГХСТ нь гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд БНФУ-ын Элчин Сайдын Яам, францын батлан хамгаалахын атташе болон Улаанбаатар дахь Францын /Alliance Française/ холбоотой хамтран ажиллаж ирсний дүнд францын талаас сурах бичгийн хангалтыг нэмэгдүүлэх, франц хэлний хичээлийн танхим, сургалтын орчинг сайжруулах, тохижуулахад маш их дэмжлэг үзүүлээд зогсохгүй жил бүр ярианы франц багшийг илгээж ажиллуулдаг сайхан уламжлал тогтоод байна.

2010 оноос хойш Нелсон Да Роша /Nelson DA ROCHA 2010–2011, 2011–2012/, Тимотей /Timotei 2012–2013/; 2013–2014 Алисон Пвалве /Alison POILVEZ/; Мари Севин /Marie SIVIN/, Патрик /Patrick 2015–2016/, Биндика Квела Санси /2016–2017 Bindika KWILA SANSI/, Эмэлин Девиж /Emeline DEVIGE 2017–2018/, Сарах Ламүрүкс /2018–2019 Sarah LAMOUROUX/, Марлен Пиотери /Marline PIOTEYRY 2020–2021/ ; Лиз Ле Лем /2021–2022 Lise LE LEM/, Женнифер Деспрез /2022–2023 Jennifer DESPREZ/ нар тус тус хамтран ажиллаж энэ хичээлийн жилд Шарлот Бонин /2023–2024 Charlotte BONIN/ ярианы дадлагын хичээл зааж байна.

Дүгнэлт. Монгол Улсын ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макроны урилгаар 2023 оны 10 дугаар сарын 10–14-ний өдрүүдэд франц улсад төрийн айлчлал хийсэн билээ.

Хэлэлцээний үеэр Монгол, Францын

¹³ <https://mn.ambafrance.org/> Мөн тэнд, т220



хооронд энэ онд Төрийн тэргүүний түвшний анхны айлчлалыг харилцан хийж байгаа нь хоёр улсын “онцгой эрхт” түншлэлийг бататгах, хамтын ажиллагааг бүхий салбарт өргөжүүлж, “стратегийн түвшин”-д хүргэх нийтлэг зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө байгааг талууд онцлов¹⁴.

Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Франц Улсын Европ, Гадаад хэргийн сайд Катрин Колоннаттай Парис хотноо албан хэлэлцээ хийж, хоёр орны харилцааг “Стратегийн түншлэл”-д хүргэхээр тохиролцлоо¹⁵.

Улмаар Монгол, Францын Онцгой эрхт түншлэлийн харилцааг өргөжүүлж, стратегийн түншлэлд хүргэхэд чиглэсэн “Монгол Улс, Бүгд Найрамдах Франц Улс хоорондын хамтын ажиллагааны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд Гадаад харилцааны сайд нар гарын үсэг зурсан байна.

Ийнхүү хоёр улсын Төрийн тэргүүн нар энэ онд төрийн айлчлал анх удаа харилцан хийж, маш богино хугацаанд тодорхой үр дүнтэй ажиллаж байгааг талууд онцолж, тохиролцсон асуудлыг эрчимтэй урагшлуулахаа нотолсон чухал үйл явдал болсон гэж үзэж байна.

Эдгээр бүх түвшний уулзалтын ачаар хоёр улс ардчилал, хүний эрх, үндсэн эрх чөлөө, хууль дээдлэх ёс зэрэг харилцан хүндэтгэл, нийтлэг үнэт зүйлд суурилсан бат бөх түншлэлийн харилцаагаа дахин нотолсон гэдгийг бид харж байна.

Түүнчлэн, хоёр улс батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаагаа дараах ажлуудаар өргөжүүлэхээр тохиролцов: Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа, тэр дундаа жил бүр зохион байгуулдаг олон үндэстний “Хааны эрэлд” сургуулилт, НҮБ-аас энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх ажиллагааг үргэлжлүүлэх, Батлан хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих, чадавхийг бэхжүүлэх, франц хэл сурах, боловсон хүчнийг тусгайлан сургах гэх мэтээр заасан байна¹⁶.

Хоёр орны хамтын ажиллагаа бүхий л салбарт тусгалаа олохын зэрэгцээ батлан хамгаалах салбарын харилцаа, франц хэлний сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх нь чухал байр эзэлж байна гэж дүгнэж байна.

Ашигласан материал:

1. Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг сахиулахын цагаан ном 1999-2015. УБ., 2015
2. Д.Уламбаяр Монгол улсын “Монгол Улсын “Гуравдагч хөршийн бодлого” УБ., 2020
3. А.Мостэрт, Ф.В.Кливи “Ил хаан Аргун, Өлзийт нараас 1289,1305 онд Гоо Филипт илгээсэн захидлууд” УБ., 1998
4. Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”
5. <https://montsame.mn/mn/read/>
6. <https://paris.embassy.mn/>
7. <https://president.mn/>
8. <https://mn.ambafrance.org/>
9. <https://montsame.mn/mn/>
10. <https://mfa.gov.mn/>
11. <https://www.elysee.fr/>

¹⁴ <https://mfa.gov.mn/> МОНГОЛ, ФРАНЦЫН ХАРИЛЦААГ СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛД ХҮРГЭХЭЭР ТОХИРОЛЦЛОО

¹⁵ Мөн тэнд

¹⁶ <https://www.elysee.fr/emmanuel-macron/2023/05/21/declaration-conjointe-de-la-france-et-de-la-mongolie>



ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦИЙН СУДАЛГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Д.ДОЛГОРМАА /ҮБХИС-ийн ЦНДС-ийн мэдээлэл арга зүйн мэргэжилтэн/
Ц.ХОНГОРЗУЛ /ҮБХИС-ийн АБДС-ийн ММТТ-ийн багш/

Түлхүүр үг: Усны нөөц, гүний ус, экологийн эмзэг тогтоц

Key words: Water resources, groundwater, ecologically sensitive formations

Оршил. Дэлхийн царцдас дотор янз бүрийн байршил ба хөдөлгөөнд орших усыг газрын доорх ус гэх бөгөөд нэгдэх нь дусал маягийн ус (хүндийн хүчний) хөрс чулуулгийн нүх сүвийг эзлэн орших бөгөөд байгалийн болон зохиомол зүсэлтээр чөлөөтэй урсан гарах чадвартай, удаах нь газар доорх чийг хэлбэртэй ус газрын хөрс, ул чулуулгийн зай завсар, нүх сүвд чөлөөтэй хэлбэрээр орших бөгөөд зарим тохиолдолд хөрсний зүсэлтээр өөрөө урсаж гарах чадваргүй байдаг.

Газрын доорх ус хөрсөнд ихэнхдээ байнгын хөдөлгөөнтэй байж, хөрс чулуулагт механик болон химийн нөлөөлөл үзүүлдэг. Газрын гадаргууд унасан тунадасны хөрсөнд шингэсэн хэсэг улмаар үндсэн хоёр хэсэгт хуваагдах бөгөөд нэг хэсэг нь хөрсний өнгөн хэсэгт тархаж, түүнийг чийглэх ба тэр нь уг хөрсний байгалийн чийглэг буюу тухайн хөрсний хамгийн бага чийг багтаамжийг бүрдүүлдэг байхад, нөгөө хэсэг нь аажмаар ул хөрсөнд нэвтрэхдээ хүндийн хүчний нөлөөллөөр ус үл нэвтрэх чулуулаг хүртэл доошилж, хөрсний уст үеийг үүсгэх ба тэр нь ул хөрсний тогтцын хэвгийг даган аль нам доор байрлал руу чиглэсэн хөдөлгөөнд ордог байна. Энэ нь газрын гүний чулуулгийн нүх сүвийг дүүргэж, газрын доорх усны нөхөгдөх нөөцийг бүрдүүлдэг.

Газрын доорх ус нь экологийн нэн эмзэг тогтоцтой, усны горим тэжээлийн систем нь өвөрмөц, нөхөн сэргэх хугацаа нь хэдэн арав, хэдэн зуун жилээр тооцогддог учраас газрын доорх усыг онцгой хамгаалалтад авч нөхөн сэлбэгдэх хэмжээнээс үл хэтрүүлэн ашиглах шаардлагатай байдаг. Тийм ч учраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.

дугаар заалт Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах үндэст усны нөөцийг хамгаалах асуудлыг онцгойлон зааж өгсөн байдаг.

Үндсэн хэсэг. Хүн төрөлхтөн, байгаль дээрх амьтан, ургамал зэргийн биологийн биет нь агааргүйгээр амьдрахгүйтэй адилаар усгүйгээр амьдарч чадахгүй.

Монголчууд байгаль дэлхийтэйгээ зүй бусаар харьцахыг цээрлэж, усыг чандмань эрдэнэ хэмээн дээдэлж, хайрлан хамгаалж ирсэн түүхэн уламжлалтай ард түмэн хэдий ч өнөөдөр усны нөөцийн асуудал тулгамдсан асуудал болоод байгаа нь усны нөөцөд нөлөөлөх олон тооны шалтгаан үр дагаврууд гарч ирсэнтэй холбоотой. Тухайлбал: Хүн амын төвлөрөл, хотжилт ихэссэнтэй холбогдон гүний усны ашиглалт их өссөн байна.

Уул уурхайн зориулалтаар ашиглагдах гадаргын болон гүний (цаашид: “газрын доорх ус”) усны ашиглалт ихсэхийн зэрэгцээ томоохон цогцолбор барилга байгууламж барих, уул уурхайг ашиглахад саад учруулж буй гүний усыг шавхан зайлуулж, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлттэй хамаарал, дэлхийн дулаарал, цөлжилттэй холбоотойгоор өнөөдөр усны хомсдол үүсэх нь тодорхой болоод байна.

Монгол орны усны нийт нөөц сүүлийн 40 гаруй жилд хийсэн судалгааны дүнгээр 608,000 сая шоо метр ба үүнд:

≈ 34,600 сая шоо метр гол, мөрөн;

≈ 500,000 сая шоо метр нуур;

≈ 62,900 сая шоо метр мөнх цас, мөсөн гол;

≈ 10,800 сая шоо метр газрын доорх усны нөөц тус тус багтана.

Усны нөөцийн тархалт жигд бус, чанар, найрлага нь оршин байгаа газар нутаг,



байгалийн бүс, бүслүүр, агуулж байгаа чулуулгийн тогтоц, найрлагаасаа хамаарч ихээхэн өөр өөр байдаг.

Гадаргын усны нөөцийн 70 хувь нь Алтай, Хангай, Хэнтийн нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт буюу Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 30 орчим хувийг эзлэх талбайд бүрэлдэн бий болжээ. Бүрэлдсэн нөөц нь

- Хойд мөсөн далай,
- Номхон далай,
- Төв Азийн гадагш урсгалгүй ай савуудад хуваарилагддаг бөгөөд дараах 29 ай савд ангилж судалдаг.

Судалгааны хэсэг. Газрын доорх ус нь Монгол орны хамгийн чухал усны эх үүсвэр юм. Нийгэм, эдийн засгийн бүхий л салбаруудын үйл ажиллагаа газрын доорх усны нөөц, түүний боломжоос шууд хамаардаг.

- малчид худгаас ундны болон малын усалгааны чиглэлээр
- газар тариалангийн усалгаанд,
- уул уурхай болон үйлдвэрүүд нь үйл ажиллагаанд хамаарна.

Түүгээр ч зогсохгүй газрын доорх ус чанарын хувьд ч ундны усны баталгаатай эх үүсвэр болдог учраас

- 95 хувь нь унд, ахуйдаа газрын доорх усыг,
- 5 хувь нь гадаргын усыг;
- Газрын доорх усыг худаг гарган авч ашигладаг ба зарим газруудад рашаан, булаг шандын усыг бас авч ашиглаж байна.

Монгол Улсад нийт ашиглагдаж байгаа уст цэгийн 8600 нь хүн амын унд-ахуйн усан хангамж болон үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн технологийн зориулалтаар ашиглагдаж байгаа бөгөөд 32263 нь бэлчээр усжуулалтын чиглэлээр ашиглагдаж байна. (<http://www.mne.mn/mn/685> – Байгаль орчин, ногоон хөгжлийн яам)

Үүнээс Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газрын доорх усыг ашиглаж байгаа уст цэгээс

ихэнх нь хүн амын унд-ахуйн усан хангамж болон үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн технологийн зориулалтаар ашиглагддаг, цөөн тооных нь бэлчээр усжуулалтын болон газар тариалангийн усалгааны чиглэлээр ашиглагдаж байна.

Төвлөрсөн бүсийн хувьд төдийгүй нийт Монгол орны усны нөөцийн асуудал нь зөвхөн ард иргэдийн өнөөдрийн усан хангамжийн тухай асуудал биш улс орны аюулгүй байдлын асуудал бөгөөд Монгол Улсад гидрогеологийн судалгаа 5 үндсэн чиглэлээр хөгжиж ирсэн байна¹. Үүнд:

1. Региональ гидрогеологийн судалгаа, тухайлбал гидрогеологийн зураглал ба төрөл бүрийн масштабын зураг зохиолтоос бүрдэнэ. Өнөөгийн байдлаар Монгол орны гидрогеологийн 1:1500000 (1973 онд) ба 1:1000000 (1996 онд) масштабтай зургууд зохиогдож хэвлэгдсэнээс гадна Монгол орны бүх нутгийн гидрогеологийн 1:500000 (1981–1997 онд) масштабтай зураг зохиогдсон байгаа билээ.
2. Мал аж ахуй, газар тариалан, хөдөөгийн хүн амыг усаар хангах зорилгоор гидрогеологи, геофизикийн эрэл болон өрөмдлөгийн ажил явуулж 125000 орчим цооног өрөмдөж, газрын доорх ус олборлодог 40000 гаруй ашиглалтын худаг гаргасан
3. Хүн ам, үйлдвэр, үйлчилгээ төвлөрсөн төв, суурин газруудын ус хангамжийн эх үүсвэрийг олох, нөөцийг тооцоолох зорилгоор газрын доорх усны эрэл, хайгуулын ажил явуулж, газрын доорх усны давхардсан тоогоор 217 ордыг илрүүлэн судалж, нөөцийг тогтоосон
4. Эрдэнэт, Оюу Толгой зэрэг хүдрийн зарим ашигт малтмал олборлодог уурхайнуудаас болон Багануур, Шивээ овоо, Адуун чулуун, Тал булаг, Таван Толгой зэрэг нүүрс олборлодог бүх уурхайнуудаас зайлуулах газрын доорх

¹ “Улсын нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл” Нэгдүгээр дэвтэр. Байгаль орчин ногоон хөгжлийн яам, 2012 он



усны хэмжээг тогтоох гидрогеологийн судалгааг явуулж байна.



5. Рашаан ус бүхий зарим булгийг түшиглүүлэн рашааны гидрогеологийн судалгаа явуулж рашааны ашиглах боломжит нөөц тогтоосон. Тухайлбал, халуун рашааны 5 ордын, хүйтэн рашааны 7 ордын нөөцийг тогтоосон.

Үр дүн боловсруулалт: Газрын доорх усны нөөц баялгийг 29 голын ай сав газруудаар тодорхойлсон байгааг 1 дүгээр зураг болон дүүрэгчилсэн зураглалаар харуулав.




Тухайлбал нөхөн сэргээгдэх болон нөхөн сэргээгдэхгүй баримжаат нөөцийг Монгол орны




баруун бүсийн, Ерөө голын болон Хэрлэн голын ай сав газрыг масштаб зургаар харуулбал:

- а. Монголын баруун бүсийн газрын доорх усны нөөцийн гидрогеологийн зураглал
- б. Ерөө голын ай сав газар Монгол орны гидрогеологийн 1:1000000–ын зураглал
- в. Хэрлэн голын ай сав газар: газрын доорх усны нөөцийн гидрогеологийн зураглал
- г. Мэнэнгийн ай сав газар: газрын доорх усны нөөцийн гидрогеологийн зураглал
- д. Дорноговь аймгийн ай сав газар: ай сав газар: газрын доорх усны нөөцийн гидрогеологийн зураглал




1 дүгээр зураг. Монгол орны усны 29 ай сав газар болон дүүрэгчилсэн зураглал (саарал өнгөтэй нь нөхөн сэргээгддэггүй нөөц тархсан газрууд)







Уст цэгүүд аймгуудад байрлах өрөмдмөл худаг байдлаар ашиглагдаж байгаа зураглал




Уст цэгүүд аймгуудад байрлах богино яндант худаг байдлаар ашиглагдаж байгаа зураглал




Уст цэгүүд аймгуудад байрлах Энгийн уурхайн буюу гар худаг байдлаар ашиглагдаж байгаа зураглал




Газарзүйн зураглал - нөхөн сэргээгддэг нөөц, түүний харуул






Тухайлбал: Бидний ундны усны эх үүсвэр болсон ТУУЛ голын ай сав газрын гүний буюу газар доорх усны нөөцийг авч үзвэл:

Ашиглалтын нөөц (үйлдвэртэй)		Хэтийн төлвийн нөөц	
Багтай нөөц А зэрэг	Бодитой нөөц В зэрэг	Боломжит нөөц С зэрэг	Таамаг нөөц Р зэрэг





Туул гол нь:

- 49,840км² ус цуглуулах талбайтай,
- өөрийн сав газрынхаа 170 орчим гүний усаар,
- Хаг, Галттай, Тэрэлж, Хурх, Улиастай, Сэлбэ зэрэг 127 жижиг голоор тэжээгддэг.
- Орхон голд цутгадаг.
- Хэнтий, Төв, Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотын нутгаар 704км урт газар (урсгалынхаа дагуу 800-1000м өндөр уулсын хоорондын багадаа 1-3км, ихдээ 10км хүртэл хөндийгөөр) үргэлжилэн урсаж өнгөрдөг.

Туул гол нь нийслэл хотын цэвэр усны эх үүсвэрийн нэг бөгөөд Нисэх, Найрамдал зуслан, Биокомбинатын цөөн тооны бүлэг

худаг, ганцаарчилсан 1610 гаруй худгийн ус ашигладаг. Эндээс харахад нийслэлийн хүн амын газрын доорх усны үндсэн нөөц эх үүсвэр гэдэг нь харагдаж байна.

Гүний буюу газрын доорх усны нөхөн сэргээгдсэн байдал, тэжээгдлийн хэмжээ нь гадаргын усны хэмжээнд шууд нөлөөлж байдаг учраас Туул голын тэжээгдэх байдал нь Улаабаатар орчмын усны тооноос хэрхэн хамаарч байгааг усны тооллогын тоо баримттай холбож үзэхэд хашиж хамгаалалтанд авах арга хэмжээ авдаг ажлын үр дүнд харьцангуйгаар Туул голын ус татрахгүй, түүнчлэн сүүлийн үед бороо хураар тэжээгдэх байдал нь өссөнтэй холбоотой байж болох юм.

Түүнчлэн эдгээр тоо өгөгдлүүд дээр хугацаан цувааны шинжилгээ хийж үзэхэд:

Гадаргын усны эх үүсвэрийн тоо					Хашиж, хамгаалалтад авсан усны тоо				
ОН	Тоо X_t	$\Delta_t = X_{t_n} - X_{t-1}$	$K_t = X_{t_n} / X_{t-1}$	$K_{эф} = X_{t_n} / X_{t-5}$	ОН	Тоо X_t	$\Delta_t = X_{t_n} - X_{t-1}$	$K_t = X_{t_n} / X_{t-1}$	$K_{эф} = X_{t_n} / X_{t-5}$
2007	51			1.06	2007	77	$= X_{t_n} - X_{t-1}$	$= X_{t_n} / X_{t-1}$	0.64
2011	20	-31	0.39	0.42	2011	38	-39	0.49	0.32



2014	35	-16	0.69	0.73	2014	113	36	1.47	0.94
2016	48	-3	0.94	1.00	2016	120	43	1.56	1.00
2017	52	1	1.02	1.08	2017	109	32	1.42	0.91
2018	64	13	1.25	1.33	2018	131	54	1.70	1.09
Сэргэсэн усны тоо					Хатаж, ширгэсэн усны тоо				
ОН	Тоо X_t	$\Delta_t = X_m - X_{t1}$	$K_t = X_m / X_{t1}$	$K_{эф} = X_{t1} / X_{t5}$	ОН	Тоо X_t	$\Delta_t = X_m - X_{t1}$	$K_t = X_m / X_{t1}$	$K_{эф} = X_{t1} / X_{t5}$
2007	18	$= X_m - X_{t1}$	$= X_m / X_{t1}$	1.29	2007	2	$= X_m - X_{t1}$	$= X_m / X_{t1}$	0.25
2011	5	-13	0.28	0.36	2011	4	2	2.00	0.50
2014	15	-3	0.83	1.07	2014	6	4	3.00	0.75
2016	14	-4	0.78	1.00	2016	8	6	4.00	1.00
2017	17	-1	0.94	1.21	2017	9	7	4.50	1.13
2018	17	-1	0.94	1.21	2018	15	13	7.50	1.88

$$\bar{\Delta}_{\text{эхүүс}} = \frac{|X_n - X_1|}{n_1} = \frac{|64 - 51|}{5 - 1} = 3.25$$


$$\bar{\Delta}_{\text{хаш хам}} = \frac{|X_n - X_1|}{n_1} = \frac{|131 - 77|}{5 - 1} = 13.5$$

$$\bar{\Delta}_{\text{сэрус}} = \frac{|X_n - X_1|}{n_1} = \frac{|17 - 18|}{5 - 1} = -0.25$$

$$\bar{\Delta}_{\text{ширгэсэн}} = \frac{|X_n - X_1|}{n_1} = \frac{|15 - 2|}{5 - 1} = 3.25$$

2007–2018 онд хийгдсэн (гол, горхи, рашаан, булаг, цөөрөм г.м.) тооллогоор гарсан Улаанбаатар хот орчмын усны буюу уст цэгүүдийн тоог Улсын статистикийн хорооны мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд гадаргын эх

үүсвэрийн тоо дундажаар 3.25 дахин, хашиж хамгаалалтад авсан усны тоо 13.5 дахин, хатаж ширгэсэн усны тоо 3.25 дахин өссөн бол сэргэсэн усны тоо 0.25 дахин буурсан байгаа нь нийт эх үсвэрийн тоо нь хашиж хамгаалалтад авсан ажлын үр дүнд өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч хатаж ширгэсэн усны тоо буураагүй харин ч өссөн байгаа нь дээрх бүдүүвчээс тодорхой байна. Энэ нь уул уурхайн ашиглалт ихсэж, улмаар хараа хяналтгүй бэлчээр болон газар тариалангийн гүний ус ашиглалттай ч холбоотой байж болох учир усны хомсдол үүсэхэд нөлөөлж буй асуудлын нэгд зайлшгүй тооцогдох юм.




Туул голын ай сав газрын урсац газрын доорх усаар тэжээгдэх байдлын өөрчлөлтийн хөдлөлзүйн муруй



Түүнчлэн дээрх бүдүүвчийг тайлбарлахад жил ирэх тусам Туул голын урсац нь газрын доорх усаар тэжээгдэх байдал буурсан нь жилд унах хур тундасны хэмжээнээс хамааралтайгаар буурсан бөгөөд энэ нь уст цэгүүд дэх ашиглагдаж буй худагны тоотой ч хамааралтай нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл доорх бүдүүвчээс ай сав газруудын орчмоор үүсгэсэн уст цэгүүдийг ай сав газраар Туул голыг дагасан өрөмдмөл худгийн тоо, харин Туул гол болон говийн бүсээр уурхайг дагасан худгийн тоо бусад ай сав газруудыг бодвол их байгааг харж болохоор байна.

баримжаат нөөц, хэтийн төлвийн нөөцийг усны эрэл хайгуулын инженерүүд, гидрогеологичид, ус судлал-усны химийн мэргэжилтнүүд өргөн хүрээнд хамтран ажиллаж 2008–2012 онд хэрэгжүүлсэн төслийн адил төсөл хэрэгжүүлж бүрэн тодорхойлох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Түүнчлэн бидний ундны усны эх үүсвэр болсон Туул голын ай сав газрын газрын доорх усны нөөц гэхэд 1990–ээд оны эхээс, тэр дундаа 1996 оноос хойш хэрхэн огцом буурсныг дээрх “өөрчлөлтийн хөдлөлзүйн муруй”-гаас харж болно.



Нэгтгэн авч үзвэл: Монгол орны газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөцийн ерөнхий үнэлгээ хийсэн хэдий ч зарим өрөмдлөгийн мэдээллийг бүрэн гүйцэд оруулаагүй. Жишээ нь: 40000 орчим худаг байгуулахын тулд 120000 орчим цэгт өрөмдлөг хайгуулын ажил хийсэн нь иж бүрэн тусгагдаагүйг усны эрэл хайгуул-гидрогеологийн мэргэжилтнүүд нь хүлээн зөвшөөрсөн төдийгүй цаашид хийгдэх ажилд бүрэн тусгах нь зүйтэй гэж үзсэн байна. Тухайлбал: Газрын доорх усны сэргээгдэх, сэргээгдэхгүй нөөц буюу ашиглалтын

Эдгээрээс үүдэн газрын доорх усны нөөцөд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг доорх байдлаар тодорхойлж томъёолон хомсдолыг харьцуулах судалгаанд хэрэглэх нь зүйтэй юм гэж үзэж байна.

- Ерөнхийд нь байгалийн ба хүний хүчин зүйлийн оролцоо нөлөөлж байна гэж үзэж байгаа бөгөөд эдгээрийг дэлгэрүүлбэл байгалийн хүчин зүйлд гол нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй цөлжилт-хуурайшилт, мод ургамлын зарим төрөл зүйл ургах чадваргүй болох;
- Гэхдээ уур амьсгалын өөрчлөлт нь

олон зуун жилээс улбаатай хүний үйл ажиллагаатай холбоотойгоор бий болоод байгаа хүчин зүйл юм. Тухайлбал: “Байгаль эх”-тэйгээ зохистой харьцаж, хайрлаж хамгаалдаг байсан Монголчууд сүүлийн 80 гаруй жилд, тэр дундаа 1990-ээд оноос хойш:



- Төлөвлөгөөтэй болон төлөвлөгөөгүй стандартад нийцэхгүй арга технологи бүхий уул уурхайн олборлолт, түүнийг дагасан гүний усны хяналтгүй хэрэглээ болон саад болсон гүний усны зайлуулалт;
- хүнд үйлдвэрүүд (утаанаас үүдэлтэй агаар дахь хүхрийн болон азотын диоксид, тоосжилт),
- Хараа хяналтгүй ан агнуур, мод бэлтгэл;
- Бэлчээрийн зохисгүй хэрэглээ-талхлалт;
- Газар тариалан эрхлэгчдийн пестицид бодисуудын зохисгүй хэрэглээ;
- Зөвхөн өөрийн эрх ашгийн үүднээс гол, горхины гольдролыг дураар өөрчлөх үзэгдэл;
- Стандартын бус барилга хот байгуулалтын үйл ажиллагаа;
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийг

төвийн халаалт, цахилгаан халаалтад шилжүүлээгүйгээс үүдэлтэй агаар, ус, хөрсний бохирдол;

- Авто машин, автомашины угаалга, засварын газрууд, хот суурин газрын хүмүүсийн хэт төвлөрөл, (тухайлбал Туул голд төдийгүй төв суурин газрын орчмын гол усанд нөлөөлж байна) хотын соёл гэлтгүй хувь хүний ёс зүй-ухамсартай холбоотойгоор хатуу болон шингэн хог хаягдлаа зүй зохисгүйгээр шууд байгальд хаядаг, улмаар хог боловсруулах үйлдвэргүй зэргээс үүдэлтэйгээр бий болоод байгаа үзэгдэл юм.

Дүгнэлт. 2021 он хүртэл хэрэгжүүлэхээр баталсан “УС” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-тэй холбоотойгоор Монгол орны газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөцийн ерөнхий үнэлгээг бүрэн хийхэд шаардлагатай газрын доорх усны эрэл хайгуул, төрөл бүрийн худгийн тоо, өрөмдлөгийн мэдээллийг нэн даруй бүрэн тодорхойлж, гүний ус ашиглалтад хяналт тавих, улмаар тус хөтөлбөрийг болон "Монгол оронд усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө"-г шинэчилж боловсруулах, ер нь газрын доорх ус, түүний нөөцөөс гадна гадаргын усны бүртгэлжилт, сэргээгдсэн болон сэргээгдээгүй, урсгал нь тасарсан усны мэдээллийг шинэчлэх ажил хийгдэх шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн усны нөөцөд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг арилгах, эерэг хүчин зүйлсийг сурталчлан таниулах ажлыг бүх шатны боловсролын байгууллага, хэвлэл нийтлэл, соёл, зан заншил, хүмүүсийн ёс зүй-ухамсрын түвшинд хийж гүйцэтгэх нь энэ салбарын мэргэжилтнүүд болоод бүх нийтийн хүртээмж, оролцоотой холбоотой асуудал тул урт хугацааны бодлого, төлөвлөлт гаргаж, хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих зэргээр системтэйгээр хууль эрх зүйн орчин бүрдүүлэх хэрэгцээ үүссэн байна.

**Ашигласан материал:**

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 он.
2. Монгол Улсын Усны тухай багц хууль 2012 он.
3. Ж.Бямба, Н.Жадамбаа “Монголын геологи ба ашигт малтмал – Гидрогеологи” УБ. 2012 он.
4. Ц.Балдандорж “Монгол орны усны аюулгүй байдал” УБ. 2015 он.
5. “Улсын нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл” Нэгдүгээр дэвтэр. Байгаль орчин ногоон хөгжлийн яам, 2012 он
6. “Туул гол: Экологийн өөрчлөлт, усны менежментийн асуудал” ШУА-Геозкологийн хүрээлэн. УБ. 2011 он.
7. “Гидрогеологийн хайгуул, судалгааны ажил, газрын доорх усны нөөцийн үнэлгээний гарын авлага” БОНХАЖЯ УБ. 2015 он
8. <http://www.mne.mn/mn/685> - Байгаль орчин, ногоон хөгжлийн яам “2016 оны зорилго-Байгалийн нөөц-Монгол орны усны нөөц”
9. https://www.nso.mn/mn/statistic/statcate/573072/table-view/DT_NSO_2400_011V1 - Үндэсний статистикийн хороо-Гадаргын усны тооллого.



МОНГОЛ УЛАМЖЛАЛД СУУРИЛСАН БАГШИЙН ЁС СУРТАХУУНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

М.БҮЖЛХАМ /ҮБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн ахлах багш/
Д.ГАНДОЛГОР /ҮБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн ахлах багш/

Түлхүүр үг: Багш, өв уламжлал, ёс суртахуун, ёс зүй, соёл

Key words: Teacher, heritage, morality, etos, culture

Оршил. Хүн төрөлхтний хөгжилд урагшлах алхмын нэг нь зайшгүй соёлтой, зохистой харилцааг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ. Зах зээлийн нийгэмд зохицон амьдрах мэдлэг чадвартай, ёс суртахуунтай, мэдлэг боловсролоо байнга дээшлүүлдэг, эрх зүйн хэм хэмжээг сахиж чадахуйц мэргэжилтэн бие хүн шаардлагатай байна. Иймд монголчууд эрт үеэс түүх шастираа хүндлэн дээдэлж, ах захаа хүндэтгэх, мэндлэх хүндлэх ёсыг эрхэмлэн ирсэн эртний агуу түүхтэй ард түмэн билээ. Өвөг дээдэс маань хойч үедээ түүхээ гээлгүй дараа дараагийн үе удамдаа өвлүүлэн залгамжлуулахыг хичээж ирсэн. Түүх бол ирээдүйн мэргэн багш мөн хэмээн сургадаг. Багш сайтын заяа сайн ч гэдэг. Баялаг түүхтэй, түүнээсээ сургамж авдаг ард түмэн хөгжих жамтай тул бидний монголчуудын ирээдүй гэрэлтэй байх нь гарцаагүй. Тиймээс бид өв соёлоосоо сурах, санаа авах, сэдэлжүүлэх олон зүйл байгааг олзуурхан авч энэхүү судалгааны ажлыг сонгох үндэслэл болж байна. Энэхүү судалгааны ажлын зорилго нь монголчуудын өв соёл, уламжлалын нөлөө хүчин зүйлсийг тодорхойлох, багшийн ёс суртахуун, ёс зүйн боловсролын түвшнийг үнэлж, цаашид авч хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход оршино.

Монгол уламжлал. Монголчуудын төр ёс, ёс суртахуун, хууль цааз, МЭӨ III зуунаас МЭ XIII зууныг хүртэлх хааны зарлиг, билиг сургаал, ёс суртахуун номлол, харилцаа, зэргийг нэг эх

сурвалжид багтаасан байна. Эдгээр шинжүүд “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Арван буянт номын цагаан түүх”, “Оюун түлхүүр”, Инжаннашийн “Хөх судар” зэрэг түүх, хэл уран зохиолын эх сурвалжуудад тодорхой харуулсан байдаг.

Алуулж өршөө намайгаа¹... гэж хэлснээр андын тангараг тавьж, ахан дүүс мэт нөхөрлөдөг байсан, “Андаа бодож, амийг чинь өршөөе” гэхэд Чингис хаан хүнлэг энэрэнгүй **нинжин сэтгэлээр** хандахад Жамуха: Тангаргаасаа няцсанаа бодож, үхэл сонгож байгаа нь эр хүний **жудгийг харуулжээ.**

Ардын уламжлалд ёс жаягт ихэс дээдэс өвгөд, хөгшдийг хүндэтгэдэг сайхан уламжлалтай. Эцэг эх, эхнэр хүүхдийн харилцааны хэм хэмжүүрийг нарийн тогтоосон байдаг. Үүнд:

Эр хүний арван эрдэмд: “Номонд мэргэн, нойронд сэргэг, дайнд баатар, далайд усч, үгэнд цэцэн, үйл нь шулуун, дээдэст зусаргүй, доодост ихэмсэггүй, хуримдаа цовоо, хуульд шударга”² хэмээн эр хүний тэр дундаа өрхийн тэргүүн, үрийн эцэг, төрийн тулгуур, түмний түшиг болж явах, ухаантай, **шулуун шударга байхыг;**

Эм хүний есөн шинжийг: “Өнгөнд цэвэр, үйлэнд уран, үрдээ энэрэлтэй, үргэлж цэмцгэр, ханьдаа түшигтэй, хадамдаа элэгтэй, найранд дуутай, настад буянтай байх”³ хэмээн **үүрэг хариуцлага,** эмх цэгцтэй, сэтгэл сайтай байх ёс суртахууны нандин чанаруудыг тус бүрд

¹ Монголын нууц товчоо УБ, 1990 он 173–176–р тал

² Б.Баярсайхан “Монгол улсын арван буянт номын цагаан түүх” УБ, 2002 он 8–р тал

³ Б.Баярсайхан “Монгол улсын арван буянт номын цагаан түүх” УБ, 2002 он 8–р тал Монголын нууц товчоо УБ, 1990 он 173–176–р тал



харуулжээ.

Хэн бүгд дагаж явах эрхэм зургаан зүйлд:

“Үнэн бат журмыг үргэлж хичээж явах
Өвөг дээдсийн санаж, шүтэж, явах
Үйлийн дээд ачийг буцааж хариулж явах
Өгөх гээхийн хорвоог учирлан таньж явах
Үргэлж мэргэн номыг тогтоон тунгааж явах
Үгээгүй доорд ардыг өргөн тэнхрүүлж
явах”⁴ үр ачийг нь хариулж, хүсэл хяслын
орчлонд хүний ухааныг таньж, үгээгүй ядууг ч
үзэн ядахын оронд өргөж тэтгэж, сэтгэл гаргах,
хүний энэрэнгүй сайхан чанарыг эрхэмлэн
явахыг сургажээ.

Үндсэн хэсэг. Орчин үед Ёс суртахуун нь хүмүүс нийгэм, анги, нам, бие биедээ болон гэр бүлдээ харилцаж байгаа зан үйлийн харилцааг тодорхойлно. Хүн хөдөлмөрийнхөө явцад өөрөөр хэлбэл материаллаг үйлдвэрлэл болон нийгмийн оюун санааны хөгжлийн явцад ёс суртахууны зарчим, хэм хэмжээгээ боловсруулдаг бөгөөд энэ утгаараа нийгмийн ухамсрын тодорхой хэлбэр болдог. Ёс суртахуун нь зөвхөн хүний нийгмийн амьдралын нөхцөлд үүссэн. Ичих, сэтгэл зовох, үүрэг, нэр төр гэсэн ухамсрын ёс суртахууны хэлбэрүүд нь адгуусанд ч байдаггүй зөвхөн хүний өвөрмөц бүтээл юм. Ёс суртахуун нь боловсролын хэмжээ төдийгүй нийгмийн харилцаа, орчин ахуй бусад зүйлсээс хамаардаг. Ёс суртахууны дэвшил бол нийгмийн хөгжлийн зүй тогтолтой гүнзгий уялдсан хүний оюун санааны амьдралын хөгжлийн үр дүн юм.

Багшийн ёс зүйн алдаа зөрчлийг багасгах, арилгах арга зам нь багшид багшийн ёс зүйн үүрэг хариуцлага, нэр төр, нэр хүндийг төлөвшүүлэх явдал юм. **Нинжин сэтгэл** гэдэг бол хүн өөрийгөө хянах болон биеэ авч явах ёс суртахууны хүчит зохицуулагч юм. Нинжин сэтгэл дутагдалтай хүн бол ёс суртахууны харилцаанд төгс оролцох чадваргүй байх бөгөөд орчин тойрныхондоо аюулт амьтан болж хувирна. Нинжин сэтгэл өөрийн мэдлэг, туршлага, авьяас, чадварыг ашиглаж хүүхдийг сургаж хүмүүжүүлэхэд багшийн үйл ажиллагаа чухал, багш боловсрол хүмүүжлийн өндөр

үр дүнд хүрэхийн төлөө өөрөөсөө хамаарах бүхнийг хийх, сурагчдын зан үйл, мэдлэгт илэрч байгаа сургалт хүмүүжлийн ажлын өө сэвтэй талын бурууг өөртөө хүлээж өөрийгөө хатуу ширүүн зэмлэх, мөн идэвх чармайлт гарган ажилласнаар хүүхэд муу сурах, сахилгын зөрчил гаргах дутагдлыг арилгах зэрэг нь багшийн нинжин сэтгэлийн тод илрэл юм. Өөрийн хөдөлмөр үйлдэлдээ төдийгүй сурагчдынхаа үйл ажиллагаанд хариуцлагатай хандах нь сурган хүмүүжүүлэгчийн нинжин сэтгэлийн нэг онцлог тал юм. Нинжин сэтгэл бол зүй ёсны ухаарал, өрөвдөх хайрлах хоёрын нэгдэл юм. Нэр төр гэдэг нь хүний үнэ цэнийг нийгэм ёс суртахууны хувьд бодитойгоор хүлээн зөвшөөрсөн хэрэг. Нэр төр гэдэг ойлголтод хамт олон, гэр бүл, мэргэжилдээ сайн нэртэй байх, бие хүний нэр алдар зэрэг орно. Нэр, төр эрхэм чанартай холбоотой. Эрхэм чанар бол хүн өөрөө бие хүний эрхэм чанараараа ухаарч ойлгох явдал. Багшийн эрхэм чанар бол нийгмийн бүхий л амьдралд өөрийн хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны ач холбогдлыг ухааран ойлгох явдал юм. Багшийн нэр төр, эрхэм чанарыг зөвхөн багш өөрөө төдийгүй сургууль уламжлал, хэвшил, бичигдсэн бичигдээгүй хуулиар хамгаалж байх ёстой. Сурагчдынхаа эрхэм чанарыг хүндэлдэггүй багш өөрийнхөө чанарыг хүндлүүлж чадахгүй. **Шударга ёс** нь хүний аливаа үйлдэлд үнэн зөв үнэлэлт өгч байгаа ёс суртахууны категори юм. Багшийн шударга ёс бол шударга шаардлага, мэдлэг ба үйлдлийн шударга үнэлэлт юм. Ийм учраас багшийн ёс зүйн шударга ёс нь хүүхдийн хувийн онцлогийг харгалзан үзэхийг шаарддаг юм. Үүрэг хариуцлага нэр хүнд гэдэг бол нийгмээс хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны эрхэм чанарын үндсэн дээр хүн хүндээ болон хамт олондоо нөлөөлөх чадвар юм. Нэр хүндийг нөлөөлж буй арга, хүрээнээс хамаарч улс төрийн шинжлэх ухааны ёс суртахууны сурган хүмүүжүүлэх, эцэг эхийн гэх мэт ангилж болно. Багшийн нэр хүндийг хадгалж хамгаалж байх талаар багш хамт олон, эцэг эхчүүд, бүх

¹ Ш.Ичинхорлоо, Г.Долингор “Сургалт” УБ, 2005 он 38–р тал



нийгмээрээ санаа тавьж байх шаардлагатай. Багшийн ёс зүйд судалгаа өгөхийн тулд ёс зүйн хэм хэмжээг үнэлэх шалгуурыг тодорхойлох нь зүйтэй. Эдгээр шалгууруудад:

1. Багшийн нэр төр
2. Багшийн нинжин сэтгэл
3. Багшийн шударга байдал
4. Багшийн үүрэг хариуцлага гэсэн дөрвөн хэв шинжийг шалгуур болгон авч үзлээ.

Багшийн ёс суртахууны судалгаа /Багш нар, суралцагчид/

Судалгааны зорилго: Монголчуудын өв соёл, уламжлалын нөлөө хүчин зүйлсийг тодорхойлох, багшийн ёс суртахуун, ёс зүйн боловсролын түвшнийг үнэлж, цаашид авч хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны хамрах хүрээ: Их, дээд болон ЕБС-ийн багш нар, суралцагчид

Судалгааны арга: Асуулгын анкетын арга

Судалгааны үр дүнг боловсруулсан программ: Google form, MS-Excel, SPSS-25




1 дугаар зураг. Судалгаанд оролцогчдын нас болон хүйсийн харьцаа

Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь буюу 68.8% нь эмэгтэй, 31.2% нь эрэгтэй байгаагаас "Y" үе /26-41 нас/, "X" үе /41-57 нас/-ийнхэн эзэлсэн байна.




2 дугаар зураг. Багшийн мэргэжлийг яагаад сонгосон эсэх

Судалгаанд оролцогчдын 81.3 хувь нь багшийн ажилд дур сонирхолтой болохоор, 12.5 хувь нь гэр бүлийн шаардлагаар, 3.1 хувь нь багшийн мэргэжил нэр хүндтэй болохоор, 3.1 хувь нь багшийн мэргэжил эрэлттэй болохоор тухайн мэргэжлийн сонгож ажиллаж байна.




3 дугаар зураг. Багш нар (нэр хүнд)

Судалгаанд оролцогчид дөрвөн хэв шинжийн нэг болох нэр хүнд хэсэгт 68.8% нь багш мэргэжлээр амжилтад хүрэх хүсэл эрмэлзэл маш их байдаг бол 84.4% нь ажилдаа чин сэтгэлээсээ маш сайн ханддаг, 78.1% нь хамтран ажиллагсдынхаа нэр хүндийг үргэлж эрхэмлэдэг бөгөөд 34.4% нь сүүлийн жилүүдэд багш мэргэжлийн нэр хүнд дунд зэрэг өссөн гэж үзсэн байна.



4 дүгээр зураг.Багш нар (нинжин сэтгэл)

Судалгаанд оролцогчид дөрвөн хэв шинжийн нэг болох нинжин сэтгэл хэсэгт 50 хувь нь багшийн ажил хийж байгаадаа маш их сэтгэл хангалуун байдаг бөгөөд 90.6 хувь нь сурагчийг үргэлж хүндэтгэн харилцаж, хайрладаг, 78.1 хувь нь бусад багш нарыг маш сайн хүндэтгэн харилцаж, 59.4 хувь нь ярихдаа этгээд бүдүүлэг үг хэллэг огт хэрэглэдэггүй, 62.5 хувь суралцагчдынхаа алдааг маш сайн уучилж, ойлгуулж чаддаг байна.




5 дугаар зураг. Багш нар (шударга байдал)

Судалгаанд оролцогчид дөрвөн хэв шинжийн нэг болох шударга байдал хэсэгт 71.9 хувь нь суралцагчдаа маш сайн шударга үнэлдэг, 53.1 хувь нь огт ажил үг хоёр нь зөрдөггүй, 65.6 хувь нь өөрийгөө маш сайн шударга гэж боддог, 53.1 хувь нь гаргасан амжилтаа огт гайхуулдаггүй бөгөөд 62.5 хувь эрх зүйн дүрэм, журмыг маш сайн сахин биелүүлдэг байна.



6 дугаар зураг. Багш нар (үүрэг хариуцлага)

Судалгаанд оролцогчид дөрвөн хэв шинжийн нэг болох үүрэг хариуцлага хэсэгт 84.4 хувь нь суралцагчдыг нийгмийн ямар нэг талаас нь огт ялгаварладаггүй, 65.6 хувь нь ажилдаа маш сайн хариуцлагатай ханддаг, 50 хувь нь өөрийнхөө мэдлэг чадварыг дунд зэрэг хөгжүүлдэг, 34.4 хувь нь уур учаргүй аливаад сайн хүлээцтэй ханддаг, 71.9 хувь нь суралцагчдынхаа авьяас, чадвар ирээдүйд маш сайн өөдрөг ханддаг байна.



7 дугаар зураг Суралцагчид (нэр хүнд)

Судалгаанд оролцогчид дөрвөн хэв шинжийн нэг болох нэр хүнд хэсэгт 46.2 хувь нь багш маш сайн хэлсэн үгэндээ хүрдэг, 43.6 хувь багш бусдын нэр хүндийг маш сайн эрхэмлэдэг, 47.4 хувь нь багш маш сайн чөлөөтэй ярилцдаг, 67.9 хувь нь багш нэр алдрын хойноос огт хөөцөлддөггүй байна.




8 дугаар зураг Суралцагчид (нинжин сэтгэл)

Судалгаанд оролцогчид дөрвөн хэв шинжийн нэг болох нинжин сэтгэл хэсэгт 64.1 хувь нь багш суралцагчдаа маш сайн хайрладаг, 35.9 хувь нь багш зовлонг маш сайн мэдэрч сэтгэлийн сэтгэлийн дэм өгдөг, 62.8 хувь нь багш огт доромжилж, гомдоодоггүй, 37.2 хувь нь багш сайн анхаарал тавьдаг, 43.6 хувь нь багш маш сайн алдааг уучилж ойлгодог байна.




9 дүгээр зураг. Суралцагчдаас (шударга байдал)

Судалгаанд оролцогчид дөрвөн хэв шинжийн нэг болох шударга байдал хэсэгт 46.2 хувь нь багш санал шүүмжлэл маш сайн хүлээн авдаг, 65.4 хувь нь багш суралцагчтай холбоотой мэдээллийг маш сайн хадгалдаг, 62.8 хувь нь багш мэдлэг чадварыг маш сайн бодитой үнэлдэг, 46.2 хувь нь багш өөрийн үг зан үйлдлийг маш сайн хянадаг байна.



10 дугаар зураг. Суралцагчид (үүрэг хариуцлага)

Судалгаанд оролцогчид дөрвөн хэв шинжийн нэг болох үүрэг хариуцлага хэсэгт 44.9 хувь нь багш сурлагын алдааг маш сайн засаж залруулдаг, 43.6 хувь нь багш аливаад маш сайн хүлээцтэй ханддаг, 56.4 хувь нь багш хичээлтэй асуудлаар маш сайн зөвлөж тусалдаг байна.



11 дүгээр зураг. Суралцагчид (үүрэг хариуцлага)

Судалгаанд оролцогчид дөрвөн хэв шинжийн нэг болох үүрэг хариуцлага хэсэгт 50% нь багш суралцагчдын эцэг, эхтэй хамтын ажиллагаатай байдаг бөгөөд 69.2% нь багш асуусан асуултаас зайлс хийдэггүй байна.

ДҮГНЭЛТ. Монгол уламжлалд суурилсан багшийн ёс суртахууны өнөөгийн байдал эрдэм шинжилгээний ажлын хүрээнд монголчуудын өв соёл, уламжлалын нөлөө хүчин зүйлсийг тодорхойлох, багшийн ёс суртахуун, ёс зүйн боловсролын түвшнийг үнэлж, санал, зөвлөмж бичихийг зорьсон. Монгол уламжлалд суурилсан багшийн ёс суртахууны өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор:

- Их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулиудын багш, суралцагчдаас асуулгын анкетын аргаар авсан судалгаа
- Статистик болон тархалтын цуваа

ашиглаж стандарт хазайлт хэлбэлзлийг олж хүрээг тодорхойлох

Судалгааг баримт бичиг, харьцуулалт, ярилцлага, ажиглалт, асуулгын анкетын аргаар судалж, Google Form, SPSS–25 программаар боловсруулан үр дүнг тооцсон. Нээлттэй асуулгыг MS–Excel программ дээр боловсруулан судалгааны үр дүнг тодорхойллоо. Судалгааны үр дүнгээс харахад дараах нэгдсэн дүгнэлтүүд гарч байна.

Дээрх судалгаанаас үндэслэн багш ба суралцагчдын хариултуудад анализ хийхэд дараах байдал харагдлаа. Багшийн нинжин сэтгэл гэсэн шалгуурын багц асуултад судалгаанд оролцсон багш нарын 57,2 хувь суралцагчдын 35,8 хувь нь нинжин сэтгэл хангалттай гэж үзсэн байна. Энэ үзүүлэлт нэлээд зөрөөтэй байгаа нь суралцагчийн зүгээс багш нарын үйл ажиллагаанд анхаарах хэрэгтэйг сануулж байгаа хэрэг. Үүнээс үзэхэд багш суралцагчийг хайрлаж хүндэтгэж чаддаггүй мөн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа ямар нэгэн байдлаар ёс зүйн үүднээс алдаа гаргаж байгааг анхаарах хэрэгтэйг харуулж байна. Багшийн нэр төрийн талаар авсан судалгаанаас харахад багш нарын 47,2 хувь, суралцагчдын 37.5 хувь нь нэр төрөө хамгаалж чаддаг гэжээ. Багш нарын нэр төр хангалттай гэсэн хариултад багш нарын 4.2 хувь, суралцагчдын 99 хувь байгаа нь хоорондоо нэлээд дөхсөн байгаа нь бодит байдлыг харуулж байна. Нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлага биелүүлдэг гэж багш нарын 42,2 хувь, гэж үзэж байхад суралцагч 45.5 хувь гэж үзсэн нь багшийн нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлага өндөр байхыг шаардаж байна. Багшийн шударга байдлын үзүүлэлт нь багш нарын хувьд 50,3 хувь, суралцагчдын 38,6 хувь байгаа нь шударга бус гэж үнэлжээ. Судалгаанд багш нарын ихэвчлэн гаргадаг алдаа нь суралцагчдыг гомдоодог, шударгаар үнэлдэггүй, сайн ойлгодоггүй нь харагдлаа. Үүнээс харахад соёл уламжлалаа дээдэлж, багш мэргэжлийн өвөрмөц онцлог, багшийн ёс зүйн дүрэм, зарчим юу болох талаар сурталчлах, танилцах, сургалт явуулах, багш мэргэжлийн ёс



зүйн дүрмийг хэрэгжүүлэх зэрэг ажил хийх нь чухал юм.

Судалгааны дүнгээс харахад багшийн ёс зүйн ухамсар хандлагад өөрчлөлт гарсан нь ажиглагдаж байна. Багшийн ёс суртахууны талаар гарч буй дутагдал зөрчил нь ихэнхдээ багшийн сурган хүмүүжүүлэх болон сэтгэлгээний түвшнээс хамаарч байгаа нь судалгаанд харагдаж байна. Цаашид ажил хэрэг болгох дараах зөвлөмжийг санал болгож байна.

Үүнд:

1. Эв эеийг хичээж, эвсэн найрамдаж сурах
2. Төрөө дээдлэх, нэр төрөө эрхэмлэх
3. Үнэнч сэтгэлийг эрхэмлэх
4. Багшийн шалгаруулалтад ёс суртахуун, ёс зүйн үнэлгээний ач холбогдлыг дээшлүүлж, нэг үндсэн шалгуур болгох
5. Багш нарын сурган хүмүүжүүлэх болон сэтгэлгээг анхаарах, энэ чиглэлийн сургалт явуулах
6. Багшийн ёс зүйн дүрмийг судалж мөрдлөг болговол хүн төрөлхтний хөгжилд урагшлах алхмын нэг нь зайшгүй соёлтой, зохистой харилцааг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ гэж үзэн санал болгож байна.

Ашигласан материал:

1. Ц.Дамдинсүрэн, “Монголын нууц товчоо”, 1990 он, Улаанбаатар хот
 2. Б.Баярсайхан, “Монгол улсын арван буянт номын цагаан түүх”, 2002 он, Улаанбаатар хот
 3. Ш.Ичинхорлоо, Г.Долингор “Сургалт”, 2005 он, Улаанбаатар хот
 4. Ц.Сонгууль, М.Бүжлхам, Ё.Эрдэмбаяр, “Статистик”, 2015 он, Улаанбаатар хот
 5. Д.Дэмбэрэл, “Ёс зүйт төр” 2011 он, Улаанбаатар хот
 6. Б.Оюунчимэг, “Бизнесийн ёс зүй”, 2014 он, Улаанбаатар хот
 7. Р.Вандангомбо, “Захиргааны ёс зүй”, 2003 он, Улаанбаатар хот
 8. Х.Пүрэвдавга, “Чингис хааны менежментийн товчоон”, 2020 он, Улаанбаатар хот
 9. Kim, Y. “Determinants of Financial Reporting System: The Case of South Korea”
 10. United nations, “Practical implementation of international reporting standards: Lessons learned”
 11. World Economic Forum, “Global Competitiveness Report” 2010-2011
 12. ACCA, Paper P1. Governance, risk and ethics. 2011
 13. ACCA, P1. Governance, risk and ethics. 2011
- www.mof.gov.mn - Сангийн яам
www.monicsra.mn - Монголын Мэргэшсэн Нягтлан бодогчдын Институт
www.frc.mn - Санхүүгийн зохицуулах хороо
www.ses.edu.mn - МУИС, Эдийн засгийн сургууль
www.mse.mn - Монголын хөрөнгийн бирж
www.ebscohost.com
www.iasplus.com – Deloitte international accounting and consulting firm
www.ifac.org – international Federation of Accountants
www.unctad.org – United Nations Conference on Trade and Development



ГАМШИГТ НЭРВЭГДЭГСДЭД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

П.МӨНХТӨР /ҮБХИС-ийн АБДС-ийн ОУХНУТ-ийн багш/
М.ИНДРАБҮД /ҮБХИС-ийн АБДС-ийн ОУХНУТ-ийн багш/
Г.ОЮУНТУЯА /ҮБХИС-ийн АБДС-ийн ОУХНУТ-ийн багш/

Түлхүүр үг: Гамшиг, Эрсдэл, хор уршиг, аюул занал

Key words: Disaster, risk, damage, danger

Оршил. Аливаа гамшигийн дараа гэмтэж бэртсэн нэрвэгдэгчдийн тоо хэвийн нөхцөлөөс хэд дахин илүү болж эмнэлгийн байгууллагын хүчин чадлаас хэтрэх нөхцөл үүсдэг. Ийм үед аврагчид нэрвэгдэгсдэд цагаа олсон, үр дүнтэй амилуулах суурь /эмнэлгийн анхны/ туламжийг үзүүлж, тээвэрлэн дараагийн эмнэлгийн байгууллагад хүргэх арга хэмжээг авдаг. Нэрвэгдэгсдийн амь нас эрүүл мэндийг хамгаалах шаналгааг хөнгөлөх аль болох түргэн эдгээх гамшигийн сөрөг үр дагаврыг багасгахад чиглэсэн нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай. Энэ өгүүлэлд гамшигт нэрвэгдэгсэд үзүүлэх тусламж үйлчилгээний аргачлал, нөхцөл байдал, авах арга хэмжээний саналыг тодруулан гаргахыг зорилгоо.

Үндэслэл. “Сендайн үйл ажиллагааны хүрээ”-д гамшигийг тэсвэрлэх чадавхыг аюулд өртсөн систем, олон нийт эсвэл нийгэм эрсдэлийг удирдан нэн чухал үндсэн бүтэц, үйл ажиллагаагаа хамгаалах, сэргээх зэрэг үйл ажиллагааг цаг алдалгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх замаар аюулын нөлөөллийг эсэргүүцэх, шингээх, зохицох, өөрчлөх, нөхөн сэргээх чадвар гэж тодорхойлжээ. Хот суурин газрын хувьд энэ нь ихэвчлэн газар хөдлөх, үер, хар салхи болох, ой, хээрийн түймэр гарах, химийн бодис асгарах, цахилгаан тасалдах зэрэг байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой гэнэтийн гамшиг, түүнчлэн хөрсний ус багасах, ой мод устах, эсвэл орон гэргүй болох, ажилгүйдэл зэрэг нийгэм, эдийн засгийн урт хугацааны асуудал, дарамтаас тэсэж гарах, сэргэн босох чадвар юм. “Гамшигийн эрсдэлийг бууруулах чиглэлээр

2015–2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ” хөтөлбөрийн хэрэгжилт, гарч буй ахиц дэвшил, тулгарч буй хүндрэл, бэрхшээлд хяналт, мониторинг хийх, гамшигийг тэсвэрлэх чадавхыг үнэлэх үнэлгээний аргачлал боловсруулагдсан байдаг. Уг арга нь НҮБ-ын Гамшигийн эрсдэлийг бууруулах газар гаргасан “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хөгжих чадавхтай хотыг бий болгох 10 үндсэн чиглэл”-д үндэслэсэн


Энэхүү үнэлгээ нь хотын гамшигийг тэсвэрлэх чадавх буюу тохиолдож болзошгүй гамшигийн эрсдэлийг ойлгож, тэдгээрийг багасгах, гамшигийн улмаас богино болон урт хугацаанд хүний амь нас, амьжиргаа, эд хөрөнгө, дэд бүтэц, эдийн засгийн үйл ажиллагаа, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй хохирлыг бууруулах хариу арга хэмжээ авах хотын боломжийг харуулна.

Гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх яаралтай тусламж үйлчилгээг “Орон нутгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааварт тусгаснаас гадна” Гамшгаас хамгаалах тухай хууль, Шадар сайд, байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/416 дугаар тушаалыг тус тус үндэслэн Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын улмаас хүн амын эрүүл мэндэд хохирол учрахаас урьдчилсан сэргийлэх, болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус цусан бүтээгдэхүүний хангамжийн бэлэн байдал, аюулгүй байдал хангах арга хэмжээг цусны албаны хэмжээнд хэрэгжүүлэх удирдлагын



бүтэц, гүйцэтгэх чиг үүрэг, бүтээгдэхүүнийг тодорхойлох, харилцан ажиллагаа хэрэгжүүлэх үйл ажиллагааг 2020 онд журамласан байдаг.

Гамшгийг эрдэмтэн судлаачид өргөн хүрээтэйгээр тал бүрээс нь судалж өөрсдийн үзэл бодлын үүднээс өөр хоорондоо зөрөөтэй олон янзын тодорхойлолт гаргасан бөгөөд эдгээр нь нийтлэг байдаг 2 ойлголт бол *Нэгд*: гамшиг нь ямар нэгэн аюул тохиолдох *Хоёр*: түүний улмаас учирсан их хэмжээний хохирлыг арилгахад нийгмийн чадавх хүрэхгүй байх нөхцөлөөр гол төлөв тодорхойлогдоно.



“Гамшиг гэж аюулт үзэгдэл техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрах”-ыг хэлнэ.

“Гамшгийн эрсдэл” гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг хэлнэ.

Гамшгаас хамгаалах гэдэг нь гамшгаас хүн, мал, амьтан, эд хөрөнгө, түүх соёлын дурсгалт зүйл, хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг дүнтэй зохион байгуулж, улс орны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн үйл явцыг хэлнэ.

Аюулгүй амьдрах гэж хувь хүний болоод нийгмийн аюулгүй амьдрах, эрүүл мэнд сайн сайхан байдлыг хадгалахын тулд бие, сэтгэл зүйн болон материаллаг хохиролд хүргэж болзошгүй бүхий л нөхцөл байдлыг хянах, сэргийлэх явдал хангагдсан байдлыг хэлнэ. Харин гамшиг судлалын талаар янз бүрээр

илэрхийлж байна.

Гамшгаас хамгаалах гэдэг нь өргөн утга агуулгатай бөгөөд Нэгд: урьдчилан сэргийлэх, Хоёр. Аврах, хор уршгийг арилгах, Гуравт: хойшлуулшгүй сэргээн босгох гэсэн 3 багц томоохон асуудлыг агуулж байна. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээх босгох ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг хэлнэ. Эдгээр үйл ажиллагааг удирдан чиглүүлэх удирдлага, гамшгаас хамгаалах менежмент, гамшгийн менежмент гэх зэргээр олон янзаар нэрлэж байна.

Гамшгийн үед нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ. Нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ. Голомтын бүсэд нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээг хэрхэн зохион байгуулах, Тухайлбал, газар хөдлөлтийн гамшгийн хөнөөлийн голомтод нэрвэгдэгсдийг олж, тэдгээрийн биеийн байдал, тоог тогтоож, аюулгүй газар зөөж тээвэрлэх, зам гарцыг сонгох, эмнэлгийн анхны тусламжийн ажлын багтаамжийг тооцох, эмнэлгийн анхны болон эмнэлгийн тусламж үзүүлэх эмнэлэг дэлгэх газар, нэрвэгдэгсдийг цуглуулах газрын сонгож, ангилан ялгах ажлыг зохион байгуулах талаар тусгах, гамшгийн бүс, ялангуяа түр хоргодох байранд амьдралын орчны огцом өөрчлөлтөөс гамшигт өртөгсдийн бие сэтгэлийн байдал муудахаас сэргийлэх, байнга эрүүл ахуйн таатай нөхцөлийг хангах арга хэмжээ авахын хамт гамшигт өртөгсдийн эрүүл мэндийн байдлыг сайтар тодруулж, шаардлагатай бол асрах, тусламж үзүүлэх цэг байгуулж, сэтгэл санааны тусламжийг багтаасан арга хэмжээ авах, анхаарал тавих шаардлагатай хүмүүсийн бие сэтгэлийн байдалд онцгой анхаарал тавьж, шаардлагатай бол асрамжийн газарт оруулах, асрах ажилтан томилох, тэргэнцэр олгох зэрэг арга хэмжээнд халамжийн байгууллага, сайн дурын байгууллагын дэмжлэг авч, төлөвлөгөөтэй

хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн нэгжийн засаг захиргааны байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн эмч сувилагчийн тойрох үзлэг зохион байгуулж, зөвлөгөө өгүүлэх, түр хоргодох байрны амьдралын орчныг хангах үүднээс шаардлагатай бол түр жорлон болон нүхэн жорлон зэргийг даруй байгуулахын хамт гамшгийн бүсийн эрүүл ахуйн нөхцөлийг хангахын тулд цэвэрлэгээ хийх, бохир зайлуулах, ахуйн хог цуглуулан зайлуулах талаар шаардлагатай арга хэмжээ авах

Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтыг зохион байгуулах. Эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн, ороох, боох материалын хангалтыг хэрхэн зохион байгуулах талаар дурдах Тухайлбал, тухайн орон нутгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн эмнэлгүүд болон эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгийн болон газар хөдлөлтийн голомтод эмнэлгийн анхны болон эмчийн тусламж үзүүлэхэд шаардагдах эм, эмийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүнийг 24–72 цагийн хугацаанд эм хангамжийн байгууллагууд болон бөөний болон жижиглэн худалдах эмийн сангуудаас нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулах бөгөөд хэрэв эм, эмийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн дутагдах тохиолдол төвөөс болон зэргэлдээ нутаг дэвсгэрийн нэгжээс татаж авах арга хэмжээ авах талаар тусгана. Түүнчлэн газар хөдлөлтийн гамшгийн үед эрэн хайх, аврах ажиллагааг явуулах томилгоот шуурхай бүлэг, ерөнхий болон тусгай зориулалттай мэргэжлийн анги, бусад хүч хэрэгсэл, бие бүрэлдэхүүний эмнэлгийн хангалтын эм, эмийн хэрэгслээр хэрхэн тасралтгүй хангах талаар тусгах;

Түр хорогдох байрны эмнэлгийн тусламж үйлчилгээ. Нүүлгэн шилжүүлэх болон түр хорогдох байранд эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрхэн зохион байгуулах талаар тусгах. Тухайлбал, нүүлгэн шилжүүлэлтийн эмнэлгийн хангалтыг төлөвлөх, нүүлгэн шилжүүлэлтийн эмнэлгийн хангалтыг зохион байгуулахад эмнэлгийн байгууллага, мэргэжлийн ангиудыг бэлтгэх, нүүлгэн шилжүүлэлтийн цугларах байр, зам, чиглэл,

суулгах, буулгах, дундын байр байрласан газарт эмнэлгийн анхны тусламж үзүүлэх.

Эрүүл ахуй, халдвар эсэргүүцэх арга хэмжээ. Гамшгийн голомтод болон нүүлгэн шилжүүлэх бүсэд эрүүл ахуй, халдвар эсэргүүцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тусгана. Тухайлбал, халдварт өвчин дэгдэж тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нэрвэгдэгсдэд эмнэлгийн үзлэг хийх, илэрсэн өвчтөнүүдийг тусгаарлан эмчлэх, эмнэлгийн ариутгал хийх ажлыг зохион байгуулах, хоол хүнсний хангалт, усны эх үүсвэрийг хамгаалах, гамшгийн болон гамшгийн бүсийн гадна нэрвэгдэгсдийг цуглуулах, түр байрлуулахдаа эмнэлэг, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж ариутгасан зөөврийн хоол, хүнс, усны хангалтыг тоолцох, нэгд 2.5м² байраар тооцох, байрны агаарын температур 18 хэмээс доошгүй 35–65 хувийн чийгшилтэй байх, ундны усыг хоногт нэг хүнд 10 литр байхаар тооцох, нүүлгэн шилжүүлэх бүсийн эргэн тойронд байнгын халдваргүйжүүлэлтийг хлорын шохой, хлорамины 3 хувийн уусмалаар усалгааны машин, авто цэвэрлэгээний тусгай зориулалтын машин, галын болон бусад техник ашиглаж эмнэлгийн болон нийтийн ахуйн үйлчилгээний албаны бие бүрэлдэхүүний хүчээр гүйцэтгэх талаар тусгана. Мөн түр цугларах талбай, түр хорогдох байр, түр орон сууцад шаардагдах нийтийн бие засах газар, био жорлонгийн хэрэгцээний талаарх мэдээллийг цуглуулж, орон сууц нийтийн аж ахуйн болон бохирын ус тээвэрлэх компаниудыг мэдээллээр хангах; Нүүн шилжигчдийг дамжин өнгөрүүлэх болон хүлээж авах цэгүүдэд шаардагдах нийтийн бие засах газар, био жорлонгийн хэрэгцээний талаарх мэдээллийг цуглуулж бохирын ус тээвэрлэх компаниудыг мэдээллээр хангах.

Монгол Улсын хэмжээнд 2022 онд нийт 4129 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол бүртгэгдэж, Онцгой байдлын байгууллагын алба хаагчид 3653 хүний амь нас, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 260.9 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан.



Ой хээрийн түймрийн тоо, давхардсан тоогоор улс, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг	Аймгийн код	2018	2019	2020	2021
Улсын дүн	0	77	121	139	65
Баруун бүс	1	13	11	8	1
Баян-Өлгий	183	–	2	–	–
Завхан	181	3	6	3	–
Увс	185	6	2	3	–
Ховд	184	4	1	2	1
Хангайн бүс	2	22	20	49	7
Архангай	265	3	2	13	1
Баянхонгор	264	1	–	2	–
Булган	263	7	11	24	4
Өвөрхангай	262	–	–	2	2
Хөвсгөл	267	11	7	8	
Орхон	261	–	–	–	–
Төвийн бүс	3	9	36	26	11
Дорноговь	344	–	2	–	–
Дундговь	348	–	1	–	–
Сэлэнгэ	343	7	26	19	9
Төв	341	2	6	7	2
Дархан-Уул	345	–	1	–	–
Зүүн бүс	4	32	46	51	46
Дорнод	421	8	28	37	14
Сүхбаатар	422	14	11	8	15
Хэнтий	423	10	7	6	17
Улаанбаатар	5	1	8	5	–
Улаанбаатар	511	1	8	5	–

Тохиолдсон гамшигт үзэгдэл, учирсан хохирол, өссөн дүнгээр,
үндсэн үзүүлэлтээр, улсын дүн сараар

Гамшигт үзэгдэл, хохирол	2010 он	2011 он	2012 он	2013 он
Гамшигт үзэгдлийн тохиолдлын тоо	2976	3548	4040	4467
Ой, хээрийн түймэр /тоо/	104	161	229	198
Шатсан ой, хээр /сая га/	1	2.1	5	6
Объектын түймэр /тоо/	2541	3063	3501	3819
Хүчтэй цасан болон шороон шуурга /тоо/	32	15	26	37
Аадар бороо, үерийн аюул /тоо/	14	18	34	52
Хорогдсон, устгасан мал, амьтан /мян.толгой/	9735.5	165.5	13.017	236
Гамшгийн улмаас нас барсан хүн /тоо/	223	213	237	201
Гамшгийн улмаас учирсан хохирлын хэмжээ /тэрбум төг/	534.8	9.6	94.4826	22



Үерт өртсөн аймаг, сумдад үерээс болж үүссэн хохирол, тусламж (сая төгрөгөөр)

Тусламж үйлчилгээ үзүүлсэн байгууллага	Баян-Өлгий	Архангай	Ховд	Булган	Нийт
Учирсан хохирол	15600	62.2	611.7	477.2	16751.1
Төрийн байгууллагаас	568.8	Мэдээлэл байхгүй байна	0.3	10.6	569.7
Хүмүүнлэгийн байгууллагуудаас	401.7	75.5	136	99	712.2
Бусад байгууллага, хувь хүн	242.4	Мэдээлэл байхгүй байна	5.3	8	259.7
Нийт тусламжийн дүн	1206.9	75.5	141.6	117.6	1541.6
Нийт тусламжийн хэмжээнд аймаг тус бүрийн харгалзах хувь	78%	5%	9%	8%	100%

Аюулт үзэгдэл осол жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2022/2023
Аюулт үзэгдэл ослын тохиолдол	385	468	311	377	121.2
Газар хөдлөлтийн тоо	2	157	7	2	28.6
Объект түймрийн тоо	320	270	239	275	115.1
Амь насаа алдсан хүний тоо	14	11	17	22	70.6
Учирсан хохирол, тэрбум төгрөг	1.4	1	1.3	5.6	4.3
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	0.02	0.01	0.1	0.1	100

2022 он гарснаас хойш эхний таван сарын байдлаар Горхи-Тэрэлжийн чиглэлд нийт 98.032 иргэн, 38.152 тээврийн хэрэгсэлтэй зорчсон нь өмнөх жилүүдийн мөн үеэс өссөн үзүүлэлт гэдгийг албаныхан хэлж байв. Ийм тооны иргэд тус чиглэлд аялал зугаалгаар зорчин, өөрсдийн санамсар болгоомжгүй байдлаас болон архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ автомашин жолоодох, гол гатлах, усанд сэлэх, хувийн бэлтгэлгүйгээр ууланд авирах зэргээс үүдэлтэй гамшиг, ослын дуудлагын тоо тасралтгүй нэмэгдэж байгаа юм.

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2023 оны 1 дүгээр сарын байдлаар 377 болж, өмнөх оны мөн үеэс 66 (21.2%)–гаар өссөн байна. Объектын түймэр 2023 оны 1 дүгээр сард 275 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 36 (15.1%)–гаар, геологийн гаралтай аюулт үзэгдэл 12 болж, 5 (71.4%)–аар тус тус өссөн байна. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2023 оны 1 дүгээр сард нийт 12 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 5 (29.4%)–аар буурсан байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Гамшиг бол улс орныг хямралт байдалд оруулах нөхцөл шалтгаануудын нэг юм. Урт хугацааны туршид гамшиг болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн хоорондын холбооны учир шалтгаан, үр нөлөөг үл хайхарч ирсэн. Ялангуяа шийдвэр гаргагчид, төлөвлөлтийн байгууллагууд гамшигийн асуудалд анхаарал бага хандуулж байв. Учир нь гамшигийн дараа үүссэн хор уршгийг арилгах үйл ажиллагааны нөхцөл байдалд түлхүү анхаарч байснаас гамшигийн дараах сэргээн босгох ажиллагааг урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн хэсэг болгон авч үздэггүй байсан. Өөрөөр хэлбэл гамшигийн дараах байдлыг урт хугацааны хөгжлийг дэмжсэн бүтцийн өөрчлөлт хийхэд дэндүү тохиромжгүй гэж үздэг байсан. Өнөө үед аливаа хөгжлийн бодлого, хөтөлбөрт гамшигийн эрсдэлийг бууруулах асуудлыг тусгахын ач холбогдлыг бүрэн ойлгож байна. Нөгөө талаас гамшиг хөгжих боломж олгож байна гэж харж болох үндэстэй. Ихэнх гамшиг нь хүн амд



сөргөөр нөлөөлж, их хэмжээний эдийн засгийн хохирол, байгаль орчны доройтол бий болгодог хэдий ч гамшгийн сэргээх босгох шатанд эмзэг байдлыг бууруулж, илүү тогтвортой хөгжлийн төлөвлөгөө гаргах замаар ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах боломжтой. Нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэг өөрчлөлт хийх боломж, олгосон гамшигт жишээ олон байдаг. Олсон мэдлэг, туршлага дээрээ үндэслэн гамшгийн улмаас эвдэрч сүйрсэн барилгыг гамшигт илүү тэсвэртэй, эрсдэлгүй болгон засаж сайжруулах, шинээр барих боломжтой. 2001–2002 онд онд болсон зуд Монгол Улсын холбогдох албаны хүмүүст гамшгийн эрсдэлийн менежментийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах хэрэгтэйг харуулсан бөгөөд энэ хүрээнд 2003 онд “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийг боловсруулж мөрдсөн байдаг. Гэсэн ч байгалийн гэнэтийн давагдашгүй хүчин зүйл, хүний санаатай болон санамсаргүй болгоомжгүйгээр хийсэн үйлдлүүдийн мөрөөр улсад хохирол учруулсаар байна. Тухайлбал: 2019 оны 12 дугаар сард анх БНХАУ–ын Ухань хотоос гаралтай шинэ төрлийн коронавирусын халдвар өдгөө дэлхийн 216 улс болон газар нутгаар тархаж, 10 дугаар сарын байдлаар нийт 40 орчим сая хүн тус өвчнөөр өвчилж, 1 сая гаруй мянган хүн эндээд байна. Цар тахал

үүссэнтэй холбоотойгоор улс орнуудад хөл хорио тогтоох, бизнесийн байгууллагууд алсын зайнаас ажиллах, эрүүл мэндийн асуудлаас үүдэн ажиллах хүчин хомсдох, цаашлаад байгууллагуудын үйл ажиллагаа зогсох хэмжээнд хүрсэн. Бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд доголдол учруулах аливаа эрсдэл нь гэнэтийн байдлаар тохиож, таамагласнаас илүү хохирол учруулах магадлалтай байдаг. Энэхүү дүгнэлтэд үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд:

Санал зөвлөмж:

1. Гамшиг ослын үед нэрвэгдэгсдэд үзүүлэх анхны тусламжийн мэдлэг, мэдээллийг нийтэд хүртээмжтэйгээр зохион байгуулах
2. Гамшгаас хамгаалах ажлыг цаг алдалгүй олон нийтэд түгээх, иргэдтэй хамтран ажиллах, ухуулга, зар сурталчилгааны ажлуудыг эрчимжүүлэх
3. Гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэжилтнүүдийг чадавхжуулах
4. Иргэдийн сэтгэл зүйг гамшигт нэрвэгдэхээс өмнө бэлтгэх, бэлэн байдалд сургах, чадавхжуулах шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Монгол улсын “Гамшгаас хамгаалах тухай” хууль. УБ., 2003 он
2. Монгол улсын “Галын аюулгүй байдлын тухай шинэчилсэн найруулга хууль” УБ., 2015 он
3. ХСИС. Гамшгаас хамгаалах менежментийн үндэс. УБ., 2017 он
4. П.Цэдэв. Гамшгаас хамгаалах төлөвлөлт. УБ., 2018 он
5. ОБЕГ. Гамшгийн эрсдэлийн удирдлагын эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2019 он
6. Б.Ганболд. Усанд эрэн хайх, аврах ажиллагааны онцлог. УБ., 2020 он
7. Үржин.О. Гамшгаас хамгаалах менежментийн үндэс. УБ., 2017 он
8. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх сендайн ажиллагааны хүрээ. 2016 он
9. Н.Мягмардорж. Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо. УБ., 2012 он
10. Ник Картер. “Гамшгийн менежмент”. УБ., 2003 он

БАГШ ХӨГЖЛИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Д.ОТГОНЦЭЦЭГ /УБХИС-ийн Эрдмийн сургуулийн Батлан хамгаалах судлалын тэнхимийн профессор багш, доктор (Ph.D) дэд профессор/

Түлхүүр үг: Багш, боловсрол, мэргэжил, хөгжил, чанар

Key words: Teacher, education, professional, development, quality

Оршил. Нийгмийн хөгжлийн тэргүүлэх салбар болох боловсролын чанарыг сайжруулахад түүнийг гардан хэрэгжүүлэгч багшийн хөгжил, ур чадварын талаар зайлшгүй ярих шаардлагатай.

Боловсролын чанараар тэргүүлэгч гадаадын улс орнууд энэ төрлийн судалгааг тогтмол хийдэг нь багшийн хөгжил нэн тэргүүнд хэрэгтэй гэдгийг харуулж байна. Иймд олон улсад багшийг мэргэжилдээ өсөн дэвжихэд хэрхэн дэмжиж, бэлддэг, багшийн хөгжил хэрхэн явагддаг талаарх туршлагыг судлан энэхүү өгүүллийг бичлээ.

Үндсэн хэсэг. Нийгмийн хөгжил шинэ шатанд гарч, хувьсан өөрчлөгдөж байгаа өнөө үед аливаа улс орны хийгээд хүн төрөлхтний тогтвортой хөгжлийн шавхагдашгүй эх сурвалж нь хүний хүчин зүйл, хүний нөөц болж, түүний чадамж, бүтээмжээс хөгжлийн чанар, үр ашиг ихээхэн хамаарч байна. Иймээс улс орон хүн төвтэй хөгжлийн бодлого баримтлан улмаар боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, иргэдийнхээ боловсролыг чанаржуулахад анхаарлаа илүү их хандуулах болсон.

Боловсролын салбарын үр ашигтай үйл ажиллагаа явуулах гол нөөц өндөр мэдлэг чадвартай багш бөгөөд тасралтгүй өөрчлөгдөн хөгжиж байхыг шаарддаг. Иймээс багшийг хөгжлийнх нь хүрээгээр:

- Хөгжих бололцоотой болсон багш
- Хөгжиж буй багш
- Хөгжсөн багш хэмээн ангилж болох юм.

Хөгжих бололцоотой болсон багш гэдэг нь багш бэлтгэдэг сургуулийг бакалаврын зэрэгтэй төгссөн, анхны жилдээ багшилж буй хүн.

Хөгжиж буй багш гэдэг нь тухайн шинжлэх ухаан болон түүний дидактикийн онол, арга

зүйг гүнзгийрүүлэн судалж, мэргэшиж байгаа, ур чадвараа системтэй дээшлүүлэн, өөрийгөө боловсруулан хөгжүүлэх тодорхой зорилго, чиглэлтэй ажиллаж буй багшийг хэлнэ.

Хөгжсөн багшийн загвар: Хөгжсөн багш нь шинэчлэлийг өөрөөсөө эрж хайдаг, шинэчлэгдэх чадвар, асуудлыг олон талаас нь авч үзэх чадвар, хамтын шийдвэр гаргах чадвар, өөрийгөө хөгжүүлэх чадвар, сургалт ба судалгааг хослуулах чадвар бүтээлч хандлага зэргээр бусдаасаа ялгарсан, сурах, сургах арга барилыг гаргуун эзэмшсэн, бүтээлч, шинийг санаачлагч, байнга сурч хөгжиж байдаг, шинэлэг сэтгэлгээ, арга барилтай бие хүн юм.

Багш нар өөрсдөө нийгмийн хөгжиж байгаа хурдаас илүүтэйгээр хөгжиж байж бусдыг хөгжүүлж сургана. Боловсрол олгодог бүх шатны байгууллага нь боловсролын салбарын өөрчлөлт, шинэчлэлийн зорилго, зорилтыг өндөр мэдлэг чадвартай багш нарын хүчээр хэрэгжүүлж иргэдэд чанартай, үр өгөөжтэй боловсролын үйлчилгээ үзүүлж чадна.

Багшийн хөгжлийн үйл явц нь тэдний өөрсдийнх нь идэвх оролцоо, санаачилга, хүсэл тэмүүлэл дээр тулгуурладаг. Багшийн хөгжил бол тасралтгүй, өсөн дээшилж шинэчлэгдэн явагдаж байдаг.

Багшийн мэргэжлийн хөгжлийг (continuing professional development) багш нарыг боловсролын олон талт үйл ажиллагаанд хамруулан тэдгээрийн мэргэжлийн мэдлэг, ойлголт, чадварыг баяжуулах насан туршийн суралцах үйл хэмээн тодорхойлж байна.

“Багшийн хөгжил” хэмээх ойлголтыг тодруулбал:

Мэргэжлийн: багшид зайлшгүй шаардагдах мэдлэг, чадварыг хөгжүүлэх, туршлага хуримтлуулахад чиглэсэн үйл ажиллагааг



хэлдэг.

Тасралтгүй: насан туршийн мэргэжлийн хөгжил талаас багш нар мэддэг, эсвэл сурсан зүйлийнхээ талаар эргэцүүлэн цаашид ямар мэдлэг, чадвар олж авах хэрэгцээ, шаардлага байгаагаа тодорхойлох, туршин хэрэгжүүлэх циклээр явагддаг үйл ажиллагааг хэлнэ.

Хөгжил: сурган хүмүүжүүлэх практик үйл ажиллагааг шинэчлэх, хөгжүүлэх талаас ямар үр өгөөжтэй байгаагаар тодорхойлогдох¹ үйл юм

Өнөөгийн боловсролын олон улсын чиг хандлага багшийн боловсролыг цогцоор нь буюу багш бэлтгэх, тодорхой хугацаанд туршлагажих, мэргэжилдээ тасралтгүй хөгжих гэсэн хоорондоо уялдаа холбоо бүхий шаталсан тогтолцоогоор дамжин хөгжиж байна.

Улс орон бүр өөрийн онцлог загваруудыг боловсруулан туршиж байгаа хэдий ч багшийн боловсролын тогтолцоо нь багш бэлтгэх, шинэ багшийн туршлагажих үе (багшлах эрх авах хугацаа), багшийн мэргэжлийн хөгжлийн эхний үе, мэргэжлийн өндөр чадвартай, манлайлагч багш болох үе шат хэмээх нийтлэг хэсгүүдтэй байна. Тухайлбал, Ирланд улсын тогтолцоо нь багш бэлтгэх, 1 жилийн туршлагажих, 2–3 жилийн мэргэжлийн хөгжлийн эхний үе, цаашдын мэргэжлийн тасралтгүй хөгжлийн гэх 4 шатлал бүхий загвартай байна.

Англи, Шотланд зэрэг зарим оронд тогтолцооны шатлал бүрийн залгамж холбоо, уялдааг хангах үүднээс багшийн цогц чадамжийн загварыг (боловсролын шатлал бүрээр эзэмших цогц чадамжийн хүрээ) боловсруулан мөрдөж байна. Сингапур улсад багш нарт захирал, сургалтын менежер, зохион байгуулагч болох, эсхүл өөрийн мэргэжлийн чиглэлээр зэргээ ахиулах (ахлах багш), дээшлүүлэх хоёр боломжийг сонголтоор олгодог байна.

Олон улсад бага сургуулийн багшийг өөрийн практик үйл ажиллагаандаа ёс суртахуунтай ханддаг, сурган хүмүүжүүлэх болон шинжлэх ухааны тодорхой чиглэлээр өндөр мэдлэг, чадвартай, соёлын мэдрэмжтэй, мэргэжлийн үйл ажиллагаандаа судалгаа, онол, арга зүйн талаас хандаж шийдвэр гаргадаг, бүтээлч эргэцүүлэл бүхий багш, суралцагч, судлаач, иргэн байхыг онцолж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн олон улсын байгууллага гишүүн орнуудынхаа дунд 2013 онд Багш мэргэжлийн хөгжлийн чиглэлээр суурь судалгаа явуулж, үр дүнд нь 3 стратегийг боловсруулсан байна². Үүнд:

- Мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд зайлшгүй хамруулах (тодорхой хугацаанд ажлаас нь чөлөөлөн хамруулах, эсвэл санхүүгийн дэмжлэг үзүүлэх мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих);
- Урамшуулалд тулгуурласан стратеги буюу хувь багшийн хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд хамруулах (зэрэг, цол ахиулах, албан тушаал ахих, цалин нэмэх);
- Сургуульд суурилсан мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд хамруулах (багшийн хөгжлийг сургуулийг хөгжүүлэх хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах үйл ажиллагаа).

Судлаач Corcoran (2006) дэвшүүлснээр багшийн мэргэжлийн хөгжлийн үр өгөөжтэй бодлого нь дараах зарчмуудад тулгуурлах ёстой байна³. Үүнд:

1. Сургуульд суурилсан үйл ажиллагааг дэмжих;
2. Багш, хамт олноос гарсан санаачилгыг дэмжих;
3. Сурах, сургах онол, арга зүйд суурилж үйл ажиллагааг төлөвлөх;
4. Суралцагчийн хөгжлийн асуудлаар

¹ БМДИ. (2019). Багш мэргэжлийн тасралтгүй хөгжих хэрэгцээ, судалгааны тайлан. 180–182;

² https://www.oecd-ilibrary.org/education/talis-2013-results_9789264196261-en TALIS 2013 Results. An International Perspective on Teaching and Learning

³ Roisin P. Corcoran, Joanne O'Flaherty "Personality Development during Teacher Preparation". Front. Psychol., 08 November 2016. Sec. Educational Psychology


хэлэлцүүлэг, суралцагчдад суралцах сэтгэлзүйн орчин бүрдүүлэх;

5. Багш нар мэргэжлийн өндөр түвшний мэргэжилтэн багш нартай хамтран эргэх холбоотой ажиллах;
6. Шинээр сурч мэдсэн зүйлээ турших, хэрэгжүүлэхэд хангалттай хугацаа өгөх, туслалцаа дэмжлэг үзүүлэх;
7. Багш бүрд сургалт, үйл ажиллагаанд нээлттэй оролцох боломжийг бүрдүүлэх.

Дээрх зарчмуудад нийцүүлэн Хонконг улс багшийн хөгжлийн бодлогоо 2003 онд боловсруулан 3 жил туршаад 2006 онд батлан хэрэгжүүлсэн арга туршлага байна. Өнөөдөр олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй багшийн

хөгжлийн үйл ажиллагаа нь албан болон албан бус дараах хэлбэрүүдтэй байна. Үүнд: сурган хүмүүжүүлэх практик үйлийн судалгаа, мэргэжлийн сүлжээ, зөвлөгөө, дагалдуулан сургах, сургалт /танхимын болон онлайн/ орж байна. Эдгээр үйл ажиллагааг зохион байгуулахдаа сурах, сургах үйлийг хөтлөн жолоодох, чиглүүлэх, сургалтын технологийн үр өгөөж, гарах үр дүн, үзүүлэх нөлөө зэрэгт анхаарч сургалтын хэлбэр, хугацааг сонгож байна.

Багшийн хөгжлийн үйл ажиллагааны олон хэлбэр өнөөдөр улс орнуудад хэрэглэгдэж байгаа бөгөөд эдгээрийг зохион байгуулагдаж буй хамаарлаар нь 3 ангилж үздэг⁴. Үүнд:



Зураг 1. Багшийн хөгжлийн зохион байгуулагдаж буй хамаарал

⁴ Бурмаа, Б. (2013). Боловсролын чанарын шинэчлэл. 33–34;

2013–2014 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас явуулсан олон улсын судалгаагаар⁵ тухайн орнуудын багш нарын хамгийн олон хамрагдсан мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд өөрийн практик үйлийг сайжруулах зорилгоор мэргэжил нэгт нөхөдтэйгөө зөвлөх, асуудлыг хэлэлцэх (93%), тодорхой хугацааны сургалт, семинарт хамрагдах (81%), мэргэжлийн судалгаа, ном зохиол судлах (78%) зэрэг байна. Хамгийн цөөн хамрагдсан үйл ажиллагаанд зэрэг ахиулах сургалт (25%) болон бусад сургуульд хичээлийн ажиглалт хийх (28%) зэрэг оржээ. Багш нар мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцох цагийн хувьд АНУ, Австралийн зарим муж, Финланд, Австри, Бельги, Унгар, Нидерланд, Шотланд, Швед, Швейцар зэрэг улсад жилд 5–аас доошгүй өдөр гэж заасан байдаг. Судалгаанд оролцсон улс орнуудын хувьд жилд 15 цаг (Австри) – аас 104 цаг (Швед)–ийн хооронд байна. Багш нарт мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцоход тухайн байгууллагад нэгдсэн ихэнх оронд судалгааны тэтгэлэг олгох, ажлаас чөлөөлөх зэргээр дэмжлэг үзүүлдэг байна. Хичээлийн жилийн явцад чөлөө олгохдоо орлох багшийг гэрээгээр ажиллуулна.

Бельги, Чех, Финланд, Итали, Литв, Люксембург, Португал, Словени, Англи улсад цалинтай чөлөө олгодог. Чех улсад нэг хичээлийн жилд багшид 12 ажлын өдөр бие даасан судалгаа хийх, Итали улсад багш нараа эрчимтэй сургалтад хамруулахад хичээл хаах хүртэл сургалтын хуваарийг зохицуулах зөвшөөрөл олгодог байна. Багш нараа сургалтад хамруулах асуудлаар дээр дурдсан орнуудад тулгарч буй бэрхшээлд

орлох багшийг олох, тэдгээрийн цалингийн асуудал орж байгаа бөгөөд энэ нь эргээд багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд хамрагдахад саад болж байгааг судалгааны үр дүн⁶ харуулж байна.

Дээрх үр дүнд үндэслэн судалгаанд хамрагдсан орнуудын хувьд тулгарч буй бэрхшээлийг даван туулах арга хэмжээг бодлогын түвшинд төлөвлөн хэрэгжүүлэхийг санал болгож, зөвлөмж боловсруулсан байна.

Дүгнэлт. Багшийн хөгжил гэдэг нь хувь хүн өөрийгөө өөрчлөх бүхий л боломжийг ашиглан мэргэжил, мэргэшил боловсролоо байнга дээшлүүлж, цаг ямагт өсөж хөгжиж байдаг идэвхтэй хандлага үйл явц болох нь судалгаанаас харагдаж байна.

Олон улсад багшийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулагдаж буй хэлбэрээр нь сургуульд суурилсан, сургууль хоорондын, сургуулийн хүрээнээс гадуурх гэж ангилдаг байна.

Хэдийгээр мэргэжлийн үйл ажиллагаанд багш нар өргөн хамрагдаж байгаа ч тэдгээр үйл ажиллагаа нь багш нарын хэрэгцээг хангах тал дээр хангалтгүй байдаг байна. Тухайлбал дээрх олон улсын судалгаануудад хамрагдсан багш нарын 50% нь хэрэгцээ хангаагүй, дахин мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд хамрагдах шаардлагатай гэж үзсэн нь үүнийг нотолж байна.

Мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцоход учирч буй бэрхшээлд багш нар ажлын ачаалал; хичээлийн хуваарь; багшийн хэрэгцээг хангах, тохиромжтой үйл ажиллагаа ховор; гэр бүлийн боломж муу; зардал өндөр; сургуулийн удирдлагын дэмжлэг сул зэргийг оруулсан байна.

Ашигласан материал:

1. Боловсролын ерөнхий хууль. 2023
2. Багшийн хөгжлийг дэмжих тухай Монгол Улсын хууль. 2018
3. "Багшийн хөгжил" мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын гарын авлага-I. УБ 2019
4. "Багш мэргэжлийн тасралтгүй хөгжих хэрэгцээ" судалгааны тайлан. БМДИ 2019

⁵ Continuous Professional Development among Primary Teachers in Ireland, OECD. 2014

⁶ National Education Association report 2012

ЦӨМИЙН ЗЭВСЭГТ ХИЙСЭН СУДАЛГАА

У.МӨНХБАТ /УБХИС ЦНДС-ИЙН ЦИХТ-ийн багш доктор (Ph.D), ахмад/

Түлхүүр үг: Цацраг, цөм, цэрэг, дайн, цөмийн зэвсэг

Key words: Radiation, nucleus, soldier, war, nuclear weapon

Оршил. Аливаа улсын зэвсэгт хүчин ямар төрлийн зэвсэгтэй байх нь тухайн улсын аюулгүй байдлыг хангах хэрэгцээ, түүнийг эзэмших нь тэр улсын цэрэг–улс төрийн удирдлага (ЦУТУ)–ын бодлого, улсынх нь язгуур ашиг сонирхлоор тодорхойлогддог. Тухайн улс Цөмийн зэвсэг эзэмших технологитой болох эсвэл үйлдвэрлэлийг дангаараа зохион байгуулах боломжийн хязгаарлагдмал байдал өнөө үед улам бүр багасаж байна.

Өнөөгийн нөхцөл байдлын нэг шинэ онцлог нь ҮОХЗ, төрийн бус бүлэглэлийн гарт орж болзошгүй болсон байна. Шинжлэх ухаан, технологийн хөгжил, технологийн ашиглах давуу тал нь улс биш бүлэглэл, хэдэн арван мянган хүнийг хөнөөх боломжийг олгоход хүргэжээ. Энэ нь 1990–ээд оны дундуур бий болсон олон улсын аюулгүй байдлын шинэ шинж төлөвөөс хамаарсан асуудал юм. Ялангуяа олон улсын терроризм, энэ зэвсгийг хоёрдмол утгагүй ашиглах аюулыг агуулж байна. Цөмийн зэвсгийг өөрчилж, боловсронгуй болгож буйгаас ч илүү аюулыг янз бүрийн хүчин – субъект ашиглах боломж ихсэж байгаад оршиж байна. Өөрөөр хэлбэл, ийм зэвсгийн аюул илүү их, түүнд тавих хяналт илүү их хүндрэлтэй болжээ.

Нэгд, XX–XXI зуунд тохиолдсон атомын цахилгаан станц (АЦС)–ын осол, цөмийн зэвсгийн туршилтаас үүсэж буй хор хөнөөл нь олон улс, улс үндэстний хэмжээнд гамшиг учруулж байна. Үүнийг Украины Чернобылийн АЦС–ын ослын хор хөнөөл, Японы Фүкүшимо АЦС–д гарсан осол харуулж байна.

Хоёрт, олон улсын терроризм дэлгэрч буй, террористууд ҮОХЗ–ийг эзэмших сонирхолтой, түүгээр улс, нийгмийг айлган сүрдүүлж, өөрсдийн тэмцлийн зорилгоо хэрэгжүүлэх

гэсэн хандлагатай байна.

Гуравт, цөм, цацраг идэвхт бодисын хэрэглээ үйлдвэр, ахуйн хэрэглээнд өргөн нэвтэрч байна. Цацрагийн хөнөөлөөс хамгаалах асуудал дайны цагт төдийгүй энх тайван цагт ч шинээр тавигдаж байна.

Иймээс тус өгүүлэлд цөмийн зэвсэгт шинжилгээ хийж, түүний аюул, эрсдлийг үнэлэх зарим асуудлыг тодруулан гаргахыг зорилоо.

Цөмийн зэвсэг – уран ба плутонийн зарим изотопын хүнд цөмүүд задрах цөмийн гинжин урвалын үед, эсвэл устөрөгчийн изотоп болох дейтери болон тритийн хөнгөн цөмүүд нэгдэх халуун цөмийн гинжин урвалын үед үүсэх цөмийн дотоод энергийг ашиглахад үндэслэсэн дэлбэрэлтийн үйлчилгээтэй үй олноор хөнөөх зэвсэг.



1 дүгээр зураг Цөмийн дэлбэрэлт

Цөмийн гинжин урвалд орсон бодисын нэгжээс ялгарах энергийн хэмжээ нь ердийн тротилын дэлбэрэлтээс ялгарах энергийн хэмжээнээс 20–80 сая дахин их байдгаараа онцлогтой. Түүний хөнөөх хүчин зүйлүүд:

- Цохих долгион
- Гэрлийн цацраг



- Нэвтрэх радиаци
- Цахилгаан соронзон импульс
- Цацраг идэвхт хордолт

Цөмийн зэвсэг:

- Цөмийн галт хэрэгсэл (пуужин, торпедийн байлдааны хошуу, нисэхийн ба гүнийн бөмбөг, цөмийн цэнэгтэй артиллерийн сум, задрах бөмбөг)
- Тэдгээрийг удирдах болон байнд хүргэх хэрэгсэл (стратегийн бөмбөгдөгч онгоц, тив алгасагч баллистик пуужин, усан доогуур шумбагч завь)



2 дугаар зураг цөмийн бөмбөг дэлбэрэх явц

Ямар ч төрлийн цөмийн цэнэгийн өрнөл цөмийн хуваагдах гинжин урвалаар эхэлнэ. Дэлбэрэлтийн явцад чөлөөлөгдсөн энергийг тээж байгаа хуваагдлын хэлтэрхийнүүд, нейтронүүд, бета-хэсгүүд, гамма цацраг нь цэнэгт үлдсэн бодисын урвалд ороогүй атомуудтай харилцан үйлчилж өөрийн энергийн ихэнх хэсгийг дамжуулснаар урвалын бүсэд хэдэн сая хэм хүрэх халууныг үүсгэнэ.

Цөмийн дэлбэрэлтийн өрнөх явц. Гялс хийлтийн дараагаар гэрлийн цацрагийн эх үүсвэр болох дугуй, эсвэл хагас дугуй хэлбэртэй гэрэлт бөмбөлөг бий болно.


Үүнтэй нэгэн зэрэг цөмийн гинжин урвалын үед болон цөмийн цэнэгийн хуваагдлаар цацраг идэвхт хэсгүүд задрах үед үүсэх гамма цацраг, нейтроны маш хүчтэй урсгал дэлбэрэлтийн бүсээс хүрээлэн буй орчин руу тархана. Цөмийн дэлбэрэлтийн үед ялгарах гамма-квант болон нейтроныг нэвтрэх радиаци гэнэ.

Эгшин зуурын гамма цацрагийн нөлөөгөөр хүрээлэн байгаа орчны атомууд ионжиж улмаар

цахилгаан ба соронзон талбайг үүсгэнэ. Түр зуурын үйлчилгээтэй энэхүү талбайг цөмийн дэлбэрэлтийн цахилгаан соронзон импульс гэнэ.

Цөмийн дэлбэрэлтийн төвд маш ахар хугацаанд агаар хэдэн сая хэм хүрч халснаар цэнэгийн бодис нь рентген цацраг ялгаруулдаг өндөр хэмтэй плазм болон хувирна. Хийн төлөвтэй бүтэгдэхүүний даралт эхлээд хэдэн миллиард атмосфер болно. Гэрэлт бөмбөлгийн улайссан хийнүүдийн хүрээ тэлэхдээ агаарын ойролцоох давхаргуудыг дарж, шахагдсан давхаргын хил дээр даралтын огцом зөрүү бий болгосноор дэлбэрэлтийн төвөөс чиг бүр тархах цохих долгионыг үүсгэнэ.

Галт бөмбөлгийг бүрдүүлж байгаа хийнүүдийн нягтрал хүрээлэн байгаа агаарынхаас хамаагүй доогуур байх учир энэхүү бөмбөлөг дээшээ хурдан хөөрнө. Энэ үед хийнүүд, усны уур, хөрсний жижиг хэсгүүд болон дэлбэрэлтийн улмаас үүссэн асар их хэмжээний цацраг идэвхт бүтэгдэхүүнийг агуулсан мөөг хэлбэрийн үүл бий болно. Үүл нь хамгийн оргил цэгтээ хүрээнд агаарын урсгалын нөлөөгөөр их хол зайд нүүн, сарних бөгөөд цацраг идэвхт бүтээгдэхүүнүүд нь газрын гадаргуу дээр тунам бууж, газар орон, объектын цацраг идэвхт хордолтыг үүсгэнэ.



3 дугаар зураг. Гэрлийн цацраг

Маш өндөр хэмд цөмийн дэлбэрэлтийн бүсээс рентген цацрагийн эрчимтэй урсгал мөн цацагдана. Энэхүү цацрагийн нөлөөгөөр урвалын бүсийг хүрээлэн байгаа агаарын хэм болон даралт огцом нэмэгдэж, улмаар гэрэлт



Цөмийн зэвсгийн тоо

2023 оны 1-р сарын байдлаар дэлхийн цөмийн зэвсгийн тоо хэмжээ						
Цөмийн зэвсэг эзэмшигч улсууд	Өндөржүүлсэн бэлэн байдалд байгаа цөмийн цэнэгт хошуу	Суурилуулахад бэлэн цөмийн хошуу	Байлдаанд бэлэн болон угсрахад бэлэн нийт цөмийн зэвсгийн тоо хэмжээ		Бэлэн угсарсан, угсарахад бэлэн цөмийн зэвсгийн тоо болон агуулахад хадгалаастай нөөцийн нийт тоо	
			2022 он	2023 он	2022 он	2023 он
НҮБ – P5						
АНУ	1,770	1,938	3,708	3,708	5,428	5,244
ОХУ	1,674	2,815	4,477	4,489	5,977	5,889
Их Британи	120	105	225	225	225	225
Франц	280	10	290	290	290	290
БНХАУ		410	350	410	350	410
Бусад улс						
Энэтхэг		164	160	164	160	164
Пакистан		170	165	170	165	170
БНАСАУ		30	25	30	25	30
Израиль		90	90	90	90	90
Нийт	3,844	5,732	9,490	9,576	12,710	12,512

бөмбөлөг болон цохих долгион үүснэ.

Цөмийн зэвсэг бүхий улс орнуудын нийт цөмийн цэнэгт хошууны тоо 2023 оны байдлаар 12512 болсон гэсэн судалгаа байдаг¹. Эдгээрийн ихэнх нь хугацаа дууссан ч байлдааны чадавхтай гэж үзэн ашиглалтын хугацааг тодорхой бус хугацаагаар хойшлуулан сунгасан байдаг гэжээ.

2022 оны 1–р сараас 2023 оны 1–р сарын хооронд дэлхий дээрх цөмийн зэвсгийн тоо 86 аар нэмэгдэж 12,512 хүрсэн байна.

Цэрэг дайны зориулалтаар цөмийн зэвсгийг АНУ хамгийн анхны цөмийн зэвсгийг Япон улсын Хирошима (1945.08.06–нд), Нагасаки (1945.08.09–нд) гэх хотод анх цохилт өгснөөр зохиомол цацраг идэвхтийн хордуулалт буюу цөмийн зэвсгийн цацраг хордуулалтын үе эхэлсэн түүхтэй. Мөн үүний дараагаар нэр бүхий зарим улс цөмийн зэвсгийг шаргуу туршиж эхэлсэн байна. Мөн үүнтэй уялдан ураны баяжилтыг хийснээр цөмийн энергийг ашиглаж аж ахуй нэгжид ашиглаж байна².

Монгол Улсын хэмжээнд цөмийн зэвсэг,

АЦС байхгүй байгаа ч цацраг идэвхт ашигт малтмалын нөөц байгаа юм. Нөөцийг 2 дугаар хүснэгтээр үзүүлэв.

2 дугаар хүснэгт

Монгол Улсын цацраг идэвхт ашигт малтмалын нөөц³

Орд	Нөөц /тн/	Агуулга (хувь)
Дорнод	56865	0.154
Гурванбулаг	13,058.3	0.162
Мардай	1,948.1	0.052
Нэмэр	5,937.62	0.111
Улаан	270	0.145
Хараат	7,288	0.026
Хайрхан	8,406.5	0.071
Дулаан-Уул	11,896.44	0.023
Гурвансайхан	4,250.1	0.034
Өлзийт	3,075.7	0.036
Зөвөч-Овоо	93,291	0.023
Энгэр ар	80.52	0.05
Бүгд	180,783.05	

Монгол орны нутаг дэвсгэрт 1940–өөд оноос хойш цацраг идэвхт ашигт малтмалын 12

¹ Стокхолмын Олон улсын энх тайвны судалгааны хүрээлэн – SIPRI

² Защита от оружия массового поражения. Изд. Второе, М.: Воениздат, 1989. — 398 с., инв. У–614.

³ Монгол Улсын цөмийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн төлөвлөгөө. Э.Нямдаваа. илтгэл 2017 он УБ



орд, 100 орчим илрэл, 1000 гаруй эрдэсэжсэн цэг илрүүлсэн. Дээрх ордуудаас 8 ордын ТЭЗҮ батлагдсан байна. Эндээс харахад Монгол улсад цацраг идэвхт бодисын хэрэглээ, олборлолт улам нэмэгдэх цаашлаад буруу ажиллагаанаас болж үүсэх цацрагийн хөнөөлийг үнэлэх шаардлага гарч ирж байна. Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах үүрэгтэй Цөмийн энергийн комисс ажиллаж байна. “Цацрагийн аюулаас хамгаалах, цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөө”⁴, мөн “Цацрагийн аюулгүйн норм”⁵ зэргийг боловсруулан гаргаад дагаж мөрдөж байна.

Харин цөмийн болон цацрагийн аюулыг бууруулах, хамгаалах төрийн бодлого, стратегийн үндсийг боловсруулах анхдагч үүргийг хүлээсэн субъект хууль, тогтоомжоор

тодорхойгүй байна.

Дүгнэлт. Цөмийн зэвсэг, болон нэн өндөр цэцтэй зэвсгүүд бий болсон, мөн цаашилбал цэргийн бүтэц, зохион байгуулалт, байлдах арга ажиллагаанд эрс өөрчлөлт орж байгаа зэрэг нь улс орон тухайн зэвсгийн хөнөөлүүдийн эрсдэлийг үнэлэх, урьдчилсан хамгаалах арга, зөвлөмж боловсруулах, хэсэгчилсэн сургалтыг явуулах зэрэг арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн үзэж байна.

Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөөс баримтлах бодлогын зорилгыг хэрэгжүүлэх зорилтууд нь түүний стратеги байх болно. Ойрын ирээдүйд хэрэгжүүлэх стратеги нь цөмийн энергийг ашиглах үед хүн ам, байгаль орчинд үзүүлэх техногенийн нөлөөллийн эрсдэлийг нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах, түүнчлэн цөмийн болон цацрагийн аюултай байгууламжид гарсан осол тохиолдоход гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэхэд оршино гэж үзэж байна.

Ашигласан материал:

1. Стокхолмын Олон улсын энх тайвны судалгааны хүрээлэн – SIPRI year book, 2023 он
2. Защита от оружия массового поражения. Изд. Второе, М.: Воениздат, 1989. — 398 с., инв. У-614.
3. Монгол Улсын цөмийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн төлөвлөгөө. Э.Нямдаваа. илтгэл 2017 он УБ;
4. Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолын хавсралт. Цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөө; Цөмийн энергийн комиссын 2015 оны 6 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт. Цацрагийн аюулгүйн норм;

⁴ Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолын хавсралт. Цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөө;

⁵ Цөмийн энергийн комиссын 2015 оны 6 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт. Цацрагийн аюулгүйн норм;



ОРОС–УКРАИНЫ ДАЙНД АРТИЛЛЕРИЙГ ХЭРЭГЛЭЖ БАЙГАА БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

М.ЭРДЭНЭТӨГС /УБХИС-ийн ЦНДС-ийн АЗТ-ийн ахлах багш, дэд хурандаа/

Түлхүүр үг: Артиллери, дайн, оператив-тактик, дрон

Key words: Artillery, war, operational- tactical, drone

Оршил. Орос Украины хооронд үүссэн мөргөлдөөн сунжирч үндсэндээ дайны байдалд шилжээд буй. Дайны эхэн үед Оросын агаарын цэрэг, кибер цэргүүд үүргээ амжилттай гүйцэтгэж ирсэн ч энэ нь дайны ажиллагааг төгсгөх цэг тавих амжилтад хүрэхэд хангалтгүй байлаа. Иймээс хуурай замын цэрэгтээ найдах болсон ба хуурай замын цэргийн галын хөнөөлийн үндсэн хэрэгсэл болсон артиллерийн хувьд голлох нөлөө үзүүлж байна. Тус өгүүлэлд Орос– Украины дайнд артиллерийг хэрэглэж байгаа байдлыг тодруулан гаргахыг зорилоо. Эхэн үедээ Оросын зэвсэгт хүчин Украинаас 2–3 дахин илүү тооны артиллеритай оролцож байсан.

Украины Зэвсэгт хүчний жанжин штабаас мэдээлснээр 2023.09.13–ний байдлаар дайн эхэлснээс хойш Оросын талын хохирлыг дараах байдлаар гаргажээ. Үүнд: бие бүрэлдэхүүн–270350, танк–4584, байлдааны машин–8792, артиллерийн систем–5902, тийрэлтэт артиллерийн систем–766, нисдэг тэрэг–316, нисэх онгоц–315, ННХ–4650, усан онгоц–19, цэргийн автотехник–8444.

Хоёр талын байлдааны хохирлын бодит

тоог гаргахад хүндрэлтэй бөгөөд аль аль тал нь эсрэг талынхаа хохирлын тоог нэмэх өөрийн талын хохирлын тоог хасаж мэдээлж байгаа юм.

Их Британид төвтэй Royal United Services Institute (RUSI) судалгааны төвөөс нийтэлсэн тайланд цэргийн шинжээч Жек Уотлинг, Ник Рейнольдс нарын Украины цэрэг, офицеруудтай биечлэн хийсэн ярилцлагаас олж авсан Оросын артиллерийг байлдаанд хэрэглэж байгаа талаарх шинэ мэдээллийг дэлгэжээ. Тухайбал ОХУ–ын Зэвсэгт хүчний 2022 оны 4–р сараас эхлэн зүүн Украинд артиллериар давамгайлсан байлдааны хэлбэрт шилжиж, Украины анги нэгтгэлүүдэд үлэмж хэмжээний хохирол учруулсан.

Уотлингийн хэлснээр "Оросын хуурай замын цэргийн хүчний тактикийн ажиллагааны гүйцэтгэл нь удаан бөгөөд үүнийгээ нөхөхийн тулд артиллерийг их хэмжээгээр ашиглаж байна. Байнгын артиллерийн галын цохилт нь орон нутгийн хүн амыг аажмаар нүүлгэн шилжүүлж, хамгаалагдсан сууринууд болон дэд бүтцийг "тэгшитгэж" байна.

Оросын гаубицууд өдөрт дунджаар 20

Украин–ОХУ–ын Артиллерийн тоо /Дайны эхэн үед/

	Украин	ОХУ	
Дайны эхэн үед	Нийт артиллерийн тоо –2900	Нийт артиллерийн тоо – 6000 /22000–нөөцөд байгаа/	
	Гаубиц–1150	Бэлэн	Нөөц
	152 мм–ийн Гаубиц–750	Миномёт–1032	Миномёт–4000
	122 мм–ийн Гаубиц–350	Гаубиц–976	Гаубиц–5600
АНУ, НАТО–гийн өгсөн	424 /Гаубиц М–777, M142 HIMARS, Panzerhaubitze 2000/	Өөрөө явагч артиллери–2228	Өөрөө явагч артиллери–3960
		Тийрэлтэт артиллери–1219	Тийрэлтэт артиллери–1800
		ТЭ буу 546	ТЭ буу–4000



мянган сум буудаж байгаа бол Украины тал 6000 сум буудаж байна. Тактикийн болон оператив-тактикийн баллистик пуужин харваж байгаа харьцаа Украины талаас хэд дахин илүү байна. Украин нь Зөвлөлтийн стандартад нийцсэн 152 мм-ийн сумны нөөцөө дууссан.

Оросын арми олон тооны артиллерийг тактикийн гол нэгж болох танк эсвэл явган цэргийн батальоны тактикийн бүлэгт (BTG) төвлөрүүлж, 1–3 артиллерийн батарейгаас бүрдсэн хүчирхэг (болон онолын хувьд илүү хариу үйлдэл үзүүлэх) нэмэлт хэрэгслийг нэгтгэнэ гэж бодож байсан. Гэвч судалгаанаас үзэхэд BTG нь практикт ихэвчлэн цөөн тооны миномёт болон хуучин гаубицуудтай байдаг. Үүний оронд бригадын болон дивизийн командлалуудад төвлөрсөн "артиллерийн тактикийн бүлгүүд"-д нь илүү орчин үеийн артиллерийг шаардаж байна. /Холбоо зохион байгуулалт г.м/

2022 оноос өмнө Оросын арми барууны хэв маягийн "тагнуул-галын цогцолбор"-ыг хөгжүүлсэн гэж үздэг бөгөөд энэ нь автомат гал удирдах системийн тусламжтайгаар нисгэгчгүй нисэх хэрэгслүүдийг ашигласнаар (ялангуяа Орлан-10, 30 г.м нисгэгчгүй онгоцнууд) цаг алдалгүй цохилт өгөх боломжийг олгодог байна юм. Жишээлбэл, Оросын артиллери дрон ашигласан үед галыг бодит цаг хугацаанд тохируулж, хөдөлгөөнтэй целийг өндөр нарийвчлалтай онох боломжтой. Дрон нь зургаан бууны батарей төдийгүй зөвхөн нэг юм уу хоёр буг чиглүүлж үр дүнтэй цохилт өгөх боломжийг олгодог.

Оросууд тусгай целүүдийг устгахад гаубицуудыг ашигладаг бол тийрэлтэт артиллерийн системээр Украины цэргүүд болон тэдний томоохон объектуудад хуралдуулсан гал явуулах, цэрийн хөдөлгөөнийг зогсооход ашигладаг.

Украины артиллери, нисгэгчгүй нисэх хэрэгслүүдийн операторуудыг чиглэсэн батарейны эсрэг тэмцэлд дивизийн түвшинд ашигладаг "Точка-У" баллистик пуужин болон Оросын хамгийн алсын тусгалын артиллери

болох 2А65 Мста, 2А36 Гиацинт чирэгч гаубиц, өөрөө явагч хувилбарууд, мөн 2S7M Malka 203 мм-ийн өөрөө явагч гаубицуудыг өргөн ашиглаж байна".

Украины эх сурвалжийн мэдээлснээр Оросын артиллерийн анги салбарууд ихэвчлэн дайсны довтолгооноос хамгаалахын тулд буудлагын холын тусгалынхаа гуравны нэгтэй тэнцэх хэмжээгээр фронтын шугамын ард галт байраа эзэлдэг. Миномётууд үндсэндээ өөрийн цэргүүдийн байрлалаас хойш 1.5 км зайд, 8 км-т артиллерийн тактикийн бүлгүүд, алсын тусгалтай артиллерийн тактикийн бүлгүүд 10–15 км зайд тус тус байрладаг. Гаубицын ангиудыг ихэвчлэн 100х300 метрийн талбайд байрлуулдаг ба, буунуудын хооронд 20–40 метр зайтай байдаг. Пуужин харвах төхөөрөмжүүд нь 150 метр хүртэл тусгаарлагддаг.

Оросын анги нэгтгэлүүд Украины галын цохилтыг өөр тийш нь чиглүүлж, төөрөгдөлд оруулахын тулд ихэвчлэн эвдэрсэн /устгагдсан/ бууны "хуурамч" батарейг газар орон дээр байрлуулдаг.

Оросын батарейны эсрэг тэмцэл нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглаагүй тохиолдолд удаан байдаг. Батарейны эсрэг тэмцэлд РЛК РОП АРК-1М, АЗК-7 радиолокацын болон, дуу чимээний цогцолборуудын ашигладаг. Гэвч батарейны эсрэг тэмцлүүд нь ихэвчлэн дунджаар 30 минут буюу их удаан байдаг.

Харин нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашигласан тохиолдолд Оросын артиллери ердөө 3–5 минутын дотор батарейны эсрэг цохилт өгөх чадвартай. Украины хамгийн орчин үеийн, барууны орнуудаас нийлүүлсэн өөрөө явагч их бууны системүүд л үүнээс зайлсхийхийн тулд хурдан буудаж галт байраа богино хугацаанд орхиж чадна.

Украины артиллерийн батарейнуудад нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг устгахын тулд агаарын довтолгооноос хамгаалах зөвөрийн пуужингуудыг тогтмол байрлуулж, оптик удирдлагатай Starstreak/Marlet пуужингуудыг байрлуулдаг.

Украин дахь цэргийн тусгай ажиллагааны



гол онцлог нь батарейны эсрэг тулаан болж байна. Батарейны эсрэг тулаан нь цэргийн тусгай ажиллагааны үеийн тактикийн гол хэлбэр болж байгаа бөгөөд, саяхныг хүртэл батарейны эсрэг тэмцэл бол өнгөрсөн зууных, хэт авианы эрин үед тэд ямар нэг байдлаар өөрөөр тулалдана гэж үзэх болов.

АНУ, ЕХ, НАТО-гийн их бууны сумны үйлдвэрийн гарц 1 сард 15000 ширхэг атал Украин Улсын 1 өдрийн хэрэглээ 2000–5000 орчим байгаа юм. Өөрөөр хэлбэл Холбоотнууд Украины 3 өдөр хэрэглэх сумыг 1 сарын хугацаанд үйлдвэрлэх боломжтой гэсэн үг юм.

Оросын “камиказе” дронууд Украины артиллерийг байнга ангуучлан устгаж цөөлсөөр байна. Оросын артиллерчид өдөртөө **20–60** мянган их бууны суман мөндөр буулгаж байгаа бөгөөд жагсаалаас гарч байгаа Украин цэргүүдийн **75%** нь артиллерийн галын хохирогч болж байна.

ОХУ яагаад сонгодог тактикийн дагуу Украины ЗХ–ний бэхэлсэн бүс рүү дайраагүй талаар Ерөнхийлөгч Владимир Путин: “Эдгээр бэхлэгдсэн газруудын ар тал руу орох системтэй ажил хийгдэж байна. Энэ нь мэдээжийн хэрэг тодорхой хугацаа шаарддаг. Тэнд батарейны эсрэг тулаан өрнөж байгаа бөгөөд энэ нь нэмэгдэх нь дамжиггүй. Бид артиллерийн хувьд маш том давуу талтай. “Ийм давуу тал нь дайсантай **харьцахгүйгээр** байлдааны даалгаврыг үр дүнтэй шийдвэрлэх боломжийг олгодог бөгөөд энэ нь харьцангуй бага цус урсдаг гэсэн үг юм. Түүгээр ч барахгүй орчин үеийн технологи нь холын зай, галын хурд, галын өндөр нарийвчлал бүхий артиллерийн системийг бий болгох боломжийг олгосон. Сүүлийн үеийн зэвсэгт мөргөлдөөний туршлагаас харахад өнөөдөр байлдааны талбарт тэргүүлэх байр суурийг пуужингийн анги, артиллери эзэлж байна.

Украинд тусгай ажиллагаа эхлэхээс өмнөхөн хамгийн сүүлийн үеийн 152 мм–ийн өөрөө явагч 2С35 “Коалиция–СВ” цогцолборын ердийн сумны туршилт явагдсан. Энэхүү өөрөө явагч буу нь өмнөх “МСТА–С”–тай харьцуулахад

буудлагын хүрээ мэдэгдэхүйц нэмэгдсэн (29 км–ийн эсрэг 80 км), галын хурд 1.5 дахин их – минутад 16 сум.

Байлдааны ажиллагаанд Оросын тал артиллерийн кассетан галт хэрэглэлийг ашиглаж байна. Энэ төрлийн галт хэрэглэл нь дотроо 200–300 ширхэг жижиг хэлтэрхий болж агаарт задарч томоохон хэмжээний талбайд үргэлжилсэн гал тавьж их хэмжээний сүйрэл, хүний аминд хүрэх чадвартай юм.

Хот доторх байлдааны ажиллагаанд миномётын батарейг байшингийн дээвэрт галт байр эзлүүлэх, огцом даяллын буудлагыг түлхүү хэрэглэж байсан.

Буудлагын тавилт тодорхойлох үндсэн арга нь буудсан бууны өгөгдөхүүн ашиглах, дүүрэн бэлтгэлийн арга байсан. Тийрэлтэт артиллери нь галын үүрэг биелүүлэх үндсэн хэрэгсэл болж байсан.

Артиллерийг хэрэглэсэн байдалд гарч буй өөрчлөлтүүд

- Артиллери нь объектод шаардагдах хэмжээний хохирол учруулахад (бүлэг цель) талбайгаар хөнөөхөөс илүү тухайн нэг объектыг хөнөөхөд чиглэсэн байдал ажиглагдсан.
- Үүнтэй уялдаатайгаар дайсны бүлэглэлд “онцгой” чухал объектуудыг сонгох шаардлага нэмэгдэж байгаа бөгөөд тэдгээрт шаардагдах хэмжээний хохирол учруулсны үр дүнд тэмцэлдэгч талуудын хүч хэрэгслийн харьцаанд эрс өөрчлөлт гарна гэж үзэж байна.
- Газрын операцид артиллериар урьтаж /өрсөж/ гал явуулах, батарейны эсрэг тэмцэлд онцгой анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Батарейны эсрэг тэмцлийг амжилттай явуулах 2 хүчин зүйл байна гэж үзсэн.

1. Тагнуулын хэрэгсэл. Буудаж байгаа артиллерийн байрлалыг найдвартай тодорхойлох хэрэгсэл чухал шаардлагатай.
2. Шаардлагатай үед агаарын зураг авах тагнуулын онгоц зайлшгүй байх хэрэгтэй.



Байлдааны ажиллагааны явцад талууд артиллерийн галт байрын байрлалыг түргэн хугацаанд сольж нэг галт байрнаас 1–2 галын үүргийг биелүүлж байсан.

Эдгээр байлдааны ажиллагаануудаас харахад 21–р зууны эхний хагаст явагдаж байгаа дайн, зэвсэгт мөргөлдөөнд дайснаа дараалан болон сонгон хөнөөх галын аргачлал давамгайлах шинжтэй гэж үзэж байна.

Ийм тохиолдолд тухайн артиллерийн салбар гал нээснээс хойш 7–9 минут өнгөрөхөд л галт салбарууд байлдааныхаа чадварын 25–35%–ийг алдахаар байна.

Төрөл бүрийн тактикийн салбаруудаас байлдаан явуулж болзошгүй ажиллагааг загварчлах үр дүнгээр хийсэн судалгааны явцад, орчин үеийн ерөнхий цэргийн байлдаанд **артиллери** нь галын нэгдсэн хөнөөлд оролцоход дайсны онц чухал объектын **60–70%**–ийг хөнөөх чадвартайг нотлон харуулж байна.

Тагнуул–галын ажиллагаа нь нэн өндөр цэцтэй зэвсгийн системүүдийн хоорондох галын харилцан эсрэг тэмцэлд үүрэг нь улам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд энд хамгийн чухал нь цаг хугацаа хожих, дайснаа илрүүлэх устгахад л ирээдүйн хөгжил харагдаж байна.

XXI зууны дайн ба бүс нутгийн мөргөлдөөнд шинэ төрлийн бригад дайсныг галаар хөнөөх үүргийг шийдвэрлэхдээ түр хугацааны

артиллерийн бүлэг байгуулахгүй (ААБ, ДАБ, ХАБ, БрАБ..г.м) орон тооны артиллериар үүрэг гүйцэтгэнэ. Артиллерийн ахлах даргаас хавсаргаж өгсөн хүч нэмэгдүүлсэн хэрэгслийг бүхэлд нь өөрийн мэдэлд эсвэл дивизион (батареи)–оор ерөнхий цэргийн салбаруудад тавигдсан үүргийг гүйцэтгэхээр эсвэл тодорхой тактикийн үүрэг гүйцэтгэхээр томилж болно.

Дүгнэлт. Артиллерийг байлдаанд хэрэглэхэд гарч байгаа өөрчлөлт нь артиллерийн хөдөлгөөнт байдал явган цэргийн анги, салбаруудын хөдөлгөөний хурдтай зохицож байх, ихэвчлэн артиллерийн буу, салаа, батареигаар галын үүрэг гүйцэтгэх, галын үүрэг гүйцэтгэсний дараа дайсны галын үйлчлэлээс зугтан гарахын тулд галт байрыг хурдан хугацаанд орхих, буудлагын цэцийг ихэсгэж буудлагыг богино хугацаанд бэлтгэж явуулах, батареины эсрэг тэмцэлд онцгой анхаарах, дайснаа дараалан болон сонгон хөнөөх, нэгжийн орших чадварыг хангах зэрэгт чиглэгдэж байна.

Байлдааны эцсийн үр дүнг байлдааны сайн ур чадвар, дэвшилтэт технологио зэргээр тодорхойлж байна. Технологийн эрин үед ч артиллери нь ач холбогдлоо алдаагүй байлдааны үеийн өөрийн байр сууриа хэнд ч өгөөгүй юм.

Ашигласан материал:

1. tvzvezda.ru, FB Military Cognization FB, Сухопутные войска ЗС Украины, defence-ua.com, forbes.com, Сухопутные Войска России СВ



ОХУ–ЫН БАТЛАН ХАМГААЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “БАМБАЙ ХӨТӨЛБӨР”

Л.МАНДАЛБАЯР /УБХИС-ийн ЦНДС-ийн АЦТ-ийн багш, ахмад/

Түлхүүр үг: Цөмийн бамбай, стратегийн цөмийн хүчин, цөмийн гурвал, тив алгасах баллистик пуужин, стратегийн бөмбөгдөгч, пуужингийн цогцолбор, харвах суурь, цэргийн нисэх хүчин, тэнгисийн флот

Key words: nuclear shield, strategic military forces, nuclear triad, interplanetary ballistic missile, strategic bomber, missile system, launcher, air Force, navy.

Оршил. ОХУ–ын Батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлж буй “Цөмийн бамбай” буюу өөрөөр мөн “Стратегийн цөмийн хүчин” /Стратегические ядерные силы – СЯС/ хэмээн нэрлэгдэх энэ хөтөлбөр нь Оросын Зэвсэгт хүчний үндсэн зэвсэглэл болох стратегийн болон тактикийн зориулалтын пуужин–цөмийн зэвсэглэлийн хөгжлийн чиглэлийг нэгтгэн тодорхойлсон хөтөлбөр юм. Түүнийг бас заримдаа “Цөмийн гурвал” ч гэж нэрлэдэг байна.


ОХУ–ын шинэ “Төрийн цэргийн номлол”–д зааснаар “... ОХУ нь өөрийн орны болон түүний холбоотон улсуудын эсрэг цөмийн, эсвэл үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсэг хэрэглэсэн үед, түүнчлэн энгийн зэвсэг хэрэглэсэн боловч улс орны оршин тогтнох аюулгүй байдалд нөлөөлөл үзүүлэх хэмжээний түрэмгийлэл үйлдсэн тохиолдолд түүний эсрэг цөмийн зэвсэг хэрэглэх болно...” гэж тодорхойлжээ.

Үндсэн хэсэг. Өнөө үед ОХУ–ын цөмийн зэвсэглэл нь дэлхийд хамгийн өргөн масштабтай бөгөөд өндөр технологиор хийгдсэн болно. Стратегийн зориулалтын пуужингийн цэргийн зэвсэглэлд 2017 оны эхэн үед ойролцоогоор 286 тив алгасах баллистик пуужингийн цогцолборын харвах суурь байсан ба тэдгээрээс 46 хүнд пуужин Р–36М2, 30 пуужин УР–100Н УТТХ, 36 хөдөлгөөнт цогцолбор РТ–2ПМ «Тополь», 60 суурин цогцолбор РТ–2ПМ2 «Тополь–М», 84 хөдөлгөөнт, 12 суурин цогцолбор РС–24 «Ярс» байлдааны жижүүрлэлтэнд гарсан байв.

Оросын хуурай газар байрлалтай Стратегийн зориулалтын пуужингийн цэргийн

хүчин нь пуужингийн 3 армийн 11 пуужингийн дивизийн бүрэлдэхүүнтэйгээр үүрэг гүйцэтгэж байгаа бол Цэргийн нисэх хүчний стратегийн зориулалтын алсын бөмбөгдөгчид нь эх газарт 3–н нисэх хүчний баазад байрлаж байгаа юм байна. Харин стратегийн зориулалт бүхий тэнгисийн цэргийн хүчин нь пуужин тээвэрлэгч хөлөг онгоцнууд, атомын шумбагч хөлөг онгоцнуудаас бүрдэнэ.

Оросын Зэвсэгт хүчний зэвсэглэлд мөн тактикийн болон оператив–тактикийн зориулалтын 2000 нэгж цөмийн зэвсэг /байлдааны толгой г.м./, тэр дундаа АДХ–ын 500 ЗУП /зенитийн удирдлагат пуужин/, 500 хүртэл “агаар–газар” ангиллын далавчит пуужин ба бусад удирдлагат пуужингууд, ойрын алсын пуужин болон цөмийн бөмбөгнүүд багтана. Олон улсын зэвсэглэлийн тоо бүртгэлийн /СНВ– III/ гэрээний дагуу стратегийн бөмбөгдөгч онгоц нь нэг цөмийн байлдааны толгой тээвэрлэгч гэж үздэг ба түүнд байрлуулсан бусад цөмийн бөмбөг, цөмийн цэнэгтэй далавчит пуужингуудыг тооцдоггүй байна.



1 дүгээр зураг. Баллистик пуужингаар харилцан цохилт өгөх тооцоолол



Ийнхүү ОХУ–д хэрэгжүүлж буй “Цөмийн бамбай”, мөн өөрөөр “Цөмийн гурвал” хэмээн нэрлэгдэх хөтөлбөр нь стратегийн зориулалтын цөмийн зэвсгийн хөгжлийг тодорхойлж байгаа бөгөөд хуурай газраас, далай тэнгисээс, агаараас цохилт өгөх гэсэн 3 чиглэлээр явагдаж байгаа болно. Хөтөлбөрийг 1974 оноос эхлэн боловсруулж эхэлсэн ба 1979–1982 онуудад туршилт, судалгааны ажлаа явуулж, анхны зэвсэглэлүүд 1985 оноос эхлэн байлдааны жижүүрлэлтэнд гарчээ. Тэдгээрийн талаар ерөнхий мэдээллийг товчхон авч үзье.

Хуурай газарт. Оросын зэвсэгт хүчний цөмийн зэвсгийн хөгжлийн энэхүү чиглэлийг юуны өмнө Стратегийн зориулалттай пуужингийн цэргийн хүчин тодорхойлно. Зэвсэглэлийн гуравны нэг нь нэн шинэ загварт ангилагдах ба алсын тусгал нь 11–16 мян.км хүрнэ. Дээр өгүүлсэнчлэн эх газрын тив алгасах пуужингууд нь 3 армийн 11 пуужингийн дивизийн байрлалд дэлгэгдсэн бөгөөд газарзүйн хувьд сөрөг талаас ямар ч өргөн газар нутгийг хамарсан цохилт өгөхөд бүх бүлэглэлийг нэгэн зэрэг устгахгүй байхаар тооцоологдсон байна. Удирдлагын системийн хувьд бүрэн автоматжуулагдсан, эсвэл хүний оролцоог эрс багасгасан. Тив алгасах пуужингийн цогцолборуудын төрөл,

тоо хэмжээ, ашиглалт болон хадгалалт, эсвэл туршилт сайжруулалт хийгдэж байгаа эсэх, мөн тэдгээрийн байрлалын талаарх мэдээллийг Хүснэгт 1–д харуулав.

Тэнгист. ОХУ–ын Зэвсэгт хүчний Тэнгисийн цэргийн флотын бүрэлдэхүүнд 2017 оны 3 сарын 1–ний өдөр гэхэд ПЛАРБ загварын баллистик пуужинтай 212 харвах суурь бүхий нэгэн зэрэг 936 байлдааны цохилт өгөх чадвартай 13 атомын шумбагч онгоц байсны 11 нь 160 харвах суурьтайгаар байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж байжээ. Оросын тэнгисийн стратегийн хүчний үндсийг 667БДРМ «Дельфин» загварын пуужин тээвэрлэгч 5 хөлөг онгоц /зэвсэглэлдээ нийт 80 баллистик пуужингийн харвах суурьтай/ мөн ижил загварын байлдааны жижүүрлэлт явуулж буй шумбагч онгоц, нөөц хүчин болох 667БДР «Кальмар» загварын 3 шумбагч онгоц /зэвсэглэлдээ Р–29Р загварын пуужин бүхий 48 харвах суурьтай/ бүрдүүлж байна. Түүнчлэн өнгөрсөн 2017 онд Р–30 «Булава» загварын стратегийн пуужингийн нийт 48 харвах суурь бүхий 3 шумбагч онгоц нэмж зэвсэглэлд оруулжээ.

Өргөн масштабын цохилтыг автомат удирдлагын системээр удирдан явуулах болон цөмийн хүчний ажиллагааны удирдлагын бусад

Хүснэгт 1.

Стратегийн зориулалтын пуужингийн цэргийн хүчний тухай мэдээлэл
/хаалтан дотор хадгалалтад, засварт болон туршилт, сайжруулалт хийгдэж байгаа цогцолборын тоо/

Пуужингийн цогцолбор	Тоо хэмжээ	Нэгж дэх цэнэгийн тоо	Нийт цэнэгийн тоо	Байрлал
Р–36М2 «Воевода»	46(40)	10	460	Домбаровский, Ужур
УР–100Н УТТХ	0(40)	0	0	Козельск, Татищево
РТ–2ПМ «Тополь»	36(60)	1	36	Сибирский
РТ–2ПМ2 «Тополь–М» (суурин)	60(10)	1	60	Татищево
РТ–2ПМ2 «Тополь–М» (хөдөлгөөнт)	18	1	18	Тейково
РС–24 «Ярс» (хөдөлгөөнт)	90(10)	3	270	Тейково, Йошкар– Ола, Нижний Тагил, Новосибирск, Иркутск, Выползово
РС–24 «Ярс» (суурин)	20(8)	3	60	Козельск
Бүгд	270(168)		904	



Хүснэгт 2.

Стратегийн зориулалтын тэнгисийн цэргийн хүчний тухай мэдээлэл
/хаалтан дотор хадгалалтад, засварт болон туршилт, сайжруулалт хийгдэж байгаа нэгжийн тоо/

Пуужин тээвэрлэгчийн төрөл	Пуужин тээвэрлэгчийн тоо	Цогцолборын нийт тоо	Цогцолборын байлдааны цэнэг	Нийт байлдааны цэнэг
667БДР «Кальмар»	3	48 Р-29Р	3	144
667БДРМ «Дельфин»	5(1)	80(16) Р-29	4	320
955 «Борей»	3	48 Р-30	3	144
941 «Акула»	0(3)	0(60) Р-30	0	0
Бүгд	11(4)	176(76)		608

хувилбаруудыг боловсруулан хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлж байна. Цөмийн бамбай хөтөлбөрийн баримтлах зарчмуудын нэг нь шинэ шинэлэг санааг нэвтрүүлэх –эд оршино. Стратегийн зориулалтын тэнгисийн цэргийн хүчний талаарх мэдээллийг Хүснэгт 2–д харуулав.

Агаарт. Стратегийн зориулалтын Цэргийн нисэх хүчний командлалын бүрэлдэхүүнд Ту-95МС, Ту-160 ба Ту-22М3 загварын 38 стратегийн бөмбөгдөгчид дөрвөн нисэх баазад байрласан байдаг байна. Турбо хөдөлгүүртэй эдгээр бүлэг онгоцнууд нь 1984–1993 онуудад үйлдвэрлэгдсэн ба 1999 онд тэдгээрт дахин сайжруулалт хийгдсэн байна. Байлдааны ажиллагааны радиус нь 6,5 мян. км ба зэвсэглэлдээ 250км алсын тусгалтай Х-55 засварын 6 далавчит пуужинтай байна. Далавчин дор нэмэлт 4 пуужин тээвэрлэх боломжтой боловч энэ тохиолдолд нислэгийн алс нь эрс багасна.

“Цөмийн бамбай” хөтөлбөрийн хөгжлийн энэ чиглэл нь хамгийн уян хатан чанартайд тооцогдоно. Учир нь онгоц агаарт хэзээ ч чиглэлээ өөрчлөх, тавигдсан үүргээ цуцлах,

өөрчлөх, эсвэл түүнд нэмэлт тодотгол хийх боломжтой байдаг байна. Мөн хөтөлбөрийн баримталж буй дулааны удирдлагаас радио удирдлагад шилжсэнээр өндөр цэцтэй байх зарчим энд хамгаас түлхүү хэрэгжиж байгаа болно. Түүнчлэн стратегийн бөмбөгдөгчид нь алсын нислэг үйлдэн Удирдлагын төв байруудаас хол зайнд үүрэг гүйцэтгэх тул суурийн /автоном/ удирдлагад шилжин санаачилгыг гартаа авах зарчим үйлчилнэ.

“Цөмийн бамбай” хөтөлбөрийн үндсэн зэвсэглэл болох стратегийн тив алгасах пуужин, бусад цөмийн цэнэгт пуужингуудын баталгаатай ажиллагааг хангахын тулд тэдгээрийн ашиглалтын хугацаа 25 жил болмогц зэвсэглэлээс авч устгалд оруулж шинэчлэх шаардлагатай юм. Стратегийн зориулалтын Цэргийн нисэх хүчний талаарх мэдээллийг Хүснэгт 3–д харуулав.

Тус хөтөлбөрийн баримтлах бас нэг зарчим нь *Удирдлагын байрын тоотын бүрэлдэхүүн бүрэн устсан үед ч гэсэн цөмийн хариу цохилтыг хийх чадвартай удирдлагын автомат бөгөөд ухаалаг системийг хэрэгжүүлэх*–д оршино.

Хүснэгт 3.

Стратегийн зориулалтын Цэргийн нисэх хүчний тухай мэдээлэл
/хаалтан дотор хадгалалтад, засварт болон туршилт, сайжруулалт хийгдэж байгаа бөмбөгдөгчийн тоо/

Бөмбөгдөгчийн төрөл	Бөмбөгдөгчийн тоо	Далавчит пуужингийн төрөл ба тоо	Нийт далавчит пуужин
Ту-95МС6 Ту-95МС16	39(45)	6-16Х-55СМ 8Х-102	
Ту-160	16	12	
Всего	55(45)		798



2 дугаар зураг. Цөмийн салбарын хөгжлийн 70 жилийн ойд зориулсан үзэсгэлэн дээр

Оросын тэргүүлэх цэргийн шинжээчдийн нэг Михаил Тимошенкогийн үзэж байгаагаар ОХУ “Цөмийн бамбай” хөтөлбөрийн зэвсэглэл дэх стратегийн зориулалттай цөмийн зэвсэглэлийг 2020 он хүртэл бараг хоёр дахин багасгах төсөл нь төдийлөн оновчтой бус гэсэн бөгөөд түүнтэй Стратегийн зориулалтын пуужингийн цэргийн Төв Командлал санал нэгтэй байгаа юм байна. Харин Батлан Хамгаалах Зөвлөлийн гишүүн Тагнуулын төв газрын бэлтгэл офицер Виталий Шлыков хэлэхдээ үүнд эмзэглэх зүйл огт үгүй ба үлдэж буй зэвсэглэл нь дайсныг баталгаатай устгахад хангалттай хүрэлцэнэ гэжээ.

Оросын газар нутаг, байгалийн баялгийг тооцоолон үзэхэд ч тэр, түүний хувьд батлан хамгаалах асуудал, тэр дундаа цөмийн хүчний

хамгаалалтыг хэрэгжүүлэх нь бусад дөрвөн " албан ёсны" цөмийн зэвсэгтэй орныг бодвол асар чухал ач холбогдолтой юм. Гадаадын цэргийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар “Цөмийн бамбай” хөтөлбөр нь Орос орныг дэлхийд тэргүүлэх их гүрэн болгож буй үндсэн хүчин зүйл болно. Сүүлийн үеийн тооцоогоор ОХУ ба АНУ-ын цөмийн мэдээлэл харилцан солилцох СНВ-3 гэрээний дагуу гаргасан мэдээллээс үзэхэд Оросын цөмийн хүчин 1492 байлдааны хэсэг бүхий 494 цөмийн тээвэрлэгч дэлгэсэн ба 387 нэгж дэлгэгдээгүй байдалд байгаа гэнэ. Мөн цөмийн хүчний цомхоттол явуулж байгаа нь ч дэлхий нийтэд илхэн байгаа билээ.

Дүгнэлт. Цэргийн шинжээчдийн тодорхойлж байгаагаар цөмийн хүчинтэй холбоотой зарим асуудлыг авч үзвэл:

1. Цөмийн зэвсэг нь өөр ямар ч аргагүй болсон үед хэрэглэх зэвсэглэлийн эцсийн хувилбар байх ёстой.
2. Хятад улс мөн цөмийн зэвсэгтэй боловч түүнийхээ талаар ямар ч мэдээлэл өгдөггүй байна. Хэдийгээр Хятадын цөмийн хүчний талаар ойролцоо мэдээлэл ч байхгүй боловч нөөцийн хэмжээ нь Оросын цөмийн хүчинтэй

Схема выхода Р-36М из пусковой шахты

1. После подготовки ракета находится в шахте, в которой поддерживается температурно-влажностный режим.
 2-3. Старт. Специальный твердотопливный газогенератор создает повышенное давление в нижней части транспортно-пускового контейнера (ТПК) и выталкивает его вместе с ракетой.
 4. После выхода ракеты на высоту примерно 20 м поддон уходит в сторону.
 5. Запускается двигательная установка первой ступени ракеты-носителя.



3 дугаар зураг. Цөмийн пуужингийн далд харвах сууриас гарах үе шатлалууд



- дүйцэх хэмжээнд байгаа нь эргэлзээгүй юм.
3. Орос улс АНУ-тай 1987 онд хийсэн гэрээний дагуу ДТБП /дунд тусгалын баллистик пуужин/-гаа устгасан бол Хятад нь энэ төрлийн пуужингийн тоогоор дэлхийд тэргүүлэх байранд байна.
 4. Орос ба Хятад улсуудын тактикийн түвшний цөмийн зэвсэглэлийн харьцаа мөн харилцан адилгүй юм. Оросын 100 нэгж 120км тусгалтай «Точка-У» тактикийн пуужинтай харвах суурийн эсрэг 150–600км тусгалтай тактикийн пуужин бүхий хэдэн мянган харвах суурь байна гэсэн тооцоо гарчээ.
 5. Орост нэн шинэ АДХ “Искандер” цогцолборын нэг л бригад байгаа ба тэр нь улсын газар нутгийн Европын хэсэгт байрлалтай. Бөмбөгдөгчдийн хувьд Орос ба Хятадын хүч ойролцоогоор тэнцүү /тус бүр 300 нэгж/ байгаа юм
 - байна.
 6. ОХУ-ын цөмийн хүчин нь бүрэн хэмжээгээр өөрийн орны нутаг дэвсгэр дээр байрлалтай байна.
 7. ОХУ нь цөмийн мэдээлэл харилцан солилцох СНВ-3 гэрээний дагуу цөмийн зэвсэгт үл тооцогдох зэвсэглэлийнхээ тоог ч гаргаж өгсөн ба хэдийгээр гэрээний болзолд байхгүй боловч бусад орны зүгээс тэдгээр зэвсэглэлээ ч мөн адил цомхотгох шаардлага тавьсаар байна.
- Ийнхүү ОХУ нь батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах “Цөмийн бамбай” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Орос орон нь мөн цөмийн мэдээллээ ил тод гаргаж байгаа бөгөөд бусад орнуудтай харилцан тохиролцсоны үндсэн дээр дэлхий дээрх цөмийн хүчний потенциалыг багасгаж, улмаар цөмийн аюулыг урьдчилан сэргийлэх бодлого явуулж байгаа гэдэг байр сууриа илэрхийлсээр байгаа билээ.

Ашигласан материал:

1. Военная доктрина РФ. 2010г.
2. ОХУ ба АНУ хоорондын стратегийн зэвсэглэлийг цомхотгох ба хязгаарлах гэрээ СНВ-3. 2010 он.
3. Статья. Скрытая угроза. 2015г.
4. Интернэт.



УХУАНЬ, СЯНЬБИЙН ГАРАЛ, ҮҮСЭЛ, ЗАН ЗАНШИЛ

Т.ЭРДЭНЭХИШИГ /БХЭШХ-ийн ЦТСТ-ийн ЭШТА, доктор (Ph.D), профессор/
Д.ЭРДЭНЭСҮВД /ЗХ-ний 124 –р ангийн сэтгэл зүй хангалтын офицер, хошууч/

Түлхүүр үг: Дунху, Сяньби, Ухуань, Хүннү, дорнод Ху, Монгол угсаатан, Модун шаньюй
Key words: Dong hu, Xianbei, Wuhan, Xiongnu, east hu, Mongolian ethnicity, Maodun chanyu

Оршил. Түүхийн тавцанд НТӨ 209 онд хүчирхэг улс гүрэн байгуулан мандан бадарч явсан Монгол угсааны Хүннү нарын дараа тэдний орыг залган хүчирхэгжин гарч ирсэн улс бол мөн л Монгол угсааны Сяньби нар юм. Эдүгээ бидэнд Хүннү, Сяньби улсуудын талаарх бичгийн мэдээ үлдэж хоцроогүй боловч тэдэнтэй ойр харилцаж байсан Хятадын төрт улсуудын талаарх түүхэн сурвалж бичгүүдэд дээрх хоёр ард түмний талаар цөөнгүй мэдээ сэлт тэмдэглэгдэн өнөөг хүрсэн нь түүхч судлаачдын гол гарын авлага болж байна. Харин Сяньбийн үед холбогдох археологийн эд өлгийн олдвор Монгол Улсын нутаг дэвсгэрээс төдийлөн хангалттай олдоогүй байна.

Үндсэн хэсэг. Сяньби нар нь Хятадын байлдаант улсуудын (МЭ 480–222) үед түүхийн хуудаснаа анх тэмдэглэгдсэн байна. Сяньби хэмээх нэрийн талаар эрдэмтэн судлаачид хэд хэдэн санаа дэвшүүлсний дотор Монголын түүхч Гүнжийн Сүхбаатар өөрийн зохиол бүтээлдээ “Сүмбэ” хэмээн монголчлон дуудаж, энэ үг нь Суварнаготара буюу алтан ураг хэмээх санскрит хэлнээс сунжиран гарсан оноосон нэр болжээ гэж баталсан¹. Энэ талаар Ф.В.Томас, О.Менчен–Хелфен, Ма Чаншоу, Ван Говэй, К.Ширатори зэрэг эрдэмтэн Сяньби гэдэг нэр нь “Сяньби, Сиби, Сьюпи, Сипи, Сьюби, Шиби” зэргээр тэмлэгдсэн байдгийг онцлон тэмдэглэж, харин Шивэй гэдэг нэр нь Сяньби гэх нэрийн сунжирсан үг болохыг П.Пеллио, Фан Жуанью, Сүрбадрах зэрэг эрдэмтэд баталсан байна. Сүмбийн гарал үүслийн тухай эрдэмтэд Монгол

эсвэл Манж Тунгусын өвөг эс бөгөөс Монгол, Тунгус холимог хүмүүс гэсэн гурван таамаглал дэвшүүлдэг бол өвөг Монгол Улс болох нь гарцаагүй бөгөөд Хүннүгийн олон отог аймгийг нэгтгэн захирч өнөөгийн Монголчуудын генийн санг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан юм. Зарим түүхчид өвөг Монголчуудыг Хүннү эцэгт Сүмбэ эхт аймгууд гэж нэрлэсэн байдаг. Сяньбичууд Умард Хятадад хэсэгтээ ноёрхож явсан ч он цагийн явцад Хятадад уусан алга болсон юм.

Эрдэмтэн Гүнжийн Сүхбаатар Хүннү, Сяньби хоёр ард түмнийг ургын давхар байгууламжаар холбогдсон хэмээн бичжээ.

БНМАУ–ын түүхийн тэргүүн ботид Ухуань, Сяньби нар бол Монголчуудын өвөг дээдсийн нэг² гэсэн бол “Монгол улсын түүх”–ийн тэргүүн ботид “Модун шаньюйд эзлэгдэн Хүннү гүрний захиргаанд орж, түүнд алба барьж байсан Дунху аймгуудын зарим нь Манж–Түнгүс угсааны овог аймгууд байсан боловч дийлэнх ихэнх нь өвөг Монгол угсааны овог аймгууд байсан юм. Дунхугийн баруун хэсэгт Хянганы нурууны зүүн талд байсан Сяньби, баруун өмнөд хэсгийн Ухуань, баруун хойд хэсгийн Муюн, Тоба аймгууд цөм Монгол угсааны аймгууд байсан нь хэл шинжлэл, түүх–угсаатны зүйн шинжилгээгээр үндсэндээ бүрэн нотлогдсон болно”³ гэж бичсэн бол түүхч Г.Сүхбаатар 1971 онд бичсэн “Сяньби” гэх бүтээлдээ “Ухуань, Сяньби бол түүх, нутаглаж байсан газар нутаг, хойшдын удам угсаагаараа Дунху нартай удам угсааны холбоотой болох нь эргэлзээгүй”⁴ гэж

¹ Сүхбаатар Г. Сяньби. УБ,1971. т.21

² БНМАУ–ын түүх. Тэргүүн боть. УБ, 1966. т.96

³ Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ, 2003. т.246

⁴ Сүхбаатар Г. Сяньби. УБ,1971. т.22



бичжээ.

Хятадын сурвалж болох “Хойд Хан улсын бичиг”-т Сяньбийн гарал үүслийн талаар “Сяньби бол Дунхугийн нэгэн салаа. Тэд Сяньби ууланд нүүн сууснаар ийнхүү нэрлэгдэх болсон”, “Тэдний хэл, зан заншил нь Ухуаньтай адил төстэй” хэмээн бичсэн нь тэд гарал угсаа нэгтэй болохыг харуулж байна. Ухуаньчууд Сяньби нарыг бодвол Хятадтай арай ойр дөт харилцаатай байснаас тэдний тухай Хятад сурвалжийн мэдээ арай илүү байдаг. Дунху гэдэг нь Хятадаас орчуулбал “Дорнын бүдүүлэг” гэсэн утгатай үг хэмээн тайлбарласан К.Шираторигийн саналыг эдүгээ олон эрдэмтэн судлаач хүлээн зөвшөөрөөд байна⁵.

Нэн эрт үеэс хятад зэргэлдээ нүүдэлчидтэй харилцах явцад гадаад харилцааны талаар хятадын номлол тогтож эхэлсэн байна. Хятадын Инь Улсын (НТӨ ХІҮ–ХІ) захирагчид дээд эзний зарлигаар ард түмнийг захирч байгаа мэт номлож байжээ. Жоу Улсын үед (НТӨ ХІІІ–ІІІ) Хятадын ван бол тэнгэрийн доорхыг (ертөнцийг) захирах тэнгэрийн зарлигтай мэт үзэж өөрийгөө “Тэнь зы” (тэнгэрийн хүү) гэж өргөмжлөн улмаар Хятад орноор барахгүй, зэргэлдээх Хятад бус ард түмнийг захирах ёстой мэт болж ертөнцийн төвийг “жун гуо” (дундад улс) хэмээн үзэх болсон⁶ ба нэг ёсондоо Хятад угсаатныг ертөнцийн төв болгон авч үзэх үзэл (этноцентризм) бий болжээ. Цин улс (НТӨ 221–207 он) байгуулагдсан тэр үеэс эхлэн Хятад төвийн үзэл буюу хятаджуулах зарчим нь Хятадын их гүрний үзэл суртлын суурь зарчим болжээ⁷.

Хятадуудын “ху” буюу “бүдүүлэг” ертөнцийн тухай ойлголт нь “төв” буюу вангийн эзэмшлээс хэр хол оршин байгаагаар тодорхойлогдоно. Харь аймгуудыг “дайсагнасан” ба “ижилссэн” (соёлын нөлөөнд орсон) хэмээн ангилж үзэх бөгөөд “ижилссэн аймгууд”-ыг гадаад,

“ижилсээгүй” буюу соёлын нөлөөнд ороогүй аймгуудыг дайсагнасан гадаад хэмээн үздэг байжээ. Ийнхүү анх газар зүйн ойлголтоор тодорхойлогдож байсан “харь”, “бусад” хэмээх ойлголт нь ёс зүй, соёл, угсаатан, улс төрийн ойлголт болон өргөжсөн нь харагдаж байна. Умардын болон баруун зүгийн Жун, Ди нар нь “төв”-өөс хамгийн алс хол оршдог, төвийн соёлыг хүлээн авдаггүй, дайсагнасан харь аймгууд байсан ажээ⁸. Хятадууд “ху” гэх нэр томъёонд Хүннү, Дунху, Линьху, Лоуфань нарыг багтааж байжээ. Хан улсын тайлбарлагч Фу Цяний бичсэнээр “Тухайн үед дунху нар Хүннүгийн дорно талд сууж байсан учраас ийнхүү нэрлэгдэх болсон”⁹ гэжээ.

Дунху гэх нэр чухам хэдийд түүхийн сурвалжид тэмдэглэгдсэн бэ? гэх асуултад судлаачид өөр өөрийн хариултыг өгсөн байдаг. Хятадын түүхч Линь Ган Дунху гэсэн нэр хамгийн анх И жоу бичгийн долдугаар боть “Ванхүйгийн чуулбар”-т харагдаж, “Дунху нарыг шар махай (нас бие гүйцсэн эр баавгай) хэмээв гэж бичсэн ба мөн “Чанх умард зүгт хүннү....дунху амой” гэжээ. Үүнээс дараахан “Шанхай жин” бичгийн 11 дүгээр ботийн “Хай нэй си жин”-д бас “Дунху нар нуурын зүүнтээ оршино, и-чүүд Дунхугийн зүүнтээ оршино” хэмээн тэмдэглэсэн байна. Дээрх хоёр сурвалж бичиг Байлдаант улсын үеийнх ажээ. Линь Ган мөн Баруун хан улсын үеийн Сы Мацяны зохиосон “Түүхэн тэмдэглэл” хэмээх сурвалжид Дунху нарын талаар олон удаа дурдсан тухай өгүүлжээ. Энд яригдаж буй дунхугийн цаг хугацааны талаар гэвэл НТӨ VII зууны дунд үе, өөрөөр хэлбэл Жоугийн Сянь вангийн сууринд байсан үе (652–619) бололтой. Жишээлбэл, хүннүгийн сул шастирт тэмдэглэсэн нь: “Жингийн Гун вэн анх сууринд суугаад хүчирхэг улсыг үүсгэн байгуулна хэмээж... Жоугийн Сянь ванг залж, Ло И хотод суужээ. Тэр үед Цин,

⁵ Эрдэнэхишиг Т. Монголын эртний улсуудын дайн байлдаан, зэр зэвсэг. УБ., 2022. 112 дахь тал

⁶ Сүхбаатар Г. Сяньби. УБ, 1971. т.7

⁷ Эрдэнэхишиг Т. Хүннү, Хан улсын цэрэг, улс төрийн харилцаа. УБ, 2009. т.131

⁸ Дэлгэржаргал П. Сяньби. Монголын эртний түүх дэд боть. УБ, 2017. т.19–20

⁹ 史记.卷 110. 匈奴列传



Жин хүчирхэг улсууд байсанЖин улсын умардад Линьху, Лоуфаний жун байх ажээ. Янь Улсын хойно Дунху, уулын Жун сууна, тус тусдаа голын хөндийгөөр нутагладаг, өөр өөрийн тэргүүн ахлагчтай. Үргэлжид зуу гаруй жун цуглах авч нэгээхэн ч адил үгүй”¹⁰ гэжээ. Оросын түүхч В.С.Таскин “Янь Улсын хойд зүгт Дунху, Шанжунь оршино” гэсэн Сы Мацяний түүхэн тэмдэглэлийн мэдээ Байлдаант улсын үед хамаарах боловч Янь Улсын тухай бичсэн 34–р бүлэгт Дунхугийн талаар огт дурдаагүй. Тиймээс В.С.Таскин НТӨ 307 онд Жаогийн Улин ван (НТӨ 326–299 он) “Тэдний дорно зүгт дунху буй” гэж хэлсэн сурвалжийн мэдээг хамгийн анхных¹¹ нь гэж үзжээ.

Доктор П.Дэлгэржаргал Дунху нар хятад сурвалжид анх тэмдэглэгдсэн талаарх судлаачдын саналыг багцлан авч үзэхдээ: 1. “Түүхэн тэмдэглэл”–ийн мэдээг Жоугийн Сян вангийн үе (НТӨ 652–619)–ийн хэрэг явдалтай холбогдуулан НТӨ VII зууны үед түүхэнд анх гарч ирсэн гэдэг Лин Ган нарын санал, 2. НТӨ IV зуун буюу нарийвчлан тодруулбал, НТӨ 454 оны үед сурвалжид анх тэмдэглэгдсэн гэдэг Л.Ю. Мюлли, Г.Сүхбаатар нарын санал, 3. НТӨ 307 он буюу Жаогийн Улин вангийн үед анх тэмдэглэгдсэн гэдэг В.С.Таскин нарын санал гэж үндсэн гурван хэсэгт хувааж болохоор байна¹² гээд сурвалжид хамгийн анх нэр дурдагдсан мэдээнд тал өгөх нь зүйтэй гэсэн түүний саналтай судлаач миний санал нийлж байна.

Эртний хятадууд Сяньби нарыг анх Сюйби, Шиби, Сиби гэх зэрэг янз бүрээр нэрлэж байснаа эцэст нь Сяньби хэмээн нэг мөр нэрлэх болсон бөгөөд тэдгээр нэрс цөм сяньби гэсэн нэг утгатай, нэг хэсэг овог аймгийг нэрлэж байгаа юм хэмээн ухаарах болсон байна. Сяньби гэдэг нэр хожмын үед шивэй хэмээх

аймгуудын нэр болсон, тэгэхдээ уг нь Шивэй хэмээх нэр байсныг Хятад сурвалжид сяньби, бүр дээр үед тийнхүү Сюйби Шиби, Сиби гэж тэмдэглэн үлдээснийг¹³ зарим эрдэмтэд нэлээд үндэстэй хэмээн үздэг ажээ.

Сяньби нарыг бүрэлдэхүүндээ багтаасан Дунхунар Модуншаньюйд бутцохиг дохоосомно Хятадын хил орчмын улсуудтай харилцаатай байсан байна. НТӨ IV зууны сүүлээр Жао Улсын У Лин ван “Ху–гийн адил хувцаслаж, харваж намнахыг сурч” байх тэр үед (НТӨ 307 он) Жао Улсын зүүн хойд хэсгийн нутгаар Дунхучуудын хөл хөдөлгөөн тасардаггүй байв. Жао овогтын удам угсааны У Лин ван хэлэхдээ: “Эдүгээгийн Жун шан (өнөөгийн Хубэй мужийн Дин сянь орчим) миний харьяанд буй, умардад Янь, зүүнтээ ху (дунху) буй” гээд дахин өгүүлэхдээ: “Чан шан (өнөөгийн Хөбэй мужийн Юань ши сянь орчим) –аас Дай (өнөөгийн Хөбэй мужийн Юй сянь орчим), Шан Дан хүртэл, зүүнтээ Янь буй, Дунхутай хиллэнэ, баруун талд Лоу Фань буй Чин, Хан улстай хиллэж байна”¹⁴ гэжээ.

Ойролцоогоор Байлдаант улсын сүүлээр Дунху аажмаар хүчирхэгжиж, Янь, Жао улсуудтай харилцаж байв. Түүхэн тэмдэглэлийн “Жао овогтын удам угсаа” бүлэгт Жао Хуй вангын 26 дугаар он (НТӨ 273 он)–д Дунхугийн хилийн оу довтлон эзлэв” гэж тэмдэглэжээ. Сурвалжид гарч буй оу–ийн орчим газар гэсэн нь Дунху хүннүгийн хилийн зааг нутагт оутуо сууна гэсний “оу”–тай адил байна. Дунхучууд аажмаар хүчирхэгжиж Янь Улсын нэгэн жанжинг барьцаанд авч байсан мэдээ ч байдаг¹⁵.

НТӨ 209 онд Хүннү Улсын Модун шаньюй (НТӨ 209–НТӨ 174 он) өөрийн эцэг Түмэн шаньюйг хороон эцгийн ор сууж улсаа улам хүчирхэгжүүлсэн байна. Энэ үед тэдний дорнод хөрш болох Дунху нар тэдэнтэй эн тэнцүү

¹⁰ Лин Ган. Дунхугийн түүх. Хөх хот. 1989. т.1

¹¹ Таскин В.С. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Москва, 1984.с.39

¹² Дэлгэржаргал П. Сяньби. Монголын эртний түүх дэд боть. УБ, 2017.т.24

¹³ Сүхбаатар Г. Сяньби. УБ,1971. т.76–77

¹⁴ 史记.卷 43. 赵世家第十三

¹⁵ Эрдэнэхишиг Т. Монголын эртний улсуудын дайн байлдаан, зэр зэвсэг. УБ., 2022. т 54



харилцаж, Маодунь шаньюйгаас хайртай хатан, хайртай аргамаг хүлгээ өгөхийг шаардаад зогссонгүй хоёр улсын дундын хилийн бүс нутаг болох хэсэг газрыг өгөхийг шаардсан нь тухайн үед Дунху нар нилээд хүчирхэг байсныг харуулж байна. Маодунь шаньюй тэдний шаардлагын хариуд “Газар бол улсын үндэс” хэмээн өгүүлээд Дунхуг гэнэдүүлэн гэнэт довтолж газар нутгийг нь эзлэн авсан тухай “Түүхэн тэмдэглэл”-ийн “Хүннүгийн шаштир”-т бичсэн байдаг. Дунху нар Хүннүг үл тоон хэнэггүй байснаас ялагдсан байж болох юм¹⁶.

Модун шаньюйд бут цохигдсон Дунху нар тарж бутран хоёр хуваагдаж Ухуань уул (өнөөгийн Өвөр монголын Улаанхад хотын Ар хорчин хошууны баруун хойдод буй) болон Сяньби уул (өнөөгийн Өвөр монголын Жирэм аймгийн Хорчин зүүн гарын дундад хошууны баруунтаа) –нд зугтаан очсоноос хойш өөрийгөө тус тус ухуань болон Сяньби хэмээн нэрлэх болжээ¹⁷. Энэ талаар Хожуу Хан Улсын бичигт “Сүмбэ гэдэг нь мөн дорнод ху нарын салбар мөн, Сүмбэ ууланд тусгайлан нутагладаг учир ийнхүү нэрийджээ. Тэдний хэл заншил нь Ухуаньтай адил” гэсэн байдаг¹⁸.

Ухуань, Сяньби хоёулаа Хүннүгийн зүүн гарт багтаж, арьс үс, малаар алба тушааж, эрчүүд нь Хүннүгийн цэргийн албанд ч хүчин зүтгэж байв. Сяньби нар харин Хүннүд төмрөөр алба барьж байсан бөгөөд хожим хүчирхэгжсэн үедээ нутаг дэвсгэртээ төмрийн хүдэр хайлуулж байжээ. Тухайлбал, Сяньби Улсыг үндэслэгч Таньшихуайн (НТ 136–181 он) эцэг Тулухоу Хүннүгийн цэрэгт 3 жил явж байв. Ухуаньчууд “Модуньд эзлэгдээд хүн амын хүч сул, Хүннүд үг дуугүй захирагдаж байв. Жил бүр үхэр, адуу, хонины арьс ширээр алба төлдөг, цагтаа өгөхгүй бол эхнэр хүүхдийг нь барьцаалан авч явдаг байсан”¹⁹ байна.

Энэ үед байдал ямар байсан тухай хятадын

сурвалжид: “Сяньбичууд хөөгдөн явж Ляодун боомтын гадна очиж Ухуаньтай хөршлөн суусан ч дундад улстай хэзээ ч холбоо харилцаа тогтоож байсангүй. Гуан У–гийн (НТ 25–57 он) хаанчлалын эхний жилүүдэд хүннүчүүд хүчирхэгжиж Ухуань, Сяньбиг толгойлон хойд зүгийн хилийн нутгуудаар довтолж түшмэдийг алж, олзлох болсноор амар тайван жил үгүй болов. Жянь У–гийн хорин нэгэн онд Сяньби, Хүннү нар Ляодунд довтолсон ч Ляодунгийн тайшоу түшмэл Жи Рунд бут цохигдож, бараг бүгдийг нь алж олзолжээ. Энэ явдлаас болж тэд ихэд айж цочив. Жянь У–гийн 25 онд өмнөд хүннүгийн шаньюй хан улсад дагаар орсноор умардын дайсан ганцаардан доройтож, сяньбичууд элч илгээх болов”²⁰ гэж бичжээ. Хүннүгийн дотоодод хагарал гарсныг далимдуулан сяньбийн зарим нэг хүмүүс Хан улсад хүчээ өгье хэмээн дагаар орж байв. Зүүн Хан улсын засаг Сяньбитай хамтран Умард Хүннүг ганцаардуулах, довтлон хүчийг сулруулж бут цохих улс төрийн бодлого хэрэгжүүлж, Сяньбийн ахлагчийг ван хоу хэмээн өргөмжилсөнд Сяньбийн олон ахлагч даган ирж жил бүр Хан улсаас шан харамж хүртдэг болсон байна. Модун шаньюйд эзлэгдэн Хүннү гүрний захиргаанд орж, түүнд алба барьж байсан

Дунху аймгуудын зарим нь Манж–Түнгүс угсааны овог аймгууд байсан боловч дийлэнх нь өвөг монгол угсааны овог аймгууд байсан юм. Дүнхүгийн баруун хэсэгт Хянганы нурууны зүүн талд байсан Сүмбийн /Сяньби/, баруун өмнөд хэсгийн Ухуань, баруун хойд хэсгийн Муюн, Тоба аймгууд цөм Монгол угсааны аймгууд байсан нь хэл шинжлэл, түүх–угсаатны зүйн шинжилгээгээр үндсэндээ бүрэн нотлогдсон болно.

НТ I зууны сүүлчээр Хүннү гүрний оронд Монголын түүхийн тавцан дээр зонхилох цэрэг–улс төрийн томоохон хүчин болж, удаа

¹⁶ Эрдэнэхишиг Т. Монголын эртний улсуудын дайн байлдаан, зэр зэвсэг. УБ., 2022. т 36

¹⁷ 林干. 东胡史. 内蒙古人民出版社. 1989. с. 3

¹⁸ Сүхбаатар Г. Монголын түүхийн дээж бичиг. Тэргүүн дэвтэр. УБ., 1992. т 27

¹⁹ 后汉书. 第 90 卷. 乌桓鲜卑列传

²⁰ 后汉书. 第 90 卷. 乌桓鲜卑列传



дараа гарч ирсэн Сүмбэ /Сяньби/, Муюн, Тоба улсууд болон тэдний захиргаан доор шүтлэг, зан заншил нь хүннүтэй үндсэндээ бараг, олон талаар төсөөтэй байсныг эртний Хятадын түүхэн сурвалжууд, эдүгээ үеийн шинжлэх ухааны үр дүнгүүд улам бүр лавшруулан баталж буй ажээ.

Тэд цөм Хүннү нарын адил Төв Азийн нүүдэлчин овог аймгууд байсан бөгөөд хэл ярианы хувьд Алтай язгуурын өвөг Монгол хэлтнүүд байлаа. Сүмбэ /Сяньби/ нарыг эртний Нангиадын түүх сурвалжид “бэлхүүс нарийн, хүзүү гуалиг”, “гар хөл тантгар бүдүүн”, “мухар толгойтой, улаан хувцастай” хүмүүс байв хэмээн тодорхойлж байжээ. Эртний Хятадууд сүмбэ нарыг анх Сюйби, Шиби, Сиби гэх зэрэг янз бүрээр нэрлэж байснаа эцэст нь Сяньби хэмээн нэг мөр нэрлэх болсон бөгөөд тэдгээр нь цөм Сяньби гэсэн нэг утгатай, нэг хэсэг овог аймгийг нэрлэж байгаа юм хэмээн ухаарах болсон байна. Зарим эрдэмтдийн нэлээд үндэстэй үзэж байгаагаар Сяньби гэдэг нэр хожмын үед шивэй хэмээх аймгуудын нэр болсон, тэгэхдээ уг нь Шивэй хэмээх нэр байсныг Хятад сурвалжид Сяньби, бүр дээр үед тийнхүү Сюйби, Шиби, Сиби гэж тэмдэглэгдэн үлдээсэн байна хэмээн үздэг байна. Гэвч хожмын үеийн Шивэй нарын нэг хэсэг Манж-Түнгүс угсааны, нөгөө хэсэг нь Хар тэрэгт Шивэй, Монголын шивэй гэх зэрэг Монгол угсааны овог аймгууд байсны дотроос Монгол угсааныханд нь язгуурын Монголын өвөг дээдэс хамаарч байжээ. Харин Манж-Түнгүс угсааны Шивэй нарын ихэнх хэсэг нь Зүүн хойд Хан Улс буюу Манжуурт үлдсэн байснаас Манжийн төр XVII зууны үед цөөн заримыг Синьцзянд очуулсан нь одоо ч мөн Шивэй нэртэй үлдэж, Манж Түнгүсээрээ ярьж, бичиж, ном сонин хэвлэсээр буй билээ.

Сүмбэ нарыг Хянгану зүүн талын Сяньби ууланд оршин амьдарч байсан учраас Сяньби хэмээн дууддаг болсон ажээ. Харин эртний Нангиадын зарим түүх сударт Сүмбэ нар бол уг нь Цинь Шихуаны үед Хан Улсын Цагаан хэрмийг барихад дайчлагдан ажиллаж байсан Хятадуудын зарим нь оргон зайлж Сяньби ууланд очиж бүгсэн нь Сяньби овог аймгууд

болсон гэдэг нь эрдэмтэд ямар ч үндэслэлгүй хэмээн үздэг.

Сяньби нар Хянгану зүүн талаар нутаглаж байхдаа тийм их хүчирхэг улс аймаг байсангүй, жирийн нүүдэлчин овог аймаг байсан юм. Тэд зэргэлдээх манж-түнгүс угсааны овог аймгууд болон Тоба нарын адил гээг сүлждэггүй, Хүннү нарын адил үсээ сул тавьдаггүй, ялангуяа гэрлэхийн өмнө үсээ сайтар хусаж, тайрч янзалдаг байжээ. Сяньби нар хаврын сүүл сар буюу одоогийнхоор дөрөвдүгээр сарын үед Луух гол хэмээн Баруун шар мөрний тэнд найр наадам хийгээд дараа нь гэрлэдэг байжээ. Сяньби нарын оршин амьдардаг Шар мөрний хавийн нутагт таван хошуу малаас гадна хулан, тахь, аргал, угалз, зэрлэг үхэр, булга, өмхий хүрэн болон зарим мич байдаг байжээ. Тэдгээрийн арьс үс нь зөөлөн зэрэг шалтгааны учир Хятадад их үнэлэгддэг байжээ. Гэвч тэд Хятадаас харьцангуй хол, замд нь Ухуань зэрэг өөр овог аймгууд байдаг байсан учир Цинь, Хань улсуудтай шууд харилцаж чадаагүй байжээ. Модун шаньюйн үед Хүннүд эзлэгдсэний дараа Сяньби нар Хүннүчүүдтэй хүч хавсран эртний Хятадын Баруун Хан Улсын харъяаны Ляодун мужийн зэрэг зүүн хойд, хойд зүгийн муж хязгааруудад довтолон түйвэргэдэг байжээ. Өмнөд Хүннү нар Хятадын Зүүн Хань Улсад дагаар орж Умард Хүннү суларсны дараах Сяньби нар анх удаа Хятадад элч илгээж шууд харилцах болсон байна.

Дүгнэлт. Ухуань, Сяньби нар нь Хүннүгийн дорно этгээдэд нутаглан сууж байсан Монгол угсааны Дунху нарын үр хойчис гэдэг нь эдүгээ археологийн болоод бичгийн сурвалжийн баримт мэдээгээр нотлогдсон билээ. Ухань, Сяньби гэдэг нэр нь нүүж суусан газар олрны нэр буюу уулын нэртэй салшгүй холбоотой. Тэд мөн Монгол хэлтэн байсан нь Л.Лигети, Г.Сүхбаатар, А.Вовин нарын зэрэг олон эрдэмтдийн судалгааны үр дүнд батлагдаад байгаа билээ.

Сяньби нар ургын давхар байгууламжаар холбогдсон Хүннүчүүдийг нэгэн үе эзлэн авч хүчирхэгжиж явсан ч тарж бутарч, унан



доройтох үедээ нэлээдгүй хэсэг нь урагш нүүн явсан ч удалгүй Хятадуудад уусан алга болсон одож тэндээ суурьшин Тоба зэрэг Улс байгуулж түүхтэй.

Ашигласан материал:

1. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ, 1966
2. Дэлгэржаргал П. Сяньби . Монголын эртний түүх дэд боть. УБ, 2017.
3. Лин Ган. Дунхугийн түүх. Хөх хот. 1989
4. Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ, 2003
5. Сүхбаатар Г. Сяньби. УБ, 1971
6. Таскин В.С. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Москва, 1984
7. Эрдэнэхишиг Т. Хүннү, Хан улсын цэрэг, улс төрийн харилцаа. УБ, 2009
8. Эрдэнэхишиг Т. Монголын эртний улсуудын дайн байлдаан, зэр зэвсэг. УБ., 2022
9. 史记.卷 110. 匈奴列传
10. 史记.卷 43. 赵世家第十三
11. 林干. 东胡史. 内蒙古人民出版社. 1989.
12. 后汉书.第90 卷. 乌桓鲜卑列传